



**ДОТООД ХЭРГИЙН ИХ СУРГУУЛЬ
ЭРДЭМ ШИНЖИЛГЭЭНИЙ НЭГДСЭН ХҮРЭЭЛЭН
ГАМШИГ СУДЛАЛЫН ТӨВ**

**ГАМШГААС ХАМГААЛАХАД САЙН ДУРЫНХНЫ ҮЙЛ
АЖИЛЛАГААНЫ ОРОЛЦООГ НЭМЭГДҮҮЛЭХ БОЛОМЖ**

СУДАЛГААНЫ ТАЙЛАН

**УЛААНБААТАР ХОТ
2023 ОН**

**ГАМШГААС ХАМГААЛАХАД САЙН ДУРЫНХНЫ ҮЙЛ
АЖИЛЛАГААНЫ ОРОЛЦООГ НЭМЭГДҮҮЛЭХ БОЛОМЖ**

СУДАЛГААНЫ ТАЙЛАН

Судалгааны захиалагч:

Эрдэм шинжилгээний нэгдсэн хүрээлэнгийн
Гамшиг судлалын төв

**Судалгааны багийн
гишүүд:**

Б.Саранцэцэг

Эрдэм шинжилгээний нэгдсэн хүрээлэнгийн
Гамшиг судлалын төвийн эрхлэгч, гамшиг
судлалын доктор (Ph.D), дэд хурандаа

Б.Ганзагас

Гамшиг судлалын төвийн эрдэм
шинжилгээний ажилтан, ахлах дэслэгч

Г.Батгэрэл

Гамшиг судлалын докторант

Агуулга

Зургийн жагсаалт	3
Хүснэгтийн жагсаалт	4-5
Точилсон үгийн жагсаалт	6-7
Удиртгал	8-15
НЭГДҮГЭЭР БҮЛЭГ. САЙН ДУРЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОНОЛ, АРГА ЗҮЙН ҮНДЭС, ОЛОН УЛСЫН ТУРШЛАГА	
1.1. Сайн дурын үйл ажиллагааны мөн чанар, зарчим	16-48
1.2. Сайн дурын үйл ажиллагааны Олон Улсын туршлага	49-68
1.3. Сайн дурын үйл ажиллагааны Олон Улсын туршлага	69-86
Нэгдүгээр бүлгийн дүгнэлт	87-90
ХОЁРДУГААР БҮЛЭГ. МОНГОЛ УЛС ДАХ САЙН ДУРЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ӨНӨӨГИЙН БАЙДАЛД ХИЙСЭН ШИНЖИЛГЭЭ	
2.1. Гамшгаас хамгаалахад сайн дурын үйл ажиллагааны эрх зүйн зохицуулалтын өнөөгийн байдал	91-116
2.2. Гамшгаас хамгаалахад сайн дурын үйл ажиллагааны өнөөгийн байдлын шинжилгээ	117-148
Хоёрдугаар бүлгийн дүгнэлт	149-155
ГУРАВДУГААР БҮЛЭГ. САЙН ДУРЫНХНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРОЛЦООГ НЭМЭГДҮҮЛЭХ АРГА ЗАМ	
3.1. Сайн дурын үйл ажиллагааны эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгох боломж	156-171
3.2. Сайн дурын үйл ажиллагааны оролцоог нэмэгдүүлэх зарим арга зам	172-204
Гуравдугаар бүлгийн дүгнэлт	205-211
Дүгнэлт	212-215
Санал	216-218
ЭХ СУРВАЛЖИЙН ЖАГСААЛТ	219-224

Зургийн жагсаалт

- Зураг 1 Гамшгийн удирдлагын мөчлөг
- Зураг 2. Олон Улсын гамшгаас хамгаалах болон яаралтай тусламжийн чиглэлээр гарсан бодлогын баримт бичгийн түүхэн хөгжил
- Зураг 3 Гамшгийн хохирлын судалгааны дүн: (1980-2019 он)
- Зураг 4. Нийт гамшигт үзэгдлийн төрлөөр нь авч үзвэл: (1980-1999 он, 2000-2019 он)
- Зураг 5 Сайн дурын идэвхтний оролцоо, ажлын гүйцэтгэлд нөлөөлөх хүчин зүйл
- Зураг 6. Сайн дурын идэвхтний оролцоо, ажлын гүйцэтгэлд нөлөөлөх хүчин зүйлийн хамаарлын шинжилгээ
- Зураг 7. Замын шинжилгээний үр дүн /Bootsrapping/
- Зураг 8. Гадаад, дотоод хүчин зүйлийн үнэлгээ, үр дүнгийн график
- Зураг 9. Сайн дурынхны үйл ажиллагааг удирдах, хамтын ажиллагааны бүдүүвч
- Зураг 10. Сайн дурынхны үйл ажиллагааны оролцоо, түншлэлийн загвар

Хүснэгтийн жагсаалт

- Хүснэгт 1. Сайн дурын үйл ажиллагааны тодорхойлолтын ангилал
- Хүснэгт 2. Сайн дурын үйл ажиллагааны шинж чанарын харьцуулалт
- Хүснэгт 3. Сайн дурынхны оролцооны чиглэл
- Хүснэгт 4. Гамшгаас хамгаалах үе шатуудад хэрэгжүүлэх үйл ажиллагаа
- Хүснэгт 5. Гамшгаас хамгаалах үйл ажиллагаа дахь сайн дурынхны оролцоо
- Хүснэгт 6. Сайн дурынхны гамшгийн хариу арга хэмжээнд үүрэг гүйцэтгэхэд илрэх давуу ба дутагдалтай талууд
- Хүснэгт 7. Гамшгаас менежментийн чиглэлээр ажилладаг сайн дурын засгийн газрын бус байгууллагын арга барилын хувьсал
- Хүснэгт 8. Түүхэн хөгжлийн явц дахь олон улсын болон үндэсний сайн дурын үйл ажиллагааны агуулга, шинж чанарын өөрчлөлтийн харьцуулалт
- Хүснэгт 9. Монгол Улс дахь сайн дурын үйл ажиллагааны түүхэн хөгжил
- Хүснэгт 10. Сайн дурын үйл ажиллагааны хууль, тогтоомжийн дүн шинжилгээ
- Хүснэгт 11. Гамшгаас хамгаалах тухай, Галын аюулгүй байдлын тухай хуулиуд дахь оролцогч талуудын зохицуулалтад хийгдсэн шинэчлэлийн харьцуулалт
- Хүснэгт 12. "Гамшгаас хамгаалах сайн дурын ажиллагааны нийтлэг журам", "Залуучуудын сайн дурын ажлыг бүртгэх, баталгаажуулах журам" харьцуулалт
- Хүснэгт 13. Төв, орон нутгийн хэмжээнд үйл ажиллагаа явуулж байгаа гамшгаас хамгаалах сайн дурын хэсгийн судалгаа (2020 оны 07 дугаар сарын 09-ний байдлаар)
- Хүснэгт 14. Улаанбаатар хотын дүүргүүдийн сайн дурын хэсгийн судалгаа

- Хүснэгт 15. Төв орон нутгийн хэмжээнд үйл ажиллагаа явуулж байгаа гамшгаас хамгаалах сайн дурын хэсгийн 2020, 2022 оны үзүүлэлтийн харьцуулалт
- Хүснэгт 16. Улаанбаатар хотын дүүргийн сайн дурын хэсгийн тоон үзүүлэлтийн харьцуулалт (2020, 2022 он)
- Хүснэгт 17. Сайн дурын идэвхтний оролцоо, ажлын гүйцэтгэлд нөлөөлөх хүчин зүйлийн хэмжил зүйн шинжилгээний үр дүн
- Хүснэгт 18. Далд хувьсагчийн хамаарлын шинжилгээний үр дүн
- Хүснэгт 19. Замын шинжилгээний үр дүн
- Хүснэгт 20. Гамшгаас хамгаалах сайн дурынхны оролцооны шинжилгээ Гадаад, дотоод хүчин зүйл. (давуу тал, сул тал)
- Хүснэгт 21. Дотоод хүчин зүйлсийн үнэлгээний матриц
- Хүснэгт 22. Гадаад хүчин зүйлийн үнэлгээний матриц
- Хүснэгт 23. Дотоод хүчин зүйлийн үнэлгээний матриц (2020-2032)
- Хүснэгт 24. Хамгийн их утгад харьцуулсан коэффициент
- Хүснэгт 25. Гадаад хүчин зүйлийн үнэлгээний матриц (2020-2032ОН)
- Хүснэгт 26. Хамгийн их утгад харьцуулсан коэффициент
- Хүснэгт 27. Сайн дурын байгууллагын үйл ажиллагааны тулгамдсан асуудлуудын төрөл, агуулгын байж болох хувилбар
- Хүснэгт 28. Сайн дурын сэдлийн үнэлгээний хэмжээс

Товчилсон үгийн жагсаалт

АНУ	Америкийн Нэгдсэн Улс
АНР	Analytic Hierarchy Process
АУЗН	Австралийн Улаан Загалмай Нийгэмлэг
ААНБ	Аж ахуйн нэгж байгууллага
БГБОАЖ	Байгалийн гамшгийг бууруулах олон улсын арван жил
БХЯ	Батлан хамгаалах яам
БНЧУ	Бүгд Найрамдах Чех Улс
ГБОУС	Гамшгийг бууруулах олон улсын стратеги
ГСХ	Гамшиг судлалын хүрээлэн
ГЭМ	Гамшгийн эрсдэлийн менежмент
ГЭБ	Гамшгийн эрсдэлийг бууруулах
ГХА	Гамшгаас хамгаалах алба
ГХСДҮА	Гамшгаас хамгаалах сайн дурын үйл ажиллагаа
ГХСДХ	Гамшгаас хамгаалах сайн дурын хэсэг
ДЭМБ	Дэлхийн эрүүл мэндийн байгууллага
ДХИС	Дотоод хэргийн их сургууль
ЕА	Ерөнхий ассамблей
ИНБ	Иргэний нийгмийн байгууллага
МУЗН	Монголын Улаан Загалмай Нийгэмлэг
НҮБ	Нэгдсэн Үндэсний Байгууллага
НҮБХТТ	НҮБ-ын Хөгжлийн Тусламжийн Тогтолцоо
ОБЕГ	Онцгой байдлын ерөнхий газар
ОБС	Онцгой байдлын сургууль
ОХУ	Оросын Холбооны Улс
ОУУЗ, УХСН	Олон Улсын Улаан Загалмай, Улаан Хавирган сар нийгэмлэг
СДБС	Сайн дурын байгууллагуудын сүлжээ
СДХГ	Сайн дурын хэсгийн гишүүд
УБОК	Улсын байнгын онцгой комисс
УЗХ	Улаан загалмайн хороо
ХХ	Хөгжлийн хөтөлбөр
ХБНГУ	Холбооны Бүгд Найрамдах Герман Улс
УАӨДЗ	Уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох
ТББ	Төрийн бус байгууллага

ДОХ
ХАБ
ЕНБД

Дархлалын олдмол хомсдол
Хөдөлмөр аюулгүй байдал
Ерөнхий нарийн бичгийн дарга

УДИРТГАЛ

Сэдвийг сонгох болсон үндэслэл: Сайн дурын үйл ажиллагааг хөхүүлэн дэмжих замаар хүний нөөцийг зөв зохион байгуулж бүрэн дүүрэн ашиглах нь улс орны хөгжлийг хурдасгах ач холбогдолтой болохыг дэлхийн олон орнууд олон жилийн өмнөөс ойлгож, төрийн бодлогодоо зохицуулах болжээ. Монгол орны хувьд ч сайн дурынхныг төрийн бодлогоор дэмжих үйл ажиллагааг нэгдсэн зохицуулалтаар хангах хэрэгцээ шаардлага хэдий нь бий болжээ. Иргэний нийгмийн байгууллагуудаас тавьж байгаа хүсэлт, шаардлага болон олон улсын байгууллагуудын хэрэгжүүлж байгаа үйл ажиллагаа, төсөл, хөтөлбөрүүдийн үр дүн давхар батлан харуулж байна.

Сүүлийн жилүүдэд сайн дурын үйл ажиллагааг дэмжих санал санаачилга өрнөн төсөл, хөтөлбөр олноороо хэрэгжин үр өгөөжөө өгч байна. Харин эдгээр санал, санаачилгыг төр, засгийн зүгээс дэмжин бодлогоо тодорхойлж, нэгдсэн удирдлагаар хангаж, үйл ажиллагаагаа чиглүүлэх асуудал тулгамдаад байна. Энэ нь улс орны хөгжилд иргэдийн оролцоог нэмэгдүүлэх, тэдний хувь нэмрийг үнэлэх, улмаар төрийн үйлчилгээнд иргэдийн бүтээлч оролцоо нэмэгдсэнээр иргэд хоорондоо илүү нягт хамтран ажиллах нөхцөл бүрдэх зэрэг олон давуу талтайгаас гадна сайн дурынхан гол төлөв иргэний нийгмээр дамжин үйл ажиллагаагаа явуулдаг тул иргэний нийгмийн салбарын хөгжлийг авч үзэх нь асуудлыг ул суурьтай, алсын хараатай шийдвэрлэх арга зам гэдгийг олон улсын туршлага болон нийгэмд үүсээд байгаа хэрэгцээ, шаардлага харуулж байна.

Иймд сайн дурын үйл ажиллагааны онол арга зүйн үндсийг нийгэм, эдийн засаг, хүмүүнлэгийн бүхий л салбарт цогц байдлаар авч үзэж, түүний дотроос гамшиг, онцгой байдлын үеийн сайн дурын үйл ажиллагааны онцлог мөн чанар, түүний эрх зүйн зохицуулалт, иргэд, сайн дурынхны үүрэг, оролцоог нэмэгдүүлэх боломжийг шинжлэх ухааны үндэстэй судалж, тодорхой санал, шийдэл дэвшүүлэх нь үндэсний хэмжээнд гамшгийн эрсдэлийг бууруулах, урьдчилан сэргийлэх, гамшгийн эрсдэлийн менежментэд хувь нэмэр оруулна гэж үзэж байна.

Гамшгаас хамгаалах үйл ажиллагаанд холбогдох талуудын оролцоо, түүний дотор иргэний нийгэм, олон нийт, сайн дурынхны үйл ажиллагааны агуулга, ойлголт, мэдлэг нь олон улсын байгууллагын 70-аад жилийн түүхэн хөгжлийн судалгаа, шинжилгээ, практик үйл ажиллагаатай салшгүй

холбоотой. Тухайлбал, Дэлхийн II дайны дараа 1945-1970 онд байгалийн гамшиг, зэвсэгт мөргөлдөөнд нэрвэгдэгсдэд хүнлэг, өгөөмөр сэтгэлийн үүднээс хүмүүнлэгийн тусламж үзүүлж байсан бол 1971-1989 оныг хүртэл Дэлхийн хамтын нийгэмлэгүүд, тухайлбал, Олон Улсын Улаан Загалмай, Улаан Хавирган сар хөдөлгөөн зэрэг байгууллагууд гамшгаас авран хамгаалах шинэ эрин үеийн эхлэлийг тавьж, НҮБ-ын гамшгийн тусламжийн зохицуулах алба (UNDRO) байгуулагдсан нь иргэний нийгмийн байгууллагууд буяны ажлаас татгалзаж, олон нийтийг илүү түлхүү хөгжүүлэхийг дэмжсэн шийдвэр гаргаж, 1990-2005 онд Байгалийн гамшгийн аюулыг бууруулах Олон Улсын 10 жил, Йокохамагийн үйл ажиллагааны хүрээ батлагдаж, улс үндэстэн, орон нутгийн гамшигтай тэмцэх чадавхыг бий болгох, олон нийтэд тулгуурласан гамшгийн эрсдэлийг бууруулах үйл ажиллагаа зонхилсон эрин үе эхэлж, 2005-2015 онд “Хёгогийн үйл ажиллагааны хүрээ” баримт бичиг батлагдаж, үндэсний болон Дэлхийн түвшинд гамшгийн эрсдэлийг бууруулах платформуудыг бий болгож, 129 орны 800 гаруй сайн дурын байгууллагыг нэгтгэсэн гамшгийн эрсдэлийг бууруулах сайн дурын байгууллагуудын Дэлхийн сүлжээ байгуулагдан НҮБ-ын тогтолцоонд чухал үүрэг гүйцэтгэж байна.

Гамшгийн эрсдэлийг бууруулах чиглэлээр 2015-2030 онд хэрэгжүүлэх Сендайн үйл ажиллагааны хүрээ баримт бичигт: “Ард иргэдийн амь нас, эрүүл мэнд, амьжиргаа, улс орны соёлын өв, нийгэм эдийн засгийн үнэт зүйл, экосистемийг хамгаалах, гамшгийн эрсдэлийг бууруулах стратегийн хүрээнд жендер, нас хүйс, хөгжлийн бэрхшээл, соёлын асуудлыг тусган иргэдийн сайн дурын зохион байгуулалттай үйл ажиллагааг сайжруулахад онцгой анхаарал хандуулах”-ыг чухалчилж, иргэдэд гамшгийн боловсрол олгох, гамшгийн эрсдэлийн платформд үр дүнтэй үүрэг гүйцэтгэх ТББ-ын чадавхыг бэхжүүлэх, сайн дурынхныг гамшгийн үед хариу арга хэмжээ авахад сургах, техникийн болон ханган нийлүүлэх чадавхыг бэхжүүлэх зорилтууд дэвшүүлж, сайн дурынхны хөгжлийн эрин үе эхэлсэн нь өмнөх далан жилийн туршлага, сургамжийн үр дүн юм.

Сүүлийн жилүүдэд уур амьсгалын өөрчлөлт, хүний буруутай үйл ажиллагааны улмаас дэлхий дахинаа аюулт үзэгдэл тохиолдох давтамж ойртож, цар хүрээ нь өргөжин шинэ төрлийн гамшиг, аюулт үзэгдэл нэмэгдсэнээс учруулах хор уршиг, хохирол нь ихсэж, онц хүчтэй салхи шуурга, үер цунами, газар хөдлөлт, цас, мөс, хөрсний гулсалт, нуранги, хүн,

мал, амьтны олон улсын хөл хориот болон байгалийн голомтот гоц халдварт өвчин зэрэг гамшиг, аюулт үзэгдэл нь Тив, дэлхий дамнан удаан хугацаанд үргэлжилж, Дэлхийн хамтын нийгэмлэгийн хүчээр шийдвэрлэх шаардлага ч бий боллоо.

Манай оронд гамшгаас хамгаалах сайн дурын үйл ажиллагаанд шаардлагатай үндэсний бодлого, стратеги, эрх зүйн орчин бүрдээгүй, засгийн газарт бүтэц байхгүй, олон нийтийн бүлэг нөхөрлөл, сайн дурынхны оролцооны механизм байхгүй байна. Иймд олон улсын туршлагыг судалж өөрийн орны онцлог, нөхцөл байдалд таарсан бодлогын бичиг баримтыг боловсруулж хууль дүрэмд нийцүүлэн гаргаж, мөрдөж ажиллах, энэ ажлын арга зүй, менежмент, эрх зүйн үндсийг боловсронгуй болгох нь энэ сэдвийг судлах үндэслэл болж байна.

Сэдвийн судлагдсан байдал: Сүүлийн үед сайн дурын үйл ажиллагаа нь Дэлхийн олон орны төрөл бүрийн мэргэжлийн эрдэмтэн, судлаачдын анхаарлыг зүй ёсоор татаж, судлагдахуун болтлоо хөгжиж, түүх, сэтгэл судлал, социологи, сурган хүмүүжүүлэх ухаан, эрх зүйн чиглэлүүдээр судалгааны ажлууд хийгдсэн байна.

Сайн дурын үйл ажиллагааны талаар Монголын Сайн Дурын Байгууллагуудын Сүлжээ (NMVO), НҮБ-ын Сайн дурынхан (UNV), Хилийн Чанад дахь Сайн Дурын Алба, Олон Улсын Байгууллага (VSO) зэрэг байгууллагуудын хамтран 2012 онд гүйцэтгэсэн “Монголын сайн дурын үйл ажиллагааны нөхцөл байдлын үнэлгээ ба зөвлөмж”, УИХ-ын Мэдээлэл, хяналт, шинжилгээ, үнэлгээний хэлтсийн Судалгаа, мэдээлэл, лавлагааны албаны судлаач Д.Халиун, Г.Алтан-Оч, Д.Жигвээгүнсэл нарын 2017 онд гүйцэтгэсэн “Сайн дурын үйл ажиллагааг зохицуулж буй эрх зүйн орчны харьцуулсан судалгаа” сэдэвт судалгааны ажилд сайн дурын үйл ажиллагааг зохицуулж байгаа олон улсын эрх зүйн орчны харьцуулсан судалгааг хийсэн, Б.Батбаярын 2016 онд “Орон нутгийн гамшгаас хамгаалах үйл ажиллагаанд сайн дурынхны оролцоог бий болгох арга зам” сэдэвт магистрын ажилд орон нутгийн гал унтраах сайн дурынхны оролцооны талаар, ОБЕГ-ын дэргэдэх Гамшиг судлалын үндэсний хүрээлэнгийн судлаач Ч.Мэндэлмаа, Т.Өсөхжаргал, Д.Базаррагчаа, Ш.Мөнхбаатар нарын “Сумдад байгуулагдсан сайн дурын хэсгийн үйл ажиллагааны өнөөгийн байдал, сайжруулах арга зам” сэдэвт судалгааны ажилд зарим сумдад байгуулагдсан сайн дурын үйл ажиллагааны үндэсний эрх зүйн зохицуулалтын өнөөгийн байдалд шинжилгээ хийсэн.

Дээрх бүтээл, судалгааны ажлуудад сайн дурын үйл ажиллагааны эрх зүйн орчин, нөхцөл байдал, олон нийтийн гамшгаас хамгаалах үйл ажиллагаанд сайн дурынхны оролцоог бий болгох асуудлыг шийдвэрлэх талаар хөндсөн байна. Гамшгаас хамгаалах чиглэлийн эрдэмтэн судлаачдын бүтээлээс дурдвал, П.Цэдэв¹ Гамшгийн менежментийн мэргэжилтэй боловсон хүчин бэлтгэх тогтолцоог сайжруулах арга замын талаар, Д.Сэржмядаг² гамшгаас хамгаалах менежментийн тогтолцоо, хандлагын талаар, Ш.Болдбаатар³ зудын гамшгийн талаар, П.Чимидцэрэн⁴ химийн хорт бодисын эрсдэлийн талаар, Б.Саранцэцэг⁵ гамшгийн эрсдэлийн менежментийг сайжруулах талаар, Ц.Ганчимэг⁶ гамшигт эмзэг бүлгийн эрсдэлийг бууруулах талаар тус тус судалсан байна.

Өнөөдөр гамшгаас хамгаалахад сайн дурын үйл ажиллагааны оролцооны талаар нэгэн сэдэвт бүтээлийн түвшинд хийгдсэн ажил байхгүй байгаа нь энэхүү сэдвийг сонгон судлах үндэс болж байна.

Судалгааны ажлын зорилго: Сайн дурын үйл ажиллагааны онол, арга зүй, гамшгаас хамгаалах үйл ажиллагаа, түүнд сайн дурынхны үйл ажиллагааны оролцоог олон улсын туршлагын судалгаан дээр тулгуурлан Монгол Улс дахь гамшгаас хамгаалахад сайн дурынхны үйл ажиллагааны оролцооны өнөөгийн байдалд шинжилгээ хийж, гамшгаас хамгаалах үйл ажиллагаанд сайн дурынхны оролцоог нэмэгдүүлэх арга замыг тодорхойлоход оршино.

Судалгааны ажлын зорилтууд:

Дээрх зорилгыг хэрэгжүүлэхийн тулд дараах зорилтуудыг дэвшүүлж байна. Үүнд:

¹ Цэдэв П. “Гамшгаас хамгаалах мэргэжилтэн бэлтгэх сургалтын тогтолцоог боловсронгуй болгох асуудал” Докторын диссертац. Уб., УБИС.2004.

² Сэржмядаг Д. “Гамшгаас хамгаалах менежментийн тогтолцооны өнөөгийн байдал, хөгжлийн хандлага”. Докторын диссертац. Уб., Удирдлагын академи. 2013.

³ Болдбаатар Ш. “Монгол оронд тохиолддог зудын гамшгийн эрсдэлийг бууруулах арга зам” Докторын диссертац. Уб., БХИС.2015.

⁴ Чимидцэрэн П. “Химийн хорт бодисоос үүсэх эрсдэл, түүнийг бууруулах арга зам” Докторын диссертац. Уб., БХИС.2018.

⁵ Саранцэцэг Б. “Гамшгийн эрсдэлийн менежментийг сайжруулах боломж”. Докторын диссертац. Уб., Докторын диссертац. Уб., ДХИС. 2021.

⁶ Ганчимэг Ц. “Гамшигт эмзэг бүлгийн эрсдэлийг бууруулах боломж” Докторын диссертац. Уб., ДХИС. 2021.

1 Сайн дурын үйл ажиллагааны онол, арга зүй, гамшгаас хамгаалах үйл ажиллагаа, түүнд сайн дурынхны үйл ажиллагааны оролцооны талаарх судлах;

2 Гамшгаас хамгаалахад сайн дурынхны үйл ажиллагааны оролцооны талаарх олон улсын туршлагыг судлах;

3 Монгол Улс дахь гамшгаас хамгаалах сайн дурынхны үйл ажиллагааны оролцооны өнөөгийн байдалд шинжилгээ хийх;

4 Гамшгаас хамгаалахад сайн дурынхны үйл ажиллагааны оролцоог нэмэгдүүлэх арга замыг тодорхойлох;

Судалгааны объект: Сайн дурынхны үйл ажиллагаа

Судлах зүйл: Гамшгаас хамгаалахад сайн дурынхны үйл ажиллагааны оролцоо

Судалгааны ажлын шинэлэг тал: Гамшгаас хамгаалах үйл ажиллагаанд сайн дурынхны оролцоог нэмэгдүүлэх явдал чухлаар тавигдаж байгаа өнөөгийн нөхцөлд улс, орнуудын сайн дурын үйл ажиллагааны туршлага, сургамж, ололттой талыг судлан, гамшгаас хамгаалах үйл ажиллагаанд **сайн дурынхны үүрэг оролцоо, хамтын ажиллагаа, үйл ажиллагааны чиглэлийг үндэсний хэмжээнд судлан, тодорхой болгож**, цаашдын төлөв, хандлагыг тодорхойлсон нь энэхүү судалгааны ажлын шинэлэг тал болно.

Судалгааны арга, арга зүй: Судалгааны ажлыг гүйцэтгэхдээ байгаль, нийгмийн юмс, үзэгдлийг танин мэдэх диалектик хандлагад тулгуурлан нийгмийн шинжлэх ухааны судалгааны ерөнхий ба тусгай арга болох ажиглалт хийх, түүхчлэх, харьцуулах, задлан шинжлэх, нэгтгэн дүгнэх (анализ-синтез), индукци-дедукци, зэрэг ерөнхий аргуудын зэрэгцээ агуулгын шинжилгээ хийх, хүчин зүйлийн нөлөөллийг судлахдаа чанарын Smart PLS 3.0, стратеги үр дүнгийн үзүүлэлтийг SWOT шинжилгээний аргуудыг өргөн хэрэглэсэн. Smart PLS чанарын судалгааны арга нь хэсэгчилсэн хамгийн бага квадрат (PLS) замыг загварчлах аргыг ашиглан хэлбэлзэлд суурилсан бүтцийн тэгшитгэлийн загварчлалыг (SEM) график хэрэглэгчийг холбох программ хангамж юм. PLS-SEM алгоритм ашиглан далд хувьсагч бүхий замын загварыг тооцоолохоос гадна программ хангамж нь стандарт үр дүнгийн үнэлгээний шалгуурыг (жишээлбэл, хэмжих загвар, бүтцийн загвар, тохирох чанар) тооцдог.

Энэ нь нэмэлт статистик шинжилгээг (жишээлбэл баталгаат дүн шинжилгээ, ач холбогдол- гүйцэтгэлийн шинжилгээ, сигментчилэл, олон бүлэг) гаргадаг. PLS замын загвар нь бидний судалгааны үр дүн, чанарыг үнэлдэг ба үнэлгээнд ашигладаг үндсэн шалгуурууд, тэдгээрийн системчилсэн хэрэглээг нэгтгэн дүгнэх боломжтой.

Салбарын тулгамдсан асуудал, цаашид хүрэхээр зорьж буй зорилго, хэрэгжүүлэх стратеги, үр дүнгийн үзүүлэлтийг SWOT шинжилгээг ашиглан тодорхойлдог. Салбар, дэд салбарын үйл ажиллагаанд нөлөөлөх хамгийн чухал дотоод хүчин зүйлсийн давуу тал (Strength) ба сул тал (Weakness), гадаад хүчин зүйлсийн боломж (Opportunities) ба аюул (Threats) жагсаалтыг матрицаар нэгтгэн гаргана. SWOT шинжилгээний уламжлалт аргаар гадаад, дотоод хүчин зүйлсийн нөлөөллийн үзүүлэлтүүдийг тоон бус утгаар ерөнхийд нь тодорхойлдог тул учир дутагдалтай юм. Иймд SWOT шинжилгээний илүү сайжирсан хэлбэр болох шатлан судлах арга буюу АНР аргыг стратеги төлөвлөлтөд хэрэглэх нь илүү тохиромжтой. (АНР (Analytic Hierarchy Process) шинжилгээ).

Хөгжилд нөлөөлөх аливаа асуудлууд хоорондоо уялдаатай гадаад, дотоод олон хүчин зүйлээс хамаарна.Тэдгээр хүчин зүйлс нь тоон болон шинж тэмдгээр илэрхийлэгдэх бөгөөд хэмжих нэгж нь харилцан адилгүй байна. Эдгээрийг нэг хэмжүүр буюу тухайлбал, тоон хэмжүүрт шилжүүлж, хооронд нь жиших боломжтой болгох шаардлагатай. Тоогоор үл илэрхийлэгдэх шинжтэй үзүүлэлтүүдийг тоон утгад шилжүүлж, тэдгээрийг ач холбогдлоор нь эрэмбэлэхэд энэхүү аргыг хэрэглэнэ. АНР шинжилгээ нь бүтэц, удирдлага, зохион байгуулалт, технологийн хувьд хоорондоо нарийн уялдаатай процессыг тэдгээрийн уялдааг нь харгалзан хүчин зүйл тус бүрийн эцсийн үр дүнд үзүүлэх нөлөөг тоон үзүүлэлтээр зангидан илэрхийлдэг арга юм.

Судалгааны хамрах хүрээ, хязгаарлалт. Сайн дурын үйл ажиллагааны оролцоог нийгмийн хүрээг бүхэлд нь хамарсан цогц системийн ойлголтоос гамшгаас хамгаалахад сайн дурынхны хүрээнд өргөн утгаар авч үзнэ.

Судалгааны ажлын үр дүнгээр дараах гурван асуудлыг хамгаалахаар дэвшүүлж байна. Үүнд:

1 Сайн дурын үйл ажиллагааны онол, арга зүй, гамшгаас хамгаалахад сайн дурынхны оролцоог олон улсын туршлага дээр тулгуурлан судалсан үр дүн.

2 Монгол Улс дахь гамшгаас хамгаалахад сайн дурынхны үйл ажиллагааны өнөөгийн байдлын шинжилгээний үр дүн.

3 Гамшгаас хамгаалахад сайн дурынхны үйл ажиллагааны оролцоог нэмэгдүүлэх арга зам.

Судалгааны ажлын онолын ач холбогдол. Сайн дурын үйл ажиллагааны онол, арга зүй, гамшгаас хамгаалахад сайн дурынхны оролцоог олон улсын туршлага, сургамж дээр тулгуурлан харьцуулан судалж, гамшгаас хамгаалахад сайн дурынхны үйл ажиллагааны оролцооны өнөөгийн байдалд шинжилгээ хийж, түүнийг нэмэгдүүлэх арга замыг тодорхойлсон нь диссертацийн ажлын онолын ач холбогдол оршино.

Судалгааны ажлын практик ач холбогдол: Гамшгаас хамгаалах менежментийн мөн чанар, гамшгаас хамгаалахад сайн дурынхны үйл ажиллагааны оролцоог онол, практикийг хослуулан судалж, хууль тогтоомжид сайн дурынхны үйл ажиллагааны оролцооны талаар санал тусгахаар тодорхойлсон нь практик ач холбогдолтой.

Судалгааны үр дүнг хэлэлцүүлж, нийтэд танилцуулсан байдал: Энэ судалгааг ДХИС-ийн Онцгой байдлын сургуулийн Гамшгаас хамгаалах тэнхим, Гамшиг судлалын профессорын судалгааны багт гүйцэтгэсэн бөгөөд тус тэнхим, профессорын судалгааны багийн хурлаар удаа дараа хэлэлцүүлж, судалгааны үр дүнг багш, судлаач, практик байгууллагын ажилтнуудад танилцуулсны сацуу Олон Улсын болон үндэсний эрдэм шинжилгээний хуралд илтгэл, өгүүллээр хүргүүлсэн болно.

Судалгааны ажлын үр дүнг дотоод, гадаадын эрх салбарын чиглэлийн сэтгүүлд хэвлүүлсэн бүтээл.

1 Г.Батгэрэл, ОБЕГ-ын дэргэдэх Гамшиг судлалын хүрээлэн. “Судалгааны ажлын эмхэтгэл - 2020” “Гамшгаас хамгаалах бодлогод сайн дурынхны оролцоог хангах нь” сэдэвт өгүүлэл нийтлүүлсэн.

2 Г.Батгэрэл, ДХИС. “Хууль сахиулахуй” онол, арга зүйн сэтгүүл. “Гамшгаас хамгаалах ажиллагаанд сайн дурынхны оролцоо, ажлын гүйцэтгэлд нөлөөлөх хүчин зүйлийн шинжилгээ” 2022.

3 Г.Батгэрэл, Гамшиг судлалын хүрээлэн. “Гамшгаас хамгаалах ажиллагаанд сайн дурынхны оролцоо, ажлын гүйцэтгэлд нөлөөлөх хүчин зүйлийн шинжилгээ” 2022.

4 Г.Батгэрэл, Олон Улсын инновацын шинжлэх ухааны судалгаа тойм сэтгүүлд “Гамшгаас хамгаалах менежментэд сайн дурынхны оролцооны нөлөөллийн дүн шинжилгээ: Монголын жишээ” сэдэвт эрдэм шинжилгээний өгүүлэл нийтлүүлсэн. 2022.,

5 Г.Батгэрэл, ОБЕГ-ын дэргэдэх Гамшиг судлалын хүрээлэн. Гамшиг судлал инновац сэтгүүлд “Гамшгаас хамгаалах ажиллагаанд сайн дурынхны оролцоо, ажлын гүйцэтгэлд нөлөөлөх хүчин зүйлийн шинжилгээ” сэдэвт судалгааны ажлын илтгэл нийтлүүлсэн. 2023,

6 Г.Батгэрэл, ДХИС-ийн ОБС-аас зохион байгуулсан “Гамшгаас хамгаалах сайн дурын үйл ажиллагааны олон улсын туршлага” сэдэвт илтгэл хэлэлцүүлсэн.

7 Г.Батгэрэл,” ДХИС, МУЗН-ээс зохион байгуулсан “Эрсдэлд суурилсан тогтвортой хөгжил” сэдэвт олон улсын эрдэм шинжилгээний хуралд “Гамшгаас хамгаалах үйл ажиллагааны сайн дурынхны оролцооны зарим асуудал” сэдэвт илтгэл нийтлүүлсэн. 2023.

Судалгааны ажлын бүтэц: Судалгааны ажил нь Удиртгал, “Сайн дурын үйл ажиллагааны онол арга зүйн үндэс”, Монгол дахь сайн дурын үйл ажиллагааны өнөөгийн байдалд хийсэн шинжилгээ”, “Сайн дурын үйл ажиллагааны оролцоог нэмэгдүүлэх арга зам”, гэсэн гурван бүлэг, бүлгийн дүгнэлтүүд, эшлэл авсан, эх сурвалжийн жагсаалт, хавсралт гэсэн бүтэцтэй ... хуудас материалаас бүрдэж байна.

НЭГДҮГЭЭР БҮЛЭГ. САЙН ДУРЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨН ЧАНАР, ОЛОН УЛСЫН ТУРШЛАГА

§1.1. Сайн дурын үйл ажиллагааны мөн чанар

Сайн дурын үйл ажиллагааны мөн чанарыг сайн дурын үйл ажиллагааны үндсэн ойлголтууд, сайн дурын үйл ажиллагааны чиглэл, хэлбэр, баримтлах зарчим, гамшгаас хамгаалах сайн дурын ажиллагаа зэргийг онол арга зүйн хүрээнд Олон улсын хүмүүнлэгийн байгууллага, Монгол хэлний тайлбар толь, эрдэмтэн судлаачдын тайлбар тодорхойлолтуудыг авч үзэн харьцуулалт хийж, сайн дурын үйл ажиллагаа, сайн дурын хөдөлгөөн, сайн дурын байгууллага, сайн дурын ажилтан, сайн дурынхан зэрэг ойлголтуудын мөн чанарыг тодруулан авч үзлээ.

Англи хэлэнд “*Voluntary*” гэдэг нэр томьёо нь зарим үед албадлага, зориуд гэсэн санааг илэрхийлдэг бол “*Volunteer*” гэдэг нэр томьёо нь сайн дураараа гэсэн утгыг илтгэдэг байна. “**VOLUNTARISM**” гэдэг нэр томьёо нь аливаа нэг зүйлийг сайн дураараа хийж гүйцэтгэхийг илэрхийлсэн утгатай бөгөөд тухайлбал, АНУ-д шашныг сайн дураараа шүтэн бишрэх явдал нь Voluntarism-д тооцогддог байна. Харин “**VOLUNTEERISM**” гэдэг нэр томьёо нь “*velle*” буюу хүсэх гэсэн латин үгнээс гаралтай бөгөөд биеэр хийж гүйцэтгэх үйл ажиллагаанд үндэслэсэн, сайн дурын үйлсэд хүчин зүтгэх, сайн дурын ажилтнаар ажиллах гэсэн утгыг илэрхийлдэг байна. Түүнчлэн “volunteerism” ба “voluntarism” гэсэн үгийн утгын нарийн ялгааг дараах байдлаар тайлбарласан байна. Үүнд: volunteerism нь нийгмийн эсвэл боловсролын салбарын сайн дурын ажиллагаанд түшиглэдэг бол voluntarism нь байгууллыг дэмжих эсвэл тавьсан зорилгодоо хүрэх сайн дурын ажиллагаанд түшиглэдэг гэжээ.⁷

Сайн дурын үйл ажиллагаа нь нийгэмд байнгын хэрэгцээтэй байдаг бөгөөд төр нийгмийн салбар, салаа мөчир бүрд тавигдаж буй шаардлагыг өөрийн зохицуулалт, үйлчилгээгээр бүрэн хангах бололцоо байхгүй учир иргэний нийгмийн байгууллага, олон нийтийн байгууллага тэрхүү орон зайг нөхөж гүйцээдэг. Түүнчлэн сайн дурын хөдөлмөр эрхэлж буй ажилтан, хувь хүн нь нийгэмд өөрийн хувь нэмрийг оруулж байгаа, олон нийтийн дунд ажиллах чадвартай, хэрэгцээтэй субъект гэх зэргээр өөртөө сэтгэл

⁷ <https://wikidiff.com/voluntarism/volunteerism>

хангалуун байдаг нь сайн дурын үйл ажиллагаа нийгэмд оршин тогтнох үндэс болдог байна.⁸

Сайн дурын үйл ажиллагаа нь соёл иргэншилт нийгмийн хөгжлийн салшгүй нэгэн хэсэг болж хөгжсөөр иржээ. Өргөн утгаар нь тодорхойлбол улс орон, олон нийт болон нийгэм гэсэн томоохон хүрээг хамран, тэдний сайн сайхны төлөө ашиг орлого, нэр төр, албан тушаал үл хөөцөлдөн, хувь хүмүүсийн зүгээс нэмэр хандиваа оруулж буй үйл ажиллагаа бөгөөд аливаа хүндрэл бэрхшээл тохиолдсон үед бие биедээ тус дэм үзүүлэх, хүндрэлээс гарах арга замыг олоход нь хүчин зүтгэх, ядуурлыг бууруулах, зөрчилдөөнийг шийдвэрлэхэд нь яс үндэс, ёс заншил, шашин шүтлэг харгалзахгүйгээр харилцан туслалцах явдал юм.

Сайн дурын үйл ажиллагаа. Сайн дурын үйл ажиллагаа гэдэг ойлголтын талаар цөөнгүй тодорхойлолтууд байна. Эдгээрээс бидний цаашид онол, арга зүйн үндэс болгон ашиглах хамгийн нийтлэг ойлголтуудыг авч үзлээ.

Сайн дурын үйл ажиллагааны талаарх олон улсын байгууллагаас өгсөн тодорхойлолтыг үндэс болговол “Сайн дурын үйл ажиллагаа” нь хүн хүнээ туслан дэмжиж байгаа сайхан сэтгэлийн ажил юм. Сэтгэл зүрхний угаас туслалцаа үзүүлж байгаа учраас шан харамж авдаггүй ажил юм” гэж НҮБ-ын Сайн дурынхны сүлжээ байгууллагын хөтөлбөрт тодорхойлжээ.

Судлаач R.A Снаан:⁹ “Сайн дурын үйл ажиллагаа”- г ямар ч шахалт дарамтгүй, өөрийн чөлөөт сонголтоор тодорхой бүтэцтэй, тодорхой зорилтот бүлэгтэй, албан ёсны байгууллагын шугамаар хийж байгаа үйл ажиллагаа гэж тодорхойлсон байна.

“Сайн дурын үйл ажиллагаа” гэдэг нь урт богино хугацаанд, ашгийн болон хувийн ашиг сонирхлын үүднээс бус, сайн дураараа хийсэн гэрээний үндсэн дээр явуулж буй үйл ажиллагаа бөгөөд ажилгүй, нийгмийн эмзэг давхаргын, асаргаанд байдаг хүмүүс, өндөр настан, үндэсний цөөнх, цагаач иргэд, хорих ял эдлээд суллагдагсад, хар тамхинд донтогсод, гэр бүлийн хүчирхийллийн хохирогчид болон хүүхэд, залуучууд, гэр бүлд чөлөөт цагаараа тусалж буй сайн дурын ажилтны үйл ажиллагаа, гамшгийн үеэр тусламж үзүүлэх, хүрээлэн буй орчныг хамгаалах, соёлын хандивын

⁸ Хууль зүйн үндэсний хүрээлэн, Нийтэд тустай ажиллагаа, сайн дурын ажиллагааны үр нөлөө, эрх зүйн зохицуулалт судалгааны ажлын тайлан, УБ хот, 2013 он, 10 дахь тал.

⁹ R.A. Snaan, F.Handy, M.Wadsworth, Defining who is a volunteer: Conceptual and empirical considerations, Nonprofit Volunt.Sect.Q.25 (1996)364–38

ажиллагааг бэлтгэхэд дэмжлэг үзүүлэх үйл ажиллагаа байна¹⁰ гэж Монголын сайн дурын үйл ажиллагааны нөхцөл байдлын үнэлгээ, зөвлөмжид тодорхойлжээ.

“Сайн дурын үйл ажиллагаа”-д нэгдэж буй хүн нь ямарваа эд материал болон ашгийн төлөө бус, нийгэм, эдийн засаг, улс төрийн дарамт шахалтгүйгээр өөрийн хүсэл эрмэлзлэлийн дагуу ажиллах ёстой”¹¹.

Сайн дурын үйл ажиллагаа гэдэг нь бусдын сайн сайхны төлөө хариу нэхэхгүй “үнэ хөлс”-гүй буюу зах зээлийн үнээс доогуур хөлсөөр ажиллах тухай ойлголт юм. Сайн үйл бүтээх хүсэлтэй иргэд нэмэгдэхийн хирээр улс орон хүмүүнлэг энэрэнгүй болдог.

Зарим бүтээлүүдэд сайн дурын үйл ажиллагааг тодорхойлсон үндсэн ойлголтуудыг хэлбэрээр ангилан системчилснийг (Хүснэгт 1)-д үзүүлээ.

Автор, эх сурвалж	Тодорхойлолт
Тодорхойлолт 1. Нийгмийн ач холбогдол бүхий үйл ажиллагаа, иргэний идэвхтэй хэлбэр.	
О.В. Решетников	Нийгмийн үйлчилгээний үнэ төлбөргүй хэлбэр. Орон нутаг, үндэсний болон олон улсын түвшинд нийгмийн ач холбогдолтой үйлчилгээг үзүүлэхэд чиглэсэн иргэдийн хүсэл эрмэлзэл, энэ үйл ажиллагааг явуулж буй сайн дурын иргэдийн хувийн өсөлт, хөгжилд хувь нэмэр оруулах.
Н.В. Тарасов	Нийгэмд хэрэгтэй үйл хэрэгт оролцох иргэдийн оролцооны хэлбэр, хамтын харилцааны арга зам, нийгмийн тулгамдсан асуудлыг шийдвэрлэх үр дүнтэй механизм.
Э. Алеччи	Нийгмийн эв нэгдлийн зарчмыг хэрэгжүүлэх хамгийн шууд арга. Хувь хүнийг ашиг сонирхлын үүднээс эсвэл эрх мэдлийн захиалгаар бус, харин хувь хүний мөн чанарт агуулагдах нийгмийн хэв, шинжийг чөлөөтэй илэрхийлж гаргаж ирдгээрээ онцлогтой.
ОХУ-ын залуучуудын асуудал хариуцсан агентлаг.	Нийгмийн асуудлыг бодитой шийдвэрлэхэд чиглэсэн залуучуудын сайн дурын практик үйл ажиллагаа нь албадлагагүйгээр хийгддэг бөгөөд тэдгээрийг нийгэмшүүлэхэд нөлөөлдөг ¹² .
Тодорхойлолт 2. Сайн дурын үндсэн дээр хийж байгаа нийгэмд тустай хөдөлмөрийн хэлбэр.	
А.В. Шарыпин	Найз, нөхөр, гэр бүлийн харилцаанаас давж, бусдын тусын тулд хийж буй аминч бус, сайн дурын үйл ажиллагаа.

¹⁰ “Монголын сайн дурын үйл ажиллагааны нөхцөл байдлын үнэлгээ ба зөвлөмж” Уб., 2012. 9 дэх тал.

¹¹ ОУУЗ, УХСН-үүдийн Холбоо, Онцгой байдлын үеийн сайн дурын ажиллагаа, Онцгой байдлын үед сайн дурын идэвхтнийг удирдан чиглүүлэх гарын авлага. Уб., 2008. 12 дахь тал.

¹² Сборник методических материалов в сфере государственной молодежной политики. Росмолодежь. Федеральное агентство по делам молодежи. М., 2009. –С. 8.

Зөвлөмж болон НҮБ-ын тогтоолууд (A/RES/57/106, A/RES/56/38)	Нийгмийн тусын тулд харилцан туслалцах, өөртөө туслах уламжлалт хэлбэр, албан ёсны үйлчилгээ үзүүлэх болон бусад сайн дурынхны оролцооны өргөн хүрээний үйл ажиллагаа.
Толь бичиг С.И.Ожегова	Нийгмийн үнэ төлбөргүй тусламж, үйлчилгээ үзүүлэх, хөгжлийн бэрхшээлтэй, өвчтэй, өндөр настан, түүнчлэн амьдралын хүнд нөхцөлд байгаа хүн ам, хувь хүн, нийгмийн бүлгүүдийг сайн дурын ивээлд хамруулах үүргээ сайн дураар биелүүлэх.
Е.Л. Шекова	Нийгмийн, буяны болон нийгэмд ашигтай бусад зорилгыг хэрэгжүүлэхэд материаллаг бус урамшууллын механизм дээр суурилсан хөдөлмөрийн харилцааны тогтолцоо ¹³
Олон улсын Хөдөлмөрийн байгууллага (ОУХБ)	Цалингүй нэмэлт ажил; Тэдгээр. байгууллагаар дамжуулан бусдын ашиг тусын тулд хувь хүмүүсийн ямар ч цалингүй зарцуулсан цаг.
Г.Г. Бородаева, И.А. Руднева	Мөнгөн урамшуулал хүлээхгүйгээр хүмүүсийн сайн сайхны төлөө сайн дураараа хийгддэг үйл ажиллагаа.
Тодорхойлолт 3. Зарцуулагдах цаг, хугацааны хэлбэр.	
Ю.В. Лукичева	Чөлөөт цагаа өөртөө болон бусдын сайн сайхны төлөө зарцуулах боломж. ¹⁴
Р.Стеббинс	Уламжлалт амралтаас ялгарах хэд хэдэн шинж чанар бүхий өвөрмөц амралт. ¹⁵

Хүснэгт 1., Сайн дурын үйл ажиллагааны тодорхойлолтын ангилал

Хүснэгт 1-ийн судалгаанаас *эхний тохиолдолд* сайн дурын үйл ажиллагаа нь иргэдийн нийгмийн идэвх гэсэн ойлголтоор тодорхойлогдож буйг харж болно. Нийгмийн санаачилга гэдэг нь нийгмийн шинэ бодит байдлыг бий болгоход чиглэсэн хувь хүн, нийгэм, төрийн ашиг сонирхол, ашиг сонирхлын төлөө хүмүүсийн сайн дурын үйл ажиллагааны нэг хэлбэр юм.¹⁶ Сайн дурын үйл ажиллагаа нь төрийн гүйцэтгэж чадаагүй нийгмийн ээдрээтэй асуудлуудыг шийдвэрлэж чаддаг хүч юм.¹⁷

¹³ Бунеева Р. И. Принципы управления, определяющие развитие некоммерческих организаций // Вестник Челябинского государственного университета. –2011.–№6 (221). Экономика. Вып. 31. –С.97–99.

¹⁴Лукичева Ю. В. Формирование активной гражданской позиции молодежи через участие в волонтерском движении / Ю. В. Лукичева // Молодежь XXI века: потенциал, тенденции и перспективы : материалы Всерос. науч.-практ. конф. с международ. участием, г. Екатеринбург, 19–20 ноября 2013 г. : в 2-х т. / отв. ред. Л. К. Тропина, Т. Н. Карфилова. —Екатеринбург : Изд-во Урал. ун-та, 2014. –Т. 2. С. 30-31.

¹⁵Стеббинс Р. А. Свободное время: к оптимальному стилю досуга // Социол. исслед. – 2006.–№7.–С. 64-72.

¹⁶Яковлев П.И. Формирование гражданского самосознания молодежи в условиях досуговой деятельности добровольческих объединений // Вестник ТГУ.–2011. –№8 (100).–С. 158-162.

¹⁷ Спирина М.О. Организационная специфика волонтерского движения: сравнение опыта России и Франции // Экономическая социология. Т. 16. –2015. –№2. –С. 24-54.

Хоёр дахь тохиолдолд, дүн шинжилгээ хийсэн үзэгдлийг ашиг хүртэгчдийн ашиг сонирхлын үүднээс үнэ төлбөргүй хөдөлмөр гэж ойлгодог. Сайн дурын ажилд зориулсан цагийг дүрмээр бол хүний хувийн цаг, өөрөөр хэлбэл чөлөөт цагаа өнгөрөөх нөөцөөс хуваарилдаг ч зарим зохиогчид энэ төрлийн үйл ажиллагааг хөдөлмөрийн тусгай хэлбэр гэж үздэг.¹⁸ Нэмж дурдахад, хэрэв сайн дурын ажилтнуудаас нийгмийн харилцан үйлчлэлийг хүлээж байгаа бол тэд тухайн үйл ажиллагааны сэтгэл хөдлөлийн уур амьсгалыг бий болгосноороо сайн дурын ажлыг сэтгэл хөдлөлийн хөдөлмөр гэж тодорхойлж болно¹⁹. Энэ утгаараа сайн дурын ажил нь орчин үеийн ойлголтоор, бусдад эмх замбараагүй тусламж үзүүлэх биш, харин материаллаг бус урамшууллын механизмыг ашигладаг хөдөлмөрийн харилцааны тусгай тогтолцоо юм.²⁰

Сайн дурын үйл ажиллагааны субъект нь бие даасан сайн дурынхан эсвэл сайн дурын баг байдаг. Харин **сайн дурын үйл ажиллагааны объект** нь тусламж хэрэгтэй байгаа хүн ам, ашгийн бус байгууллага, олон нийтийн арга хэмжээ, арга хэмжээг зохион байгуулагчид, түүнчлэн нийгмийн асуудал, байгаль орчны эрсдэл байж болно.

Сайн дурын үйл ажиллагаа, сайн дураараа хөдөлмөрлөх хүсэл зориг нь тухайн нийгмийн түүхэн хөгжил, улс төрийн нөхцөл байдал, шашин, соёлтой байнга холбоотой байдаг. Иймд сайн дурынхныг тодорхойлох ерөнхий гурван зарчмын шаардлагыг АНУ-ын Балтимори хот дахь Жон Хопкинскийн нэрэмжит их сургуулийн гаргасан тодорхойлолтод үндэслэжээ. Үүнд:

- Цалин хөлсгүйгээр (шаардлагатай зардлыг нөхөн төлж болно).
- Өөрийн хүсэл зоригоор ажиллах.
- Бусдын болон нийтийн ашгийн төлөө байх гэсэн үндсэн 3 шаардлага багтана.

Нэгдсэн Үндэстний Байгууллагаас сайн дурын үйл ажиллагааг дараах үндсэн шинжээр тодорхойлдог. Үүнд:

- Ашиг орлого, шан харамжийн төлөө зорилго агуулаагүй.

¹⁸Колосова Р.П., Красновид А.В. Занятость волонтеров: возможности и ограничения. – М.: Экон. ф-т МГУ имени М.В. Ломоносова; ТЕИС, 2010.–С. 14.

¹⁹Вандышева Л.В. Эмоциональный труд волонтеров: анализ опыта реализации // Фундаментальные исследования. – 2014. – No 9.–С. 838-842.

²⁰Шекова, Е. Л. Экономика и менеджмент некоммерческих организаций: учебное пособие. –СПб., 2003. – С. 147-149.

- Хувь хүнийх нь өөрийн сэтгэл зүрх, хүсэл сонирхолд тулгуурласан чөлөөт сонголт
- Бусдад буюу нийгэмд ач тустай байх зэрэг юм.

Иймд сайн дурын үйл ажиллагааны шинж чанарыг Монгол хэлний эх тайлбар толь ба НҮБ болон ОУУЗ, УХСН-үүдийн холбоо, зарим эрдэмтэн, судлаачдын тайлбарласнаар харьцуулан шинжилгээ хийж хүснэгт 2 -д харууллаа.

Дүд	Байгууллага, толь бичиг, судлаачид	Сайн дурын үйл ажиллагааны шинж чанар
1.	Нэгдсэн Үндэстний Байгууллага	- мөнгөн орлогогүй - өөрийн хүсэлтээр - олон нийтийн ашиг тусын тулд
2.	Олон Улсын Улаан Загалмай, Улаан хавирган сар Нийгэмлэгийн Холбоо	- ашгийн төлөө бус - өөрийн хүсэл эрмэлзлэлийн дагуу - бусдын сайн, сайхны төлөө
3.	Монгол хэлний эх тайлбар толь бичигт	- цалин хөлсгүй - өөрийн санаачилгаар
4.	Судлаач J.Wilson ²¹	- аливаа хүн, байгууллагад туслах зорилгоор - өөрийн цагийн үнэ төлбөргүйгээр зориулж буй үйл ажиллагаа
5.	Судлаач R.A Cnaan ²²	- өөрийн чөлөөт сонголтоор - цалин авдаггүй - тодорхой бүтэцтэй - тодорхой зорилтот бүлэгтэй - ямарваа шахалт албадлагагүйгээр - сайн дурын үндсэн дээр - албан ёсны байгууллагын шугамаар - хувь хүний сонирхол байхгүй
6.	Судлаач A Penner ²³	- урт хугацаанд явагддаг, тодорхой төлөвлөлттэй ажил
7.	M.Snyder, A.M Omoto ²⁴	- гамшиг осол болсон тохиолдолд урьдчилан төлөвлөх боломжгүй тул ихэнхдээ түргэн шуурхай, шууд газар дээр нь үзүүлэх үйл ажиллагаа

Хүснэгт 2., Сайн дурын үйл ажиллагааны шинж чанарын харьцуулалт.

²¹ J. Wilson, Volunteering, Annu. Rev. Sociol. 26(1) (2000) 215–240.

²² R.A. Cnaan, F.Handy, M.Wadsworth, Defining who is a volunteer: Conceptual and empirical considerations, Nonprofit Volunt.Sect.Q.25 (1996)364–383

²³ L.A.Penner, Volunteerism and social problems: making things better or worse, J. Soc.Issues 60(3)(2004)645–666.

²⁴ M. Snyder, A.M.Omoto, Volunteerism: social issues perspectives and social policy implications, Soc.IssuesPolicyRev. 2(1)(2008)1–36.

Хүснэгт 2-с сайн дурын үйл ажиллагааны шинж чанарыг харьцуулан үзэхэд сайн дурын үйл ажиллагаа нь:

- цалин авдаггүй,
- өөрийн санаачилга, чөлөөт сонголт, сайн дурын үндсэн дээр
- олон нийтийн ашиг, тусын тулд,
- ямарваа албадлага, шахалтгүйгээр,
- хувь хүний сонирхол байхгүй зэрэг шинж чанарыг агуулж байна.

Мөн хугацааны хувьд харилцан адилгүй зэрэг шинж чанартай байна.

Судалгаанаас үзэхэд сайн дурын ажил гэж яг юуг хэлэх, сайн дурынхан гэж чухам хэн болохыг тодорхойлсон тодорхойлолтууд одоо ч нэг мөр шийдэгдээгүй байдаг байна..

Хэл, соёл, зан заншлын ялгаанаас үүдэн сайн дурын ажлыг улс орнуудад өөр, өөрөөр хүлээн авах тохиолдол байдаг. Тухайлбал барууны соёлын хувьд сайн дурын ажилд тооцогддог ажлууд нь Маори (Шинэ Зеландын уугуул иргэд) омгийнхны хувьд уламжлалын дагуу зайлшгүй хийх ёстой иргэний үүрэг гэж зөвшөөрдөг. Иймд зарим судлаачид сайн дурын ажлын тодорхойлолтод тухайн соёлын ялгааг тусгасан байх ёстой гэж үздэг^{25, 26}.

Сайн дурын ажлын тодорхойлолтод чухал байдаг нэг үзүүлэлт бол цаг хугацааны ойлголт юм. Сайн дурын ажил гэдэг нь хүмүүсийн “өөрийн цаг хугацааг зориулж, зарцуулдаг”²⁷ үйл ажиллагаа гэж тодорхойлдог бол харин урт хугацаанд хийгддэг ажлын хувьд хязгаарлагдмал болж ирдэг. Пеннерийн²⁸ тодорхойлсноор “сайн дурын ажил бол урт хугацаанд явагддаг, тодорхой төлөвлөлттэй хийгддэг ажил юм. Иймд түр зуурын туслагч (bystander intervention) нараас сайн дурын ажлыг салгаж үзэх нь зүйтэй” гэж үзсэн байдаг.²⁹

²⁵ Common wealth of Australia, National strategy for disaster resilience: building our nation’s resilience to disasters.

²⁶ J.Wilson, Volunteerism research: a essay, Nonprofit Volunt. Sect. Q.41(2) (2012) 176-212.

²⁷ J.Wilson, M.Musick, Who cares? Toward an integrated theory of volunteer work, Am. Sociol. Rev.62(5) (1997) 694-713.

²⁸ L.A.Penner, Volunteerism and social problems: making things better or worse, J. Soc.Issues 60(3)(2004)645–666.

²⁹ L.A.Penner, Volunteerism and social problems: making things better or worse, J.Soc.Issues 60(3)(2004)645-666.

Монгол хэлний тайлбар толь бичигт “сайн дурын” гэж өөрийн хүслийн дагуу, сайн дураар ажиллагсад³⁰, Монгол хэлний товч тайлбар толь буюу “Цэвэлийн ногоон толь”-д сайн дураар элсэгчид, дур зоригоороо³¹, гэж хэл зүйн үүднээс тодорхойлсон байдаг.

Монгол Улсын Үндсэн хууль шинжлэх ухааны тайлбарт “сайн дурын” гэж хүчээр, дээрээс гэдгийн эсрэг утгаар хэрэглэх... хэнийг ч аливаа эвлэл холбоонд албадан оруулах ёсгүй³², Монголын эрх зүйн эх толь бичигт “сайн дурынхан” гэж дайтаж буй аль нэг талын армид сайн дураараа элсэн орсон этгээд гэж эрх зүйн үүднээс тайлбарласан.³³

Дээрх тодорхойлолтуудыг нэгтгэн дүгнэвэл сайн дурын ажил гэдэг нь хувь хүн буюу хэсэг бүлэг, баг хамт олноос сайн дураараа ямар нэгэн байгууллагад зуучлагчаар дамжуулан эсвэл өөрсдөө шууд харьцаа холбоо тогтоож, тодорхой ажлын байранд зорилго, чиглэлтэйгээр, заагдсан цаг хугацааны дотор биеийн ба оюуны хүч хөдөлмөрөө зориулахыг хэлнэ. Иймд сайн дурын ажилд дараах нийтлэг шинжүүд байна. Үүнд: *нэгд*, цаг хугацаа янз бүр, цаг агаар, газар нутгаас хамааралгүй, *хоёрт*, эдийн засаг, нийгмийн бүх салбарыг хамардаг, *гуравт*, цалин хөлс, шан харамж чухалчилдаггүй, *дөрөвт*, нас хүйс, үндэс угсаа, хэл шашин боловсрол ялгаварладаггүй, *тавд*, ганцаарчилсан ба хэсэг бүлгээр хийгддэгээрээ онцлогтой.

Сайн дурын үйл ажиллагааны үндсэн чиглэл, хэлбэр. Сайн дурын үйл ажиллагаа нь тухайн хүнийг нийгмийн ямар үүрэг оролцоо сэдээж байгаагаас шалтгаалан шашны, оюутны, байгууллагын, гэр бүлийн, дотоод, гадаад сайн дурын аялал жуулчлал гэсэн чиглэлтэй байдаг.³⁴ Сайн дурын ажил нь сэдэвчилсэн хэсгүүдээс бүрдэх ба эдгээрээс хамгийн түгээмэл нь дараах байдалтай байна: нийгэмд чиглэсэн³⁵, урьдчилан

³⁰ Монгол хэлний их тайлбар толь.

³¹ <https://tsevel.toli.query.mn/search>

³² Монгол Улсын Үндсэн хууль шинжлэх ухааны тайлбар Н.Лүндэндорж 2022 он, х384

³³ Монголын эрх зүйн эх толь бичиг С.Нарангэрэл 2015 он, х 357

³⁴ Моисейчева М. Виды волонтерства // *BiZ-Bote*, No 4.–М.: АНО«Брайтенарбайт», 2011.– С. 5.

³⁵ Вахрамеева О. А. Пути решения социальной адаптации детей-сирот // Научно-методический электронный журнал «Концепт». –2013. –No 2. –С. 11–15. –URL: <http://e-koncept.ru/2013/13515.htm>.(дата обращения: 15.03.2016

сэргийлэх (эрүүл амьдралын хэв маягийг дэмжих)³⁶, иргэн-эх оронч³⁷, байгаль орчны³⁸, спорт³⁹, боловсролын⁴⁰, эрүүл мэндийн⁴¹, соёлын салбарт⁴², түүнчлэн амралт зугаалгын, интернэт сайн дурын ажил, онцгой байдлын үед хариу арга хэмжээ авах зэрэг болно.

Сайн дурынхны үйл ажиллагааны хамрах хүрээ маш өргөн. Сайн дурын ажилтан хувь нэмрээ оруулах боломжгүй тохиолдлыг төсөөлөхөд хэцүү байдаг. Уламжлал ёсоор сайн дурынхны ажлыг хэд хэдэн чиглэлээр хуваадаг.⁴³

- Нийгмийн сайн дурын ажил (нийгмийн эмзэг бүлэг, халамж анхаарал шаардлагатай өндөр настан, тэтгэврийн хүмүүс, хөгжлийн бэрхшээлтэй иргэд, өнчин хүүхэд гэх мэт);

- Эмнэлгийн сайн дурын ажил (эмнэлгийн тусламж үйлчилгээний чанарыг сайжруулах, хүртээмжтэй болгох, эрүүл мэндийн боловсрол олгох,

³⁶ Ильина Н.В., Прошина И.И. Опыт организации волонтерского движения в общеобразовательном учреждении // Вестник КРАУНЦ. Гуманитарные науки. –2013. – No 2.–С. 22

³⁷ Железовская И.А., Тарасова Т.Л. Гражданско-патриотическое воспитание обучающихся колледжа через систему волонтерской деятельности // Научные исследования в образовании. –2011.–No 12.–С. 16-20.

³⁸ Переясловец В.М., Переясловец Т.С. Опыт привлечения волонтеров для организации системы экологического мониторинга в Юганском заповеднике. URL: <http://www.ugansky.ru/upload/medialibrary/852/pereyaslovets-v.m.-pereyaslovets-t.s.-opyt-privlecheniya-volonterov-dlya-organizatsii-sistemyekologicheskogo-monitoringa-v-yuganskom-zapovednike.pdf> (дата обращения: 15.03.2016).

³⁹ Телепаева Д. Ф. Специфика управления общностью спортивных волонтеров в России // Стратегии развития социальных общностей, институтов и территорий: материалы Международн. науч.-практ. конф. Екатеринбург, 23–24 апреля 2015 г. — Екатеринбург : Изд-во Урал. ун-та, 2015. —Т. 2. —С. 17-20. ; Файзуллин И.Ф. Мотивы волонтерской деятельности на спортивных мероприятиях // Фундаментальные исследования. –2015. – No 2-7. –С. 1499-1503..

⁴⁰ Петошина С.И., Рыжкова И.В., Тегалева Т.Д. Педагогическое волонтерство в образовательных учреждениях как фактор развития социальных и профессиональных компетенций студенческой молодежи // Современные проблемы науки и образования. – 2015. –No 6.–С. 431.

⁴¹ Галактионова М.Ю., Маисеенко Д.А., Савельева Е.А. Организация волонтерского движения в Красноярском государственном медицинском университете им. проф. В.Ф. Войно-Ясенецкого // Сибирское медицинское обозрение.–2014.–No 3. –С. 97-100

⁴² Горлова Н.И. Исторические аспекты развития культурного волонтерства в России // Ученые записки. Электронный научный журнал Курского государственного университета. –2016. –No3(39).URL: <http://scientific-notes.ru/pdf/044-012.pdf> (дата обращения 01.01.2017).

⁴³ ОХУ-д сайн дурын үйл ажиллагааны чиглэлүүд. Сайн дурын хөдөлгөөний жил. <https://bazar-dvd.ru/mn/home-business/volonterstvo-v-rossii-v-teoriya-i-istoriya-volonterskaya-deyatelnkst.html>

нийгмийн эрүүл мэндийн чиглэлээр өвчлөлөөс урьдчилан сэргийлэх, цус цусан бүтээгдэхүүний хангамжийг сайжруулахад чиглэсэн сайн дурын үйл ажиллагаа)

- Байгаль орчин, экологийг хамгаалах (байгаль орчин, хүрээлэн буй орчны экологийн тэнцвэртэй байдлыг хамгаалах, хадгалахад чиглэсэн сайн дурын үйл ажиллагаа);

- Соёлын сайн дурын ажил (соёлын өвийг хадгалах, хамгаалах, түгээн дэлгэрүүлэх, үндэсний түүх соёлыг залуу үед уламжлуулан сурталчлахад чиглэсэн сайн дурын үйл ажиллагаа);

- Урьдчилан сэргийлэх сайн дурын ажил (эрүүл амьдралын хэв маяг, спорт, сөрөг илрэл, муу зуршлаас урьдчилан сэргийлэхэд чиглэсэн сайн дурын үйл ажиллагаа);

- Гамшиг, онцгой байдлын үеийн сайн дурын ажил (хүн ам, нутаг дэвсгэрийг гамшиг, онцгой байдлын үед хамгаалах чиглэлээр сайн дурын ажил хийх, онцгой байдлын үед урьдчилан сэргийлэх, гамшгийн хор уршгийг арилгахад яаралтай тусламжийн үйлчилгээнд туслах, хүн амын дунд аюулгүй байдлын соёлыг төлөвшүүлэх);

- Арга хэмжээний сайн дурын ажил (орон нутаг, бүс нутаг болон олон улсын түвшний спорт, нийгэм-соёл, боловсролын болон бусад арга хэмжээнд сайн дурын ажил хийх);

- Эх оронч сайн дурын ажил (эх оронч хүмүүжил, түүхэн дурсгалт үйл явдлыг сануулахад чиглэсэн сайн дурын үйл ажиллагаа);

Сайн дурын үйл ажиллагааны хэлбэрүүд нь нийгэм, улс төр, соёл, эдийн засгийн нөхцөл байдлаас шалтгаалан орчин үед дараах хэлбэрүүдтэй байгааг судлаачид тогтоожээ. Үүнд:

- 1 Харилцан туслалцах буюу өөрөө өөртөө туслах хэлбэр
- 2 Бусдад туслах хэлбэр
- 3 Оролцоо болон өөрийгөө удирдах хэлбэр
- 4 Сурталчилгаа буюу компанит ажлын хэлбэр

Хөгжиж буй орнуудад харилцан туслах нь нийгэм, эдийн засгийн туслалцааны гол хэлбэр нь болдог. Өөрөө өөртөө туслах хэлбэр нь аж үйлдвэржсэн бүс нутагт ялангуяа эрүүл мэнд, нийгмийн халамжийн салбарт нь чухал үүрэг гүйцэтгэдэг ба тусламж, дэмжлэг шаардлагатай байгаа хүмүүст зориулан олон тооны байгууллага сайн дурын үйл ажиллагаа явуулж байна. Хэдийгээр олон хүн бусдад туслах хэлбэр нь хувийн сонирхлыг агуулсан байдаг гэж үздэг ч сайн дурын үйл

ажиллагааны ашиг тусыг хүртэж байгаа хүмүүс нь тухайн бүлгийн гишүүн өөрөө биш, харин гурав дахь этгээд байдгаараа өөрөө өөртөө туслах хэлбэрээс ялгагддаг. Засгийн газрын зөвлөх нэгжээс орон нутгийн хөгжлийн төсөлд хамрагдагч хувь хүн тус бүрийн гүйцэтгэж байгаа үүргийг оролцоо гэж үздэг.

Сайн дурын үйл ажиллагааны оролцоо болон өөрийгөө удирдах хэлбэрийн хувьд иргэний оролцоо их хөгжсөн улсуудад оролцоог сайн засаглалын нэг чухал хэсэг гэж онцгойлон үздэг ба сүүлийн үед улс орнуудын иргэний нийгмийн үзэл баримтлалын гол чиглэл болж байна. Төр ба иргэний харилцааг хариуцлагын тогтолцоотой уялдуулж бэхжүүлбэл төрийн үйлчилгээний хүртээмж нэмэгддэг болох нь нотлогдсон. Тусламжийн үр ашгийг дээшлүүлэх Парисын тунхаглалын гол таван зарчим нь төсөл, хөтөлбөрт өөриймсөг хандаж, манлайлах, уялдаа холбоог хангах, үндэсний бодлого, журамд нийцүүлэх, үр дүнд чиглэсэн удирдлагаар хангах, харилцан хариуцлагатай байх явдал бөгөөд оролцоо нь энэ бүгдтэй салшгүй холбоотой учраас чухал ач холбогдолтой.

Сурталчилгаа буюу компанит ажил нь сайн дурын ажилтан, сайн дурын идэвхтэн гэж нэрлэгддэг сайн дурынхны оролцоотойгоор хийгддэг. Сайн дурынхан ДОХ, Бэлгийн замын халдварт өвчинтэй тэмцэх ажлын хүрээнд халамжийн шинэ төрлийн үйлчилгээ нэвтрүүлж, байгаль орчны доройтол, хүний эрхийг зөрчих асуудлаар олон нийтэд мэдлэг, мэдээллийг түгээн дэлгэрүүлэн сурталчилж, дэлхийн олон оронд эмэгтэйчүүдийн хөдөлгөөн, ардчиллын төлөө компанит ажлуудад идэвхтэй оролцож байна.

Сайн дурын хөдөлгөөн. Сайн дурын үйлсийн эхлэл нь бүх нийтийн сайн сайхныг бүтээх үүднээс чадавх бэхжүүлэх, мэдээлэл түгээх, ухуулга нөлөөлөл хийх, харилцаа холбоо үүсгэх зэрэг өөрийн байгууллагын болон бусад байгууллагын төсөл хөтөлбөрт оролцуулахаар сайн дурынхныг элсүүлэх, тохирох ажлыг нь сонгуулах, илгээх, дэмжлэг үзүүлэх үйл ажиллагаануудыг явуулдаг дотоодын болон гадаадын бүлэг юм⁴⁴. Сайн дурынхны хөдөлгөөнд нэгдэх нь гишүүддээ туршлага, мэдлэг, ур чадвар олж авах төдийгүй харилцаа холбоо тогтоох талбар болдог. Мөн залуучуудын хувьд сайн дурын ажил хийх нь ажил, мэргэжлийн өсөлтөд

⁴⁴ Монголын сайн дурын байгууллагын нөхцөл байдлын үнэлгээ ба зөвлөмж.Уб., 2012. 11 дэх тал.

хүрэх алхам болж ирээдүйн ажил, амьдралын чиг хандлагаа зөв тодорхойлоход тусалдаг.

Сайн дурын хөдөлгөөн гэдэг нь нийгэм ба ард иргэдийн эрх ашиг, сайн сайхны төлөө асуудалд олон нийтийн хүч анхаарлыг хандуулж, оролцогчдын сайн дурын хүсэл эрмэлзэл дээр тулгуурлан зорилгодоо хүрэхийн тулд зохион байгуулж буй нийтийг хамарсан үйл ажиллагааг хэлнэ.⁴⁵

Сайн дурын хөдөлгөөний шинжүүд нь: гишүүнчлэлтэй, гишүүнчлэлгүй сайн дурын үндсэн дээр эвлэлдэн нэгддэг, бусдад туслах, нийгмийг хөгжүүлэх хүсэлд тулгуурлан, хийж бүтээснийхээ төлөө хариу нэхдэггүй, үргэлжлэх хугацаа янз бүр, өмнөө тавьсан зорилготой, үр өгөөж ихтэй байдгаараа ялгаатай. Сайн дурын хөдөлгөөнд нэгдэх нь гишүүддээ туршлага, мэдлэг, ур чадвар олж авах төдийгүй, харилцаа холбоо тогтоох талбар нь болж, олон нийтийн болон төрийн бус байгууллагуудад нийгмийн харилцааны чиглэлээр манлайлагч удирдагчдыг бэлтгэхэд үнэлж баршгүй хувь нэмэр оруулдагаараа онцлог шинж чанартай.

Олон Улсын сайн дурын хөдөлгөөний томоохон төлөөллөөс авч үзье. Үүнд:

- ОУУЗ,УХС Хөдөлгөөн (ICRC) нь 1863 онд байгуулагдсан. Өдгөө дэлхийн 192 оронд 250,0 сая сайн дурынхныг эгнээндээ нэгтгэсэн хүмүүнлэгийн том хөдөлгөөн юм. Эрүүл мэнд, анхны тусламж, гамшгийн менежмент, хүмүүнлэгийн тусламж, залуучуудын улаан загалмай, нийгмийн халамжийн чиглэлээр сайн дурынхныг сургаж бэлтгэдэг.

- Олон Улсын Иргэний үйлчилгээний байгууллага SCI (Service Civil International) нь 1920 онд байгуулагдсан. Дэлхий даяар 33 салбартай. Тус хөдөлгөөний гол зорилго нь энх тайван, олон улсын ойлголцол, эв нэгдэл, нийгмийн шударга ёс, байгаль орчныг хамгаалах үзэл санааг сурталчилж, олон улсын сайн дурын төсөл, семинар, богино, дунд, урт хугацааны хөтөлбөр, боловсролын сургалт, олон улсын солилцоог зохион байгуулахад чиглэгддэг.

- Олон Улсын сайн дурын үйлчилгээний хөдөлгөөн IVS (International Voluntary Service) 1920 онд байгуулагдаж, олон улсын харилцан ойлголцол, хүндэтгэл, нөхөрлөл, солилцоо, хамтын

⁴⁵ Монголын сайн дурын байгууллагын нөхцөл байдлын үнэлгээ ба зөвлөмж.Уб., 2012. 11 дэх тал.

ажиллагаагаар дамжуулан энх тайвныг эрэлхийлж, хүчирхийлэлгүй нийгмийг дэмжих зорилготой, дэлхийн 79 орны 188 байгууллагыг нэгтгэсэн сайн дурын хөдөлгөөний томоохон төлөөллийн нэг юм.

- Олон улсын сайн дурын үйлчилгээг зохицуулах хороо CCIVS (Coordinating Committee for International Service) 1948 онд ЮНЕСКО-гийн ивээл дор байгуулагдсан. Дэлхийн 100 гаруй орны 250 гаруй үндэсний сайн дурын байгууллагыг нэгтгэсэн дэлхий нийтийн сайн дурын хөдөлгөөн болон хөгжиж, эдгээр байгууллагын үйл ажиллагааг зохицуулах, хүчин чадлыг бэхжүүлэх сургалт, сурталчилгааны ажил, НҮБ-ын төслүүдийн уялдаа холбоог хангаж ажилладаг.

1863 онд дайнд шархадсан цэргүүдэд туслах эмнэлгийн сайн дурын ажилтнуудыг сургаж бэлтгэхээс эхэлсэн, 160 гаруй жилийн түүхтэй Олон улсын Улаан загалмайн хөдөлгөөн өдгөө 192 орны 250,0 сая сайн дурынхныг нэгтгэсэн дэлхий нийтийн хөдөлгөөн болж, түүний дараа 1920 –иод онд олон улсын иргэний үйлчилгээний хөдөлгөөн 33 оронд үүсэн байгуулагдаж, олон улсын энх тайван, хамтын ажиллагааны хөгжилд чухал хувь нэмрээ оруулж, 1948 онд ЮНЕСКО-гийн ивээл дор байгуулагдсан олон улсын сайн дурынхны үйлчилгээг зохицуулах хороо 100 гаруй орны 250 гаруй үндэсний сайн дурын байгууллагын үйл ажиллагааны уялдаа холбоог зохицуулж, түгээн дэлгэрүүлэх, тогтвортой хөгжлийг хангах үйлст хувь нэмрээ оруулан дэлхий нийтийн хөдөлгөөн болтлоо хөгжиж ирснийг эдгээр жишээнээс харж болохоор байна.

Сайн дурын байгууллага. Сайн дурын үйл ажиллагаа нь нийгмийн баялгийн гол цөм бөгөөд иргэний нийгмийн ихэнхи нийгэмшсэн үйл ажиллагааны суурь болж, доороосоо ундрэн хөгжин цэцэглэж байдаг. Сайн дурын үйл ажиллагаа нь сайн дурын байгууллагуудаар дамжин зохион байгуулалттай хэрэгждэг ба эдгээр байгууллагууд нь олон төрөл хэлбэртэйгээс нь гадна янз бүрийн зорилтот бүлэгт үйлчилдэг төдийгүй, сайн дурын санаачилга дээр үндэслэсэн, хүн төвтэй хөгжлийн хөдөлгөх хүчин байдгаараа нийтлэг чанартай. Мөн нийгэмд итгэлцэл, харилцан ойлголцлын шижмээр холбогдож, эерэг өөрчлөлт хийх, идэвхтэй хүчин байх боломжийг хүн бүхэнд олгодог шинж чанартай. Сайн дурынхны идэвхтэй оролцоо нь энгийн ард иргэдийг эрх мэдэлжүүлдэг бөгөөд бүхий

л түвшинд хамтын ажиллагаа, дэмжлэгээр хангагдсан нөхцөлд энэ нь бүр ч их үр дүнтэй болдог⁴⁶.

Сайн дурын байгууллага гэдэг нь сайн дурын хөдөлгөөнд хамрагдах хүсэл сонирхолтой хамт олон, хүмүүсийн үйл ажиллагааг зохион байгуулах, сурталчлах, зуучлах, зэргээр сайн дурын ажилтнуудын эрх ашиг, хүсэл сонирхолд нийцсэн үйл ажиллагаа явуулдаг байгууллагыг хэлнэ⁴⁷ гэж, өөр нэг тодорхойлолтод “Сайн дурын байгууллага” гэдэг нь эрх зүйн байдал нь тодорхой, байнгын ажиллагаатай, ашгийн бус, өөрөө өөрийгөө удирддаг, гишүүнчлэл, оролцоо, хандив өргөх журам нь сайн дурын зарчимд суурилсан хувийн хэвшлийн болон төрийн бус байгууллага байна⁴⁸ гэж тус тус тодорхойлжээ.

Сайн дурынхантай ажилладаг байгууллага гэдэг нь иргэний идэвхтэй оролцооныхоо илрэл болгон үйл ажиллагаанд нь оролцдог иргэний нийгэм, сургалт эрдэм шинжилгээ, хэвлэл мэдээлэл, хувийн буюу төрийн хэвшлийн аливаа байгууллага юм.⁴⁹ гэж Монголын сайн дурын байгууллагуудын нөхцөл байдлын үнэлгээ ба зөвлөмжид тодорхойлжээ.

Сайн дурынхны салбар гэж орон нутгийн болон үндэсний хөгжил, дэвшил, түүнчлэн олон улсын харилцан ойлголцол, хамтын ажиллагаа, нөлөөллийн ажилд хувь нэмрээ оруулахаар сайн дураараа зохион байгуулалтад орсон нийгэм, хүн амын хэсгийг хэлнэ⁵⁰ гэж тус тус тодорхойлжээ. Ардчиллын суурь зарчим болох төрийн эрх мэдлийн хуваарилалт, хүний эрх, эрх чөлөөний хэрэгжилт, төрийн үйл ажиллагаанд тавих хөндлөнгийн хараат бус хяналтын төлөвшилт нь сайн дураар эвлэлдэн нэгдэж нийтлэг эрх ашиг, үнэт зүйлсийн төлөө төр, бизнесийн үйл ажиллагаанаас гадуур үйл ажиллагаа явуулдаг, ашгийн төлөө бус олон нийтийн байгууллагууд нийгэмд дараах түгээмэл үүргийг хэрэгжүүлж байна гэж судлаачид тодорхойлсон байна⁵¹. Үүнд:

⁴⁶ НҮБ-ын сайн дурынхны (UNV) гүйцэтгэх зохицуулагч Флавия Пансиерийн 2011 оны ОУ-ын сайн дурынхны өдрөөр хэлсэн үгээс.

⁴⁷ Монголын сайн дурын байгууллагын нөхцөл байдлын үнэлгээ ба зөвлөмж.Уб., 2012. 11 дэх тал.

⁴⁸ Мөн тэнд.

⁴⁹ Мөн тэнд

⁵⁰ Мөн тэнд.

⁵¹ Giske C Lillehammer, State-NGO relationships in transitional democracies: The case of CPA-ONG-a government center for the Aadvancement of NGOs Benin, Apri 20031

- *Тулгамдсан асуудлыг тодорхойлох.* Нийгмийн шийдвэрлэвэл зохих тулгамдсан асуудлыг ил гарган тавьж, төрийн болон загийн газрын бодлогод тусгуулах, нөлөөлөхөд чухал үүрэг гүйцэтгэдэг.

- *Бодлогод нөлөөлөх.* Төрийн бодлого боловсруулагч, шийдвэр гаргагчдад нөлөөлөх, лоббины шахалт үзүүлэх нь төрийн бус байгууллагын чухал үүргийн нэг юм.

- *Шинэчлэлийн чиг үүрэг.* Нийгэмд зөвлөн туслах ажил хэрэгжүүлэх явцдаа иргэдийн оюун санаанд эерэг шинэчлэл, өөрчлөлтийг бий болгох зорилготой.

- *Хэрэгжүүлэгчийн чиг үүрэг.* Хүн амд хэрэгцээтэй байгаа боловсрол, эрүүл мэнд, санхүү, хөдөө аж ахуй болон хүний эрхийг хангах олон салбарт үйлчилгээ үзүүлдэг нь түүний чухал чиг үүрэг юм.

- *Хамтран ажиллах чиг үүрэг.* ТББ нь өөрийн зорилго, зорилтыг хэрэгжүүлэхийн тулд төр засаг, хувийн эвшлийн болон хандивлагч донор байгууллагуудтай өргөн хүрээнд хамтран ажилладаг.

- *Нөхөх чиг үүрэг.* Төр, засгийн газраас үзүүлж буй олон нийтэд зориулсан бодлого, үйл ажиллагаанд хамрагдаж чадаагүй нийгмийн гишүүдийн эрх ашгийг хамгаалж, тэдэнд үйлчилдэг.

Үүнээс дүгнэж үзэхэд нэг талаас нийгэмд сайн дурын үндсэн дээр нэгдсэн байгууллагуудын чадавх, хяналт, оролцоо хүчтэй байхын хирээр төрийн зүгээс нийгмийн өмнө хүлээсэн чиг үүргээ бүрэн дүүрэн хэрэгжүүлэх, захиргааны хүнд суртлыг халж, нээлттэй, ил тод, хариуцлагатай болгох, төрийн үйлчилгээг иргэдэд илүү ойртуулах зэрэг боломжийг бүрдүүлдэг давуу талтай. Нөгөө талаас төрд дэмжлэг болж, нөхөж ажиллах, олон нийтийг соён гэгээрүүлэх зэргээр нийгэмд эерэг өөрчлөлтийг авчрахад эдгээр байгууллагууд чухал үүрэгтэй тул чадавх бүхий үндэсний сайн дурын байгууллагыг хөгжүүлэх нь төрийн нэг чухал зорилт болно. Энэ утгаараа сайн дурын байгууллагууд нийгэмд гүйцэтгэх үүргээ бодитой, үр дүнтэй хэрэгжүүлж чадах эсэх нь тэдгээрийг дэмжих төрийн бодлого, хараат бусаар үйл ажиллагаа явуулах эрх зүйн таатай орчноос шууд хамаардаг байна.

Олон Улсын сайн дурын томоохон байгууллагын жишээг авч үзье.

- Нэгдсэн Үндэстний Байгууллагын Сайн дурын байгууллага UNV (United National Voluntary) нь 1970 онд байгуулагдсан. НҮБ-д шууд харьяалалтай, сайн дурын ажлыг дэлхий нийтэд түгээн дэлгэрүүлэх, сайн дурынхныг дайчлах замаар дэлхийн тогтвортой хөгжлийг дэмжих

зорилготой. НҮБ-ын 4000 орчим сайн дурын ажилтнууд хүүхэд, насанд хүрэгчдийн боловсрол, эрүүл мэнд, байгаль орчин, хот байгуулалт, сонгуулийн хууль ба сонгогчдын эрхийг хамгаалах, жендерийн тэгш байдал, эмэгтэйчүүдийн эрх, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн эрхийг хамгаалах чиглэлээр НҮБ-ын гишүүн бүх орнуудад үйл ажиллагаа явуулдаг.

- Европын сайн дурын үйлчилгээний байгууллагуудын Холбоо. (Alliance of European Voluntary Service Organisations) 1982 онд байгуулагдсан. Тус холбоо нь Европ, Ази тивийн 31 орны 53 гишүүн байгууллагыг эгнээндээ нэгтгэж, олон улсын хамтын ажиллагаа, энх тайван, ойлголцлыг дэмжих зорилгоор урт, богино хугацааны сайн дурынхны хөтөлбөрийг хэрэгжүүлж, орон нутгийн болон олон нийтийн 1200 гаруй төсөлд дунджаар 12000 сайн дурын залуус оролцон ажиллаж байна.

- GVI (Global Vision International). Тус байгууллага нь 1998 онд байгуулагдсан. НҮБ-ын Тогтвортой хөгжлийн 17 зорилттой нийцсэн тогтвортой хөгжил, туршлага боловсролын хөтөлбөрүүдийг хэрэгжүүлдэг. Дэлхийн 5 тивийн 13 улсад эдийн засаг, нийгэм, уур амьсгалын өөрчлөлт, байгаль орчин, зэрлэг амьтдыг хамгаалах, зэрлэг ан амьтад, эмэгтэйчүүдийн эрх, жендерийн тэгш байдал, боловсролын чиглэлээр үйл ажиллагаа явуулж, жил бүр 2500 гаруй хүн сайн дурын хөтөлбөр, дадлагад хамрагдаж, өнөөдрийг хүртэл 28,000 гаруй хүн дэлхийн чухал асуудлуудыг шийдвэрлэх зорилготой 150 төсөлд хамрагджээ.

- Projects Abroad. Олон Улсын сайн дурын байгууллага. НҮБ-ын Тогтвортой хөгжлийн зорилтуудыг хэрэгжүүлэхэд хяналт-шинжилгээ, үнэлгээний өргөн арга хэрэгслийг ашиглан хууль эрх зүй, хүний эрх, боловсрол, эрүүл мэнд, спорт, археологи, ан амьтдыг хамгаалах чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг, эгнээндээ 120, 000 гаруй сайн дурын ажилтныг нэгтгэсэн нэр хүндтэй олон улсын байгууллага юм.

Сайн дурын ажилтан. Сайн дурын үйл ажиллагаа нь сайн дурын ажилтнуудаар дамжин хэрэгждэг. НҮБ-ын тодорхойлсноор “Сайн дурын ажилтан” гэж сайн дурын үйл ажиллагааг гардан гүйцэтгэгчид бөгөөд ямарваа цалин хөлс, ашиг орлогогүйгээр өөрийн хөдөлмөр, оролцоо, үйл ажиллагаагаар нийгэмд хувь нэмэр оруулж буй хувь хүн юм. Өргөн агуулгаараа сайн дурын ажилтан бүр иргэний нийгмийн байгууллагын гишүүн гэж үзэж болно.

“Сайн дурынхан” гэж зах зээлийн жам ёсны үйл явцад үүссэн нийгмийн эмзэг, ядуу амьдралыг тэтгэх, тохиолдлын гамшиг, хүндрэлд нэрвэгдсэн хүмүүст сайн санааны туслалцаа, ивээл үзүүлэх зэрэг нь энэ үнэт зүйлийн гол илэрхийлэл юм. Ийм үйл ажиллагааг голлон эрхэлдэг иргэд, хамтлагийг сайн дурынхан гэж нэрлэнэ.

Сайн дурынхны нийтлэг эрх, үүрэг, баримтлах ёс зүйн талаар авч үзье.

Сайн дурын ажилтны эрх:

- Өөрийн сонирхол, мэдлэг, оюуны болон биеийн чадавхад нийцсэн ажил үйлчилгээг шударгаар сонгох

- Ажиллах нөхцөл байдал болон үйл ажиллагааг хийж гүйцэтгэхэд шаардлагатай мэдлэг, ур, чадвараа нэмэгдүүлэх, сурах хөгжих боломжоор хангагдах, мэдээлэл авах

- Удирдах ажилтан болон сургагч багш нартаа санал, хүсэлтээ гаргах, зааварчилгаа авах,

- Гэрээ ёсоор ажил үйлчилгээг гүйцэтгэх, ажлын зохистой нөхцөл, материал хэрэгслээр хангагдах

- Сайн дурын ажил, үйлчилгээний ёс зүйн дүрэм болон ажлын тодорхойлолтод заагдаагүй аливаа үүрэг, даалгаврыг хүлээн авахаас татгалзах

- Сайн дурын ажилтан нь ажил үүргийнхээ талаар тодорхойлолт гаргуулах, өөрийн байр сууриа илэрхийлэх

- Хүлээсэн үүргийн биелэлт ажлаа шалгуулах, үнэлүүлэх, шагнал урамшилд нэр дэвших, авах

- Сайн дурын бусад ажилтантай холбоотой ажиллаж, бие биеэсээ суралцаж хамтран ажиллах

- Сургалт, зөвлөгөөнд оролцох, хийх ажлынхаа талаар бусдаас санал, зөвлөгөө авах

Сайн дурын ажилтны үүрэг:

- Сайн дурын байгууллагын дүрэм, эрхэм зорилгыг ойлгон хүндэтгэн мөрдөж, ажил, үйлчилгээ явуулах, санаачлага гаргах, тэдгээрийг түгээн дэлгэрүүлэхэд идэвхтэй оролцох

- Байгууллагатай холбоотой асуудлаар удирдлагаасаа зөвлөгөө авч, мэдээллийн нууцлалыг чанд хадгална.

- Сайн дурын ажилтны ёс зүйн хэм хэмжээг чандлан сахина.

- Сайн дурын байгууллагатай байгуулсан гэрээний дагуу хариуцсан ажилдаа итгэмжлэгдэж олон нийтийн дунд үлгэр жишээ үзүүлж, итгэл найдварыг биелүүлж ажиллана.

- Олон нийт, үйлчлүүлэгчдэд хүнлэг энэрэнгүй сэтгэлээр тусалж хүмүүсийн хувийн нууцыг хүндэтгэнэ.

- Өөрийн мэдлэг, ур чадвар, дадлагаа байнга хөгжүүлж, ажил, үйлчилгээг үр бүтээлтэй шударгаар чанартай гүйцэтгэж, удирдлагадаа тайлагнана.

- Хамт олны дунд таагүй уур амьсгал, буруу мэдээлэл түгээхгүй сонгосон ажилдаа үнэнчээр зүтгэнэ.

Сайн дурын ажилтны ёс зүйн хэм хэмжээ:

- Олон нийтийн итгэл өөрсдөөс нь шууд хамааралтай болохыг ухамсарлаж үг, үйлдлээ сайтар хянаж, ажил, асуудлынхаа зорилгыг танилцуулж, үйлдэл үйл ажиллагааныхаа талаар тов тодорхой, ойлгомжтой тайлбарлана.

- Хийж буй ажлыг хувийн ашиг сонирхлоос дээгүүр тавьж, гүйцэтгэлийг бүрэн ханган, хувийн болон албаны эрх ашгийн зөрчилдөөн үүсэх нөхцөл байдлаас зайлсхийнэ.

- Сахилга дэг журам, харилцааны соёлыг чандлан сахиж, бүдүүлэг зан авир гаргах, хэрүүл маргаанд өртөхийг цээрлэнэ.

- Бусдын хувийн мэдээлэл, олж авсан аливаа мэдээлэл баримтын нууцлалыг хуулийн дагуу чандлан хадгалж, тэдний зөвшөөрөлгүй нийтэд ил болгож, бусдад ашиглуулахгүй байна.

- Бусдын тавьсан санал хүсэлтийг түргэн шуурхай шийдвэрлэж, хүмүүс хоорондын харилцаа, ашиг сонирхлын тэнцвэртэй байдлыг хангана.

- Хүмүүнлэгийн ажлыг хэсэг бүлэг хүмүүс, байгууллагын явцуу ашиг сонирхолд зориулах, зохион байгуулахыг хориглоно.

Түүхийн туршид сайн дурын хөдөлгөөнийг санаачилж, өөрийн авьяас чадвар, уран бүтээлээ бусдын өвчин шаналал, зовлон зүдүүрийг хуваалцахад зориулсан алдартай, домог болсон хүмүүсийн жишээнээс дурдъя.

Бен Франклин. 1736 онд АНУ-ын Филадельфи хотод их хэмжээний түймэр гарсны улмаас 30 хүний бүрэлдэхүүнтэй анхны сайн дурын гал унтраах анги “Union Fire” компанийг байгуулсан. Тэрээр “Урьдчилан сэргийлэх нэг унц нь нэг фунт эдгээх үнэ цэнтэй юм” гэсэн алдарт эшлэлийг хэлсэн.

Агата Кристи. Агата Кристи 1890 онд төрсөн. Тэрээр Дэлхийн 1-р дайны үед Торки дахь Улаан загалмайн эмнэлгийн сайн дурын тусламжийн отрядод сувилагчаар ажиллаж байхдаа детектив зохиол бичиж эхэлсэн ба Кристигийн анхны томоохон нэр хүнд нь "Рожер Акройдын аллага" (1926) зохиолоор эхэлсэн ба дараа нь 75 орчим зохиол нь ихэвчлэн шилдэг борлуулалттай номын жагсаалтад орж, Англи, АНУ-ын алдартай сэтгүүлүүдэд цувралаар хэвлэгдсэн байдаг.

Элла Фицжералд. 1917 онд төрсөн АНУ-ын “Дууны тэргүүн хатагтай” Элла Фицжералд нь жааз болон скэт маягийн дуугаараа алдартай. Тэрээр иргэний эрхийн төлөө тэмцэгч, арьсны өнгөөр ялгаварлахын эсрэг сайн дурын хөдөлгөөнийг санаачлагч, авьяас чадвараа зориулсан нийгмийн зүтгэлтэнд зүй ёсоор тооцогддог. Тэрээр өнгөт арьстнуудыг хөгжүүлэх үндэсний нийгэмлэгийн тэгш шударга ёсны шагналыг хүртсэн. 1993 онд Фицжералд “Элла Фицжералд” буяны санг байгуулж, хүүхдүүдэд зориулсан эрдэм шинжилгээний боломж, хөгжмийн боловсрол, ядуусын тусламж үйлчилгээний үндсэн хэрэгцээ, чихрийн шижин, зүрхний өвчин, харааны бэрхшээлтэй иргэдийн эрүүл мэндийн судалгаа гэсэн чиглэлийн үйл ажиллагааг санхүүжүүлдэг.

Кристофер Рив. АНУ-ын кино дэлгэцийн алдартай жүжигчин. 1995 онд морин уралдааны улмаас нуруу нугасны саажилттай болж, ослын улмаас саажилттай болсон хүмүүст туслах, нуруу нугасны гэмтлийг эмчлэх сувилах, энэ чиглэлийн судалгааны ажлыг санхүүжүүлж (тус сан нь 1998 онд 12.0 тэрбум ам.доллар, 2003 онд 27,2 тэрбум ам. долларын хөрөнгөтэй байсан), АНУ-ын саажилттай иргэдийн нийгэмлэгийн даргаар ажиллаж, Нью-Йорк болон хэд хэдэн мужид “Нуруу нугасны судалгааны тухай” хуулийн төслийг батлуулж, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн амьдралын чанарыг сайжруулах үйлсэд хувь нэмэр оруулсан сайн дурын үйлсийн алдартай зүтгэлтний төлөөлөл юм.

Орчин үед нийгэмд тулгарч буй өргөн хүрээний үзэгдэл, сорилтоос хамаарч сайн дурын үйл ажиллагааны хэв шинж, сайн дурын үйл ажиллагааны хэрэгцээ шаардлага өөрчлөгдөж байгаатай холбогдуулан судлаачид сайн дурынхны үүрэг, оролцоо, үйл ажиллагааг хэрэгжүүлэх арга замыг таван чиглэлээр судалгаагаар тогтоосныг хүснэгт 3-д үзүүлээ.

Нийгэмд үүссэн бэрхшээл, сорилт	Сайн дурын үйл ажиллагааны хэв шинжийн өөрчлөлт	Сайн дурынхны оролцооны чиглэл
---------------------------------	---	--------------------------------

<ul style="list-style-type: none"> - Уур амьсгалын өөрчлөлт, - Ган гачиг, - Өлсгөлөн, - Хүмүүнлэгийн хямрал, - Тэгш бус байдал - Технологийн дэвшил - Шилжилт хөдөлгөөн 	<ul style="list-style-type: none"> - Богино хугацааны сайн дурын ажил өссөн. - Илүү уян хатан, олон талт загваруудыг хөгжүүлэх, - Дэвшилтэт технологийг түлхүү ашиглах, - Оролцооны зарчмуудыг тодорхойлсон тогтолцоог боловсруулах, - Албан бус сайн дурынхны оролцоог хангах, - Сайн дурынхны дижитал ажиллах чадавхыг хөгжүүлэх 	<ul style="list-style-type: none"> - <i>Хүртээмжтэй байдлыг хангах.</i> Төрийн үйлчилгээний хамрах хүрээг хүн амын орлого багатай, нийгмээс гадуурхагдсан хэсэгт хамгийн ихээр хандуулах - <i>Хариуцлагатай хуваарилалт.</i> Орон нутгийн хөгжлийн стратегид хэрэгжилтийн хариуцлагын тогтолцоог боловсронгуй болгох - <i>Шинэлэг шийдлүүдийг хэрэгжүүлэх.</i> Нийгмийн хөгжил, өөрчлөлтөд хувь нэмрээ оруулж, хамтын ажиллагааны шинэ хэлбэрийг бий болгох - <i>Оролцоог хангах.</i> Хүмүүсийн оролцох таатай орчныг бүрдүүлэх - <i>Үйл ажиллагааны сэдэл.</i> Зан үйлийн шинэ хэм хэмжээг бий болгох зэрэг арга замууд багтаж байна.
--	--	---

Хүснэгт 3., Сайн дурын үйл ажиллагаанд сайн дурынхны оролцооны өнөөгийн чиглэл, үйл ажиллагаа.

Хүснэгт 3-аас дүгнэхэд нийгэмд үүссэн эдгээр бэрхшээлээс үүдэлтэй сайн дурын үйл ажиллагааны хэв шинж өөрчлөгдөж, илүү уян хатан, хугацааны хувьд богино, дэвшилтэт технологи, дижитал чадавхыг эзэмшсэн, оролцооны зарчмуудыг тэгш хангасан тогтолцоотой, хамтын ажиллагааны шинэ хэлбэрт шилжих хэрэгцээ шаардлага сайн дурын хөдөлгөөн, байгууллага, ажилтнуудад тавигдаж байна гэж дүгнэж болохоор байна.

Сайн дурын үйл ажиллагаанд баримтлах зарчим. Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалд “Монгол Улсын иргэн бүрийн үндэсний үнэт зүйлээрээ бахархагч, тэдгээрийг хайрлан хамгаалагч, тээн хөгжүүлэгч байх эх оронч үндэсний үзэл, улс, үндэснийхээ ирээдүйн сайн сайхны төлөө хувь нэмрээ оруулахыг эрмэлзсэн идэвхтэй үйл ажиллагаа нь үндэсний аюулгүй байдлыг хангах бодлого, үйл ажиллагааны эх үндэс болно” гэсэн “эх оронч үндэсний үзлийг дээдлэх” үндэсний аюулгүй байдлыг хангах үйл ажиллагааны зарчим⁵²-ыг гамшгаас хамгаалах үйл ажиллагаанд оролцогч сайн дурынхны хувьд үндсэн суурь зарчим гэж үзэж болно. Үүний үндэслэл нь иргэн бүр, тэдгээрийн дотроос ялангуяа сайн

⁵² Монгол Улсын үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал. Монгол Улсын Их Хурлын 2010 оны 48 дугаар тогтоолын хавсралт. Заалт 1.2.1. Монгол Улсын Их хурлын тогтоол. “Төрийн мэдээлэл” эмхэтгэл № 48.2010.

дурынхны үйл ажиллагаа үндэсний ашиг сонирхлыг хамгаалахад чиглэж байдагт оршино.

Мөн бидний судалгааны хувьд гамшгаас хамгаалах үйл ажиллагааны зарчим нь сайн дурынхны үйл ажиллагаанд мөрдөгдөж байх чухал зарчим байх болно. Үүнд:

- Хууль дээдлэх
- Ардчилал, шударга ёс, тэгш байдал, эв нэгдлийг хангах;
- Хүмүүнлэг, энэрэнгүй, ил тод, хариуцлагатай байх;
- Мэргэжлийн нэгдмэл удирдлагатай байх;
- Шинжлэх ухаан, дэвшилтэт техник, технологи, инновацад тулгуурласан байх;
- Өмчийн хэлбэрийг үл харгалзах;
- Иргэдийн оролцоонд тулгуурлах.

Эдгээр зарчмуудын зэрэгцээ Олон Улсын Улаан Загалмай, Улаан Хавирган Сар хөдөлгөөн нь Энэрэнгүй, Шударга, Төвийг сахих, Бие даасан, Сайн дурын, Нэгдмэл, Түгээмэл гэсэн үндсэн 7 зарчмыг дэлхий нийтээр дагаж мөрдөн ажилладаг.

Энэрэнгүй байх зарчим. ОУУЗ,УХС хөдөлгөөний хүмүүнлэгийн үйл ажиллагаа нь тулалдааны талбарт ялгаварлалгүйгээр тусламж үзүүлэх, олон улсын болон үндэсний хэмжээнд хаана ч болов хүнийг зовлон зүдгүүрээс урьдчилан сэргийлэх, хуваалцан хөнгөвчлөх чин хүслээр туслах явдал юм. Түүний зорилго нь хүний амь нас, эрүүл мэндийг хамгаалах, хүнийг хүн ёсоор хүндэтгэх явдлыг хангуулахад оршино. Хөдөлгөөн нь хүмүүсийн хоорондын харилцан ойлголцол, нөхөрлөл, хамтын ажиллагаа болон урт хугацаанд энх тайван байдлыг хөхиүлэн дэмжинэ.

Шударга байх зарчим. Нийгэмлэг нь хүнийг яс үндэс, арьс өнгө, шашин шүтлэг, нийгмийн давхарга, улс төрийн үзэл бодлоор ялгаварлан гадуурхахгүй. Хувь хүний зовлонг нимгэлж, гагцхүү тэдний хэрэгцээнд тулгуурлах бөгөөд хамгийн хүнд нөхцөлд байгаа хүмүүст эн тэргүүнд анхаарал тавина.

Төвийг сахих зарчим. Олны итгэл, найдварыг хүлээхийн тулд хөдөлгөөн нь сөргөлдсөн талуудын аль нэг талыг баримтлахгүй байх бөгөөд ямар ч үед улс төр, арьс өнгө, шашин, үзэл бодлын шинж чанартай сөргөлдөөнд орж болохгүй.

Бие даах зарчим. Хөдөлгөөн нь бие даасан байна. Үндэсний нийгэмлэг нь өөрийн улсын төр, засгийн хүмүүнлэгийн үйл ажиллагаанд нэмэлт хүч болж, улсын хууль тогтоомжид захирагдахын зэрэгцээ ямар ч үед хөдөлгөөний зарчимд нийцсэн үйл ажиллагаа явуулж байхын тулд өөрсдийн бие даасан байдлыг ямагт хангаж байх ёстой.

Сайн дурын байх зарчим. Нийгэмлэг нь тусламж үзүүлэх зорилготой сайн дурын хөдөлгөөн бөгөөд ямар ч үед ашиг олохыг эрмэлзэхгүй.

Нэгдмэл байх зарчим. Аливаа улсад нэг л улаан загалмай эсхүл улаан хавирган сар нийгэмлэг байна. Энэ нь бүх нийтэд нээлттэй байх ба хүмүүнлэгийн үйл ажиллагааг нийт нутаг дэвсгэрийн хэмжээнд явуулна.

Түгээмэл байх зарчим. ОУУЗ,УХС Хөдөлгөөнд аливаа нийгэмлэг бүр тэгш эрхтэй байх ба бие биедээ харилцан туслах талаар адил, үүрэг хариуцлага хүлээдгээрээ дэлхийд түгээмэл шинжтэй байна.

Сайн дурын үйл ажиллагааны эдийн засаг, нийгмийн ач холбогдол. Зарим улс, оронд сайн дурын үйл ажиллагаа нь тухайн улсын дотоодын нийт бүтээгдэхүүний өсөлтөд тодорхой хэмжээгээр нөлөөлөхүйц эдийн засгийн ач холбогдолтой байдаг. Тухайлбал АНУ-д сайн дурын салбарт 9 сая хүн ажиллаж, жилд 225 тэрбум доллар зарцуулдаг төдийгүй, 32% орчим нь шашны байгууллагад, 25,7% нь соёл, спортын салбарт, 19,2% нь боловсролын салбарт сайн дурын ажил хийдэг ба насны хувьд сайн дурынхны ихэнх нь 35-44 насныхан байна. Канадын 15 –с дээш насны хүн амын 88% нь буюу 21 сая шахам залуучууд сайн дурын үйлсэд оролцож, буяны ба ашгийн бус байгууллагад хөрөнгө санхүү, нинжин сэтгэлээ, 7,5 сая залуучууд цаг зав, ур чадвараа зориулж, жилд дунджаар бусдын сайн сайхны төлөө нэг тэрбум гаруй цагийг зарцуулдаг байна. Их Британид нийт хүн амын бараг тэн хагас нь сайн дурын хөдөлгөөнд хамрагдаж, жил бүр 140 гаруй үндэстний 450 орчим НҮБ-ын сайн дурын ажилтнууд дэлхийн 150 гаруй орнуудад хүрэлцэн очиж ажилладаг байна.

Австрали улсад 2019 онд албан ёсны сайн дурын үйл ажиллагааны 98,3% -д сайн дурынхан биечлэн, 8,5% -д нь интернэтээр, 9,5%-д нь утсаар оролцсон бол 2020 онд сайн дурынхны 96,6% нь биечлэн, 17,3% нь интернэтээр, 13,9% нь утсаар сайн дурын ажил хийсэн нь интернэт болон утсан харилцаагаар хийх сайн дурын ажил өссөн байгаа нь шинэ технологи, интернэтийн хурдацтай тархалт нь сайн дурын ажлыг төрөлжүүлж, хувь

хүмүүст илүү хүртээмжтэй болгож, олон сайн дурын байгууллагууд онлайн харилцааг стратегиа болгон ашиглаж байгаа нь харагдаж байна.

Сайн дурын үйл ажиллагаа нь нийгмийн тогтвортой хөгжлийг хангах, ирээдүйн сайн сайхан, бусдын төлөө сэтгэл харамгүй хөдөлмөрөө зориулсан, улс орны нийгэм, эдийн засгийн хөгжилд үнэлж баршгүй хувь нэмэр оруулдаг, хүүхэд, залуусыг энэрэнгүй үйлст уриалан дуудсан, хүнлэг хандлага, хамтын ажиллагаа, эв нэгдэл бүхий үнэт зүйлс дээр суурилсан нийгмийн чухал ач холбогдолтой үйл ажиллагаа болох нь харагдаж байна.

Сайн дурын үйл ажиллагааны үүсэл хөгжил ба орчин үе.

Олон улсын сайн дурын үүсэл хөгжил. 1755 онд Европын орнууд өөрийн хүсэлтээр армид элсэж, дайнд оролцохыг хүсэгчдийг бүртгэх үеэс сайн дурын үйл ажиллагаа анх үүсэх эхлэл тавигдсан байна. Яваандаа байлдаж буй цэргүүдэд туслах, хувцас оёж, хоол хийх, шархдагсдыг эмчлэх, асарч сувилахад сайн дураараа ажиллаж байсан эмэгтэйчүүдийг ийнхүү нэрлэх болсон.

1863 онд Анри Дюнан нутгийн дөрвөн иргэнтэй нэгдэн “Шархдагсдад туслах тавын хороо”-г байгуулсан нь хожим Олон Улсын Улаан Загалмай Хороо болж өргөжжээ. Ийнхүү Улаан загалмайн сайн дурын үйл ажиллагаа нь Сольфериногийн тулалдааны үед дайсагнагч талуудын шархдагсдад ялгаварлалгүйгээр тусламж үзүүлэх чиглэлээр анх үүсэж байсан бол өнөө цагт эрүүл мэндийн тулгамдсан асуудлаас үүдэн хүний аюулгүй байдлыг хангах, гамшгаас урьдчилан сэргийлэх, гамшгийн бэлэн байдлыг хангах болон яаралтай үеийн тусламж үйлчилгээ үзүүлэхийн зэрэгцээ, нийгмийн нэн эмзэг бүлэгт халамж дэмжлэг үзүүлэх, цусаа бэлэглэх зэргээр гүйцэтгэж байгаа ажлууд тооны төдийгүй чанарын хувьд өргөн хүрээг хамарч, нийгэмд чухал ач холбогдолтой байр суурь эзэлж байна.⁵³

Дэлхийн I дайны төгсгөлд хийгдсэн 1919 оны хэлэлцээрийн дагуу цэргийн албыг хориглох болсон тул Австри, Герман, Унгар, Болгар зэрэг улсуудад 1920 оноос эхлэн цэргийн албыг орлох хөдөлмөрийн албыг байгуулж, эрэгтэй залуучуудыг татан оролцуулж ажиллуулах болсон. Болгар Улс л гэхэд 1920 онд нийгэм, улс төрийн сэдлээр Албан журмын хөдөлмөрийн албыг⁵⁴ байгуулж, хүн амын 30% нь жил бүр татагдаж,

⁵³ МУЗН “Улаан загалмайн сайн дурын идэвхтэн” гарын авлага.Уб., 2012, 5 дахь тал

⁵⁴ Zwangsarbeitsdienst -германаар

нийгэмд тустай ажил үүрэг гүйцэтгэдэг байв. Дэлхийн I дайны дараа 1920 онд Швейцарын иргэн Пиер Кересоль энх тайвны төсөл санаачилж, Дайныг эсэргүүцэгчид⁵⁵ нэртэйгээр анхны олон улсын сайн дурын албыг байгуулж, европын өнцөг булан бүрээс залуучуудыг цуглуулан дайны хөлд нэрвэгдсэн тосгодыг сэргээн босгож, хамтдаа хөдөлмөрлөж, цугтаа амьдран европ дахь ирээдүйн сэргөлдөөнийг намжаан ард түмнүүдийн харилцан ойлголцолд хувь нэмэр оруулж байв.

1924 онд Германд Холбооны залуучуудын бүлэг хэмээх байгууллага үүсэж 200 ахимаг насны удирдагчдыг бэлтгэн хөдөлмөрийн зуслан зохион байгуулж хүүхэд залуучуудыг хүмүүжүүлэх ажил хийж эхэлсэн байдаг.

1929 онд эхэлсэн дэлхийн эдийн засгийн хямралын улмаас ажилгүйчүүдийн тоо маш их болсон тул олон оронд залуу ажилгүйчүүдэд зориулан орлуулах зорилгоор сайн дурын албаны хөтөлбөрүүдийг хэрэгжүүлсэн байдаг.

Герман Улсад 1931 оны 8 дугаар сарын 8-ны өдөр “Сайн дурын хөдөлмөрийн алба” байгуулах тухай хууль батлагдаж, 25-аас доош настай ажилгүй иргэн 20 гараг (долоо хоног) хүртэл хугацаагаар давын өмнө нийгмийн, эсхүл залуучуудын хөдөлмөр эрхлэх боломжтой болсон. Залуучуудын холбоо нь дээрх хөдөлмөрийн албаны хүрээнд 1933 он хүртэл нийгэмд тустай 454 төслийг амжилттай хэрэгжүүлсэн байдаг.

АНУ-д 1933 оны хавар “Civilian Conservation Corps”⁵⁶ (CCC) байгуулагдаж, 1942 он хүртэл мөн л ажилгүй залуучуудад зориулсан ажлын байр бий болгох арга хэмжээнүүдийг хэрэгжүүлсэн байна. Эдийн засгийн хямралыг сөрөх энэхүү төсөлд Нэгдсэн Улсын армийн 3,463,766 бэлтгэл офицер сайн дураараа нийтийн дэд бүтцийн салбарын бүтээн байгуулалтын ажилд оролцсон нь хамгийн цар хүрээтэй нь юм.

Дэлхийн II дайн дууссан 1945 онд мөн л ард түмнүүдийн харилцан ойлголцол болон сэргээн босгох ажлын хэрэгцээ их байсан. Олон улсын сайн дурын байгууллагууд олноор бий болж, улмаар 1948 онд НҮБ-ын ЮНЕСКО-гийн дэргэд энэ салбарт үйл ажиллагаа явуулж буй ТББ-дын дээвэр байгууллага болох “Coordinating Committee for International Voluntary Service”⁵⁷ (CCIVS) байгуулагдсан юм.

⁵⁵ Pazifissten - германаар

⁵⁶ Иргэний нөөц корпус - үгчилбэл

⁵⁷ Олон Улсын сайн дурын албыг зохицуулах хороо- үгчилбэл

1960-аад онд Энхийг сахиулах зорилготой олон арван сайн дурын хөтөлбөрүүд гарч, өдгөө ЮНЕСКО-гийн Зохицуулах зөвлөлд нэгдсэн дэлхийн 50 гаруй орны байгууллагууд жил бүр 500 гаруй олон улсын залуучуудын лагерийг АНУ, Англи, Герман, Испани, Франц, Финлянд, Швейцар зэрэг орнуудад зохион байгуулж, оюутнууд, их сургуулийн багш нар, төрөл бүрийн мэргэжлийн хүмүүс сайн дурын хөдөлгөөнд нэгдсэн. Сайн дурын лагерь нь ой, талбай, гол мөрөн цэвэрлэх, мод тарих, байгаль, эх газрыг нөхөн сэргээх, засварлах, тариалангийн талбайд ажиллах, фермийн баяр зохион байгуулах, хүүхэд асрах, хүнд өвчтэй болон хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст туслах зэрэг ажлуудыг хийдэг. 1960-аад оны эхээр Америкчууд ЗХУ, БНАГУ, Унгарт олон улсын сайн дурынхны лагерьд оролцож, Дорнын болон европын соёл уламжлал, ёс заншилтай танилцаж, сайн дурын үйлс нь эв нэгдлийн үйлс болж байсан.

1970-аад он Дэлхийн сайн дурынхны бага хурал болж, дэлхийн өнцөг булан бүрээс ирсэн сайн дурын ажилтнууд нэгдэж, туршлагаа хуваалцах, бие биеэсээ суралцах, соёл, улс төр, хэл шинжлэлийн саад бэрхшээлийг даван туулах зорилгоор Олон Улсын сайн дурын байгууллага (IAVE)⁵⁸ байгуулагдсан. 1970 онд Лос Анжелес хотноо болсон дэлхийн анхны бага хурлаас хойш IAVE дэлхийн бага хурлыг 25 удаа хуралдуулжээ. 2001 оны 01 дүгээр сард Амстердам хотноо НҮБ-ын Олон улсын сайн дурынхны жилийг эхлүүлж, сайн дурын үйл ажиллагааны Тунхаглал баталсан. Уг тунхаглалд: Сайн дурын үйл ажиллагаа нь хүний нөөц бололцоонд тулгуурлан хүний үнэт зүйлийг хадгалах, бэхжүүлэх, иргэдийн эрх, үүргийг хэрэгжүүлэх хувь хүний өсөлт хөгжилт юм гэж тодорхойлсон.

Түүхэн хөгжлийн үе шатуудад сайн дурын үйл ажиллагааны агуулга, шинж чанарын өөрчлөлтийн харьцуулалтыг АНУ болон баруун европын орнууд, Орос улстай харьцуулан 4 үе шаттайгаар судлаачдын⁵⁹ тодорхойлсны үндсэн дээр Монгол Улсын сайн дурын ажлын агуулга, онцлогийг адилтган харьцуулалт хийж хүснэгт 4-д харууллаа.

Сайн дурын үйл ажиллагааны үндсэн агуулга, үе шатуудын онцлог шинж чанар						
Үе шат	АНУ болон Баруун Европын орнууд		Орос улс		Монгол Улс	
1750-1913	Баруун нийгмийн	Европын дунд болон	Сүм асрамжийн	хийдэд газар	Шашин хөгжиж	шүтлэг эхэлсэн үеэс

⁵⁸ Олон Улсын хүчин чармайлтаас суралц гэсэн үгийн товчлол

⁵⁹ Кудринская Л.А. Добровольческий труд опыт теоретической реконструкции. 2006.

	<p>дээд давхаргын төлөөллийг ядууралтай тэмцэх нийгмийн ажилд татан оролцуулах, орон нутгийн оршин суугчдын амьдрах нөхцөлийг сайжруулах, цагаачдыг дэмжих, анги хоорондын харилцан бие биедээ туслах хэлбэр хөршийн харилцаагаар илэрч, шашин хүмүүнлэгийн үзэл санаанд суурилсан дэлхий нийтийн сүлжээ болон хөгжих эхлэл тавигдсан.</p>	<p>байгуулж,буяны байгууллагууд боловсролын байгууллагуудыг асран хамгаалалтдаа авч, Эзэн хаан I Александрын санаачилгаар хүмүүнлэгийн нийгэм байгуулагдаж, Нигүүлслийн эгч нарын иргэний сайн дурын хөдөлгөөн өрнөсөн.</p>	<p>одоог хүртэл үргэлжилж байгаа сүм хийдийн хурал номд өргөл барьц өргөх, амь нас буян заяагаа даатгах, сүм хийдийн бүтээн байгуулалтад оролцох, хандив өргөх, биеийн хүчин зүтгэх зэрэг нь сайн дурын хэлбэртэй байсан.</p>
1914-1971	<p>Нийгмийн үйлчилгээг бүрэн хангасан төрийн бүтцийг өргөжүүлэх, сайн дурын үйлчилгээг нийгмийн үйлчилгээний салбараас салгах, сайн дурынхныг сонирхогч туслагч гэж үзэж аль болох мэргэжлийн боловсон хүчнээр солиход чиглэгдэж байсан.</p>	<p>Орост скаутын хөдөлгөөн гарч ирж, Комсомолын гишүүн сайн дурын ажилтны дүр төрх Оросын түүхэн дэх Зөвлөлтийн үеийн бүх чухал үйл явдал, бүтээн байгуулалтад шингэсэн байдаг.</p>	<p>Улс орны тусгаар тогтнол, батлан хамгаалахад туслах, МХЗЭ-ийн ажилтны дүр төрх, сайн дураараа цэрэгт элсэх, цусаа өгөх зэрэг нийтийг хамарсан нийгэм эдийн засгийн үе шат бүрд тухайн үеийн нөхцөл байдалд тохирсон сайн дурын хөдөлгөөнүүд өрнөж байсан</p>
1972-1991	<p>Нийгмийн зорилтот үйлчилгээний салбарыг төрийн байгууллагуудад шилжүүлж, орон нутгийн хөгжилд түлхүү анхаарч, хүнд суртлыг иргэдийн оролцоотойгоор арилгах, залуучуудыг сайн дурын ажилд татан оролцуулж олон тооны санаачилгын бүлэг, хөдөлгөөн байгууллагууд олноор үүсэж, сайн дурын</p>	<p>ЗХУ-ын олон нийтийн байгууллагуудын дотор залуучуудад нийгэмд тустай, нийгэмд ач холбогдолтой сайн дурын үйл ажиллагаа явуулах боломж нээгдсэн.</p>	<p>Оюутны сайн дурын отряд, төл хүлээн авалт болон намрын ургац хураалт зэрэг Улс ардын аж ахуйн салбарт бүтээн байгуулалтын, нийгэмд тустай сайн дурын ажлууд хийгдэж байсан.</p>

	байгууллагуудын сүлжээ бий болсон.		
1991-ээс одоо	Сайн дурын хөдөлгөөн нь ардчиллыг хөгжүүлэх үйлсэд хувь нэмрээ оруулж, олон нийтийн өмнө хариуцлага хүлээж, үндэсний цөөнхийн төлөөлөл, хөгжлийн бэрхшээлтэй иргэд, тэтгэврийн насныхан зэрэг гадуурхагдсан бүлгүүдийн оролцоог хангах чухал хэрэгсэл болсон. Сайн дурын ажлыг боловсролын тогтолцоонд нэгтгэх, залуучуудын оролцоог хангах, сайн дурын хөдөлгөөнийг зохицуулах эрх зүйн орчин бүрдсэн.	Нийгмийн харилцаанд иргэдийг идэвхтэй оролцох боломжийг олгох шаардлагатай байгааг төрөөс хүлээн зөвшөөрсөн. Соёл, эрүүл мэнд, хүүхдийн сан, залуучууд, өсвөр үеийнхний хөгжлийг дэмжих холбоод бий болж, буяны байгууллагуудын тухай хуулийг баталсан.	Ардчилсан нийгэм, эдийн засгийг цогцлон байгуулж, хөгжлийн шинэ эрин үед алхан орсонтой холбоотойгоор манай оронд сайн дурын хөдөлгөөний агуулга зорилго, түүнд хамрагдагсад, дэмжигчдийн ойлголт, үзэл бодол, үнэлэмж ихээхэн өөрчлөгдөж, үндэсний сайн дурын хөдөлгөөн шинэ арга барилаар хөгжих эхлэл тавигдсан.

Хүснэгт 4., Түүхэн хөгжлийн явц дахь олон улсын болон үндэсний сайн дурын үйл ажиллагааны агуулга, шинж чанарын өөрчлөлтийн харьцуулалт

Сайн дурын үйл ажиллагааны түүхэн хөгжлийн агуулга, туулж өнгөрүүлсэн хугацаа, үе шатаас харахад улс орон бүр өмнөө тулгарч байгаа саад бэрхшээлийг сайн дурын үйл ажиллагаагаар дамжуулан хүний нөөцийг зөв зохион байгуулж, бүрэн дүүрэн ашиглах замаар даван туулж, тогтвортой хөгжлийн нөхцөлөө бүрдүүлж иржээ. XVIII зууны дунд үеэс эхлэн үндэстэн хоорондын зэвсэгт мөргөлдөөн, Дэлхийн I, II дайн, томоохон байгалийн гамшиг, үй олноор алан хядах террорист үйл ажиллагаа зэрэг үйл явдал, түүний нөлөөгөөр үүсэн хор уршгийг арилгахад хүмүүст сэтгэл зүрхнийхээ угаас тусалж, мэдлэг, чадвараа зориулж, нийгмийн хөгжилд үнэлж баршгүй хувь нэмэр оруулж байдаг сайн дурынхны үйлсийг олон улсын түвшинд албан ёсоор хүлээн зөвшөөрч, НҮБ-ын системийн байгууллагууд дэмжин ажиллаж байна.

Монгол Улс дахь сайн дурын үйл ажиллагааны үүсэл хөгжил. 1920-иод оноос эхлэн сайн дурын үндсэн дээр эвлэлдэн нэгдсэн улс төр, олон нийтийн байгууллагаас эхтэй сайн дурын үйл ажиллагааны түүхэн хөгжлийг судалж үзэхэд 1921-1990 онд байгуулагдсан олон нийтийн

байгууллага, 1990-ээд оныг хүртэл сайн дурын үндсэн дээр зохион байгуулагдаж байсан бүх нийтийн бүтээн байгуулалтын компанит ажил, 1990-ээд оноос хойш байгуулагдсан сайн дурын байгууллагууд гэж ангилж үзэж, тэдгээрийн тухайн үеийн нийгэмд гүйцэтгэж байсан чиг үүрэг, улс орны аюулгүй байдал, тусгаар тогтнол, нийгэм эдийн засгийн хөгжилд оруулж байсан хувь нэмрийн талаар хүснэгт 5-д үзүүлээ.

А. 1921-1990 онд байгуулагдсан Олон нийтийн байгууллагын түүх		
1	Монголын Хувьсгалт Залуучуудын Эвлэл	1921 онд Монголын залуучуудын тэргүүний хэсгийг сайн дурын үндсэн дээр эгнээндээ нэгтгэсэн олон нийт улс төрийн байгууллага болох “Бошгыг халах Залуучуудын эвлэл” нэртэй байгуулагдсан. 1950-аад оныг хүртэл залуучуудын байгууллагын үүрэг, оролцоо нийгмийн оюун санаанд чиглэж, соёлжуулах, эрдэм боловсролыг нэн тэргүүнд тавих чиглэлээр өрнөж иржээ.
2	Монголын Үйлдвэрчний Эвлэл	1924 оноос Монголын Үйлдвэрчний Эвлэлийн Холбоо нь үйлдвэрчний эвлэлийн хөдөлгөөнийг эрчимтэй хөгжүүлэх замаар гишүүд, иргэдийн хөдөлмөрлөх эрх, түүнтэй холбогдсон хууль ёсны ашиг сонирхлыг тууштай хамгаалж, тэдний амьдралын түвшнийг байнга дээшлүүлэх болон сайн дурын үндсэн дээр нийгэмд болон гишүүн байгууллагууддаа үйлчилдэг, ашгийн бус байгууллага юм.
3	Монголын Эмэгтэйчүүдийн Холбоо	1924 онд «Бүсгүйчүүдийг боловсруулах тасаг» нэртэйгээр байгуулагдсан (эхчүүд, охид, бүсгүйчүүд, ахмад настан эмэгтэйчүүд) эрхийг хамгаалах зорилготой сайн дурын байгууллага юм.
4	Улсыг Батлан хамгаалахад туслах нийгэмлэг	1942 онд “Ардын өөрийгөө хамгаалах сайн дурын морьт отряд” байгуулагдав. 1957 онд “Ардын цэрэгт туслах Сайн дурын нийгэмлэг” болж өргөжин Биеийн тамир, спорт хорооны бүрэлдэхүүнд ажиллаж, богино долгионы холбоочин бэлтгэх, радио, спортын төв, авто мото спортын клубийн эх суурийг тавьсан байна. 1970 оноос БНМАУ-ын Батлан хамгаалахад туслах нийгэмлэг болгож сургалт, техникийн спорт, цэрэг эх оронч сурталчилгааны ажил эрхэлдэг олон нийтийн томоохон байгууллага болон өргөжсөн байна.
5	Монголын Ахмадын Холбоо	1931 онд Эх орныхоо тусгаар тогтнол, ард түмнийхээ эрх чөлөөний төлөө тэмцсэн ардын хувьсгалын ахмад партизануудын амьдрал ахуйд сайн дураар дэмжлэг үзүүлэх зорилгоор анх “Партизаны хэрэг эрхлэх комисс” нэртэйгээр суурь нь тавигдаж 1988 онд

		тэтгэвэрт гарсан нийт ахмад настны нийтлэг эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалах, ахмад настны нийгмийн хамгааллыг сайжруулах зорилгоор Монголын ахмадын холбоо болгон өргөжүүлэн зохион байгуулсан.
6	Монголын Улаан Загалмай Нийгэмлэг	1937 онд Ардын Сайд нарын Зөвлөлийн хурлаас Монгол Улсын бүх газар дэвсгэр дээр үйл ажиллагаа явуулах Улаан Загалмайн Сайн дурын Нийгэмлэгийг байгуулах шийдвэр гарч, тус нийгэмлэгийн зорилгыг “Хөдөлмөрийн нөхцөлийг эрүүлжүүлэх, ард, олны эмнэлэг, ариун цэврийн мэдлэгийг дээшлүүлэх, дайн байлдаан, гэнэтийн аюулд сүйтгэгдсэн хүмүүст тусламж үзүүлэх” гэж тодорхойлжээ.
7	Хил хамгаалахад туслах хүчин	Улсын хил хамгаалалт нь зөвхөн Хил хамгаалах байгууллагын хүч хэрэгслээр бус орон нутгийн засаг захиргаа, Улсын хил орчмын иргэдийг сайн дураар оролцуулж ирсэн туршлага, практикийг 1.1933-1940 Хязгаарын цэрэг анх байгуулагдах үеийн хил орчмын иргэдийн оролцоо 2.1940-1953 он баруун хязгаарын ард иргэдийг зэвсэгжүүлэн хамгаалсан үе. 3.1953-1967 он Хилийн цэрэг татан буугдсан үеийн хил орчмын иргэдийн оролцоо 4. 1967-1990 он Хүйтэн дайны жилүүд дэх хил хамгаалалт гэж үечлэн авч үзжээ.
<i>Б.1990 оныг хүртэл Сайн дурын үндсэн дээр зохион байгуулагдаж байсан бүх нийтийн томоохон компани ажлын түүх, сургамж.</i>		
1	Аугаа Их Эх орны дайны жилүүдэд Зөвлөлтийн Улаан Армид туслах бүх нийтийн Хөдөлгөөн	Аугаа их Эх орны дайны жилүүдэд буюу 1942 онд Монголын ард түмэн Зөвлөлтийн Улаан армид туслах ард нийтийн хөдөлгөөн өрнүүлж, 413 мянган агт морь худалдаж, 32 мянган агт морь, дулаан хувцас бусад эд зүйлийг бэлэглэжээ.
2	Хөдөө аж ахуйн салбар дахь “Нэгдэлжих” хөдөлгөөн	1958 онд МАХН-ын XIII Их хурал хуралдаж, нэгдэлжих хөдөлгөөнийг цаашид өрнүүлэх явдал тус орны социалист бүтээн байгуулалтын тулгамдсан асуудал болсныг онцлон тэмдэглээд "ойрын гурван жилд ардын аж ахуйтны ихэнхийг Сайн дурын зарчмын үндсэн дээр хоршоолон нэгтгэх нь зүйтэй" гэж заажээ. Ингэж Хөдөө Аж Ахуйн салбарт анхны нэгдлүүд үүсэж байсан түүхтэй.

3	“Атрын аян” хөдөлгөөн	<p>1959 онд МАХН-ын Төв Хорооны III бүгд хурлаас Атрын аяныг эхлүүлэх тогтоол анх удаа гаргасан бол хоёр дахь аян 1976 оноос өрнөжээ. Атар газрыг эзэмшиж, газар тариаланг хөгжүүлэх замаар хүн амын хүнсний хангамжийг сайжруулах, мал аж ахуйн тогтвортой өсөлтийг хангах, орчин үеийн техник, технологи нэвтрүүлэх, эдийн засгийн хөгжлийг хурдасгах шаардлагын дагуу ийнхүү олон нийтийн сайн дурын оролцоон дээр тулгуурлан Намын бодлогоор зохион байгуулалттай хийж, энэхүү атар газар эзэмших эхний аянуудыг МАХН-ын дайчин туслагч Монголын Хувьсгалт Залуучуудын Эвлэлийн байгууллага гардан зохион байгуулж, залуучуудыг өргөнөөр оролцуулж, шинээр байгуулагдсан САА-г шефлэн авч ажиллаж байв.</p> <p>Монгол Улсын Засгийн газрын 2008 оны 70 дугаар тогтоолоор “Атрын III аян” үндэсний хөтөлбөрийг баталсан. Атрын гурав дахь аяны үндсэн зорилго нь хөрсний үржил шимийг хамгаалж, нөхөн сэргээх, үр сортын болон техник технологийн шинэчлэлийг эрчимжүүлж, импортыг орлох, экспортын чиг баримжаатай газар тариалангийн тогтвортой хөгжлийг хангахад чиглэж байв</p>
4	“Илгээлтийн эзэн” хөдөлгөөн	<p>Социализм буюу 1960-80 оны хооронд манай улсад идэр залуусыг социалист бүтээн байгуулалтад сайн дураар нь дуудан дагуулахын тулд Эвлэлийн Төв хорооны дуудлагаар “Илгээлтийн эзэд” хэмээх хөдөлгөөн өрнүүлж, хөдөө аж ахуйд туслах зорилгоор анги, хамт олноороо, ганц нэгээрээ уриа лоозон дэвшүүлж ажиллан, сайн ажилласан төлчин, малчдыг ХААДС-д урилгаар суралцуулах ажлыг Нам, Эвлэлийн Их хурлын шийдвэрт бодлогоор тусгаж ажиллаж байсан.</p>
<i>В.1990 оноос хойших үеийн Сайн дурын байгууллагууд</i>		
1	Монголын Залуучуудын Холбоо	<p>1991 онд хуралдсан МХЗЭ-ийн XX их хурлаар залуучууд өөрчлөлт, шинэчлэлтийн асуудлыг хэлэлцэж, МХЗЭ-ийн үйл ажиллагааг зогсоож, тус байгууллагын суурин олон нийтийн шинэ байгууллага байгуулах болж, Монголын Залуучуудын Холбоо нь Монголын залуучуудын эрх ашгийг хамгаалах, дэмжих зорилгоор тэдгээрийн оюун ухаан, сэтгэлгээ, бие бялдрыг хөгжүүлэх, бие даасан, зорилготой,</p>

		шударга, аз жаргалтай амьдрах боломжоор хангах, нийгмээ соён гэгээрүүлэх сайн үйлсийн аянд түүчээлэх, залуучуудын нийгмийн ухамсарт хандсан эх оронч үзлийг төлөвшүүлэх, тэдний бие бялдар, гоо зүйн хүмүүжилд анхаарч, оюутан, залуусыг ажлын байраар хангах, мэдлэг боловсролыг дээшлүүлж, нийгмийн хөгжилд хувь нэмрээ оруулах үйлсийг дэмжин ажиллаж байна.
2	Монголын Скаутын холбоо	Монголын скаутын хөдөлгөөн 1992 онд байгуулагдсан түүхтэй. Скаутын хөдөлгөөний гол зорилго нь хүүхэд залуучуудыг оюун ухаан, нийгэм, сэтгэл санааны чадамжаа дээшлүүлэхэд тусалж хүүхэд өсвөр үеийг тал бүрийн мэдлэг боловсролтой, эрүүл чийрэг бие бялдартай, хамт олны дунд биеэ авч явах чадвартай иргэн болж төлөвшихөд нь туслах зорилготой хүүхэд залуучуудын сайн дурын хөдөлгөөн юм.
3	Монголын Хараагүйчүүдийн Үндэсний Холбоо	Монголын Хараагүйчүүдийн Үндэсний Холбоо нь 1993 онд байгуулагдсан. Хараагүй иргэдийн боловсрол, хөдөлмөр эрхлэлтийг дэмжин соёл урлаг, спорт, эрүүл мэнд, өглөг буяны чиглэлээр төрөл бүрийн үйл ажиллагаа явуулж, гишүүдийнхээ эрхийг хамгаалах, нийгмийн харилцаанд оролцоход нь бүх талын дэмжлэг үзүүлэх зорилготой сайн дурын ашгийн бус, төрийн бус олон нийтийн байгууллага юм.
4	Өрхийн эмнэлэг.	Төрөөс сайн дурын үйл ажиллагааг дэмжих зорилгоор ЭМЯ-ны 1993 оны шийдвэрээр өрхийн эмнэлгүүд байгуулагдаж, орон нутгийн сайн дурынхантай хамтран ажиллахаар заасан байдаг. Өрхийн эмнэлэг тус бүр орон нутагтаа тодорхой тооны эрүүл мэндийн сайн дурын ажилтнуудтай байхыг зөвлөмж болгоод, хүүхэд, өндөр настныг асрах, мэдээлэл өгөх, нөхөн үржихүйн эрүүл мэнд, гэр бүл төлөвлөлтийн зөвлөгөө өгөх зэрэг тодорхой чиг үүргийг тусгасан.
5	Монголын Донорын Холбоо	1999 онд байгуулагдсан, сайн дурын ашгийн бус төрийн бус байгууллага. Тус Холбооны зорилго нь хүн ардынхаа эрүүл энхийн төлөө, тэдний амь насыг аврахад хүнлэг энэрэнгүй сэтгэлээр хандаж цусаа бэлэглэх ажлыг уриалах, хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулдаг.
6	Монголын Сайн дурынхны байгууллагуудын	2004 онд ашгийн бус байгууллагын журмаар байгуулагдсан бөгөөд сайн дурынхны оролцоотой 30 гаруй ТББ-ыг багтаасан. Сүлжээний зорилго нь

	Сүлжээ зохицуулагч байгууллага	Монголын сайн дурынхны байгууллагуудыг холбож, туршлага солилцох нөхцөл бүрдүүлж өгөх, түншлэл байгуулж, тэдний нийтлэг дуу хоолой болох, сайн дурын үйл ажиллагааны ач тусын талаар олон нийтэд ойлгуулах, төрийн зохион байгуулалттай дэмжлэгийг авах, ухуулга, нөлөөллийн ажил хийх, сайн дурын байгууллагуудыг чадавхжуулах, сургалт, сурталчилгааны ажил зохион байгуулах замаар сайн дурынхны удирдлагыг боловсронгуй болгох, үйл ажиллагааны чанарыг дээшлүүлэх, сайн дурын үйлсийн талаар мэдээлэл боловсруулах, түгээх зэрэг өргөн хүрээний чиглэлийг хамардаг.
7	Сайн дурынхны хөгжлийн төв ТББ	Залуучуудын санаачилгаар 2009 онд байгуулагдсан бөгөөд нийгмийн бүхий л салбарт сайн дурынхны оролцоо, хувь нэмрийг нэмэгдүүлэх үндсэн зорилготой. Сайн дурынхны хөгжлийн төвийн нэг үйл ажиллагаа нь бүртгэлтэй сайн дурын ажилтнуудаа бусад байгууллагуудтай холбож, хооронд нь гүүр болон ажилладаг ба хувь хүний хөгжлийн болон сайн дурын үйл ажиллагааны талаар зөв ойлголт өгөх сургалт явуулах, "Сайн дурынхан сайн дурынхандаа" хөтөлбөрөөр гадаад хэлний сургалт зохион байгуулах, ахмадуудад чиглэсэн стресс бууруулах нийгмийн сэтгэл заслын хөтөлбөр, хэвлэл мэдээлэл, сэтгүүл зүй, олон нийтийн хөгжил, хоол тэжээлийн чиглэлээр мэдлэг, туршлагаа нэмэгдүүлэх сонирхолтой ажлуудыг сайн дурынхны дунд явуулдаг.
8	Гал түймэр унтраах сайн дурын бүлэг, хэсэг	Нийслэлийн хэмжээнд 2010 оноос Гал түймэр унтраах сайн дурын бүлэг, 2016 оноос орон нутагт "Гал түймэртэй тэмцэх сайн дурын хэсэг"-ийг байгуулан ажиллуулж байна.

Хүснэгт 5., Монгол Улс дахь сайн дурын үйл ажиллагааны түүхэн хөгжил.

Хүснэгт 5-аас харахад Монгол Улс дахь сайн дурын байгууллага, хөдөлгөөний хөгжлийн түүх нь 1921 оноос эхлэн залуучуудыг сайн дурын үндсэн дээр нэгтгэн, залуучуудын байгууллагын үүрэг, оролцоог нийгмийн оюун санаанд чиглүүлж, соёлжуулах, эрдэм боловсролыг тэргүүнд эгнээнд тавьж, эх орон, тусгаар тогтнолоо хамгаалах зорилгоор 1942 онд “Ардын өөрийгөө хамгаалах сайн дурын морьт отряд” байгуулагдаж, хөдөлмөрчдийн эрх ашгийг хамгаалах үйлдвэрчний эвлэл, Улаан загалмай нийгэмлэг зэрэг байгууллагууд бий болж, 1950-аад оны сүүлээр нэгдэлжих хөдөлгөөн, атрын аян, илгээлтийн эзэд зэрэг томоохон компанит ажил өрнөж, 1990-ээд оноос хойш нийгмийг соён гэгээрүүлэх, сайн үйлсийн аянд

олон нийтийг нэгтгэх, залуучуудын нийгмийн ухамсарт хандсан эх оронч үзлийг төлөвшүүлэх, тэдний бие бялдар, гоо зүйн хүмүүжилд анхаарах, эрүүл мэнд, байгаль орчин, гамшгаас хамгаалах, урьдчилан сэргийлэх чиглэлээр ажилладаг сайн дурын байгууллагууд бий болж, олон улсын сайн дурын байгууллагуудаас суралцан хөгжиж байна.

§1.2. Сайн дурын үйл ажиллагааны олон улсын туршлага

Сайн дурын үйл ажиллагааны олон улс дахь туршлагыг судлахдаа сайн дурын үйл ажиллагааны эрх зүйн зохицуулалт, удирдлага зохион байгуулалтын туршлага, сургамжийн талаар авч үзье.

Сайн дурын үйл ажиллагааны талаарх Олон Улс дахь Эрх зүйн зохицуулалт.

НҮБ-ын Ерөнхий Асемблейгаас 2001 оныг “Олон улсын сайн дурынхны жил” болгон зарласнаас хойш олон улс орнуудын засгийн газрууд сайн дурын ажил бол улс төр, эдийн засаг, нийгмийн хөгжлийг дэмжих гол тулгуурын нэг болохыг хүлээн зөвшөөрч, 2001 оны эцэст 125 улсад Үндэсний сайн дурын ажлын хороо байгуулагдаж, өөр өөрийн улсад сайн дурын ажлыг хуульчлах, эрх зүйн орчныг бүрдүүлэх ажлыг зохион байгуулж, 70 гаруй улсад сайн дурын ажлын талаар баримтлах бодлого, хууль эрх зүйн актууд батлагджээ.

Дэлхийн улс орнууд гамшгийн эрсдэлийг бууруулах, урьдчилан сэргийлэх, түүнтэй тэмцэх, хор уршгийг арилгах, сэргээн босгох зэрэг гамшгийн менежментийн цогц арга хэмжээг оновчтой явуулахын тулд тухайлсан хуулиуд, эрх зүйн актуудаар нарийвчилсан зохицуулалтыг хийдэг. Эдгээр баримт бичигт гамшгийн эрсдэлийг бууруулах үйл ажиллагаанд орон нутгийн засаг захиргаа, хуулийн этгээд, иргэд, олон нийт, сайн дурынхны үүргийг тодорхой зааж өгдөг.

Гамшгийн менежментийн чиглэлд суурь шинжтэй хуулиудыг (“Гамшгийн удирдлагын хууль” Шри Ланка, Өмнөд Африк, Энэтхэг гэх мэт) батлан гаргахаас гадна газар зүйн байршил, түгээмэл тохиолддог гамшгийн эрсдэлтэй холбогдуулан (“Хур тунадастай холбоотой гамшгаас урьдчилан сэргийлэх тухай хууль” Япон, “Газар хөдлөлтөөс урьдчилан сэргийлэх, эрсдэлийг бууруулах тухай хууль” БНХАУ)⁶⁰ тухайлсан хуулиудыг батлан гаргаж мөрддөг байна.

Сайн дурын үйл ажиллагааг зохицуулж буй зохицуулалтын хувилбаруудын хувьд улс орон бүр өөрийн хэрэгцээ шаардлага, нөхцөл байдалдаа тохируулан харилцан адилгүй зохицуулалттай байна. Турк, Албани зэрэг улсад сайн дурын ажил, үйлчилгээг зохицуулсан зохицуулалт

⁶⁰ www.adrc.or.jp/publications

байхгүй байгаа бол бусад улс орнуудын зохицуулалтыг (Европын холбооны хэмжээнд) үндсэн 3 ангилалд хувааж болохоор байна⁶¹.

Эхний ангилалд зан заншлын, өөрөө өөрийгөө зохицуулах хэм, хэмжээ бүхий, сайн дурын үйл ажиллагааг тусгайлан зохицуулсан хууль тогтоомж гаргаагүй улс орнууд орж байна Тус ангилалд: Сайн дурын үйл ажиллагаа эртнээс хөгжсөн Скандинавын улс орнууд болон Их Британи, Ирланд, Норвеги, Швед, Дани, Герман зэрэг улс орж байна.

Хоёрдугаар ангилалд сайн дурын үйл ажиллагаатай холбоотой харилцааг бие даасан хуулиар бус тус асуудлыг хамаарах олон хуулиар зохицуулсан улс орнууд багтаж байна. Тухайлбал, Тухайлбал, Унгарт “Нийтэд тустай сайн дурын үйл ажиллагааны тухай” хууль, (2005), Литвад “Буяны үйл ажиллагаа болон түүнд үзүүлэх дэмжлэгийн тухай” хууль. (2002), Польшид “Нийтэд тустай үйл ажиллагаа болон сайн дурын үйл ажиллагааны тухай” хууль (2003), Латвид “Нийтэд тустай үйл ажиллагааны тухай” хууль, Босни, Болгар, Румын улсуудад “Ашгийн бус хуулийн этгээдүүдийн тухай” хуулиар тус тус зохицуулж байна⁶². Зарим оронд татварын хуулиар энэхүү асуудлыг зохицуулдаг бол Швейцарт эрх, үүргийн тухай хуулиар зохицуулдаг байна.

Гуравдугаар ангилалд сайн дурын үйл ажиллагааг бие даасан хуулиар зохицуулж буй улс орнууд орж байгаа бөгөөд Европын орнуудад хамгийн түгээмэл хэрэглэгдэж буй хувилбар юм. Үүнд: Бельги, Литва, Македон, Молдав, Словак, Серб, Украин, ОХУ, Гүрж, Хорват, Чех, Унгар, Итали, Люксембург, Португал, Испани зэрэг улс орнууд багтаж байна.

Сайн дурын үйл ажиллагааны үр нөлөөтэй эрх зүйн зохицуулалтыг тодруулах зорилгоор сайн дурынхныг дэмжих орчин бүрдүүлэх чиглэлээр гаргасан олон улсын баримт бичиг / НҮБ-ын Ерөнхий ассамблейн “Сайн дурын үйл ажиллагааг дэмжих тухай” 56/38 дугаар тогтоолын хавсралт, Залуучуудын хил дамнасан урт хугацааны сайн дурын үйл ажиллагааг дэлгэрүүлэх тухай Европын конвенц⁶³/, зөвлөмж, аргачлал/, НҮБ-ын Сайн дурын байгууллагын “Сайн дурын үйл ажиллагааны тухай хууль, бодлого

⁶¹ Д.Халиун, Г.Алтан-Оч (Ph.D) нарын “Сайн дурын үйл ажиллагааг зохицуулж буй эрх зүйн орчны харьцуулсан судалгаа”. УБ. 2017.

⁶² Хууль зүйн үндэсний хүрээлэн. “Нийтэд тустай, сайн дурын үйл ажиллагааны үр нөлөөтэй эрх зүйн зохицуулалт” судалгаа. УБ. 2013.

⁶³ “Монголын сайн дурын үйл ажиллагааны нөхцөл байдлын үнэлгээ ба зөвлөмж” УБ.,2012

боловсруулах, хэрэгжүүлэх зөвлөмж- 2011 он/ болон энэхүү харилцаа сайн хөгжиж буй БНСУ, Македона, Польш зэрэг орнуудын сайн дурын үйл ажиллагааны үндэсний хууль тогтоомжийн ялгаатай болон онцлог талын шинжилгээг хуулийн зорилго, сайн дурын ажлын тодорхойлолт, гэрээ, сайн дурын ажилтны эрх, үүрэг, урамшуулал, хамгаалалт, сайн дурын үйл ажиллагааны менежмент, сурталчилгаа зэрэг 7 асуудлын хүрээнд харьцуулан авч шинжиллээ. (Хүснэгт 6).

Асуулт	Улс	Дүн шинжилгээ
1.Зорилго / Цар хүрээ /	БНСУ	Хуулийн зорилт: Сайн дурын үйл ажиллагааг хөгжүүлэх, иргэний эрүүл нийгмийг байгуулах, сайн дурын үйл ажиллагаанд санхүүгийн болон захиргааны байнгын дэмжлэг үзүүлж, нийгмийн нэгдмэл байдлыг хангахад оршино. Хуулийн хамрах хүрээ: Хууль нь дараах хүрээг хамарна. Нийгмийн халамж болон эрүүл мэндийн үйлчилгээг сайжруулах, Орон нутгийг хөгжүүлэх, байгаль орчны хадгалалт, хамгаалалт, залуучуудыг хамгаалах, гамшгийн менежмент болон үр дагаврыг арилгах, боловсролд анхаарах, хүний эрхийг хамгаалах, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, соёл урлаг, жуулчлал спортыг хөгжүүлэх, авлигаас сэргийлэх, шударга сонгуулийг дэмжих зэрэг үйл ажиллагааг хуульчилсан.
	Македона	Хуулийн зорилт: сайн дурын үйл ажиллагаа, үйл ажиллагаанд оролцох нөхцөл, арга хэлбэр,байгуулах гэрээ болон тайлан илтгэлийг зохицуулах, журамлах. Хуульд дурдсан нийгмийн зорилтууд: Амьдралын түвшнийг дээшлүүлэх, ард иргэдийн нийгмийн амьдралын оролцоог нэмэгдүүлэх, хүмүүнлэг, эрх тэгш нийгмийг байгуулахад хувь нэмэр оруулах,
	Польш	Зорилго: Хууль нь дараах харилцааг зохицуулна. Олон нийтийн ашгийн төлөө ТББ-ын ажиллагаа, тэдний статус, олон нийтийн захиргаатай хамтран ажиллах, хяналт тавих, Сайн дурын үйл ажиллагааг хэрэгжүүлэх нөхцөл болон ашиглах чиглэл. Хуулийн хамрах хүрээ: ТББ-уудын олон нийтийн ашгийн төлөө үйл ажиллагаа болон олон нийтийн захиргааны үүрэг, хариуцлага (чадавхын үнэлгээ, ажлын чанар, зардлын үнэлгээ гэх.мэт.)

		ТББ-ын болон олон нийтийн захиргааны үйл ажиллагаанд сайн дурын албаны оролцоог хангах
2. Тодорхойлолт. - сайн дурын үйл ажиллагааг хэрхэн тодорхойлох вэ? - тавигдах доод шаардлага, эдгээр шаардлагын мөн чанар - хуульд сайн дурын үйл ажиллагааг нийгмийн тодорхой давхаргатай уялдуулах уу? Тухайлбал: залуучууд, ахмадууд тахир дутуу иргэд зэрэг. - Ямар байгууллагад сайн дурын үйл ажиллагааг ашиглах эрх олгох вэ? Тухайлбал, төр засгийн, ашгийн бус, олон нийтийн, бизнесийн зэрэг	БНСУ	Сайн дурын үйл ажиллагааны зарчим: Сайн дурын үйл ажиллагаа нь олон нийтийн ашиг тусын тулд, санхүүгийн шагнал, урамшуулал, ашиг, аливаа улс төрийн нам, шашны ашиг сонирхлын төлөө бус, сайн дурын үндсэн дээр явагдана. “Сайн дурын ажилтны тодорхойлолт”: Сайн дурын үйл ажиллагаанд оролцож буй хүнийг сайн дурын ажилтан гэнэ.“Сайн дурын үйл ажиллагааны тодорхойлолт”: Сайн дурын үйл ажиллагаа гэж хувь хүн, байгууллага, ард иргэд, улс орон, хүний нийгмийн ашиг тусын тулд ямарваа нэгэн шан харамж авахгүйгээр сайн дураар цаг, хүчин чармайлтаа зориулахыг хэлнэ. “Сайн дурын байгууллагын тодорхойлолт”: Сайн дурын байгууллага гэж ашгийн бус сан, сайн дурын үйл ажиллагаа, ажилтанд дэмжлэг үзүүлдэг байгууллагыг хэлнэ. “ Сайн дурын үйл ажиллагааны төв”-ийн тодорхойлолт: Сайн дурын ажиллагааг хөгжүүлэх, дэмжих, зохицуулах үүрэг бүхий байгууллага, сан, нэгжийг хэлнэ. Хэн сайн дурын ажилтан байж болох вэ? Хүн бүр нийгмийн гарал үүсэл, нас хүйс, чадвар, төрсөн газар, боловсрол зэргийг харгалзахгүйгээр сайн дурын үйл ажиллагаанд оролцох эрхтэй. Сонгуулийн компанит ажлын явцад сайн дурын үйл ажиллагаанд хязгаарлалт тавих: Үндэсний Засгийн Газар, орон нутгийн захиргаанаас санхүүжилт авдаг сайн дурын байгууллага, төвүүд аливаа нам, нэр дэвшигчийн сонгуулийн компанит ажилд оролцохыг хориглоно.
	Македона	Хуулийн тодорхойлолт: Өөрийн хувийн мэдлэг, чадвар, үйл ажиллагааг хүн ард байгууллагад сайн дурын үндсэн дээр ямарваа нэгэн шан харамжгүй зориулах, Сайн дурын үйлчилгээг албан бусаар үзүүлж болохыг хуульд заасан байна. Тавигдах шаардлага: Байхгүй. Сайн дурын үйл ажиллагаанд оролцох нөхцөл: Насанд хүрээгүй иргэн, хүүхэд сайн дурын үйл ажиллагаанд оролцох тохиолдолд эцэг, эхээс нь зөвшөөрлийн бичиг авна. Гадаадын иргэн сайн

		<p>дурын үйл ажиллагаанд оролцоход хатуу хяналт тавина.</p> <p>Сайн дурын үйл ажиллагаанд зарим иргэдийг оролцуулах асуудал: Хуульд тусгаагүй.</p> <p>Сайн дурын үйл ажиллагааг ашиглах эрхтэй байгууллагууд: Сайн дурын үйл ажиллагааг дараах байгууллагууд зохион байгуулж болно.</p> <p>Үүнд:</p> <ul style="list-style-type: none"> - Иргэдийн нийгэмлэг, сан, - Шашны байгууллагууд, бүлгүүд - Төрийн болон олон нийтийн байгууллагууд
	Польш	<p>Сайн дурын ажилтны тодорхойлолт: “Сайн дурын ажилтан гэж сайн дураар, шан харамжгүй үйлчилгээ үзүүлж буй хүнийг хэлнэ.”</p> <p>Тавигдах шаардлага:</p> <p>“Сайн дурын ажилтан нь бусад хууль тогтоомжид өөрөөр заагаагүй бол ажиллаж буй салбарын нөхцөл шаардлагыг бүрэн хангасан, зохих мэдлэг чадвартай байна.”</p> <p>Сайн дурын үйл ажиллагаа, байгууллага, төвийн тодорхойлолт байхгүй, сайн дураар хэн ажиллаж болохыг тодорхойлоогүй.</p> <p>Сайн дурын үйл ажиллагааг ашиглах эрхтэй байгууллагуудад хязгаарлалт тогтоох:</p> <p>Сайн дурынхан дараах үйлчилгээ, дэмжлэг үзүүлнэ. Үүнд:</p> <ul style="list-style-type: none"> -ТББ болон бусад байгууллагуудад хууль ёсны ажиллагаа, ялангуяа олон нийтийн ашгийн төлөө үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх. Чингэхдээ бизнесийн үйл ажиллагаанд оролцохгүй. -Бизнесийн бус олон нийтийн захиргааны байгууллагын үйл ажиллагаа.
3. Гэрээ байгуулах/ зардал, нөхөн олговор Сайн дурын ажилтан ХАБ-ын хооронд ямар гэрээ байгуулах вэ? Тухайлбал, хөдөлмөрийн гэрээ, иргэний гэрээ, арилжаа, худалдааны зэрэг	Македона	<p>Гэрээ: Сайн дурын үйл ажиллагааг зохион байгуулж буй байгууллага нь хувь хүнийг сард 40-өөс илүү цаг ажиллуулах бол бичгээр гэрээ байгуулах үүрэгтэй.</p> <p>Гэрээнд тавигдах шаардлага:</p> <p>Гэрээ байгуулагч талууд:</p> <ul style="list-style-type: none"> - Үйл ажиллагааг зохион байгуулагч (албан ёсны нэр, хаяг). - Зардлын хэмжээг урьдчилан тохиролцох нь зөв, уян хатан арга юм.
	Польш	<p>Гэрээ: Сайн дурын ажилтан нь 30-аас дээш хоногийн хугацаагаар ажиллах тохиолдолд</p>

		тухайн байгууллагатай (ТББ, олон нийтийн захиргааны байгууллага) –тай бичгээр гэрээ байгуулна.
4. Эрх, үүрэг. Сайн дурын ажилтны эрх, үүрэг. Тухайн байгууллагын эрх үүрэг.	Македона	Сайн дурын ажилтны эрх: Сайн дурын ажилтан нь : - Үйл ажиллагаанд шаардлагатай сургалтад хамрагдах - Мэдээлэл, заавар зөвлөгөө авах - Амралт, чөлөө эдлэх - Хувийн мэдээллээ хамгаалуулах Сайн дурын ажилтны үүрэг: - Ажил үүргээ гэрээ холбогдох хууль, дүрэм журам, байгуулсан гэрээний дагуу гүйцэтгэх - Ажил үүргээ биечлэн гүйцэтгэх Байгууллагын үүрэг: - Ажиллах нөхцөлөөр хангах - Ажиллах үүргээ гүйцэтгэхэд шаардлагатай материал хэрэгслээр хангах Мэргэжлийн өвчин, ажлын ослын даатгал олгох, харилцан тохирсон бол эрүүл мэндийн даатгал, тахир дутуугийн тэтгэлэг олгох
	Польш	Сайн дурын ажилтны эрх, үүрэг: Сайн дурын ажилтнууд байгууллагатай байгуулсан гэрээний дагуу холбогдох үүрэг, үйлчилгээг цаг хугацаанд нь чанарын түвшинд гүйцэтгэнэ. Сайн дурын ажилтнууд нь эмнэлгийн үйлчилгээнд хамрагдах ба үйлчилгээг олон нийтийн сангаас санхүүжүүлж болно. Байгууллагын үүрэг: Ажиллах нөхцөлөөр хангах 30-аас доош хоногоор үүрэг гүйцэтгэж буй сайн дурын ажилтны ослоос хамгаалах даатгалыг хариуцна. Сайн дурын ажилтан нь байгалийн гамшиг, зэвсэгт мөргөлдөөнтэй гадаад улс оронд үүрэг гүйцэтгэж байгаа тохиолдолд сайн дурын ажилтны ослын болон эрүүл мэндийн даатгалыг хариуцна. Сайн дурын ажилтны хүсэлтээр гэрээний дагуу гүйцэтгэсэн ажил, ажлын чанарын талаар бичгээр үнэлгээ гаргаж өгнө
5. Сайн дурын ажилтны	БНСУ	Сайн дурынхны хамгаалал: Сайн дурын үйл ажиллагааны төвүүдийг аюултай нөхцөлд ажиллаж байгаа хүмүүсийг хамгаалах арга

урамшуулал, хамгаалалт.		хэмжээ, тухайлбал сургалт явуулж болно. Сайн дурын ажилтны биед нь гэмтэл учруулах, эдийн засгийн хувьд хохирох, гуравдагч этгээдийн бие хөрөнгөд хохирол учруулах зэргээс хамгаална.
	Македона	<p>Урамшуулал:</p> <p>Зорилт 1. Сайн дурын үйл ажиллагааг олон нийтээр дэмжүүлэх.</p> <p>Сайн дурын үйл ажиллагааг дэмжих компани ажлыг зохин байгуулах, хэвлэл, мэдээллийн байгууллагатай байнгын харилцаа тогтоох, Сайн дурынхны өдрийг тэмдэглэх, “Оны тэргүүний ажилтан” үндэсний шагнал бий болгох.</p> <p>Зорилт 2. Боловсролын системд сайн дурын үйл ажиллагааг дэмжих тогтолцоог бий болгох, Бага болон дунд сургуулийн хөтөлбөрт сайн дурын үйл ажиллагааны мэдлэг олгох</p> <p>Оюутнуудыг сайн дурын үйл ажиллагаанд оролцох механизмыг их дээд сургуулиудад бий болгох</p> <p>Сайн дурын үйл ажиллагааг дэмжих хөгжүүлэх стратегийг боловсруулах</p> <p>Залуучуудын дунд сайн дурын үйл ажиллагаанд оролцох эрмэлзлэлийг хөгжүүлэх,</p> <p>Зорилт 3. Иргэний нийгмийн сайн дурын үйл ажиллагаанд оролцох түвшнийг дээшлүүлэх.</p> <p>Иргэний нийгмийн сайн дурын үйл ажиллагаанд оролцох боломжийн талаарх мэдээллийн солилцоог өргөжүүлэх</p> <p>Иргэний нийгмийн байгууллагуудын сайн дурынхантай ажиллах, ашиглах чадавхыг хөгжүүлэх</p> <p>Сайн дурын үйл ажиллагааны дэд бүтцийг хөгжүүлэх, (сайн дурын үйл ажиллагааны болон мэдээллийн төвүүд, эрдэм шинжилгээ, мэдээллийн сан),</p> <p>Зорилт 4. Сайн дурын үйл ажиллагааг дэмжих институцийн системийг бий болгох;</p> <p>Сайн дурын ажиллагааг хөгжүүлэх Үндэсний зөвлөлийг байгуулах,</p> <p>Хуулийн заалтын хэрэгжилт, үйл ажиллагаанд мониторинг, үнэлгээ хийх</p> <p>Сайн дурын үйл ажиллагааг дэмжих, хөгжүүлэх төсөл, хөтөлбөрт санхүүгийн туслалцаа үзүүлэх,</p>

		<p>Төрийн байгууллагуудын сайн дурынхантай ажиллах чадавхыг нэмэгдүүлэх</p> <p>Залуучуудын сайн дурын үйл ажиллагаанд оролцох боломжийг нэмэгдүүлэх.</p> <p>Байгууламж: мэдээлэлгүй.</p> <p>Хамгаалалт: сайн дурын үйл ажиллагаанд гэрээгээр оролцсоноор ажилгүй байсан хугацааны статус, тэтгэлгийг хадгалж болно.</p>
<p>6. Менежмент</p> <p>Сайн дурынхныг бүртгэлд хамруулах уу, хамруулбал хэн, ямар зорилгоор, ямар хугацаагаар бүртгэх, тэдэнд үнэмлэх, бичиг баримт олгох эсэх,</p>	<p>БНСУ</p>	<p>Сайн дурын үйл ажиллагааны менежмент:</p> <p>Сайн дурын үйл ажиллагааны байгууллага, төвүүд нь сургалт, аюулгүй байдлын менежментийг тогтмол хэрэгжүүлэх ёстой бөгөөд сургалтад боловсролын холбогдох байгууллагуудыг дайчлан ажиллуулж болно.</p> <p>Сайн дурын үйл ажиллагааг хөгжүүлэх хороо:</p> <p>Сайн дурын үйл ажиллагааны бодлогыг тодорхойлох үүрэг бүхий Хороог Ерөнхий сайдын дор байгуулж, бүрэлдэхүүнд нь удирдлага, шинжээчдийг оруулна.</p> <p>Сайн дурын үйл ажиллагааны Үндэсний зөвлөл:</p> <p>Сайн дурын үйл ажиллагааны байгууллагууд нь улсын хэмжээнд сайн дурын үйл ажиллагааг зохион байгуулах, хөгжүүлэх зорилгоор Сайн дурын үйл ажиллагааны Үндэсний зөвлөлийг ашгийн бус байгууллагын статустай байгуулж болно. Сайн дурын үйл ажиллагааны Үндэсний зөвлөл нь сайн дурын үйл ажиллагааны төслүүдийг дэмжих, байгууллага хоорондын хамтын ажиллагааг идэвхжүүлэх, олон нийтийн дэмжлэгийг эрэлхийлэх, олон улсын солилцоог бэхжүүлэх, бодлогыг тодорхойлох, эрдэм шинжилгээний ажлыг хэрэгжүүлэх, мэдээлэл солилцох, Засгийн газрын үйл ажиллагааг дэмжих зэрэг үүргийг гүйцэтгэнэ.</p> <p>Сайн дурын үйл ажиллагааны төвүүд: Үндэсний Засгийн Газар нь ашгийн бус байгууллагын статусаар сайн дурын үйл ажиллагааны төвүүдийг байгуулж, санхүүжүүлэх арга хэмжээг авч болно. Сайн дурын үйл ажиллагааны төвийг Удирдах зөвлөл (сангийн хэлбэрээр байгуулсан бол Залуучуудын зөвлөл) удирдах ба НБДНГ-тай байна. Сөүл болон бусад томоохон хотууд, мужуудын сайн дурын үйл ажиллагааны төвүүд дараах үүрэгтэй. Бусад хот, мужийн</p>

		байгууллагууд, бүлгүүдтэй байнгын хамтын ажиллагааны тогтолцоо бий болгох, сайн дурын үйл ажиллагааны менежер, удирдах бүрэлдэхүүнийг сурган бэлтгэх, сайн дурын үйл ажиллагааны хөтөлбөрүүдийг боловсруулах, хэрэгжүүлэх, сайн дурын үйл ажиллагааны судалгаа, шинжилгээ хийх, сайн дурын үйл ажиллагааны мэдээллийн төвүүдийг ажиллуулах, бүс нутгийн төвүүдийн хамтын ажиллагаа, мэдээлэл солилцоог идэвхжүүлэх, төслүүдийг дэмжих, сайн дурын үйл ажиллагааг хөгжүүлэх бусад үйл ажиллагааг хэрэгжүүлэх.
	Македона	<p>Бүртгэл: Тодорхой бус, зөвхөн гадаадын сайн дурынхныг бүртгэх тогтолцоотой мэт.</p> <p>Журам дүрэм: Сайн дурын ажиллагааны хууль (гэрээ байгуулах шаардлага болон талуудын эрх үүргийг тодорхойлсон).</p> <p>Баримт бичгийг хадгалах: Хууль батлагдсанаар сайн дурын ажиллагааны байгууллага нь ажлын тайлан, товхимол гаргах үүрэг хүлээсэн (баримт бичгийг хадгалах эсэхийг тусгаагүй).</p> <p>Мониторинг: Сайн дурын ажилтан ХАБ нь үндсэн үүргээ биелүүлээгүй тохиолдолд торгууль ноогдуулахаар тусгасан.</p> <p>Сайн дурын ажиллагааг дэмжих, мэдээллийг түгээх: Доор дурдав.</p> <p>Судалгаа, шинэчлэл. Стратегийг хэрэгжүүлэх механизм болох сайн дурын ажиллагааны үндэсний зөвлөлийг байгуулах, салбар бүрийн үнэлгээний үзүүлэлтийг үйл ажиллагааны нарийн хөтөлбөрт тусгах</p> <p>Хуулийн заалтууд, төлөвлөсөн арга хэмжээг хэрэгжүүлсэн тухай Хөдөлмөр, нийгмийн бодлогын яам болон сайн дурын ажиллагааны Үндэсний зөвлөлийн жилийн тайлан гаргах болно. Зардлыг төсвөөс гаргана.</p>
	Польш	<p>Мэдээлэлгүй.</p> <p>Хяналт: Нийгмийн аюулгүй байдлыг хариуцсан сайд нь олон нийтийн байгууллагын ажиллагаанд хяналт тавина.</p> <p>Мониторинг ба үнэлгээ:</p> <p>Олон нийтийн ажиллагаа (сайн дурын ажиллагаа хамрагдана) эрхэлдэг төр засгийн байгууллагууд</p>

		<p>нь ажиллагааны мониторинг ба үнэлгээг хийнэ. Үүнд: 1 Ажиллагааны дэвшил 2 Ажиллагааны үр дүн, нөхцөл, чанар 3 Төсөв хөрөнгийн зарцуулалтын байдал 4 Гэрээнд заасан журмын дагуу бүх баримт бичгийг зохих ёсоор хадгална.</p> <p>Тайлагнах зарчим: “Олон нийтийн байгууллага (ТББ) нь өөрийн үйл ажиллагааг холбогдох хуулийн хүрээнд хэрэгжүүлсэн жилийн тайланг боловсруулна”. Сайн дурын ажиллагааг дэмжих хөгжүүлэх, мэдээллийг түгээх талаар тусгаагүй. Байнгын шинэчлэл судалгааны талаар тусгайлан тусгаагүй. “Олон нийтийн байгууллага (ТББ) нь өөрийн үйл ажиллагааг холбогдох хуулийн хүрээнд хэрэгжүүлсэн жилийн тайланг боловсруулна”.</p>
<p>7.Сурталчлах /хүлээн зөвшөөрөх/ Сайн дурын ажиллагааг хөгжүүлэх, дэмжих ямар ажлыг зохион байгуулах вэ? Тухайлбал сайн дурын ажиллагааг хэвлэл мэдээллээр сурталчлах, мэдээллийн компанит ажил, орон нутгийн сургуулиудад танилцуулга, сургалт зохион байгуулах, эцэг эхчүүд болон оюутнуудад сайн дурын ажиллагааны ач тусыг ойлгуулан танилцуулах,</p>	<p>БНСУ</p>	<p>Сайн дурын ажиллагааг дэмжих үндэсний суурь төлөвлөгөө: Засгийн Газрын захиргаа, дотоод хэргийн сайд нь төр засгийн холбогдох төв байгууллагуудын дарга нартай зөвшилцсөний үндсэн дээр Сайн дурын ажиллагааг дэмжих үндэсний суурь төлөвлөгөөг 5 жилд тутам боловсруулж, Сайн дурын ажиллагааг хороогоор хэлэлцүүлнэ.</p> <p>Төлөвлөгөөнд: Сайн дурын ажиллагааг хөгжүүлэх үндсэн чиглэл, Төлөвлөгөөг хэрэгжүүлэх хуваарь, төр, засгийн төв байгууллагуудын хэрэгжүүлэх төлөвлөгөө, төлөвлөгөөг хэрэгжүүлэх санхүүгийн эх үүсвэр, сайн дурын ажиллагааг хөгжүүлэх бусад асуудлуудыг тусгана.</p> <p>Жилийн төлөвлөгөө: 5 жилийн төлөвлөгөөнд үндэслэн төр засгийн холбогдох төв байгууллагууд олон орон нутгийн засгийн газрууд нь жилийн төлөвлөгөөг боловсруулж, гүйцэтгэлийг Засгийн Газрын захиргаа, Дотоод хэргийн сайдад илтгэнэ. Ерөнхий сайд нь хэрэгжилтийн ажиллагааны менежер, удирдах бүрэлдэхүүнийг сурган бэлтгэх, сайн дурын ажиллагааны хөтөлбөрүүдийг боловсруулах, хэрэгжүүлэх, сайн дурын ажиллагааны судалгаа шинжилгээ</p>

<p>хэвлэл, мэдээлэл болон шашны номлолд сайн дурын ажиллагааны талаар ухуулах, менежмент, сургалт, Сайн дурын ажиллагааны Дэлхийн форумыг зохион байгуулах гэх мэт.</p> <p>Сайн дурын менежмент, сургалт зэрэг.</p> <p>Улс орны сайн дурын ажиллагаа, тэргүүн туршлага, хөнгөлөлт,</p>		<p>хийх, сайн дурын ажиллагааны мэдээллийн төвийг ажиллуулах, бүс нутгийн төвүүдийн хамтын ажиллагаа, мэдээлэл солилцоог идэвхжүүлэх төслүүдийг дэмжих, сайн дурын үйл ажиллагааг хөгжүүлэх бусад үйл ажиллагааг хэрэгжүүлэх. Хот бие даасан дүүргийн сайн дурын ажиллагааны төвүүд дараах үүрэгтэй. Бусад хот бие даасан дүүргүүдийн байгууллага, бүлгүүдтэй байнгын хамтын ажиллагааны тогтолцоо бий болгох, сайн дурын ажиллагааг сурталчлах, сайн дурынхныг дайчлах, бэлтгэх, ХАБ-д илгээх сайн дурын ажиллагааны хөтөлбөрүүдийг боловсруулах, дэмжих, хэрэгжүүлэх,</p> <p>Сайн дурын ажиллагааны эрдэм шинжилгээ, судалгаа:</p> <p>Сайн дурын ажиллагааг хөгжүүлэх Хороо нь сайн дурын ажиллагааны эрдэм, шинжилгээ, судалгаа хийлгэх зорилгоор 5 хүртэлх бүрэлдэхүүнтэй зөвлөх шинжээчдийг ажиллуулах</p>
<p>урамшууллын тухай мэдээллийг хэрхэн түгээх вэ?</p> <p>Энэ ажиллагааг хэрхэн санхүүжүүлэх вэ?</p> <p>Энэ ажиллагаа нь бие даасан байдалтай байна уу?</p> <p>Сайн дурын ажиллагааны</p>	<p>Македона</p>	<p>Сайн дурын ажиллагааг хэрэгжүүлэх арга хэмжээ:</p> <p>Сайн дурын ажиллагааг хэрэгжүүлэх телевиз болон радиогийн компанит ажил, мэдээлэл түгээх, Олон Улсын сайн дурынхны өдрийг тэмдэглэх, жилийн шагнал гардуулах, сургуулийн хөтөлбөрт тусгах, оюутнуудыг сайн дурын ажиллагаанд оролцохыг дэмжих, цахим хуудсаар сурталчлах, сургалт зохилон байгуулах төвүүдийг байгуулах, эрдэм шинжилгээ хийх, мэдээллийн сан байгуулах зэрэг өргөн цар хүрээтэй ажиллагааг хэрэгжүүлнэ.</p>
<p>нөлөөллийг ямар үзүүлэлтээр тогтоох вэ?</p>	<p>Польш</p>	<p>Сайн дурын ажиллагааг хөгжүүлэх талаар тусгайлан дурьдаагүй.</p> <p>Сайн дурын ажиллагааг хөгжүүлэх орчинг бүрдүүлэх:</p> <p>“Холбогдох хуульд заасны дагуу олон нийтийн байгууллагууд нь радио телевизээр өөрийн ажиллагааг төлбөргүй суралчлах цагтай байна.</p> <p>Сайн дурын ажиллагааг хүлээн зөвшөөрөх талаар тусгайлан дурьдаагүй.</p>

Хүснэгт 6., Сайн дурын үйл ажиллагааны хууль, тогтоомжийн дүн шинжилгээ.⁶⁴

Хүснэгт 6-д тусгаснаар сайн дурын үйл ажиллагааны үндэсний хууль тогтоомжийн дүн шинжилгээнээс үзэхэд БНСУ, Македона, Польш улсын сайн дурын үйл ажиллагааг дэмжих хууль эрх, зүйн зохицуулалт нь улс бүрийн онцлогоос хамааран харилцан адилгүй байна. Сайн дурын үйл ажиллагааны талаар эдгээр улсуудад мөрдөгдөж байгаа хуулийн заалтуудыг хооронд нь харьцуулж шинжлэхийн зэрэгцээ манай улсын онцлогт нийцүүлэн авч хэрэгжүүлэх боломжтой талаас нь судалж, дараах дүгнэлтэд хүрлээ. Үүнд:

1. БНСУ-ын хуулийн зорилго, хамрах хүрээний хувьд сайн дурын үйл ажиллагааг хөгжүүлэх, сайн дурын үйл ажиллагаанд санхүүгийн болон захиргааны байнгын дэмжлэг үзүүлэхийг тусгасан бол Македона улсын хуульд сайн дурын үйл ажиллагаа, үйл ажиллагаанд оролцох нөхцөл, арга хэлбэр, байгуулах гэрээ болон тайлан илтгэлийг зохицуулах, журамлах, амьдралын түвшнийг дээшлүүлэх, ард иргэдийн нийгмийн амьдралын оролцоог нэмэгдүүлэхийг онцолсон. Польш улсын хуульд олон нийтийн ашгийн төлөө ТББ-ын ажиллагаа, тэдний статус, олон нийтийн захиргаатай хамтран ажиллах, хяналт тавих, сайн дурын үйл ажиллагааг хэрэгжүүлэх нөхцөл болон ашиглах чиглэлийг тусгаж, ТББ-ын болон олон нийтийн байгууллагын захиргааны үйл ажиллагаанд сайн дурынхны оролцоог хангахаар тус тус тусгажээ.

2. Сайн дурын үйл ажиллагааг тодорхойлох асуудлын хүрээнд БНСУ-ын хуульд сайн дурын үйл ажиллагаанд баримтлах зарчмыг тусгаад, сайн дурын ажилтан, сайн дурын үйл ажиллагаа, сайн дурын байгууллага, сайн дурын үйл ажиллагааны төв зэрэг 4 төрлийн субъектийн тодорхойлолтыг нарийн зааж, улс төрийн сонгуулийн компанит ажлын үед үйл ажиллагааны хязгаарлалтыг зааж өгсөн давуу талтай байна. Харин Польш улсын хуульд сайн дурын ажилтанд тавигдах шаардлагыг илүү нарийвчлан тусгаж, ТББ болон бусад байгууллагуудад хууль ёсны ажиллагаа, ялангуяа олон нийтийн ашгийн төлөө үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх, чингэхдээ бизнесийн үйл ажиллагаа (ашиг олох зорилгоор) -нд оролцохгүй гэж тусгасан.

⁶⁴ Монгол Улс дахь Сайн дурын ажиллагааны Үндэсний хөтөлбөрийн үзэл баримтлал Зөвлөмж бичиг.Уб., 2013, 76-90 дэх тал.

3. Сайн дурын ажилтантай гэрээ байгуулах, нөхөн олговор олгох талаар Македона улсын хуульд сайн дурын ажилтан нь сард 40-өөс илүү цаг ажиллах нөхцөлд гэрээ байгуулах гэж, Польш улсын хуульд сайн дурын ажилтан нь 30-аас дээш хоногийн хугацаагаар ажиллах тохиолдолд бичгээр гэрээ байгуулна гэж албан ёсны болох хугацааг тодорхойлсноороо ялгаатай байна гэж үзэж байна.

4. Сайн дурын ажилтны эрх, үүргийн талаар БНСУ-ын хуульд заалт тусгагдаагүй, харин Македона улсын хуульд заахдаа: үйл ажиллагаанд шаардлагатай сургалтад хамрагдах, мэдээлэл, заавар зөвлөгөө авах, амралт, чөлөө эдлэх, хувийн мэдээллээ хамгаалуулах гэж сайн дурын ажилтны эдлэх эрхийн хэмжээг тусгасан ба сайн дурын ажилтны хүлээх үүргийн тухайд ажил үүргээ гэрээ, холбогдох хууль, дүрэм журмын хүрээнд гүйцэтгэх, байгууллагын үүргийн тухайд сайн дурын ажилтныг ажиллах нөхцөлөөр хангах, ажиллах үүргээ гүйцэтгэхэд шаардлагатай материал хэрэгслээр хангах, мэргэжлийн өвчин, ажлын ослын даатгал олгох, харилцан тохирсон бол эрүүл мэндийн даатгал, тахир дутуугийн тэтгэлэг олгох зэргээр тусгажээ.

5. Сайн дурын ажилтны урамшуулал, хамгаалалтын талаар БНСУ-ын хуульд: сайн дурын үйл ажиллагааны төвүүдийг аюултай нөхцөлд ажиллаж байгаа хүмүүсийг хамгаалах арга хэмжээ, тухайлбал сургалт явуулж болно. Сайн дурын ажилтны биед нь гэмтэл учруулах, эдийн засгийн хувьд хохирох, гуравдагч этгээдийн бие хөрөнгөд хохирол учруулах зэргээс хамгаална гэж, Македони улсын хуульд сайн дурын үйл ажиллагааг дэмжих компанит ажлыг зохион байгуулах, хэвлэл, мэдээллийн байгууллагатай байнгын харилцаа тогтоох, Сайн дурынхны өдрийг тэмдэглэх, “Оны тэргүүний ажилтан” үндэсний шагнал бий болгох, оюутнуудыг сайн дурын үйл ажиллагаанд оролцох механизмыг их дээд сургуулиудад бий болгох, сайн дурын үйл ажиллагааны оролцооны түвшнийг дээшлүүлэх, сайн дурын үйл ажиллагааг дэмжих, хөгжүүлэх төсөл, хөтөлбөрт санхүүгийн туслалцаа үзүүлэх, төрийн байгууллагуудын сайн дурынхантай ажиллах чадавхыг нэмэгдүүлэх, залуучуудыг сайн дурын үйл ажиллагаанд оролцох боломжийг нэмэгдүүлэхээр тусгаж, урамшууллын механизмыг хөгжүүлэх бодлого барьж байгаа нь харьцуулсан судалгаанаас харагдаж байна.

6. Сайн дурын үйл ажиллагааны менежментийн талаар БНСУ хуульд Сайн дурын үйл ажиллагааны байгууллага, төвүүд нь сургалт, аюулгүй

байдлын менежментийг тогтмол хэрэгжүүлэх ёстой бөгөөд сургалтад боловсролын холбогдох байгууллагуудыг дайчлан ажиллуулж болно. Сайн дурын үйл ажиллагааны бодлогыг тодорхойлох үүрэг бүхий Хороог Ерөнхий сайдын дор байгуулж, бүрэлдэхүүнд нь удирдлага, шинжээчдийг оруулна. Сайн дурын үйл ажиллагааны байгууллагууд нь улсын хэмжээнд сайн дурын үйл ажиллагааг зохион байгуулах, хөгжүүлэх зорилгоор Сайн дурын үйл ажиллагааны Үндэсний зөвлөлийг ашгийн бус байгууллагын статустай байгуулж болно. Энэ зөвлөл нь сайн дурын үйл ажиллагааны төслүүдийг дэмжих, байгууллага хоорондын хамтын ажиллагааг идэвхжүүлэх, олон нийтийн дэмжлэгийг эрэлхийлэх, олон улсын солилцоог бэхжүүлэх, бодлогыг тодорхойлох, эрдэм шинжилгээний ажлыг хэрэгжүүлэх, мэдээлэл солилцох, Засгийн газрын үйл ажиллагааг дэмжих зэрэг үүргийг гүйцэтгэнэ.

Үндэсний Засгийн Газар нь ашгийн бус байгууллагын статусаар сайн дурын үйл ажиллагааны төвүүдийг байгуулж, санхүүжүүлэх арга хэмжээг авч болно. Сайн дурын үйл ажиллагааны төвийг Удирдах зөвлөл (Сангийн хэлбэрээр байгуулсан бол Залуучуудын зөвлөл) удирдах ба НБДНГ- тай байна гэж хуульдаа тусгаж, Сөүл болон бусад томоохон хотууд, мужуудын сайн дурын үйл ажиллагааны төвүүд нь бусад хот, мужийн байгууллагууд, бүлгүүдтэй байнгын хамтын ажиллагааны тогтолцоо бий болгох, сайн дурын үйл ажиллагааны менежер, удирдах бүрэлдэхүүнийг сурган бэлтгэх, сайн дурын үйл ажиллагааны хөтөлбөрүүдийг боловсруулах, хэрэгжүүлэх, сайн дурын үйл ажиллагааны судалгаа, шинжилгээ хийх, сайн дурын үйл ажиллагааны мэдээллийн төвүүдийг ажиллуулах, бүс нутгийн төвүүдийн хамтын ажиллагаа, мэдээлэл солилцоог идэвхжүүлэх, төслүүдийг дэмжих, сайн дурын үйл ажиллагааг хөгжүүлэх бусад үйл ажиллагааг хэрэгжүүлэхээр хуульчилсан нь бусад орны хуулийн заалтыг бодвол сайн дурын үйл ажиллагааны дэд бүтэц дээр илүү анхаарсан байгаа нь судалгааны дүнгээс харагдаж байна.

7. Сайн дурын үйл ажиллагааг сурталчлах, хүлээн зөвшөөрөх талаар БНСУ-ын хуульд сайн дурын ажиллагааг дэмжих үндэсний суурь төлөвлөгөөг 5 жилд тутам боловсруулж, хороогоор хэлэлцүүлнэ. Төлөвлөгөөнд сайн дурын ажиллагааг хөгжүүлэх үндсэн чиглэл, төлөвлөгөөг хэрэгжүүлэх хуваарь, төр, засгийн төв байгууллагуудын хэрэгжүүлэх төлөвлөгөө, санхүүгийн эх үүсвэр, сайн дурын ажиллагааг хөгжүүлэх бусад асуудлуудыг тусгахаар хуульчилжээ. Македона улсын

хуульд Сайн дурын ажиллагааг хэрэгжүүлэх телевиз болон радиогийн компани ажил, мэдээлэл түгээх, Олон Улсын сайн дурынхны өдрийг тэмдэглэх, жилийн шагнал гардуулах, сургуулийн хөтөлбөрт тусгах, оюутнуудыг сайн дурын ажиллагаанд оролцохыг дэмжих, цахим хуудсаар сурталчлах, сургалт зохион байгуулах төвүүдийг байгуулах, эрдэм шинжилгээ хийх, мэдээллийн сан байгуулах зэрэг өргөн цар хүрээтэй ажиллагааг хэрэгжүүлэхээр тусгасан. Польш улсын сайн дурын үйл ажиллагааг дэмжих хуульд сайн дурын үйлсийг сурталчлах талаар холбогдох хуульд заасны дагуу олон нийтийн байгууллагууд нь радио телевизээр өөрийн ажиллагааг үнэ төлбөргүй сурталчлах цагтай байна гэж тусгасан.

Эндээс дүгнэлт хийхэд сайн дурын үйл ажиллагааны сурталчилгааг үнэ төлбөргүй явуулах, үндэсний суурь төлөвлөгөөг 5 жилээр баталж, үр дүнг нь хэлэлцдэг, оюутан, залуусын оролцоог дэмжих, эрдэм шинжилгээний ажил хийх, нэгдсэн мэдээллийн сантай болох зэрэг асуудлыг хуульдаа тусгасан нь авууштай туршлага байна гэж үзэж байна.

Сайн дурын үйл ажиллагааны бүтэц, зохион байгуулалт, үйл ажиллагааны чиглэлийн талаар.

Сайн дурын үйл ажиллагааг эрхлэх бүтэц нь улс орон бүрд өөр өөр байна. Ихэнх орнуудад сайн дурын ажлыг хөгжүүлэх “Үндэсний төв”, “Үндэсний Зөвлөл”, “Сайн дурын ажлын хөгжлийн зөвлөл”, “Үндэсний хороо” гэх мэт нэртэй Засгийн газар, иргэний нийгмийн төлөөлөл, сайн дурын ажлаар мэргэшсэн зөвлөхүүдээс бүрдсэн 15-19 хүний бүрэлдэхүүнтэй зөвлөл, зарим улсад сайн дурын үйлчилгээг хариуцсан агентлаг, яам тусгай албаны зохион байгуулалттайгаар зохион байгуулагдан үйл ажиллагаа явуулж байна.

Австрали, Аргентин, Барбадос, Бразил, Хорват, Кипр, Египет, Эл Сальвадор, Люксембург, Өмнөд Солонгос, Украин гэх мэт улсуудад “Үндэсний сайн дурынхны төв”⁶⁵-үүд шинээр үүсэн бий болж, үндэсний хэмжээнд сайн дурын ажлыг хөхүүлэн дэмжиж, эрх зүйн зохицуулалтыг ханган, мэдээлэл сурталчилгаа, боловсролын чиглэлээр үйл ажиллагаа явуулж байна.. Тайланд улсад муж бүрд нэг байхаар нийт 75 үндэсний төв байгуулагдан ажиллаж байна⁶⁶. “Үндэсний сайн дурынхны төв” нь сайн дурын ажлын эрх зүйн зохицуулалттай ч бай, зохицуулалтгүй ч бай аль ч

⁶⁵Laws and Poicies affecting volunteerism since 2001.

⁶⁶ A/57/352 para 28.

улс оронд Засгийн газар, иргэний нийгмийг холбосон гүүр нь болон ажиллаж, сайн дурын үйлсийг хөгжүүлэх, сайн дурынхны ажлыг дэмжсэн үр дүнтэй механизм болдгоороо ач холбогдолтой байгаа нь олон улсын туршлагаас харагдаж байна.

Хорват улсад 2007 онд батлагдсан “Сайн дурын үйл ажиллагааны тухай хууль”-д *Сайн дурын ажлыг хөгжүүлэх “Үндэсний зөвлөл” нь төр, иргэний нийгмийн төлөөлөл, мэргэжсэн сайн дурын зөвлөхүүдээс бүрдсэн 19 хүний бүрэлдэхүүнтэй* байгуулагдаж, үйл ажиллагаа явуулж байхад **Англи улсад** *Сайн дурын ажлын хөгжлийн зөвлөл* байгуулагдаж, сайн дурын ажлын чиглэлээр засгийн газрын бодлогыг хэрэгжүүлж, Засгийн газар болон сөрөг хүчний намтай хамтран ажилладаг. **Филиппин** улсад байгуулагдсан *Сайн дурын үйлчилгээг зохицуулах үндэсний агентлаг* нь орон нутгийн хөгжил, Сайн дурын ажлыг хөгжүүлэх, бусад зорилгыг хэрэгжүүлэх стратегийг институцичлах тухай хуулийн хэрэгжилтийг хангаж, бодлого боловсруулах, сайн дурын байгууллагуудын хүчин чадлыг бэхжүүлэх, мэргэжлийн зөвлөгөөгөөр хангах ажлыг хэрэгжүүлдэг байна. **Норвеги улс** нь сайн дурын ажил явуулж байсан уламжлалаараа олон талын туршлагатай бөгөөд Олон Улсын түвшинд зохион байгуулалттай, сайн дурын ажлыг хамгийн өндөр түвшинд явуулж буй улсуудын нэг гэж үздэг. 2014 онд Норвегийн Засгийн газар “Сайн Дурын Ажлын Тунхаглал”-ыг баталж, нийгмийн оролцоог дэмжихэд сайн дурын салбарын ач холбогдлыг үнэлж буй дээд шатны бодлогын баримт бичиг болж, Олон Улсад туршлага болон хэрэгжиж, Засгийн Газар болон сайн дурын салбар хоорондын харилцаан дахь урт хугацааны төлөвлөгөөг дэмжих зорилготой судалгаа ба менежментийн ач холбогдолтой⁶⁷ хэмээн Олон улсад үнэлэгдсэн байна. **Латви улс.**⁶⁸ Сайн дурынхан болон сайн дурын ажил зохион байгуулахад шаардагдах мэдээлэл, дата бааз, хууль эрх зүйн зохицуулалт зэрэг нөөцийг багтааж, сайн дурын хөдөлгөөнийг амжилттай зохион байгуулахад чухал шаардлагатай болох дараах элементүүдийг сайн дурын хөдөлгөөний бүтцэд тооцож, хэрэгжилтийг хангуулдаг улсын нэг юм. Сайн дурын хөдөлгөөний дэд бүтцийг дараах чиглэлээр түлхүү хөгжүүлж, **Нээлттэй оролцох боломж: Хүчин чадал: Олон нийтийн санаа бодол:** зэрэгт илүүтэй анхаарал хандуулж, сайн дурынхны үйл ажиллагааг зохицуулах тусдаа

⁶⁷ Дэлхийн сайн дурын үйл ажиллагааны төлөв байдлын тайлан. Засаглалыг өөрчлөх нь. Уб., 2015.38 дахь тал.

⁶⁸ Laws and Poicies affecting volunteerism since 2001.

хууль байхгүй ч гэсэн сайн дурын үйл ажиллагаа явуулах орчныг бүрдүүлж, ард иргэдэд сайн дурын үйл ажиллагааны талаар нэгдсэн ойлголт өгөх, тухайн ажлын ач холбогдлыг ойлгуулах талаар ихээхэн туршлага хуримтлуулсан байна.

Сайн дурынханд үзүүлэх хөнгөлөлт, урамшууллын талаар .Шинэ Зеланд улсад “Олон нийт ба Засгийн газрын харилцааг хөгжүүлэхэд чиглэсэн Засгийн газрын тогтоол” гэх мэт хэд хэдэн хууль эрх зүйн баримт бичиг батлагдсанаар албан ёсны сайн дурын ажил ихээхэн өргөжиж, сайн дурынхан нь осол, гэмтлийн даатгалд албан ёсоор даатгуулагдаж, сайн дурынхны эрх, үүргийн талаарх сургалтад хамрагдаж, оюутны сургалтын зээлийн хөнгөлөлт зэрэг урамшуулал хүртэх эрхтэй болсон, **Боливи улсад** 2005 онд батлагдсан №3314 дугаартай хуульд сайн дурынхны эдлэх эрхийг тодорхой тусгаж, гал, түймрийн аюул болон түүнд нэрвэгдэгсдэд туслах, авран хамгаалах ажилд оролцож байгаа сайн дурын оюутнуудад кредит цаг тооцох, **Буркина Фасо** улсын №031-2007/AN дугаартай сайн дурын үйл ажиллагааг дэмжих хуульд сайн дурынхны ажиллах нөхцөлийн эрүүл мэнд, аюулгүй байдлын стандарт болон үндэсний хөтөлбөр батлагдаж, нэг жилийн хугацаанд сайн дурын ажил, үйлчилгээ үзүүлсэн сайн дурынхныг хугацаат цэргийн албанаас чөлөөлөх хөнгөлөлт үзүүлэхээр тус тус заасан байна.

ХБНГУ-д 2011 онд Холбооны сайн дурын албаны тухай хууль баталж, нийтийн сайн сайхны төлөө, нийгэм, экологи, соёл, спорт, иргэний болон гамшгаас хамгаалах үйл ажиллагаанд оролцсон сайн дурын ажилтны төлөх шимтгэлийн хэмжээг 2017 оны 1-р сарын 1-ний өдрөөс эхлэн тэтгэврийн даатгалыг 18,7%, эрүүл мэндийн даатгалыг 14,6%, халамжийн даатгалыг 2,5% -аар тус тус тооцож улсаас хариуцахаар болсон, **Их Британид** Төрийн албан хаагч болон корпорацуудын сайн дурын ажилтны оролцоог дэмжиж, төрийн яамдын албан хаагчдыг жил бүр 2-5 хоногийн цалинтай чөлөө олгож, сайн дурын ажилд оролцуулж, нийгэм дэх манлайлал, нэр хүндийг нь өсгөж, олон нийтэд ил тод мэдээлдэг. Мөн парламентын гишүүдийг гадаадын чанад дахь сайн дурын байгууллага (VSO)-д дэмжлэг үзүүлэх, ядуурлыг бууруулахад гадаадын тусламжийн үүргийг таниулах зорилгоор богино хугацаагаар сайн дураар ажиллахыг Засгийн Газраас уриалдаг байна.

Сайн дурын үйл ажиллагааг хүлээн зөвшөөрүүлэх, дэмжих, туслах чиглэлээр улс орнуудад хэрэгжүүлж байгаа бодлого, үйл ажиллагааны

туришлага. **Ливан улсад** Олон улсын сайн дурынхны өдрийг тэмдэглэх, хэвлэл мэдээллийн хэрэгслээр сурталчлах, хэвлэл мэдээллийн ажилтнууд, сэтгүүлчдэд сургалт зохион байгуулах, мэдээлэл сурталчилгааны аян зохион байгуулах, сайн дурын үйл ажиллагааг үндэсний сургалтын хөтөлбөрт оруулах, **ОХУ**-д Ерөнхий боловсролын сургуулийн хөтөлбөрт сайн дурын үйл ажиллагааны талаар сургалтын хөтөлбөр оруулах, **Саудын Арабт** олон орны төлөөлөгчдийг урьж оролцуулан “Сайн дурын үйл ажиллагааны дэлхий нийтийн чуулга” уулзалтыг эх орондоо зохион байгуулах, сайн дурынхны удирдлагын сургалт, чадавхыг бэхжүүлэх хөтөлбөр, сайн дурын үйлсийн онцгой жишээнүүдийн судалгаа, шилдэг туршлагын талаар мэдээлэл цуглуулах, чиглэл бүрийн сайн дурын оролцоотой байгууллага, сайн дурын ажиллагаанд оролцох боломжийн талаар мэдээллийн сан бүрдүүлэх, сайн дурын ажиллагааны талаар товхимол гаргаж хуулийн зохистой хэрэгжилтэд дэмжлэг үзүүлэх гэх мэт улс орны шилдэг туршлагуудыг нэрлэж болно.

Нийгмийн эмзэг давхаргын хүмүүс сайн дурын үйл ажиллагаанд идэвхтэй оролцож байгаа сайхан жишээ **Монгол улсад** олон байгааг “Монголын сайн дурын үйл ажиллагааны нөхцөл байдлын үнэлгээ ба зөвлөмж” тайланд дурджээ. Тухайлбал, Монголын эмэгтэйчүүдийн сан өмнө нь гэр бүлийн хүчирхийлэлд өртөгсдөд үзүүлдэг тусламжид хамрагдсан эмэгтэйчүүдийг бусдадаа туслах сайн дурын ажилд оролцуулдаг байна. Өөрсдийн туулсан амьдралын гашуун сургамж туршлага нь бусдыг ойлгох, тэдэнд туслахад илүү дөхөм байдаг байна. Түүнчлэн Хөгжлийн Бэрхшээлтэй Иргэдийн Мэргэжлийн Сургалт, Нөхөн Сэргээх Үндэсний Төв, Хараагүйчүүдийн нийгэмлэг, Тэргэнцэртэй Иргэдийн Холбооны зохион байгуулсан хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд туслах сайн дурын үйл ажиллагаанд хөгжлийн бэрхшээлтэй иргэд сайн дураараа оролцсон жишээ олон байна.

Олон улс дахь сайн дурын үйл ажиллагааны эдийн засаг, нийгмийн ач холбогдол. Зарим улс, оронд сайн дурын үйл ажиллагаа нь тухайн улсын дотоодын нийт бүтээгдэхүүний өсөлтөд тодорхой хэмжээгээр нөлөөлөхүйц эдийн засгийн ач холбогдолтой байдаг. Тухайлбал АНУ-д сайн дурын салбарт 9 сая хүн ажиллаж, жилд 225 тэрбум доллар зарцуулдаг төдийгүй, 32% орчим нь шашны байгууллагад, 25,7% нь соёл, спортын салбарт, 19,2% нь боловсролын салбарт сайн дурын ажил хийдэг ба насны хувьд сайн дурынхны ихэнх нь 35-44 насныхан байна. Канадын 15 –с дээш насны хүн

амын 88% нь буюу 21 сая шахам залуучууд сайн дурын үйлсэд оролцож, буяны ба ашгийн бус байгууллагад хөрөнгө санхүү, нинжин сэтгэлээ, 7,5 сая залуучууд цаг зав, ур чадвараа зориулж, жилд дунджаар бусдын сайн сайхны төлөө нэг тэрбум гаруй цагийг зарцуулдаг байна. Их Британид нийт хүн амын бараг тэн хагас нь сайн дурын хөдөлгөөнд хамрагдаж, жил бүр 140 гаруй үндэстний 450 орчим НҮБ-ын сайн дурын ажилтнууд дэлхийн 150 гаруй орнуудад хүрэлцэн очиж ажилладаг байна.

Австрали улсад 2019 онд албан ёсны сайн дурын үйл ажиллагааны 98,3% -д сайн дурынхан биечлэн, 8,5% -д нь интернэтээр, 9,5%-д нь утсаар оролцсон бол 2020 онд сайн дурынхны 96,6% нь биечлэн, 17,3% нь интернэтээр, 13,9% нь утсаар сайн дурын ажил хийсэн нь интернэт болон утсан харилцаагаар хийх сайн дурын ажил өссөн байгаа нь шинэ технологи, интернэтийн хурдацтай тархалт нь сайн дурын ажлыг төрөлжүүлж, хувь хүмүүст илүү хүртээмжтэй болгож, олон сайн дурын байгууллагууд онлайн харилцааг стратегиа болгон ашиглаж, нийгмийн тогтвортой хөгжлийг хангаж, улс орны нийгэм, эдийн засгийн хөгжилд үнэлж баршгүй хувь нэмэр оруулдаг байна.

Залуучуудын олон улсын шагнал. Залуучуудын олон улсын шагнал нь 14-25 насны залуучуудад өөрийгөө хөгжүүлэхэд тусалдаг хөтөлбөр юм. Нийт 130 орны 7 сая идэр залуучууд шагналын болзол хангахаар оролцож, бие бялдар хөгжүүлэх, амралт чөлөөт цагийн үйл ажиллагаа, ур чадвараа хөгжүүлэх, сайн дурын ажлыг тодорхой хугацаанд хийсэн байх зэрэг болзол багтсан. Эдгээр болзлыг ямар түвшинд хангаснаас хамааран алт, мөнгө, хүрэл гэсэн шагнал олгодог. Зарим улс оронд шагналыг Төрийн тэргүүн буюу Улсын ерөнхийлөгч ивээн тэтгэдэг байна. Сайн дурын байгууллагууд энэхүү шагналын хөшүүргийг ашиглан залуучуудын зохистой үйл ажиллагааны хөтөлбөр хэрэгжүүлэх боломжтой.

1965 он. Улаан Загалайн Олон Улсын 20—р бага хурлын 18 дугаар тогтоол. "Яаралтай тусламжийн үйл ажиллагааг олон улсад хэрэгжүүлэх" баримт бичиг баталсан.

1969он Улаан Загалайн Олон Улсын 21 —р Бага хурал. "Гамшгийн нөхцөл байдал энгийн иргэдэд үзүүлэх Олон улсын хүмүүнлэгийн тусламжийн зарчмууд" Тунхаглыг баталсан.

1977он НҮБ — ын Ерөнхий Ассамблейн тогтоол № 32/56. Олон Улсын "Яаралтай тусламжийг шуурхай хэрэгжүүлэх арга хэмжээ" — г баталсан.

1988он НҮБ — ын Ерөнхий ассамблейн тогтоол № 43/131. "Байгалийн гамшиг болон түүнтэй адилгах онцгой байдлын үед хохирогчдоо үзүүлэх хүмүүнлэгийн тусламжийг зохин байгуулах" тухай тогтоол баталсан.

1990он НҮБ байгалийн гамшигт бууруулах олон улсын арван жилийг тунхаглав.

1991он НҮБ — ын Ерөнхий Ассамблейн тогтоол № 46/182 тогтоол. Гамшгаас урьдчилан сэргийлэх, бэлэн байдал, хариу арга хэмжээ авах, нөхөн сэргээх чиглэгдсэн. "Байгалийн гамшиг болон онцгой байдлын үед үзүүлэх хүмүүнлэгийн тусламжийн зохицуулалт" — ийн бодлогыг баталсан.

1994он ОУУЗ, УХСН — үүдийн Холбоо. Олон улсын Улаан Загалай, Улаан хавирган сар хөдөлгөөний болон Төрийн бус байгууллагуудын "Гамшгаас хамгаалах үйл ажиллагааны дүрэм" — ийг баталсан.

1994он Улаан Загалай Хөдөлгөөн ба ТББ — уудын Гамшгийн яаралтай тусламжийн үед баримтлах ёс зүйн хэм хэмжээний минимум стандартыг баталсан.

1994он Байгалийн гамшигт бууруулах Дэлхийн 1 —р бага хурал нь Екохама стратеги, түүний үйл ажиллагааны төлөвлөгөөг баталсан.

2002он НҮБ — ын Ерөнхий ассамблейн тогтоол № 57/150 "Гамшгийн үнэлгээ, зохицуулалт нь гэнэтг үүссэн онцгой байдлын үед улс орнуудын Засгийн газарт эхний үед яаралтай тусламж үзүүлэх" тухай тогтоол баталсан.

ОЛОН УЛСЫН ГАМШГААС ХАМГААЛАХ БОЛОН ЯАРАЛТАЙ ТУСЛАМЖИЙН ЧИГЛЭЛЭЭР ГАРСАН БОДЛОГЫН БАРИМТ БИЧГИЙН ТҮҮХЭН ХӨГЖИЛ

2004он Улаан Загалай, улаан хавирган сар нийгэмлэгүүдийн холбоо. Нэмэлт өөрчлөлт оруулсан сфер төслийн Хүмүүнлэгийн тунхаглаа, гамшгийн яаралтай тусламжийн минимум стандарт.

2005он Гамшгийг бууруулах Дэлхийн 2 —р бага хурал гамшгийн эрсдэлийг бууруулах зорилгоор 2005 — 2015 оны Хөтөлгөөн үйл ажиллагааны хөтөлбөрийг баталсан.

2007он Улаан Загалайн хөдөлгөөний 30 —р бага хурал 140 орны төлөөлөгчидтэй санал нэгтгэж "ОУ — ын гамшгийн яаралтай болон нөхөн сэргээх анхан шатны тусламжийг улс орны дотоодоо дэмжих болон зохицуулах удирдамж" баталсан.

2016он "Гамшгийн эрсдэлийг бууруулах Азийн сайд нарын анхдугаар бага хурал" — аас Гамшгийн эрсдэлийг бууруулах чиглэлээр 2015 — 2030 онд хэрэгжүүлэх Сендайн үйл ажиллагааны хүрээ" баримт бичгийг хэрэгжүүлэх Азийн бүс нутгийн төлөвлөгөө, Делигийн тунхаглыг батлав.

2018он Монгол улс. "Гамшгийн эрсдэлийг бууруулах Азийн сайд нарын II бага хурал" — аас "Улаанбаатар тунхаглах" баримт бичиг баталсан.

2020он. Азийн гамшгийн аюулыг бууруулах төвөг "Гамшгийн эрсдэлийг бууруулах Азийн бага хурал — 2020" — ыг зохин байгуулаж, Ази Номхон далайн бүсийн үйл ажиллагааны 2021 — 2024 оны төлөвлөгөөг боловсруулан баталсан.

1.3. Гамшгаас хамгаалахад сайн дурынхны үйл ажиллагаа.

“Гамшиг” гэж аюулт үзэгдэл, ослын улмаас олон хүний амь нас, эрүүл мэнд хохирох, мал, амьтан олноор хорогдох, эд хөрөнгө, түүх соёлын дурсгалт зүйл, хүрээлэн байгаа орчинд улс болон орон нутгийн эдийн засаг, нийгмийн дотоод нөөц боломжоос давсан хохирол учрахыг хэлнэ”⁶⁹ гэж, Оксфордын толь бичигт гамшиг гэх ойлголтыг “гэнэтийн осол, байгалийн аюулт үзэгдлийн улмаас их хэмжээний хохирол учрах, хүний амь нас хохирох” гэж тодорхойлсон байна.

Гамшиг ослын үеийн сайн дурын ажлын тодорхойлолтын талаар Судлаач Снайдер ба Омото нар “гамшиг, осол болсон тохиолдолд урьдчилсан төлөвлөх, таамаглах боломж тун хомс байдаг бөгөөд ихэнхдээ түргэн шуурхай, шууд газар дээр үзүүлэх тусламж үйлчилгээ шаардлагатай байдаг”⁷⁰ гэсэн байна. Тэдгээрийн судалгаанаас харахад гамшиг, ослын үед тусламж үйлчилгээ үзүүлж буй иргэдийн оролцоог зүгээр нэг түр зуурын тусламжийн ажлаас (bystander intervention) илүү өргөн хүрээнд авч үзэх нь зүйтэй юм.

Гамшиг, осолтой холбоотой тодорхойлолтууд нь сайн дурынхныг хэрхэн тодорхойлох хийгээд тэдний мотивацийг авч үзэхээсээ илүүтэй хийж буй ажлууд болон үр дүнд нь илүү төвлөрсөн байдаг. ХХ зууны 60, 70-аад оны үед хийгдсэн гамшгийн үеийн сайн дурын ажлын талаарх нийтлэлүүдэд, тухайлбал, Шасколский сайн дурын ажлыг тодорхойлохдоо, тухайн ажлыг хийж буй этгээдийн ашиг сонирхлоос үл хамааран хэсэг хүмүүс, эсвэл үйл хэргийн төлөө хийж буй шууд болон шууд бус аливаа үйл ажиллагааг хамааруулсан байна.⁷¹ Мөн Воленски хэлэхдээ сайн дурын ажил бол “гэнэтийн болон зохион байгуулалттай ямар ч бүтэцтэй байх нь хамаагүй, урамшуулал үл горилон, өөрийн хүслээр хийж буй, аливаа хүн эсвэл бүлгийн хүсэл сонирхол, нэн тэргүүний шаардлагатай байгаа хэрэгцээг сэргээхэд чиглэгдсэн үйл ажиллагаа юм”⁷² гэж тодорхойлсон байна.

⁶⁹ Монгол Улсын гамшгаас хамгаалах тухай хууль.

⁷⁰ M.Snyder, A.M.Omoto, Volunteerism: social issues perspectives and social policy implications, Soc.Issues Policy Rev. 2(1) (2008)1-36

⁷¹ L.Shaskolsky, Volunteerism in disaster situations. Preliminary paper no.1. Disaster Research Center, University of Delaware. Delaware. 1967

⁷² R.P.Wolensky, Toward a broader conceptualization of volunteerism ny disaster, Nonprofit Volunt. Sect.Q.8 (1979) 33-42.

Шасколскийн тодорхойлсноор гамшгийн нөхцөл байдалд 4 төрлийн сайн дурынхнаар дамжиж үйл ажиллагаа явагддаг. Тэрээр:

- 1 *Танигдсан сайн дурынхан (Anticipated individual volunteers)* нь нийгмийн зүгээс хүсэн хүлээж буй нийтлэг хэрэгцээг хувь хүний зүгээс гүйцэтгэх. Тухайлбал, гамшигт өртсөн хүмүүст эмч, сургаж бэлтгэгдсэн сайн дурынхан хамгийн түрүүнд туслахаар ирдэг.
- 2 *Танигдсан байгууллагын гишүүд, сайн дурынхан* нь албан ёсны байгууллагад бүртгэлтэй, сургалтанд хамрагдсан, үүрэг оролцоо нь тодорхой хэсэг бүлэг хүмүүс байдаг. (Тухайлбал, Улаан Загалмайн идэвхтнүүд, сайн дурынхан гэх мэт).
- 3 *Шинээр үүссэн албан бус сайн дурынхан (Spontaneous individual volunteers)* гэж үүссэн нөхцөл байдалд өөрийн хүсэлтээр туслахаар ирсэн хүмүүсийг хэлнэ. Тэд ихэнхдээ эрэл хайгуулын ажилд оролцох, хог зэм цэвэрлэх зэрэг ажилд оролцдог.
- 4 *Шинэ байгууллагын сайн дурынхан* нь гамшиг, осол болсон үед аль нэг зохион байгуулалттай байгууллагаас үзүүлж буй тусламжийн үйл ажиллагаанд оролцож, үүрэг гүйцэтгэж буй хүмүүс юм. Эдгээр сайн дурынхан нь гамшгийн тусламжийн үйл ажиллагаанд туслах буюу шинээр байгууллага үүсгэж оролцох, гамшгийн тусламж үзүүлэхээр үйл ажиллагаанд мэргэшээгүй ч өмнө нь байгуулагдсан байгууллагаар дамжуулан оролцох, мөн албан бус сүлжээгээр дамжуулан үйл ажиллагаанд оролцох гэх мэт төрлүүдээс сонгон ажиллаж болдог байна.

Воленский⁷³ мөн дээрх байдлаар гамшгийн дараах сайн дурын ажиллагааг 4 төрөлд хуваасан.

1 *Олон нийтийн хэрэгцээ, сонирхлын төлөө үүссэн сайн дурын үйл ажиллагаанд* эрэн хайх, авран туслах ажиллагаа зохион байгуулах баг, гамшгийн дараах цэвэрлэгээний ажил хийх, орон байраар хангах зэрэг ажиллагаанд тусалдаг байна. Энэ төрлийн сайн дурын ажил нь хүний аюулгүй байдал, нийгмийн сайн сайхан байдлын төлөө үнэн сэтгэлээсээ санаа зовсон сайн дурынхны хүнлэг, энэрэнгүй үзэлд тулгуурлаж хийгддэг.

2 *Олон нийтийн сонирхлын төлөөх байгууллагын сайн дурын хөдөлгөөн* нь иргэний хамгаалалт, гамшгийн тусламж үйлчилгээ болон

⁷³ R.P.Wolensky, Toward a broader conceptualization of volunteerism ny disaster, Nonprofit Volunt. Sect.Q.8 (1979) 33-42

нийгмийн сайн сайхны төлөө үйлчилдэг байгууллагууд байнгын болон түр зуурын тусламжийн үйл ажиллагаа явуулдаг.

3 *Хувийн сонирхол бүхий шинээр үүссэн сайн дурын хөдөлгөөн нь гамшгийн дараа өөрсдийн эрх ашгийг хамгаалах зорилгоор зохион байгуулагдсан бүлэг, эсвэл иргэдийн үйл ажиллагааг хамардаг. Эдгээр бүлгүүд нь голдуу өөрийн гишүүдийн ашиг сонирхолд нийцүүлж үйл ажиллагаа явуулдаг учир эгоистик гэж үздэг.*

4 *Хувийн сонирхол бүхий байгууллагын сайн дурын хөдөлгөөн нь сүм, эвлэл, клубийн хүрээнд явагдаж ихэнхдээ өөрсдийн гишүүдэд зориулсан үйл ажиллагааг зохион байгуулдаг.*⁷⁴

Гамшгийн үед мэргэжлийн байгууллагын тусламж иртэл ихэнх тохиолдолд иргэд өөрсдийгөө авран хамгаалж, эрсдэлээс өөрийгөө болон бусдыг хамгаалах үүрэг гүйцэтгэдэг. Гамшгаас хамгаалах сайн дурын үйл ажиллагаатай холбоо бүхий нэр томъёоллыг дараах байдлаар авч үзсэн байна. Үүнд:

Гамшгаас хамгаалах сайн дурын ажиллагаа гэж иргэн өөрийн хүсэлтээр гамшгаас хамгаалах ажиллагаанд хүчин зүтгэж байгаа оролцоог хэлнэ.

Гамшгаас хамгаалах сайн дурын хэсэг гэж нэгдсэн зохион байгуулалтад орж, техник, багаж хэрэгсэл, материалаар хангагдан гамшгаас хамгаалах сайн дурын ажиллагаанд оролцох орон тооны бус бүрэлдэхүүнийг хэлнэ. Сайн дурын үндсэн дээр гамшгаас хамгаалах үйл ажиллагаанд оролцохоор зохих сургалтад хамрагдсан иргэдийг хэлнэ.⁷⁵

Гамшгаас хамгаалах сайн дурын ажилтан гэж гамшгаас хамгаалах сайн дурын ажиллагаанд оролцох бүртгэлтэй, тодорхой шаардлагыг хангасан иргэнийг хэлнэ. Өөрөөр хэлбэл, орон тооны бус сайн дурын бүрэлдэхүүнд орж, сайн дурын үндсэн дээр авлагагүйгээр гамшгаас урьдчилан сэргийлэх, эрэн хайх, аврах, гамшгийн эрсдэлийг бууруулах үйл ажиллагаанд оролцогчийг гамшгаас хамгаалах сайн дурын ажилтан гэнэ.

Гамшгаас урьдчилан сэргийлэх, учирч болзошгүй эрсдэлд бэлэн байх, учирсан хямралын үеийг давах туулах, сэргээн босгох нь “гамшгийн удирдлага”-ын хэрэгцээ шаардлагыг тодорхойлдог. Гамшгийн удирдлага

⁷⁴ R.P.Wolensky, Toward a broader conceptualization of volunteerism ny disaster, Nonprofit Volunt. Sect.Q.8 (1979) 33-42

⁷⁵ Монгол Улсын Гамшгаас хамгаалах тухай хуулийн 4.1.18 дахь заалт.


гэдэг нь шаардлагатай эсвэл тохиромжтой арга хэмжээг төлөвлөх, зохион байгуулах, зохицуулах, хэрэгжүүлэх тасралтгүй, нэгдсэн үйл явцыг хэлдэг. Энэ ойлголтод дараах үйл ажиллагаанууд багтдаг. Үүнд:

- 1 аливаа гамшгийн аюул, аюулаас урьдчилан сэргийлэх;
- 2 аливаа гамшгийн эрсдэлийг бууруулах;
- 3 гамшгийн даван туулах чадавхыг бэхжүүлэх;
- 4 аливаа гамшгийг даван туулахад бэлэн байх;
- 5 гамшгийн үед шуурхай хариу арга хэмжээ авах;
- 6 аливаа гамшгийн нөлөөлөл, цар хүрээг үнэлэх; нүүлгэн шилжүүлэх, аврах, тусламж үзүүлэх;
- 7 нөхөн сэргээх, сэргээн босголт.


Гамшгаас хамгаалах үйл ажиллагааны гурван үндсэн үе шат байдаг.

Үүнд:

- 1 Гамшгийн өмнөх үе: Гамшгийн өмнөх гамшгаас урьдчилан сэргийлэх, учирч болох хохирлыг бууруулах, багасгахад чиглэгдсэн арга хэмжээ авах үе;
- 2 Гамшгийн үе: Гамшгийн бэлэн байдлыг хангах, хариу арга хэмжээ авахад чиглэгдсэн арга хэмжээ авах;
- 3 Гамшгийн дараах үе: Гамшгийн дараах нөхөн сэргээх, сэргээн босгох, хөгжүүлэх ажиллагааг зохион байгуулах



Зураг 1. Гамшгийн үе шат (Монгол Улсын хэмжээнд)



Зураг 2. Гамшгийн үе шат (Олон улсын чиг хандлага)

Гамшгийн үе шатыг гамшгийн өмнөх үе, гамшгийн дараах үе гэж хуваан үзээд эдгээр үе шатанд аюулаас үүдэлтэй учирч болзошгүй хохирлыг бууруулах, эрсдэлээс зайлсхийх, гамшигт нэрвэгдэгсдэд цаг алдалгүй, зохих ёсоор тусламж үзүүлэх, хурдан бөгөөд үр дүнтэй хойшлуулшгүй сэргээн босгох боломжийг олгох зорилготой үйл ажиллагаагаа хэрэгжүүлж байна.

Гамшгаас хамгаалах үе шатуудад хэрэгжүүлэх үйл ажиллагааг Хүснэгт 7-д үзүүллээ.

1.Гамшгийн өмнөх үеийн үйл ажиллагаа		
1	Урьдчилан сэргийлэх, бууруулах	Гамшгийн эрсдэлийг бууруулах нь тулгарч буй аюулын цар хүрээ, эрчмийг багасгах, өөрчлөх, эрсдэлд байгаа элементүүдийн нөхцөл байдлыг сайжруулах зэрэг үйл ажиллагааг хамардаг.
	Бэлэн байдал	Энэ үйл явц нь засгийн газар, олон нийт, хувь хүмүүст гамшгийн нөхцөл байдлыг үр дүнтэй даван туулахын тулд хариу арга хэмжээг цаг алдалгүй авах боломжийг олгодог арга хэмжээг хамардаг.
	Эрт сэрэмжлүүлэг	Энэ нь аюулд өртөмтгий гэж мэдэгдэж буй орон нутаг бүс нутгийн нөхцөл байдлыг хянах, хүлээгдэж буй аюулын талаарх мэдлэгийг хүмүүст дамжуулах үйл явц юм.
	Гамшгийн нөлөөлөл	Энэ нь “эрсдэлтэй элементүүдэд нөлөөлж буй аюулын бодит цагийн үйл явдлыг хэлнэ. Үйл явдлын үргэлжлэх хугацаа нь аюулын төрлөөс хамаарна;
2.Гамшгийн үеийн үйл ажиллагаа		
2	Хариу арга хэмжээ	Энэ нь аливаа гамшгийн үед авах эхний шатны хариу арга хэмжээ бөгөөд онцгой байдлын төлөвлөгөөг хэрэгжүүлэх, сэрэмжлүүлэг өгөх, нүүлгэн шилжүүлэх, хүмүүсийг аюулгүй газар нүүлгэн шилжүүлэх, тусламж хэрэгтэй хүмүүст эмнэлгийн болон бусад төрлийн тусламж үйлчилгээг үзүүлэх гэх мэт

3.Гамшгийн дараах үйл ажиллагаа		
3	Нөхөн сэргээх	Нөхөн сэргээлт нь урт хугацааны болон түр зуурын арга хэмжээ авах, ахуйн үйлчилгээ болон орон сууцаар хангах явдал юм.
	Сэргээн босгох	Сэргээн босголт нь гамшигт нэрвэгдэгсдийг гамшгийн өмнөх хэвийн нөхцөл оруулах оролдлого юм. Барилга байгууламж, дэд бүтцийг сэргээн босгох урт хугацааны хөгжлийн төлөвийг хэлнэ.
	Хөгжүүлэлт	Урт хугацааны урьдчилан сэргийлэх/гамшгийн аюулыг бууруулах арга хэмжээ, тухайлбал, үерийн далан барих, усалгааны байгууламжийг бий болгох, хөрсний гулгалтыг бууруулах ургамлын бүрхэвчийг нэмэгдүүлэх, газар хөдлөлт, аадар бороонд тэсвэртэй орон сууц барих/ зэрэг арга хэмжээ юм.

Хүснэгт 7., Гамшгаас хамгаалах үе шатуудад хэрэгжүүлэх үйл ажиллагаа.

Гамшгийн эрсдэлийг бууруулах чиглэлээр 2015-2030 онд хэрэгжүүлэх “Сендайн үйл ажиллагааны хүрээ” баримт бичигт бүх түвшний төрийн албан хаагчид, иргэний нийгэм, ТББ, олон нийт, сайн дурынхан, хувийн хэвшлийнхний гамшгийн эрсдэлийг бууруулах түншлэл, хамтын ажиллагааг сайжруулж, ялангуяа төрийн бус байгууллагуудын дэмжлэг, үүрэг амлалт, хүсэл зориг, мэдлэг туршлага, нөөц чадавхыг дайчлахыг чухалчилсан. Гамшгийн менежментийг бэлэн байдал, хариу арга хэмжээ авах, сэргээн босголт, хариуцлагын зохион байгуулалт, удирдлага гэж тодорхойлж болно.

Гамшиг болсон үед сайн дурын үйл ажиллагаанд жирийн иргэд оролцох хүсэлтээ илэрхийлж, хамтран ажилласан тохиолдол олон бий. Сайн дурын идэвхтнүүд олноор бий болгоход дараах хүчин зүйлс нөлөөлдөг гэсэн судалгаа гарчээ. Үүнд: Гамшигт өртсөн хүн амын тоо болон газар зүйн нягтаршил, ойрхон байх тусам сайн дурын идэвхтнүүд өсөн нэмэгдэх шалтгаан болдог. Онцгой байдал үүссэн газарт нөхцөл байдал улам бэрхшээлтэй болж, хамрах хүрээ нь тэлэх тусам хамтын хүчээр туслах, сайн дурын бүлгүүд нэгдэх үйл явц ажиглагддаг. Хэвлэл, мэдээллийн хэрэгслээр илүү их мэдээлэгдэх тусам сайн дурын бүлгүүд хоорондоо нэгдэн, нягтардаг. Эдгээр бүлгүүдийн гол шинж чанар нь бүтэц, үйл ажиллагааныхаа хувьд хамтын үйл ажиллагааны шинэ хэлбэр юм. Тухайлбал, 1980 онд Италийн өмнөд хэсэгт болсон газар хөдлөлтийн дараа гамшигт нэрвэгдсэн долоон сууринд хийсэн судалгаагаар нурсан барилгаас аврагдсан хохирогчдын 90 хувийг тосгоны жирийн иргэд, албан бус сайн дурынхан аварсан болохыг тогтоожээ. Мөн 1995 онд Японы Кобе хотод болсон газар хөдлөлтийн дараа нурсан барилгуудад дарагдсан хүмүүсийн

60-90 хувийг нутгийн иргэд аварч, сайн дурынхны тоо 630,000- 1,4 саяд хүрч, 1985 онд Мехико хотод болсон газар хөдлөлтийн гамшгийн дараа хариу арга хэмжээ нь олон зуун бүлгүүдийн бие даасан үйл ажиллагаа давамгайлж, хотын хүн амын ойролцоогоор 10 хувь нь (ойролцоогоор 2 сая хүн) ямар нэгэн байдлаар сайн дурын ажилд оролцож, Австралид 2009 онд болсон ой хээрийн түймрийн дараа 22,000 хүн онцгой байдлын байгууллагад сайн дурын ажилтнаар бүртгүүлсэн жишээ байна.

Ямарваа онцгой нөхцөл байдал үүсэхэд сайн дурын үйл ажиллагаа үүсэх нь гарцаагүй зүйл юм. Тиймээс сайн дураар ажиллах хүсэлт гаргасан иргэдийг үйл ажиллагаандаа оролцуулах нь сорилт, нөгөө талаар бэрхшээлтэй асуудал үүсгэхийг ч үгүйсгэхгүй.

Сүүлийн үед судлаачид гамшгийн менежментэд албан бус сайн дурынхны оролцоог хангах нь нөөц бололцоог дайчлах, цаг хугацааг хэмнэх, гамшгаас үүдэх хохирлыг бууруулах асуудал болж байна гэж үзэж байна. Иймд гамшиг тохиолдсон үед албан бус сайн дурынхны үүрэг оролцооны ололт, амжилтыг түүхийн сургамж дээр зөв, оновчтой зохион байгуулах асуудал аль ч үндэстний нийгмийн чухал асуудал болж байгаа учраас энэ талаар авч үзэж, гамшгийн менежментийн сургалтад хамрагдсан сайн дурын ажилтан, гамшгийн менежментийн сургалтад хамрагдаагүй өөрийн хүсэл, сонирхлоор оролцож буй сайн дурынхны үүрэг оролцооны ялгаатай байдлыг мэргэжилтнүүдийн тодорхойлсноор хүснэгт 8-д харууллаа.

Гамшгийн үе шат мөчлөг	Гамшгийн менежментийн сургалтад хамрагдсан сайн дурын ажилтан	Гамшгийн менежментийн сургалтад хамрагдаагүй албан бус сайн дурынхан
Гамшгийн өмнөх үе	Гамшиг, ослын талаар сургалтад хамрагдаж, гүйцэтгэх үүрэг, баримтлах зарчмын талаар ойлголттой болох Гамшгаас хамгаалах сургалт, дадлагад хамрагдаж, сэтгэл зүйгээ бэлтгэх Эмзэг байдал хүчин чадлын үнэлгээ хийхэд оролцох	Бусдад туслах хүсэл эрмэлзлэлээр оролцох санаачилга гаргаж, бусдыг манлайлж оролцох Өөрийн чадварт тохирсон ажлыг хийхэд биеэ бэлтгэх Биет болон материаллаг хандив тусламж үзүүлэхэд сэтгэл зүйгээ бэлтгэх
Гамшгийн үе	Гамшгийн үеийн яаралтай хариу арга хэмжээ авах ажиллагаанд аюулгүй байдлаа хангаж оролцох	Бусдад туслах уриалга гаргаж, гамшгийн голомтод очиж, өөрийн хүчин чадалд тулгуурласан ажилд туслах

	Яаралтай үеийн хариу арга хэмжээнд мөрдвөл зохих дүрэм, журмыг ягштал биелүүлж оролцох Дараагийн болзошгүй гамшгаас сэрэмжлүүлэх сурталчилгаа хийх	Хандив тусламж үзүүлэх олон нийтийн санаачилгыг өрнүүлэх Олон нийтийг үнэн зөв мэдээллээр хангах
Гамшгийн дараах үед	Сайн дурын бүлэг, хэсгийн үйл ажиллагааны оролцоонд дүгнэлт хийж, сургамж авах Гамшгийн үеийн сайн дурын үйл ажиллагааны сургамжаас суралцах	Сайн дурынхны оролцоог нэмэгдүүлэх хөдөлгөөн өрнүүлэх Бусдаас суралцаж, сургамж авах

Хүснэгт 8., Гамшгаас хамгаалах үйл ажиллагаа дахь сайн дурынхны үүрэг оролцоо

Гамшгийн эрсдэлийг бууруулах Дэлхийн санаачилга нь Улаан загалмайн нийгэмлэг, НҮБ, хувийн хэвшил, даатгалын салбар, эрдэм шинжилгээний байгууллага, сайн дурын байгууллага зэрэг оролцогчдын хүрээг тэлэх үүднээс тасралтгүй өргөжиж, өсөн нэмэгдэж буй систем болон хөгжиж, гамшгийн эсрэг хариу арга хэмжээ авах, эрсдэлийг бууруулахад оролцогч бүр өөрийн оролцоотой байх хүмүүнлэгийн хамтын зайлшгүй шаардлага болсоор байна.

Сайн дурынхан гамшгийн хариу арга хэмжээнд үүрэг гүйцэтгэхэд илрэх давуу ба дутагдалтай талуудыг судлаачид судалсныг хүснэгт 9-д үзүүлэв.

Давуу талууд	Дутагдалтай талууд
Орон нутгийн сайн дурынхан гамшгийн үед эхний ээлжид хариу арга хэмжээг авч хэрэгжүүлж, сургагдсан сайн дурынхан эмнэлгийн анхны тусламж үзүүлэх, эрэн хайх аврах ажиллагааг эхлүүлэх, нуранги зайлуулах арга хэмжээнд оролцдог.	Гамшгийн голомтод олон тооны хүн, техник хэрэгсэл, хангамж, тээврийн хэрэгсэл хүрэлцэн ирсэн нь түгжрэл үүсгэж, яаралтай тусламжийн албан ёсны хариу арга хэмжээ авахад саад болдог. Хууль эрх зүйн бэрхшээл: Сайн дурынхныг үр дүнтэй оролцуулах хууль эрх зүйн зохицуулалт сул.
Орон нутгийн удирдлагын ачааллыг хөнгөлж өгдөг: Сайн зохион байгуулалт бүхий сайн дурынхан гамшгийн хариу арга хэмжээний үед зардал хэмнэсэн, үнэлж баршгүй нөөц болдог. Нийгмийн эв нэгдлийг бий болгодог: Хямралын үеийн хариу арга хэмжээнд олон нийтийн нэг хэсэг оролцож байгааг харуулснаар	Улс төр ба соёлын бэрхшээл: Сайн дурын хөдөлгөөн үүсэж гарч ирэх үйл явц нийгмийн шинж чанартай өөрчлөлтүүдтэй зэрэгцдэг ба улс төр, соёл болон гамшиг, онцгой байдлын үед сайн дурын ажиллагааны талаар баримтлах үзэл баримтлалд тулгарах бэрхшээлтэй тулгардаг. Шинэ гарч ирж буй сайн дурынхныг нэгэнт тогтсон гамшгийн менежментийн үйл ажиллагаатай нэгтгэх бэрхшээлүүд болон боломжуудын тэнцвэртэй байдлыг хадгалах нь

<p>гамшигт нэрвэгдсэн болон нэрвэгдээгүй хүмүүст нийгмийн идэвхтэй үйл ажиллагааг сурталчилдаг.</p>	<p>хэцүү байдаг. Гэхдээ энэхүү тэнцвэрийг хадгалахад зарим нэг арга зам тус болох талаар судлаачид дурдсан байна.⁷⁶</p>
<p>Шинэ технологи ашиглах: Гамшиг, онцгой байдлын үед холбоо харилцааны шинэ технологийг ашиглах иргэд олон нийтийн дунд хурдан хугацаанд харилцах чадавхыг нэмэгдүүлэх боломжийг бий болгодог.</p> <p>Сайн дурынхан нь гамшгаас хамгаалах арга хэмжээнд оролцсоноор орон нутгийн түвшинд гамшгийн хариу арга хэмжээний ажиллагааны чадавх, хариуцлагыг дээшлүүлдэг.</p>	<p>Албан бус сайн дурынханд тохиолдох бэрхшээл:</p> <p>Яаралтай тусламжийн удирдлага зохион байгуулалтын дэг журам өөрчлөгддөг.</p> <p>Сайн дурынхан туслахыг маш их хүсдэг ч албан ёсны шийдвэр гаргах үйл явц, үйлчилгээ үзүүлэх арга барилд дасгахгүй, бие даан ажиллах, дүрэм журам зөрчих магадлал өндөр байдаг.</p> <p>Даатгалд хамрагдаагүй учраас бэртэж гэмтэх, амь насаа алдах тохиолдолд хуулийн өмнө хариуцлага хүлээх субъект байхгүй байх эрсдэлтэй.</p>

Хүснэгт 9., Сайн дурынхан гамшгийн хариу арга хэмжээнд үүрэг гүйцэтгэхэд илрэх давуу ба дутагдалтай талууд.

Сайн дурын зарчим дээр эвлэлдэн нэгдсэн Засгийн Газрын бус байгууллагууд ХХ зуунд 400 орчим байсан бол сүүлийн жилүүдэд 25000 болтлоо өсөн нэмэгдсэн судалгаа байна. Засгийн Газрын бус байгууллагыг хувийн сайн дурын байгууллага (PVO) гэж бас нэрлэдэг. Хувийн сайн дурын байгууллага нь 1950-аад оноос хойш АНУ-ын Засгийн Газрын гол оролцогч талууд байсаар ирсэн. Дэлхийн улс орнуудад тохиолдож буй байгалийн гамшиг, ган гачиг, хүнсний хямралд үзүүлэх олон улсын тусламжийг АНУ-ын олон Улсын хөгжлийн агентлаг (USAID) удирдаж, сайн дурын байгууллагууд хэрэгжүүлдэг нь Засгийн Газар – сайн дурын үндсэн дээр нэгдсэн Засгийн Газрын бус байгууллагын хамтын ажиллагааны төгс жишээ юм. АНУ-ын Олон улсын хөгжлийн агентлаг нь хөтөлбөрүүдийг боловсруулж хэрэгжүүлэхдээ хувийн сайн дурын байгууллагуудын дагаж мөрдөх дүрэм журам, бодлогын баримт бичгийг баталж гаргадаг. Судлаачид гамшгийн менежментийн чиглэлээр ажилладаг сайн дурын Засгийн Газрын бус сайн дурын байгууллагуудыг гамшгийн эрсдэлийг бууруулах үйл ажиллагаанд баримтлах стратеги, үйл ажиллагааны агуулга, хамрах хүрээ, хандлага, хамтран оролцогчид, сайн дурын байгууллагын үүрэг оролцоог гамшгийн эрсдэлийг бууруулах

⁷⁶ Risk and Resilience Team Center for Security Studies (CSS), *Volunteerism in Disaster Management Opportunities, Challenges and Instruments for Improvement*, ETH Zurich, 2019. www.researchgate.net/

түүхийн хөгжлийн 5 үе шатанд авч үзэж тодорхойлжээ. Үүнийг хүснэгт 10-д үзүүлээ.

Сайн дурын байгууллагын арга барилын хувьсал	1-р үе (1945-1970)	2-р үе (1971-1989)	3-р үе (1990-2005)	4-р үе (2005-2015)	5-р үе (2015- с хойш)
Гамшгийн эрсдэлийг бууруулах бодлогын баримт бичиг	Тусламж/ Үндсэн	НҮБ-ын Гамшгийн тусламжийг зохицуулах алба (UNDRO)	Йокахама үйл ажиллагааны хүрээ	Хёогогийн үйл ажиллагааны хүрээ	Сендайн үйл ажиллаганы хүрээ.Тогтвортой байдал, Алсын хараа
Хандлага	Хүмүүнлэг Үзэл	Олон нийтийн хөгжил	Сурталчилгаа	Холимог хандлага	Цогц хамтын ажиллагаа
Түвшин	Орон нутаг/ тусгай	Орон нутаг/ тусгай	Бүс нутаг/ үндэсний	Үндэсний/ дэлхийн	Экосистем /тэнцвэртэй систем
Цаг, хугацааны хүрээ	Шууд	Төслийн ойрын хугацаа	10-20 жил	Нээлттэй	Хувьсагч
Хамрах хүрээ	Хувь хүн	Хөрш	Бүс нутаг/ Үндэсний хэмжээнд	Үндэсний хэмжээнд	Экосистем
Хамтран оролцогчид	Гишүүд	Олон нийт	Хүн бүр	Сүлжээ	Супер сүлжээ
Үүрэг	Анхан шат	Дайчлах, шууд	Катализатор /шинэчлэх	Идэвхтэй/ Шууд оролцох	Боловсрол , Техникийн дэмжлэг

Хүснэгт 10., Гамшгийн менежментийн чиглэлээр ажилладаг Засгийн Газрын бус сайн дурын байгууллагын арга барилын хувьсал

Эхний үед (1945-1970) Засгийн газрын бус сайн дурын байгууллагууд нь ихэвчлэн хүмүүнлэг, өгөөмөр сэтгэлийн үүднээс байгалийн гамшиг, зэвсэг мөргөлдөөнд нэрвэгдэгсдэд хүмүүнлэгийн тусламжийн үйл ажиллагааг чиглүүлж, Дэлхийн 2-р дайны дараа гучаад жилийн турш гамшигт хариу үйлдэл үзүүлсэн урт хугацаа байв.

Хоёр дахь үед (1971-1989) Дэлхийн хамтын нийгэмлэгүүд тухайлбал, Олон Улсын Улаан загалмай, Улаан Хавирган сар хөдөлгөөн зэрэг байгууллагууд гамшгаас авран хамгаалах шинэ эрин үеийн эхлэлийг

тавьж, НҮБ-ын Гамшгийн тусламжийн зохицуулагчийн алба (UNDRO) байгуулагдсан нь гамшгийн эсрэг илүү системтэй хариу арга хэмжээ авах эхлэл болж, Олон улсын хөгжлийн нийгэмлэгүүдийн хүрээнд буяны байгууллагуудаас татгалзаж, олон нийтийг илүү хөгжүүлэхийг дэмжих үйл явц эхэлсэн.

Гурав дахь үед (1990-2005) Засгийн газрын бус сайн дурын байгууллагуудын шинэ хөдөлгөөн нь засгийн газрын үйл ажиллагааг сайжруулах чиглэлд анхаарч, олон нийтийн сурталчилгааг гол стратеги болгон ашиглаж, урт хугацааны хөтөлбөрүүдийг хэрэгжүүлснээрээ онцлог байв. Дэлхийн хэмжээнд гамшгаас хамгаалах хамтын нийгэмлэгүүд НҮБ-ын дэргэдэх Байгалийн гамшгийн аюулыг бууруулах олон улсын 10 жил (IDNDR) хөтөлбөрийг хэрэгжүүлэх үүрэг хүлээж, гамшгийн хор уршгийг бууруулах чиглэлээр орон нутгийн үйл ажиллагаанд хяналт тавих, 1994 онд гаргасан Йокохамагийн Аюулгүй ертөнцийг бий болгох үйл ажиллагааг хэрэгжүүлэх, Олон нийтэд тулгуурласан гамшгийн эрсдэлийг бууруулах үйл ажиллагаа зонхилсон шинэ эрин үе эхэлсэн гэж үздэг.

Дөрөв дэх үе шатанд (2005-2015) Гамшгийн эрсдэлийг бууруулах Хёогогийн үйл ажиллагааны хүрээг (HFA) баталж, хэрэгжүүлэхтэй холбоотой орон нутгийн, үндэсний болон дэлхийн түвшинд Гамшгийн эрсдэлийг бууруулах платформуудыг бий болгож, гамшгийн эрсдэлийг бууруулах иргэний нийгмийн байгууллагуудын дэлхийн сүлжээ (GNDR) зэрэг сайн дурын байгууллагын сүлжээ байгуулагдсан. GNDR нь дэлхийн 129 гаруй оронд 800 гаруй байгууллагыг нэгтгэсэн сайн дурын байгууллагын сүлжээ төдийгүй "иргэний нийгмийг орон нутгийнхан болон дэлхий дахинтай холбож, гамшгийн эрсдэлийг бууруулах, хамгийн эмзэг бүлгийнхний чадавхыг нэмэгдүүлэх ажилд хамтын дуу хоолойг хүргэх боломжийг олгох" зорилготой. Энэ мэтчилэн Дэлхийн түвшинд Засгийн газрын бус сайн дурын байгууллагууд НҮБ-ын тогтолцоонд, тэр дундаа UNISDR-д чухал үүрэг гүйцэтгэх болсон.

Тав дахь үе шатанд (2015-аас хойш). Энэ үе бол гамшгаас хамгаалах уламжлалт нийгэмлэгүүдээс гадна гамшгийн эрсдэлийг бууруулах хөтөлбөрүүдийг нэгтгэх шинэ мэдлэгийн эрин үе юм. "Гамшгийн эрсдэлийг бууруулах Сендайн үйл ажиллагааны хүрээ 2015-2030 баримт бичиг баталж, гамшгийн эрсдэлийг ойлгох, гамшгийн эрсдэлийг удирдах засаглалыг бэхжүүлэх, гамшгийг даван туулах чадварыг бэхжүүлэхэд чиглэсэн эрсдэлийг бууруулах үйл ажиллагаанд хөрөнгө оруулах,

гамшгийн бэлэн байдлыг хангах, сэргээн босгох нөхөн сэргээх шатанд “сайжруулан барих” үйл ажиллагааг хэрэгжүүлэх зорилтууд дэвшүүлж, ТББ, сайн дурын байгууллага, олон нийтийн оролцоонд тулгуурласан байгууллагууд, мэргэжлийн холбоод, хүмүүнлэгийн сангуудын олон улсын хамтын ажиллагаа, улс орнуудын нөхөрлөлийн шинэ эрин эрин үе эхэлсэн. Засгийн газрын бус сайн дурын байгууллагууд өөрсдийгөө дэлхийн гамшгийн эрсдэлийг бууруулах болон хүмүүнлэгийн экосистемийн нэг хэсэг болгон өөрчилж, санхүүгийн болон санхүүгийн бус зуучлалын чиглэлээр зуучлалын үүрэг гүйцэтгэж, олон улсын хөгжил төдийгүй дэлхийн хүмүүнлэгийн салбарын гол оролцогчид болон гарч ирсэн.

Судлаачид гамшиг онцгой байдлын үед сайн дурын ажиллагаатай холбоотой доорх гурван томоохон асуудлыг хөндөж тавьсан байна.

- Нэгдүгээрт, төрөл бүрийн шалтгаанаар эрх баригчид иргэд олон нийтийн сайн дурын дэмжлэг туслалцаа, сайн дурынхнаас татгалзаж чадахгүй болно. Иймд сайн дурынхныг гамшгаас хамгаалах арга хэмжээнд дүр дүнтэй холбон нэгтгэх арга замыг эрэлхийлэх.

- Хоёрдугаарт, сайн дурынхныг нэгтгэн оролцуулах асуудлыг гамшгаас хамгаалах үйл ажиллагаанд оруулж буй хөрөнгө оруулалт гэсэн утгаар харах.

- Гуравдугаарт, гамшгийн менежмент дэх үйл ажиллагаанд гамшгаас хамгаалах байгууллагын дангаараа давамгайлах албан ёсны оролцоо удаан үргэлжлэхгүй ба түншлэл хамтын ажиллагааны шинэ үе бий болж байна гэжээ⁷⁷.


Олон Улсын гамшгаас хамгаалах сайн дурын үйл ажиллагааны туршилага, сургамж.

Гамшгаас урьдчилан сэргийлэх, гамшигт бэлэн байх, хариу арга хэмжээ авахад улс орнуудын гамшгаас хамгаалах эрх зүйн зохицуулалт, гамшгаас хамгаалах систем нь хэрхэн ажилладаг, түүнд сайн дурынхан, иргэд хэрхэн оролцдог талаар улс орнуудын Сайн дурын байгууллагуудын туршлага, сургамжаас авч үзье.

Гамшгийн нэгдсэн мэдээллийн санд (Зураг №3.) 1.23 сая хүн амь насаа алдаж, жилд дунджаар 60,000 амиа алдаж, нийт 4 тэрбум гаруй хүн өртсөн байна. Гамшгийн улмаас дэлхий даяар 2.97 их наяд долларын эдийн засгийн хохирол учирсан. Өмнөх хорин жилийнхтэй харьцуулахад

⁷⁷ Тэнд

гамшгийн мэдээллийн санд бүртгэгдсэн байгалийн гамшгийн тоо огцом өссөнийг харуулж байна. 1980-1999 оны хооронд нь дэлхий даяар байгалийн аюултай холбоотой 4,212 гамшгийг бүртгэж, ойролцоогоор 1.19 сая хүний амь насаа алдаж, 3 тэрбум гаруй хүн гамшигт өртсөн. Эдийн засгийн хохирол 1.63 их наяд ам.доллар байна. (Зураг 3)



Зураг 3., Гамшгийн хохирлын судалгааны дүн: (1980-2019 он)

Эх сурвалж⁷⁸: “Гамшигийн эрсдэлийн менежментийг сайжруулах боломж” диссертацийн ажил

2002-2019 оны хооронд 510,837 нас баралт, 3.8 тэрбум хүн уур амьсгалтай холбоотой гамшигт нэрвэгдсэн. Энэ нь цаг ууртай холбоотой 3,656 гамшгийн төрлийг харьцуулж үзэхэд 995,330 хүн нас барсан (47% нь ган, өлсгөлөнгийн улмаас), 3,1 тэрбум нь 1980-1999 онуудад өртжээ.



Зураг 4., Нийт гамшигт үзэгдлийн төрлөөр нь авч үзвэл: 1980-1999 он, 2000-2019 он

⁷⁸ Саранцэцэг.Б “Гамшигийн эрсдэлийн менежментийг сайжруулах боломж” диссертацийн ажил, 2021 он

Энэ нь дэлхийн дундаж температур 2019 онд өмнөх үеэс 1.1°C-аас нэмэгдсэн нь цаг агаарын эрс тэс үзэгдлийн давтамж, түүний дотор халуун, ган гачиг, үер, өвлийн шуурга, хар салхи, хээрийн түймэр зэрэгт нөлөөлж буйн тод нотолгоо юм.

Дэлхийн дулаарал, уур амьсгалын өөрчлөлт, хүний буруутай үйл ажиллагааны улмаас дэлхий нийтэд тохиолдох гамшгийн аюул, түүнээс учрах хохирол жил бүр өсөн нэмэгдэж, улс орнуудын нийгэм, эдийн засгийн хөгжил, хүн амын амьжиргаанд сөрөг нөлөө үзүүлж байгааг дээрх зургаас харж болно. Дэлхийн улс орнууд үүний эсрэг нэгдэн гамшгийн эрсдэлийг бууруулах, уур амьсгалын өөрчлөлтийн нөлөөллийг багасгах, дэлхийн тогтвортой хөгжлийг хангах чиглэлээр үүрэг, хариуцлага хүлээж, дэлхий нийтээр хэрэгжүүлэх бодлогын баримт бичгүүдийг батлан гаргаж, олон улсын ба бүс нутгийн түвшинд, харилцан мэдээлэл солилцож, туршлагаа хуваалцаж хамтран ажиллаж байна.

АНУ. Холбооны Онцгой байдлын газар, (FEMA) УЗН, бусад төрийн бус байгууллагууд хамтран үндэсний хэмжээнд төдийгүй Олон улсад гамшгийн үед инженер техник, холбоо харилцаа, яаралтай тусламж үйлчилгээ үзүүлэх нэгж илгээж ажилладгаараа онцлогтой. Сайн дурын идэвхтэнтэй, үйл ажиллагааны гол чиглэл нь гамшгийн бэлэн байдал, эрүүл мэнд, аюулгүй байдлын чиглэлээр хувийн хэвшил, бизнесийн байгууллагын ажилтнуудтай түлхүү ажилладаг.⁷⁹

Жил бүр объектын гал түймэр, үер, хар салхи, далайн шуурга торнадо, газар хөдлөлт, аюултай бодис асгарах, зам тээврийн осол болон байгалийн болон хүний үйл ажиллагаатай холбоотой 60.000 гамшигт хариу үйлдэл үзүүлдэг. Муж орон нутагт Улаан загалмайн салбар нэгжид сургагдсан Гамшгийн хариу үйлдэл үзүүлэх баг байдаг. Гамшгийн үед анхан шатны тусламж үзүүлэх хоол хүнс, хувцас, оромж байраар хангах, урт, богино хугацааны нөхөн сэргээх төсөл хэрэгжүүлэх, гамшгийн хариу үйлдэл үзүүлэх багийн гишүүд нь өөртөө итгэлтэй, гамшгийн нөхцөл байдлын үнэлгээ хийх чадвартай, дуудлагын үйлчилгээ үзүүлээд сурчихсан, үүрэг хариуцлагаа мэддэг, туршлагатай хүмүүс байдгаараа онцлогтой.

Япон ба БНХАУ. Япон орон нь гамшгийн менежмент, тэр тусмаа сайн дурынхны хүчийг дайчлах, зохион байгуулах талаар их хэмжээний

⁷⁹ En.wikipedia.org/wiki/American_Red_Cross.

туршлага хуримтлуулсан орны тоонд ордог. 2018 онд болсон үерийн гамшигт нэрвэгдэгсдэд эмнэлгийн яаралтай тусламжийн (Medical Emergency Team) 53 баг, эмнэлгийн тусламжийг зохицуулах (Medical Coordination Team) 14 баг, гамшгийн үеийн эмнэлгийн тусламж үзүүлэх (Disaster Medical Assistance Team) 23 баг, сэтгэл зүйн (Psychocial Support) 7 багийг илгээсэн. Нүүлгэн шилжүүлэх төвд байрлаж буй үерийн гамшигт нэрвэгдэгсдэд тусламжийн үйл ажиллагааг төрөлжүүлэн зохион байгуулж, дадлага, сургалтыг байнга хийдэг. Бэлэн мөнгөний тусламжид хамрагдах тодорхой шалгууртай аппликейшнийг хүн бүр бөглөж, бэлэн мөнгө тараах ажлыг зохион байгуулж хяналт тавьж ажилладаг тогтсон системтэй байна.

2008 онд БНХАУ-ын Сычуан мужид болсон газар хөдлөлтийн улмаас 87,000 хүн нас барж, 375,000 хүн гэмтэж, 46 сая хүн өртсөн. 2021 онд Хятадын баруун өмнөд нутагт хүчтэй газар хөдлөлтийн гамшигт нэрвэгдэгсдэд яаралтай тусламж үзүүлж, орон сууцны хороолол, эмнэлэг, сургууль шинээр барих хөрөнгө босгох ажлыг төр, хувийн хэвшил, төрийн бус байгууллага, сайн дурынхны оролцоотойгоор хийж, Дэлхийн хэмжээнд гамшгийн дараах сэргээн босгох ажлыг гамшгийн үеийн удирдлага, зохион байгуулалт, салбаруудын хамтын ажиллагаа, иргэдийн санаачилга, сайн дурынхны үйл ажиллагааны томоохон жишээ, туршлага болсон байна.

Олон Улсын хэмжээн дэх томоохон гамшигт оролцсон иргэд, сайн дурын түүхэн сургамжийн талаар:

Олон улсад албан бус сайн дурын талаарх туршлага бас сургамж болгон анхаарах асуудлын талаар эрдэмтэн судлаачид багагүй судалгаа хийсэн байна. Олон улсын практикаас үзэхэд сайн дурын үйл ажиллагааг зохион байгуулахад анхаарах сургамж цөөнгүй гарч байсан байна. Энэ талаар Фернандезийн судалгаанд⁸⁰ шинээр бий болсон сайн дурын хөдөлгөөнтэй холбогдох хоёр үндсэн эрсдэл байдгийг авч үзсэн байдаг. Үүнд:

Эхний эрсдэл бол гамшгийн тусламжийн үйл ажиллагааг удирдаж буй зохион байгуулагчид уг сайн дурынхныг үр дүнтэй удирдаж чадахгүй байх эрсдэл үүсдэг бөгөөд үүнээс улбаалан хүний амь үрэгдэх, гэмтэх, эд хөрөнгөөр хохирох зэрэг явдал гарснаар гамшгийн үйл ажиллагааг үр

⁸⁰ L.S.Fernandez, J.A.Barbera, J.R.Vandorp, Spontaneous volunteer response to disasters: the benefits and consequences of good intentions, J.Emerg.Manag. 4(5)(2006)57-68

дүнтэй удирдаж чадахгүй байгаа мэт сэтгэгдлийг олон нийтэд төрүүлдэг явдал болно.

Хоёр дахь эрсдэл бол мэргэжлийн түвшинд сургагдаагүй, албан ёсоор зохион байгуулалтад ороогүй сайн дурынхан нь өөрсдөө зохион байгуулагдаж буй тусламжийн үйл ажиллагааг тасалдуулж, гамшигт өртсөн хүмүүст хүрэх ёстой тусламжийн ажиллагаанд нөлөөлөх явдал байдаг. Энэ талын баримтыг дурдвал: 1999 онд Турк улсад болсон Голкукийн газар хөдлөлтийн үеэр 17000 хүн амь насаа алдсан ба яаралтай тусламж үзүүлэх үйлчилгээг тасалдуулсан зүйл нь туслах зорилгоор цугласан сайн дурынхан 32 км урт автомашины түгжрэлийн цуваа үүсгэсэн явдал байсан. Мөн сургагдаагүй, зохион байгуулалтгүй сайн дурынхан нь гамшгаас амьд үлдсэн хохирогчид, тусламж үзүүлж буй хүмүүс, бусад сайн дурынхандаа ч эрсдэл учруулах тохиолдол бий. 1985 оны Мехико хотын газар хөдлөлтийн үеэр мэргэшиж сургагдаагүй энгийн иргэд 800 хүний амийг аварсан боловч, бусдыг аврахаар ажилласан 100 сайн дурынхан амиа алдсан харамсалтай явдал гарч байв.⁸¹ Үүнтэй адилаар, Өмнөд Солонгос улсад болсон газрын тос алдагдсан гамшгийн үеэр гамшгийн голомтоос ялгардаг хорт бодис болон сөрөг нөлөөний талаарх мэдээлэл дутмаг байснаас болж олон сайн дурынхан хамгаалалтын хувцасгүй ажилласнаас үүдэн арьсны өвчнөөр өвдсөн тохиолдол гарсан байна.⁸² 1976 онд БНХАУ-ын Тангшанд болсон газар хөдлөлтийн үеэр 300.000 хүн нуранги доороос мөлхөж гарч ирсэн бөгөөд эдгээр хүмүүсээс маш олон хүн эрэл хайгуулын баг байгуулан ажиллаж, нурангид дарагдсан хүмүүсийн 80%-ийг аварсан жишээ бий.⁸³ Мөн 1995 онд Кобе хотод болсон газар хөдлөлтийн үеэр Японы болон гадаадын нэг сая сайн дурынхан ирж тусламжийн үйл ажиллагааг зохион байгуулсан⁸⁴ гэх мэт олон жишээ бий. Хэдийгээр сайн дурын хөдөлгөөн нь аливаа гамшиг ослын үед шинээр үүсэх нь тодорхой байдаг ч үүнд бүрэн найдах аргагүй юм. Кобегийн газар хөдлөлтийн үеэр ажиллаж байсан сайн дурынхан үргэлжлүүлэн ажилласаар Гамшгийн үед

⁸¹ I.Helsloot, A.Ruitenber, Citizen response to disasters: a survey of literature and some practical implications, J.Conting. Crisis Manage. 12(3)(2004) 98-111.

⁸² J.Y.Hur, Disaster management from the perspective of governance: case study of the Hebei Spirit oil spill, Disaster Prev. Manage. 21(3)(20)(2012) 288-298

⁸³ E.K. Noji, Earthquakes, in: E.K.Noji(Ed.), The Public Health Consequences of Disasters, Oxford University Press, New York, 1997, pp.135–178.

⁸⁴ R. Shaw, K.Goda, From disaster to sustainable civil society: the Kobe experience, Disasters28(1)(2004)16–40.

тусламж үзүүлэх Японы сайн дурынхны сүлжээ (NOVID) нэртэй байгууллага болон өргөжсөн байна.

Дэлхий нийтэд тулгарч буй сургамж, бэрхшээл.

1 Хотжилт: 2010 оны байдлаар дэлхийн нийт хүн амын 42% нь хотод амьдарч буй бөгөөд 2025 он гэхэд 10 том хот дутмын 7 нь Ази тивд байна гэсэн хүлээлттэй байгаа юм. Хэдийгээр эдгээр мега хотуудын эдийн засгийн өсөлт, ДНБ-д оруулах хувь нэмэр өндөр боловч ядуурал, тэгш бус байдал их байдаг. Энэхүү байдал нь сайн дурын үйл хэргийн боломж ба сорилт юм. Том хотуудын асуудлууд маш өргөн хүрээг хамардаг учир хот төлөвлөлт, засаглал болон иргэний оролцооны шинэ аргуудыг шаардаж байна.

2 Уур амьсгалын өөрчлөлт: Нийтийн баялгийн тэгш бус хүртээмж, байгалийн баялгийн ашиглалт нь уламжлалт техникийн болон тусламжинд суурилсан хамтын ажиллагаанаас илүүтэй шинэ арга хэлбэрийг шаардаж байна. Эдгээр асуудлууд хамтын хүчээр шийдэгдэх асуудлууд учир хүмүүс хоорондын харилцаа, урт хугацаанд тогтвортой хийх арга барилыг шаардаж буй тул олон тооны сайн дурын ажилтны хэрэгцээ гарч байна.

3 Халдварт өвчин ба өлсгөлөн: Нэг тэрбум орчим хүмүүмс өлсөж хоол тэжээлийн дутагдалтай амьдарч байна. Өнөөдөр 178 сая таваас доош насны хүүхдүүд тэжээлийн дутагдлын улмаас өлөн зэлмэн байдалтай, үүнээс 55 сая орчим нь архаг хоол тэжээлийн дутагдалтай байна. Байгалийн гамшгийн улмаас олон тооны хүмүүс орох оронгүй болсноор өвчлөл нэмэгдсэн. Гол шалтгаан нь тэжээллэг хүнс, ундны усны хүрэлцээгүй байдал ба эрүүл мэндийн үйлчилгээнд хамрагддаггүй явдал юм.

4 Дэлхийн дулаарал ба хүлэмжийн хийн дулаан ялгаруулалт: Дэлхийн хуурай газар, далайн гадаргуу орчмын агаарын дундаж температур ихсэх үзэгдлийг дэлхийн дулаарал гэж хэлдэг. Сүүлийн 100 жилд дэлхийн дундаж температур $0,74 \pm 0,18$ °C-аар нэмэгдсэн. Дулаарлын улмаас далайн усны төвшин, цаг уурын гол үзэгдэл ихсэж хур тунадасны хэмжээ өөрчлөгдөнө. Энэ нь хөдөө аж ахуй, мөсөн гол, мөнх цасны хэмжээ, амьтан ургамлын төрөл зүйлд сөргөөр нөлөөлж байна. Дэлхийн агаарын температур хоёр хэмээс дээш дулаарвал экологийн тэнцвэр алдагдаж гамшгийн хэмжээнд хүрнэ гэж үздэг. ХХ зуунд агаарын температур 0,9 хэмээр дулаарсан байна. Эрдэмтдийн судалгаагаар агаар мандал дахь хүлэмжийн хийг яаралтай бууруулахгүй бол ойрын 15 жилд дэлхийн температур 2-4 хэмээр дулаарах төлөвтэй байгаа нь гамшиг болоход ойрхон байна.

5 Албан ба албан бус сайн дурын хэргийн тодорхойлолт болон хэмжүүрийг судалсан судалгаа цөөхөн ба хэнийг сайн дурын ажилтанд тооцож байгаа, хүмүүс хир удаан хир давтамжтайгаар сайн дурын ажил хийдэг тухай тоо баримт хомс байна. Эрдэм шинжилгээний судалгаа, сайн дурын ажлын бүртгэл, хөгжингүй орнуудын номын сангийн сан бүрдүүлэлт хангалтгүй байдгаас болж сайн дурын ажлын хэмжүүр муу байна. 2011 онд сайн дурын үйл ажиллагааны төлөв байдлын тайланд Жонс Хопкинсын их сургууль, Галлап, Дэлхийн үнэ цэний судалгаа болон СИВИКУС иргэний нийгмийн индексээс боловсруулсан сайн дурын ажлын хэмжих хэмжүүрүүдийг харьцуулж дүгнэсэн бөгөөд дээрх байгууллагууд бүгд өөр тодорхойлолт, арга зүйг хэрэглэж, сайн дурын ажлын эзлэхүүн, аж байдал болон эдийн засгийн үр ашгийн талаар өөр өөр дүгнэлтэд хүрчээ. Гэвч тоо мэдээлэл нь ихэнхдээ эргэлзээтэй, маргаантай байсан.

Нэгдүгээр бүлгийн дүгнэлт

Энэхүү бүлэгт сайн дурын үйл ажиллагааны мөн чанар, зарчим болон сайн дурын үйл ажиллагааны олон улсын туршлагын судалгаа явууллаа. Сайн дурын үйл ажиллагааны мөн чанар, зарчмыг тодорхойлох онол арга зүйн судалгааг: *нэгд*, сайн дурын үйл ажиллагааны үндсэн ойлголтууд, сайн дурын үйл ажиллагаанд баримтлах зарчим *хоёрт*, сайн дурын үйл ажиллагааны үүсэл хөгжил ба орчин үе, *гуравт*, гамшгаас хамгаалахад сайн дурынхны үйл ажиллагааны онцлог, олон улсын туршлага, сургамж, бэрхшээл зэрэг асуудлын логик уялдааны хүрээнд авч үзлээ.

Судалгааны үр дүн дараах дүгнэлтүүд хийх боломжийг олголоо. Үүнд:

1 Сайн дурын үйл ажиллагаа нь нийгэм, эдийн засаг, улс төрийн харилцааны өргөн хүрээнд сайн дурын үйл ажиллагаа явуулах, сайн дурынхны янз бүрийн дэд бүлгүүдийн хууль ёсны хэм хэмжээ, уламжлал, зан үйлийн хэв маягийг бий болгож, сайн дурын ажилтнуудын бүтцийн харилцан үйлчлэлийн нийгмийн тогтолцоо болтлоо хөгжиж, өсвөр үе, залуучуудын дунд зохион байгуулах онцлогт анхаарлаа хандуулж, тэднийг нийгэмшүүлэх амьдралын практик гэж тодорхойлон сургалтын технологи болгон ашиглаж байна.

2 Сайн дурын үйл ажиллагааны мөн чанарыг нийгмийн ач холбогдол бүхий үйл ажиллагаа, иргэний идэвхтэй хэлбэр талаас нь эрдэмтэн судлаач, Олон улсын байгууллагаас гаргасан 4 тодорхойлолт, нийгэмд тустай хөдөлмөрийн хэлбэр талаас нь 7 тодорхойлолт, зарцуулагдах цаг, хугацааны хэлбэр талаас нь 2 тодорхойлолт бүгд 13 тодорхойлолт, ойлголтоор харьцуулан нэгтгэн судлахад сайн дурын үйл ажиллагаа нь цалин авдаггүй, өөрийн санаачилга, чөлөөт сонголт, сайн дурын үндсэн дээр, олон нийтийн ашиг, тусын тулд, ямарваа албадлага, шахалтгүйгээр, хувь хүний сонирхол байхгүй, хугацааны хувьд харилцан адилгүй шинж чанарыг агуулж байна.

3 Сайн дурын үйл ажиллагааны нийтлэг шинжүүд: *нэгд*, цаг хугацаа янз бүр, цаг агаар, газар нутгаас хамааралгүй, *хоёрт*, эдийн засаг, нийгмийн бүх салбарыг хамардаг, *гуравт*, цалин хөлс, шан харамж чухалчилдаггүй, *дөрөвт*, нас хүйс, үндэс угсаа, хэл шашин боловсролоор ялгаварладаггүй, *тавод*, ганцаарчилсан ба хэсэг бүлгээр хийгддэгт оршиж байгаа бол сайн дурын хөдөлгөөний шинжүүд нь: гишүүнчлэлгүй, сайн

дурын үндсэн дээр эвлэлдэн нэгддэг, бусдад туслах, нийгмийг хөгжүүлэх хүсэлд тулгуурлан, хийж бүтээснийхээ төлөө хариу нэхдэггүй, үргэлжлэх хугацаа янз бүр, өмнөө тавьсан зорилготой, үр өгөөж ихтэй байдаг байна.

4 Сайн дурын үйл ажиллагаа нь нийгэм, эдийн засаг, улс төрийн харилцааны өргөн хүрээнд сайн дурын үйл ажиллагаа явуулах, сайн дурынхны янз бүрийн дэд бүлгүүдийн хууль ёсны хэм хэмжээ, уламжлал, зан үйлийн хэв маягийг тусгаж, сайн дурын ажилтны үйл ажиллагааны хэв маягийг бий болгосон сайн дурын ажилтнуудын бүтцийн харилцан үйлчлэлийн нийгмийн тогтолцоо болжээ. Тиймээс ийм тогтолцооны бүтэц, үйл ажиллагааны зохицуулалт болон гамшгаас хамгаалах үйл ажиллагаанд оролцож буй сайн дурын ажилтны аюулгүй байдал, нийгмийн баталгааг хангах эрх зүйг уялдуулан хангах зохицуулалт тулгамдсан асуудал болж байна.

5 Сайн дурын үйл ажиллагааны үүсэл, хөгжлийн түүхийг авч үзэхэд аль ч үндэсний түүх соёл, шашин шүтлэг, уламжлалт зан заншил, нийгэм, аж байдлаас үүдэлтэй бие биедээ туслах санаанаас үүсэж, нийгмийн нэгэн эд эс болон хөгжиж, орчин үеийн хөгжлийн чиг хандлагад тулгуурлан ХХ зууны сүүлчээс эхлэн улс төр, нийгэм, эдийн засаг, соёл хоорондын олон тооны судалгааны үндсэн дээр сайн дурын ажлын онол хөгжиж эхэлжээ.

Сайн дурын үйл ажиллагааны олон улсын туршлагыг судлахдаа *нэгд*, сайн дурын үйл ажиллагааны эрх зүйн зохицуулалт, *хоёрт*, сайн дурын үйл ажиллагааны үндсэн чиглэл, бүтэц зохион байгуулалтын туршлагын талаар харьцуулалт хийлээ. Судалгааны үр дүн:

1 Сайн дурын үйл ажиллагаа өндөр хөгжсөн улс орнуудын эрх зүйн зохицуулалтад сайн дурын үйл ажиллагааны хамрах хүрээ, сайн дурын ажилтны эрх, үүрэг, сайн дурын үйл ажиллагааны хариуцлага, сайн дурын үйл ажиллагаа явуулах байгууллага, түүний үйл ажиллагаа, үүрэг, сайн дурын байгууллагын санхүүжилт ба татварын хөнгөлөлт, сайн дурын үйл ажиллагааг урамшуулах механизм гэсэн төрлүүдээр зохицуулсан байдаг байна.

2 Сайн дурын үйл ажиллагааны үндэсний хууль тогтоомжийн дүн шинжилгээг харьцуулан судлахад БНСУ-ын хууль эрх зүйн зохицуулалтын зорилго, хамрах хүрээ, сайн дурын ажилтны эрх үүрэг, урамшуулал, хөнгөлөлтийн нөхцөлийг илүү сайн судалсны үндсэн дээр манай оронд зарим зүйл, заалтыг авч хэрэгжүүлж болохоор байна гэж үзэж байна.

3 Олон улсын туршлагаас харахад сайн дурын үйл ажиллагааг бодлогоор дэмжлэг үзүүлдэг хууль тогтоомжуудаас нийгмийн даатгал,

татвар, иргэний хариуцлага, гадаадын иргэдийн эрх зүйн байдал, хөдөлмөрийн зэрэг хууль шийдвэрлэх ач холбогдолтой байдаг байна.

4 Ихэнх улс орнууд экологи, хүрээлэн буй орчныг хамгаалах, боловсрол сургалт, соён гэгээрүүлэх, ядуурлыг бууруулах, устгах, гамшгийн хор хөнөөлийг арилгах, хүмүүнлэгийн үйлс, эрүүл мэнд, биеийн тамир, эрүүл мэндийн асаргаа сувилгаа, нийгмийн халамж, тусламж үйлчилгээ, хүүхэд, залуучууд, орлого багатай иргэдийг хамгаалах зэрэг чиглэлээр сайн дурын үйл ажиллагаа явуулж байгаа нь судалгаанаас харагдаж байна.

Орчин үед олон улсын түвшинд сайн дурын сүлжээнүүд технологи ашиглан холбоо байгуулж, сайн дурын үйл хэргийг амжилтад хүргэн, түүнд оролцогч талуудыг хооронд нь холбож, гар утас болон бусад мэдээлэл, холбооны орчин үеийн технологи ашиглан сайн дурын үйл ажиллагааны хүртээмж, хамрах хүрээг тэлж, сайн дурын үйл ажиллагаанд оролцох хүсэлтэй хүмүүс болон бүлгүүдийг нэгтгэн, бие биеэсээ суралцан, шинэ нөөц боломжуудыг дайчлан ажиллаж, Засгийн газар сайн дурынхны оролцоо, санаачилгыг дэмжсэн орчин, орон зайг бүрдүүлэх нь сайн дурын үйл ажиллагааны хөгжилд үнэтэй хувь нэмэр оруулдгийг олон орны туршлага, сургамж харуулж байна.

Цаашид манай оронд сайн дурын хөдөлгөөнийг хөгжүүлэхэд тусламж хүртэгчдийн загвараас илүү харилцан үйлчлэлийн загварт шилжиж, залуучууд, ахмад үеийнхэн, төрийн албан хаагчдыг татан оролцуулах, сайн дурын ажиллагааг удирдах мэргэжилтэн, менежерүүдийг сургаж бэлтгэх тогтолцоо бүрдүүлэх, нийгмийн хөгжилд оруулж буй хөдөлмөр зүтгэлийг нь үнэлж хүлээн зөвшөөрөх, үндэсний тайланд тусгах, сайн дурын үйл ажиллагааны талаар олон нийтэд зөв ойлголт өгөх хэрэгцээ, шаардлага байна гэж дүгнэж байна.

Гамшгаас хамгаалахад сайн дурынхны үйл ажиллагааг судлахдаа нэгд, гамшгаас хамгаалах үйл ажиллагаа хоёрт, олон улсын туршлага гуравд, сургамж, бэрхшээлийг судалж дараах дүгнэлтийг хийлээ. Судалгааны үр дүн:

1. “Гамшгийн эрсдэлийг бууруулах Сендайн үйл ажиллагааны хүрээ 2015-2030 баримт бичиг баталж, гамшгийн эрсдэлийг ойлгох, гамшгийн эрсдэлийг удирдах засаглалыг бэхжүүлэх, гамшгийг даван туулах чадварыг бэхжүүлэхэд чиглэсэн эрсдэлийг бууруулах үйл ажиллагаанд хөрөнгө оруулах, гамшгийн бэлэн байдлыг хангах, сэргээн босгох нөхөн сэргээх

шатанд “сайжруулан барих” үйл ажиллагааг хэрэгжүүлэх зорилтууд дэвшүүлж, ТББ, сайн дурын байгууллага, олон нийтийн оролцоонд тулгуурласан байгууллагууд, мэргэжлийн холбоод, хүмүүнлэгийн сангуудын олон улсын хамтын ажиллагаа, улс орнуудын нөхөрлөлийн шинэ эрин эрин үе эхэлсэн. Засгийн газрын бус сайн дурын байгууллагууд өөрсдийгөө дэлхийн гамшгийн эрсдэлийг бууруулах болон хүмүүнлэгийн экосистемийн нэг хэсэг болгон өөрчилж, санхүүгийн болон санхүүгийн бус зуучлалын чиглэлээр зуучлалын үүрэг гүйцэтгэж, олон улсын хөгжил төдийгүй дэлхийн хүмүүнлэгийн салбарын гол оролцогчид болон гарч ирсэн байна.

2. Гамшгаас хамгаалах үйл ажиллагаанд сайн дурынхны оролцоог судалж үзэхэд бусад салбарт оролцож байгаа сайн дурынхандаа харьцуулж үзэхэд тавигдах шаардлага нь илүү өндөр зохион байгуулалт, дэг журам, түүнийг мөрдөж ажилладаг онцлогтой.

3. Гамшгийн үеийн үйл ажиллагаанд оролцдог сайн дурынхны идэвхтнүүдийг дараах төрлүүдэд ангилан авч үзэхэд гамшгийн менежментийн хөтөлбөрийн хүрээнд сургагдсан сайн дурынхны идэвхтнүүд, үндэсний нийгэмлэгийн сайн дурын идэвхтнүүд, гамшгийн үеийн үйл ажиллагаанд оролцохыг хүссэн жирийн иргэд, бизнесийн салбарын сайн дурынхны ажилтнууд, олон улсын сайн дурын идэвхтнүүд, онлайн сайн дурын идэвхтнүүд гэсэн төрөлтэй байна. Тэдгээр нь гамшгийн өмнөх үе, гамшгийн үе, гамшгийн дараах үед үүрэг гүйцэтгэх чадвартай бэлтгэгдсэн байдаг.

ХОЁРДУГААР БҮЛЭГ. ГАМШГААС ХАМГААЛАХАД САЙН ДУРЫНХНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРОЛЦООНЫ ӨНӨӨГИЙН БАЙДЛЫН ШИНЖИЛГЭЭ

§2.1. Гамшгаас хамгаалахад сайн дурынхны үйл ажиллагааны эрх зүйн зохицуулалтын өнөөгийн байдалд хийсэн шинжилгээ.

Гамшгаас хамгаалах бодлого, гамшгийн эрсдэлийг бууруулах, гамшгийн эрсдэлийн менежментийг хэрэгжүүлэхэд бие биеэсээ харилцан хамааралтай, нийгмийн олон талт харилцааг зохицуулсан эрх зүйн зохицуулалт шаардлагатай. Бидний хийсэн судалгаагаар гамшгаас хамгаалах, гамшигтай тэмцэх, гамшгийн эрсдэлийг бууруулах талаар 80 гаруй хуульд эрх зүйн зохицуулалт орсон. Мөн гамшгаас хамгаалах, гамшигтай тэмцэх, гамшгийн эрсдэлийг бууруулах төрийн бодлогыг тусгасан үндэсний хөтөлбөр 20 гаруй, холбогдох дүрэм, журам 30 гаруй байгаагаас Иргэний нийгмийн байгууллагаар дамжуулан иргэд, сайн дурынхантай холбоотой заалт, зүйлийг тусгасан 14 хууль, 14 бодлогын баримт бичигт дүн шинжилгээ хийв. Шадар сайдын тушаал, ОБЕГ-ын даргын тушаалаар батлагдсан журам заавар, үзүүлэлт, загварын дагуу явагдаж байгаагаас Монгол Улсын Шадар сайдын тушаалаар баталсан гамшгаас хамгаалах сайн дурын үйл ажиллагааны журам-1, Хөдөлмөр Нийгэм хамгааллын сайдын баталсан Залуучуудын сайн дурын ажилтай холбоотой журам -1, ОБЕГ-ын даргын тушаалаар баталсан “Гамшгаас хамгаалах сайн дурын ажиллагааны заавар - 1 тус тус байна.

2017 онд гамшгаас хамгаалах тухай хуулийг шинэчлэн найруулахдаа орчин үеийн гамшгаас хамгаалах бодлого, стратегид нийцүүлэн, төрийн бус байгууллага, гамшгаас хамгаалах сайн дурынхан, сайн дурын хэсгийн эрх, үүрэг, олон улсын хүмүүнлэгийн тусламжийн зохицуулалтын талаар илүү боловсронгуй болгон хуульчилсан юм.

Гамшгаас хамгаалах үйл ажиллагаанд нутгийн өөрөө удирдах болон нутгийн захиргааны байгууллага, гамшгаас хамгаалах алба, аж ахуйн нэгж байгууллага, хуулийн этгээд, төрийн бус байгууллага, иргэд, сайн дурын хэсэг, сайн дурынхны оролцоог уялдуулан зохицуулах талаар гамшгаас хамгаалах тухай хууль болон бусад холбогдох хууль, эрх зүйн зохицуулалтад дүн шинжилгээ хийснийг хүснэгт 11-д үзүүлэв.

Д/д	Оролцогч талуудын жагсаалт	Гамшгаас хамгаалах тухай хууль		Галын аюулгүй байдлын тухай хууль	
		2003	2017	1999	2015
1.	Нутгийн өөрөө удирдах байгууллагын бүрэн эрх		3		
2.	Засаг даргын бүрэн эрх	13	14	6	8
3.	Гамшгаас хамгаалах албаны чиг үүрэг	12	15		
4.	ААНБ, хуулийн этгээдийн эрх/үүрэг	0/10	2/9	0/9	3/12
5.	ТББ-ын эрх, үүрэг		5		
6.	Сайн дурын хэсэг, гэрээт албаны үүрэг		9	9	3/12
7.	Иргэний эрх/үүрэг	0/8	5/7	3/4	8/5
Нийт заалтын тоо		34	7/62	3/28	14/37

Хүснэгт 11., Гамшгаас хамгаалах тухай, Галын аюулгүй байдлын тухай хуулиуд дахь оролцогч талуудын зохицуулалтад хийгдсэн шинэчлэлийн харьцуулалт

Эдгээр суурь хуулиудын үзэл баримтлал гамшгаас урьдчилан сэргийлэх, гамшгийн эрсдэлийг бууруулахад бүхэлдээ чиглэж, гамшгийн эрсдэлийн удирдлагын засаглалыг сайжруулах, ялангуяа иргэд, олон нийт, сайн дурынхын оролцоог нэмэгдүүлэхэд чиглэгдсэн. Эдгээр хуулиудад холбогдох оролцогч 7 талуудын эрх зүйн зохицуулалт гамшгаас хамгаалах тухай хуульд 34 заалтаас 7 зүйл 62 заалт болж нэмэгдэж, Галын аюулгүй байдлын тухай хуульд 3 зүйл 28 заалтаас 14 зүйл 37 заалттай болж өссөн байна⁸⁵. Үүний дотор галын аюулгүй байдлын тухай 1999 оны хуульд сайн дурын хэсэг, сайн дурынхантай холбоотой эрх байхгүй, үүрэг 9 заалттай байснаас 2015 онд батлагдсан хуульд эрх 3, үүрэг 12 заалттай болж өссөн, Гамшгаас хамгаалах тухай 2003 онд батлагдсан хуульд сайн дурынхны эрх, үүрэг аль аль нь байхгүй байсан бол 2017 онд батлагдсан хуульд сайн дурынхны оролцооны үүрэг 9 заалтаар тус тус нэмэгдсэн нь гамшгаас хамгаалах үйл ажиллагаанд сайн дурын хэсэг, сайн дурынхан, гэрээт байгууллагын үүрэг, оролцоо өндөр байгааг харуулж байна. (Хүснэгт 11-д үзүүлэв).

Гамшгаас хамгаалах үйл ажиллагаанд төрийн бус байгууллага, сайн дурынхны оролцооны талаарх эрх зүйн зохицуулалтын өнөөгийн байдлын дүн шинжилгээг Монгол Улсын Үндсэн хууль, түүнд нийцүүлэн гаргасан

⁸⁵ ОБЕГ, ГСХ Гамшгаас хамгаалах бодлого, стратеги. 66 дахь тал. Уб., 2020.

хууль болон хуулийн заалттай нийцүүлэн боловсруулагдсан бодлогын баримт бичиг, түүнийг хэрэгжүүлэх бусад эрх зүйн акт гэсэн гурван чиглэлээр гүйцэтгэлээ.

Нэг. Монгол Улсын хуулиуд.

Сүүлийн үед олон улсын болон үндэсний бодлогын баримт бичгүүдэд гамшгаас хамгаалах үйл ажиллагаанд иргэний нийгэм-хувийн хэвшил-төрийн түншлэлийг бэхжүүлэх замаар үндэсний хөгжлийн бодлого, төлөвлөлт, хэрэгжилтэд хамаарал бүхий талуудын оролцоог хангасан зохистой тогтолцоог бүрдүүлэх зорилт чухал байр суурийг эзэлж байгаа болохоор судлагдаж байгаа сэдвийн хүрээнд Монгол Улсын хуулиудад нутгийн өөрөө удирдах байгууллага болон нутгийн захиргааны байгууллага, аж ахуйн нэгж байгууллага, иргэд, төрийн бус байгууллага, сайн дурынхны гамшгаас хамгаалах үйл ажиллагаанд оролцох, эрх, үүрэг, харилцан ажиллагааны уялдаа холбоотой заалтуудыг авч үзэж, шинжлэн судалж, дүгнэлт гаргахыг зорилоо.

Д/д	Хуулийн нэр	Иргэдийн Төлөөлөгчдийн хурал	Засаг дарга	Аж ахуйн, нэгж байгууллага	Иргэд	ТББ, Сайн дурынхан	Бүгд
1.	Гамшгаас хамгаалах тухай хууль.	1/3	1/17	1/2	1/11	1/5	5/38
2.	Галын аюулгүй байдлын тухай хууль.		1/3	1/9	1/7		3/20
3.	Ус цаг уур, орчны хяналт шинжилгээний тухай хууль		1/3	1/2	2/5		4/10
4.	Ойн тухай хууль .		2/13	3/6	1/10		6/29
5.	Эрүүл мэндийн тухай хууль.2011.05.05.	1/1	1/3	1/1	1/4	1/3	5/12
6.	Нийгмийн халамжийн тухай хууль.				3/3		3/3
7.	Байгаль орчныг хамгаалах тухай хууль.	1/4	2/4	1/5	2/8	3/7	8/24

8.	Ургамал хамгааллын тухай хууль.	2/5		1/1	1/1		4/7
9.	Донорын тухай хууль.	1/2	1/2	2/3		1/4	5/11
10	Химийн хорт бодис болон аюултай бодисын тухай хууль.			3/3			3/3
11	Цацрагийн хамгаалалт, аюулгүй байдлын тухай хууль.	1/1	1/1	1/2	1/6		᠑᠐/10
12	Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль.	1/2	3/7				3/9
13	Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хууль.	1/2	1/4	1/7	1/7		4/20
14	МУЗН-ийн эрх зүйн байдлын тухай хууль.		1/3	1/6		1/2	3/11
15	Залуучуудын хөгжлийг дэмжих тухай хууль.	1/1	1/4	1/1		1/5	5/11
16	Үндэсний аюулгүй байдлын тухай хууль.	1/1	1/1	1/2	1/2		4/6
17	Хүүхэд хамгааллын тухай хууль.	1/1		5/6		4/4	10/11
	Бүгд	12/21	18/64	24/66	15/64	11/30	79/245
	Заалтуудын эзлэх хувь (%)	8,6	26,1	26,9	26,1	12,3	

Хүснэгт 12., Монгол Улсын хуульд гамшгаас хамгаалах үйл ажиллагаанд оролцоог хангах талаар тусгасан заалтуудын судалгааны дүн

Гамшгаас хамгаалах үйл ажиллагаанд орон нутгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурал, Бүх шатны засаг дарга, аж ахуйн нэгж байгууллага, иргэд, Төрийн бус байгууллага, сайн дурынхан гэсэн 5 оролцоогоор дээрх 17 хуульд бүх түншлэл, хамтын ажиллагааг хангахтай холбоотой зохицуулалтыг ангилан авч үзэхэд бүх шатны иргэдийн төлөөлөгчдийн хурлын бүрэн эрх хэмжээ тогтоосон нь 21 заалт буюу 8,6 %, бүх шатны засаг даргын бүрэн эрх хэмжээ тогтоосон 64 заалт буюу 26,1 %, аж ахуйн нэгж байгууллагын үүргийг тодорхойлсон нь 66 заалт буюу 26,9 %, иргэдийн үүргийг тодорхойлсон нь 64 заалт буюу 26,1%, Төрийн бус байгууллага, сайн дурынхантай холбоотой заалтууд нь 30 буюу 12,3 % тус тус байгаагаас Бүх шатны засаг дарга, аж ахуйн нэгж байгууллага, иргэдийн

бүрэн эрх хэмжээ тогтоосон заалтууд хамгийн өндөр, ойролцоо хувьтай байгаа нь зүй тогтлын хувьд зөв байна гэж дүгнэхээр байна. Харин орон нутгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын бүрэн эрхийн хэмжээ нь хамгийн бага 21, Төрийн бус байгууллага, сайн дурынхны бүрэн эрх, хэмжээ тогтоосон нь 30 заалт буюу 12,3 % -тай байгаа нь гамшгаас хамгаалах үйл ажиллагаанд сайн дурынхны үүрэг, оролцоо өсөн нэмэгдэж байгааг илтгэж байна.

Судалгаанаас харахад гамшгаас хамгаалах арга хэмжээнд бүх шатны Засаг дарга, аж ахуйн нэгж байгууллага, иргэний үйл ажиллагааны зохицуулалт, бүрэн эрх үүрэг, оролцоог тодорхойлсон заалтууд ойролцоо хувьтай, ***төрийн бус байгууллага, сайн дурынхны оролцоог хангасан заалт бага хувьтай байна.*** Гэвч иргэн, байгууллагатай холбоотой заалтын агуулга нь бүхэлдээ үүрэгжүүлсэн шинжтэй зохицуулалтаар тодорхойлогдож, харин тэдгээрийн хэрхэн гамшгаас хамгаалах бэлэн байдлаа хангах, эрсдэлийг бууруулах чиглэлд зохион байгуулалттай ажиллах, төрөөс уг санаачилгыг дэмжих гэх мэт нарийвчилсан заалтууд нь тодорхой бус байгаа нь судалгаанаас харагдлаа.

Гамшгаас хамгаалах тухай хуульд гамшгаас хамгаалах үйл ажиллагаанд сайн дурын оролцооны талаар авч үзвэл: 3.2.5-д “иргэдийн гамшгаас хамгаалах мэдлэгийг дээшлүүлэх, ардын уламжлалт арга ухааныг түгээн дэлгэрүүлэх”, 3.3.4-д “гамшгийн үед үзүүлэх хүмүүнлэгийн тусламжийг зохицуулах эрх зүйн орчныг бий болгох”, 4.1.18-д “сайн дурын хэсэг” гэж сайн дурын үндсэн дээр гамшгаас хамгаалах үйл ажиллагаанд оролцохоор зохих сургалтад хамрагдсан иргэдийг”, 13.3.3-д “сум дүүргийн мэргэжлийн анги, гамшгаас хамгаалах сайн дурын хэсгийн сургалтыг тухайн шатны Засаг дарга”, 18.3-д “эрэн хайх, аврах ажиллагаанд оролцож байгаа сайн дурын хэсэг, иргэн шуурхай бүлгийн удирдагчийн зааврын дагуу үүрэг гүйцэтгэнэ”, 22.7-д “сум, баг, хороонд нутгийн иргэдэд түшиглэн гамшгаас хамгаалах сайн дурын хэсгийг байгуулж болно”, 24.1-д “гамшгаас хамгаалах хүч хэрэгсэл нь онцгой байдлын асуудал эрхэлсэн байгууллагын алба хаагч, цэргийн албыг дүйцүүлэн хааж байгаа болон цэргийн жинхэнэ алба хаасан иргэн, гамшгаас хамгаалах сайн дурын хэсэг, хуулийн этгээд, түүний техник хэрэгсэл байна”, 32.1.2-д “нутаг дэвсгэрийн онцлогт нийцүүлэн гамшгаас хамгаалах алба, мэргэжлийн анги, сайн дурын хэсгийг байгуулах, тэдгээрийг гамшгийн үед үүрэг гүйцэтгэх, дадлага чадвартай болгох”, 35.1.4-д “гамшгаас хамгаалах үйл ажиллагаанд иргэн,

сайн дурын хэсэг, бүлэг, нөхөрлөлийн оролцоог идэвхжүүлэхэд дэмжлэг, туслалцаа үзүүлэх”, 36.2-д “сайн дурын хэсгийн ажилтан гамшгаас хамгаалах үйл ажиллагаанд оролцох үед хөдөлмөрийн чадвараа бүрэн алдсан, хөгжлийн бэрхшээлтэй болсон бол түүнд онцгой байдлын байгууллагын албан хаагчийн ахлагчийн албан тушаалын зэрэглэлийн анхны шатлалын үндсэн цалингаар тооцон 2 жилийн, амь насаа алдсан бол түүний гэр бүлд 5 жилийн цалинтай тэнцэх хэмжээний нэг удаагийн буцалтгүй тусламж олгоно”, 36.3-д “сайн дурын хэсэг нь тухайн шатны Засаг даргад гамшгаас хамгаалах чиглэлээр явуулж байгаа үйл ажиллагаагаа тайлагнана”, 36.4-д “гамшгаас хамгаалах сайн дурын хэсгийн ажиллах журмыг онцгой байдлын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална”, 37.1.2-д “гамшгаас хамгаалах сайн дурын хэсэг байгуулах, гишүүнээр элсэх, гамшгаас хамгаалах дундын хөрөнгийн сан үүсгэх”, 39.4-д “Монголын улаан загалмай нийгэмлэг нь Олон улсын улаан загалмай, улаан хавирган сар нийгэмлэг, холбоонд хандан гамшгаас хамгаалах хүмүүнлэгийн тусламж хүсэх, хүлээж авах, бүртгэх, байршуулах, хадгалах, тээвэрлэх, хуваарилах үйл ажиллагааг хууль тогтоомжийн хүрээнд хэрэгжүүлнэ” гэж тус тус хуульчилсан нь сайн дурын хэсэг, сайн дурын хэсгийн сургалт зохион байгуулалт болон гамшгаас хамгаалах үйл ажиллагаанд иргэд, олон нийт, сайн дурын хэсэг, орон нутгийн засаг захиргаа, хуулийн этгээдийн үйл ажиллагааны уялдаа холбоог чухалчилж авч үзсэн байна.

Эндээс харахад Гамшгаас хамгаалах тухай хууль-д Төрийн бус байгууллага, МУЗН-ийн үйл ажиллагаатай холбоотой 8 заалт, гамшгаас хамгаалах сайн дурын хэсгийн эрх үүрэг, үйл ажиллагаатай холбоотой мөн 8 заалт, сайн дурын ажилтан гэмтэж бэртэж, хөдөлмөрийн чадвараа алдах эрсдэлтэй холбоотой 1 заалт, олон улсын хүмүүнлэгийн тусламжийн зохицуулалттай холбоотой 8 заалт бүгд 25 заалт тусгалаа олсон нь иргэний нийгмийн байгууллагуудыг хүлээн зөвшөөрч түншлэл, хамтын ажиллагааны хүрээнд идэвхтэй хамтрах, хууль тогтоомж, зөвлөмж арга зүй боловсруулахад тэдний дуу хоолойг сонсох, шийдвэр гаргалтад үр ашигтай нөлөөлөх сайн хэлбэр болж байгаа нь олон улсын хамтын шийдвэр, бүс нутгийн өмнө тавигдсан зорилго, зорилтуудыг шийдвэрлэхэд сайнаар нөлөөлнө гэж үзэж байна.

“Галын аюулгүй байдлын тухай хууль”⁸⁶-д сайн дурын үйл ажиллагаатай холбоотой заалтууд тухайлбал, 10.2-д гал түймэртэй тэмцэх нэгж нь 4 төрөл байна гэж үзсэний нэг төрөл нь гал түймэртэй тэмцэх сайн дурын хэсэг гэж тусгасан. Мөн хуулийн 10.3-д “гал түймэр унтраах аврах ангийг улсын төсвөөс, гал түймэртэй тэмцэх гэрээт ангийг иргэн, аж ахуйн нэгж байгууллагатай байгуулсан гэрээний үндсэн дээр улсын төсвөөс, гал түймэртэй тэмцэх хэсгийг тухайн иргэн, байгууллага, гал түймэртэй тэмцэх сайн дурын хэсгийг тухайн орон нутгийн төсвөөс тус тус санхүүжүүлнэ”, 14.1-д “гал түймэртэй тэмцэх сайн дурын хэсэг орон нутгийн засаг, захиргааны санаачилгаар сайн дурын үндсэн дээр нэгдэж, объектын болон ой, хээрийн түймрээс урьдчилан сэргийлэх, гал түймрийг унтраах чиг үүргийг орон нутгийн хэмжээнд хэрэгжүүлэх зорилгоор хязгаарлагдмал хүрээнд зохион байгуулагдана”, 14.2-д гал түймэртэй тэмцэх сайн дурын ажилтан гал түймэр унтраах чиг үүргээ гүйцэтгэж яваад эрүүл мэнд нь хохирсон, амь насаа алдсан тохиолдолд онцгой байдлын алба хаагчийн нэгэн адил тэтгэвэр, тэтгэмж олгоно, 15.1.4-д “нутаг дэвсгэртээ гал түймэртэй тэмцэх сайн дурын хэсэг ажиллуулах зардлыг жил бүрийн орон нутгийн төсөвт тусган шийдвэрлүүлэх”, 15.1.5-д “гал түймэр унтраах аврах анги, гал түймэртэй тэмцэх сайн дурын хэсгийн үйл ажиллагааг хэвийн явуулах нөхцөлөөр хангах”, 16.1.7-д “иргэн нь гал түймэртэй тэмцэх сайн дурын хэсэгт ажиллах эрх эдэлнэ, үүрэг хүлээнэ.” 17.2.11-д “аж ахуйн нэгж байгууллага нь галын аюулгүй байдлыг хангах талаар байгууллагын хэмжээнд галын сайн дурын бүлгэм ажиллуулах”, 18.2-д “... алслагдсан суурин газарт 2000 хүн ам тутамд гал түймэр унтраах аврах анги, эсхүл гал түймэртэй тэмцэх сайн дурын хэсэг үйлчилж байхаар тусгана”, 18.6-д “гал түймрийн онц аюултай болон гал түймрийн аюултай нэг, хоёрдугаар зэргийн барилга, байгууламж нь сайн дурын үндсэн дээр гал түймрийн үнэлгээ хийлгэнэ” гэж тус тус заажээ.

”Монголын Улаан Загалмай нийгэмлэгийн эрх зүйн байдлын тухай”⁸⁷ хуулийн 6.1-д “Монголын Улаан Загалмай Нийгэмлэгийн зорилго нь зэвсэгт мөргөлдөөн ба нийтэд учирсан гамшигт байдлын үед хүн амд эрүүл мэнд, нийгэм сэтгэл зүйн тусламж үзүүлэхээс гадна хүнийг зовлон зүдгүүрт өртөхөөс сэргийлэх, учирсан зовлон зүдгүүрийг хөнгөвчлөх, шударга ёсны зарчимд үндэслэн хүнийг яс үндэс, иргэний харьяалал, угсаа,

⁸⁶ “Галын аюулгүй байдлын тухай хууль”. “Төрийн мэдээлэл” эмхэтгэл № 28. 2015

⁸⁷ Монголын Улаан Загалмай Нийгэмлэгийн эрх зүйн байдлын тухай хууль. “Төрийн мэдээлэл” эмхэтгэл. № 5. 2016.

хэл, арьсны өнгө, нас, хүйс, бэлгийн чиг хандлага, нийгмийн гарал байдал, хөрөнгө чинээ, эрхэлсэн ажил, шашин шүтлэг, улс төрийн үзэл бодол, боловсролоос үл хамааран хүний аюулгүй байдал, амь нас, эрүүл мэндийг хамгаалах, хүмүүнлэг ёсыг хангахад дэмжлэг, туслалцаа үзүүлэх, хүмүүс хоорондын ойлголцол, нөхөрлөл, хамтын ажиллагааг дэмжих, энх тайвныг бэхжүүлэх үйлсэд хувь нэмэр оруулахад оршино”, 6.2.-д “гамшиг, гэнэтийн ослоос урьдчилан сэргийлэх, бэлэн байдлыг хангах, эрсдэлийг бууруулах, нөхөн сэргээх үйл ажиллагааг зохион байгуулах, нэрвэгдэгсдэд яаралтай тусламж үзүүлэх, хүн амд гамшгийн үед арга хэмжээ авах талаар мэдлэг олгох”, 6.2.4-д “сайн дурын үйл ажиллагааг дэмжих, зэвсэгт мөргөлдөөн гамшиг болон бусад хүчирхийлэлд өртсөн нэн эмзэг бүлгийн хүмүүст халамж үйлчилгээ үзүүлэх, амьжиргаа, амьдралын чанарыг дээшлүүлэхэд төрд нэмэлт хүч болон ажиллах”, 6.2.9-д “сайн дурын авлагагүй донорын хөдөлгөөн өрнүүлэх, сурталчлах ажлыг үндэсний хэмжээнд зохион байгуулах”, 6.3.4-д “олон нийтийн оролцоонд түшиглэн нийгмийн эмзэг бүлэгт халамжийн үйлчилгээ үзүүлэх” гэж тус тус заасан.

“Эрүүл мэндийн тухай хууль”⁸⁸-ийн 8.1.5-д хүн амын эрүүл мэндийг хамгаалах, дэмжих талаар иргэд, төрийн болон төрийн бус байгууллагад мэргэжил, арга зүйн туслалцаа үзүүлэх; 8.1.15-д эрүүл мэндийн салбарын төр, хувийн хэвшлийн түншлэлийн бодлогыг тодорхойлох, түншлэл, концессын төсөл, хөтөлбөрийг төлөвлөх, хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах, эрүүл мэндийн асуудлаар хувийн хэвшил, төрийн бус байгууллага болон гадаад улс, олон улсын байгууллагатай хамтран ажиллах; 13.7-д хүн амыг олноор хамарсан халдварт өвчний дэгдэлт болон аюулт үзэгдлийн үед голомтыг хязгаарлах, цомхотгох, хохирлыг багасгахад чиглэсэн эрүүл мэндийн байгууллагын дангаар болон төр, олон нийт, аж ахуйн нэгж, байгууллага, иргэдтэй хамтран үзүүлэх гамшгийн үеийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээг Гамшгаас хамгаалах тухай хуульд заасны дагуу байгуулагдсан гамшгаас хамгаалах эрүүл мэндийн алба мөн хуульд заасны дагуу зохион байгуулна, 16.2-д өрхийн эрүүл мэндийн төв нь хот, суурин газрын хүн амд төрөөс үзүүлэх өрхийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээг гэрээгээр гүйцэтгэх үндсэн чиг үүрэг бүхий сайн дурын үндсэн дээр бүртгүүлсэн хувийн хэвшлийн эрүүл мэндийн байгууллага байна, *Эрүүл мэндийг хамгаалах дэмжихэд төрийн бус байгууллагын оролцооны талаар*: 45.1.1-д эрүүл

⁸⁸ Эрүүл мэндийн тухай хууль. “Төрийн мэдээлэл” эмхэтгэл. № 21. 2011.

мэндийн тухай хууль тогтоомжийн биелэлтэд олон нийтийн хяналт тавих, илэрсэн зөрчлийг арилгахыг шаардах, уг асуудлыг эрх бүхий байгууллагад тавьж шийдвэрлүүлэх, 45.1.2-д эрүүл мэндийг дэмжих хамгаалах үйл ажиллагаанд хамт, олон иргэнийг оролцуулах, эрүүл зан үйл төлөвшүүлэхэд чиглэсэн сургалт, сурталчилгаа, эрүүл мэндийн боловсрол олгох ажлыг дангаар болон бусад байгууллагатай хамтран зохион байгуулах, 45.3-д эрүүл мэндийн салбарын зарим ажил, үйлчилгээг төрийн бус байгууллагаар сайн дурын үндсэн дээр гүйцэтгүүлэхээр хуульчилсан.

“Донорын тухай хууль”⁸⁹-д сайн дурын үндсэн дээр байгууллага, иргэдийн оролцоог идэвхжүүлэх талаар 21.1-д цусны донорын эгнээг өргөжүүлэх зорилгоор донорын хөдөлгөөнийг сурталчлах, элсүүлэх ажлыг Монголын Улаан Загалмай Нийгэмлэг, төрийн болон төрийн бус байгууллага, аж ахуйн нэгжтэй хамтран зохион байгуулна, 21.2-д төрийн болон төрийн бус байгууллага, аж ахуйн нэгж, албан тушаалтан, иргэн, донорын эгнээг өргөжүүлэх үйл ажиллагаа, үйлсийг сурталчлах, тэдгээрт зориулсан сургалт явуулахад цусны асуудал хариуцсан байгууллагад дэмжлэг үзүүлэх, 22.1-д цусны байнгын болон амьд донорт эмнэлгийн тусламж, үйлчилгээг хөнгөлөлттэй үзүүлэх, жилд нэг удаа эрүүл мэндийн үзлэгт үнэ төлбөргүй хамруулах, цусаа 35-аас дээш удаа өгсөн донорыг магадлан итгэмжлэгдсэн дотоодын рашаан сувилалд жилд нэг удаа үнэ төлбөргүй сувилуулах, 13.1.1-д цус, эс, эд эрхтнээ өгөх явцдаа өөрийн эрүүл мэнд, амь нас аюулгүй байх эрхээр хангагдана, 13.1.2-д донорын үүргээ гүйцэтгэх үедээ Хөдөлмөрийн тухай хуулийн 64.1-д заасан дундаж цалин хөлстэй тэнцэх олговор авах, 13.1.4-д Донор нь цус, эс, эд, эрхтнээ өгөхдөө тухайн ажилбарыг гүйцэтгэх байгууллагатай гэрээ байгуулах, заавал даатгуулах болон бусад даатгалд хамрагдах, 13.1.6-д цусны донорын үйлсийг сурталчлах, эгнээг өргөжүүлэх ажилд оролцох гэж заасан байна.

Нийгмийн халамжийн тухай хууль”⁹⁰-д сайн дурын үндсэн дээр иргэд, төрийн бус байгууллагын оролцооны талаар 13.5-д “онцгой тохиолдлын болон амьжиргааг дэмжих мөнгөн тэтгэмжийг дор дурдсан өрх, иргэнд олгоно. 13.5.1-д гэнэтийн аюул, осол, урьдчилан төсөөлөх боломжгүй бусад шалтгаанаар гэр оронгүй, гэр орон нь цаашид амьдрах боломжгүй болсон болон амьжиргааны эх үүсвэрээ алдсан өрх, 18.1-д олон нийтийн оролцоонд түшиглэсэн халамжийн үйлчилгээ, 18.1.1-д амьдралын

⁸⁹ Донорын тухай хууль. “Төрийн мэдээлэл” эмхэтгэл. №06. 2018.

⁹⁰ Нийгмийн халамжийн тухай хууль. “Төрийн мэдээлэл” эмхэтгэл. № 08. 2012.

итгэл үнэмшил, бие даан амьдрах чадвар, хөдөлмөрийн дадал олгох, авьяасыг нь дэмжих зорилгоор сургалт зохион байгуулах, 18.5-д аймаг, нийслэл, дүүргийн халамжийн үйлчилгээний байгууллага нь энэ хуулийн 17.1-д заасан үйлчилгээг иргэн, аж ахуйн нэгж, төрийн бус байгууллагаар гэрээний үндсэн дээр гүйцэтгүүлж болно гэж тус тус заасан байна.

Байгаль орчныг хамгаалах тухай хууль⁹¹-д сайн дурын үйл ажиллагааны оролцооны талаар 4.1.6-д сайн дурын үндсэн дээр зохион байгуулалтад орж, энэ хуулийн 3.2.8-д заасан нөхөрлөл байгуулах замаар оршин суугаа нутгийнхаа байгалийн тодорхой төрлийн баялгийг хамгаалах, холбогдох хууль тогтоомжийн дагуу гэрээгээр ашиглах, эзэмших, 32.2-д Засгийн газар байгаль орчныг хамгаалах талаарх төрийн гүйцэтгэх байгууллагын тодорхой чиг үүргийг гэрээний үндсэн дээр байгаль орчныг хамгаалах дүрмийн зорилго бүхий төрийн бус байгууллагад эсхүл тухайн нутгийн иргэдийн сайн дурын үндсэн дээр нэгдэн байгуулагдсан этгээдэд шилжүүлж, түүний хэрэгжилтийг санхүүжүүлж болно гэж, 50.1-д Байгалийн нөөцийн хамтын менежментийн үйл ажиллагаанд тухайн орон нутгийн иргэд энэ хуулийн 3 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн 8 дахь заалтад заасан нөхөрлөлийн хэлбэрээр зохион байгуулагдан оролцож болох бөгөөд гэрээний үндсэн дээр хамтын менежментээр хариуцаж байгаа нутаг дэвсгэрийнхээ тодорхой төрлийн байгалийн нөөцийг хуулийн хүрээнд гэрээнд заасны дагуу зохистой ашиглах давуу эрхтэй байна, 50.9-д нөхөрлөл нь энэ хуулийн 31 дүгээр зүйл, тодорхой төрлийн байгалийн нөөцийг хамгаалах, зохистой ашиглах, нөхөн сэргээх харилцааг зохицуулсан холбогдох хууль тогтоомжид заасан үүргийг биелүүлэхийн зэрэгцээ, тухайн шатны Засаг даргатай байгуулсан гэрээнд заасны дагуу өөрийн үйл ажиллагааг хууль тогтоомжид нийцүүлэн эрхэлнэ гэж, 50.10-д нөхөрлөл нь өөрийн дотоод дүрэмтэй байх бөгөөд дүрэмдээ бүх гишүүдийн хурал, удирдах зөвлөл, хяналтын зөвлөл, ахлагч, гишүүний эрх, үүрэг, хариуцлага, дундын өмч хөрөнгийн харилцааны асуудлыг хуульд заасны дагуу тусгасан байна гэж тус тус хуульчилсан байна.

“Ойн тухай хууль”⁹²-ийн сайн дурын үндсэн дээр иргэд, төрийн бус байгууллагын үүргийн талаар 17.3.9-д ойн сангийн тодорхой хэсгийг эзэмшигч ойн нөхөрлөл, аж ахуйн нэгж, байгууллагын ойн менежментийн төлөвлөгөөг батлах, хэрэгжилтэд хяналт тавих; 18.2.12-д нутаг дэвсгэртээ

⁹¹ Байгаль орчныг хамгаалах тухай хууль. “Төрийн мэдээлэл” эмхэтгэл. № 05-06.1995.

⁹² Ойн тухай хууль. “Төрийн мэдээлэл” эмхэтгэл. № 22. 2012.

ой, хээрийн түймрийн аюултай үед эргүүл, харуул ажиллуулах, иргэд, ойн нөхөрлөл, аж ахуйн нэгж, байгууллагыг энэ ажилд татан оролцуулах; 18.2.17-д ой, хээрийн түймрээс урьдчилан сэргийлэх талаар нутаг дэвсгэртээ сургалт, сурталчилгаа явуулах болон нутгийн өрх, мод бэлтгэх үйл ажиллагаа эрхэлдэг ойн нөхөрлөл, аж ахуйн нэгж, байгууллагад ойн сан бүхий газрыг хариуцуулж, хяналт тавих; 18.3.10-д иргэдэд ойг хамгаалах, зохистой ашиглах, нөхөн сэргээх, үржүүлэх болон ой, хээрийг түймрээс хамгаалах чиглэлээр сургалт, сурталчилгаа явуулах; 19.2.3-д ой, хээрийн түймрээс хамгаалах сурталчилгааг хүн бүрд хүргэж түймэртэй тэмцэх бэлтгэлийг хангуулах; 21.1-д ойн нөхөрлөл нь энэ хуулийн 4.9, 9.3-т заасны дагуу ойн сангийн тодорхой хэсгийг хамгаалах, зохистой ашиглах, нөхөн сэргээх, үржүүлэх ойн менежментийн төлөвлөгөөтэй байна. 21.2-д ойн нөхөрлөл нь хууль тогтоомжид нийцсэн дүрэмтэй байна” гэж тус тус заасан. Мөн ойн санг хамгаалахад 25.1-д ойн баялгийг хамгаалах дүрмийн зорилго бүхий төрийн бус байгууллага холбогдох төрийн захиргааны төв байгууллагатай зөвшилцөн Байгаль орчныг хамгаалах тухай хуулийн 32 дугаар зүйлд заасны дагуу ойг хамгаалах талаар дараах үйл ажиллагааг явуулж болно: 39.10-д иргэн, ойн нөхөрлөл, аж ахуйн нэгж, байгууллага өөрийн хөрөнгөөр ой, хээрийн түймэр, хөнөөлт шавжтай тэмцсэн тохиолдолд зохих журмын дагуу урамшуулал олгохоор тус тус заажээ.

Залуучуудын хөгжлийг дэмжих тухай хууль⁹³-д *ТББ, сайн дурынхны оролцооны талаар*: 15.1-д Залуучуудын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага залуучуудын иргэний нийгмийн байгууллага, нийтэд тустай үйл ажиллагаа, хөдөлгөөнийг дараах чиглэлээр дэмжинэ. 15.1.1. Залуучуудыг бие даан амьдрах нийгэм, эдийн засгийн эрсдэлээс хамгаалахад чиглэсэн мэдээлэл сурталчилгаа, нөлөөллийн арга хэмжээг тэдний оролцоо, дэмжлэгтэйгээр зохион байгуулах, 15.1.3. зорилтот бүлгийн залуучуудыг нийгэмшүүлэх, хөгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх чиглэлээр олон нийтэд түшиглэсэн үйл ажиллагааг сайн дурынхны оролцоотойгоор зохион байгуулах, 15.1.4. хараа хяналтгүй хүүхдийг нийгэмшүүлэх, ахмад, хөгжлийн бэрхшээлтэй иргэн, хүүхдийн асрамж, халамжийн үйл ажиллагаанд сайн дурынхан, аж ахуйн нэгж байгууллага хамтран ажиллахыг дэмжих, энэ хуулийн 6.1.3, 6.1.4-т заасан сайн дурын ажилд оролцсон цагийг бүртгэж, баталгаажуулах журмыг хөдөлмөрийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага баталж, залуучуудын

⁹³ Залуучуудын хөгжлийг дэмжих тухай хууль. “Төрийн мэдээлэл” эмхэтгэл. №17. 2017.

асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага хэрэгжүүлнэ гэж тусгасан байна.

“Төрийн бус байгууллагын тухай хууль”⁹⁴-ийн зорилт нь “Үндсэн хууль болон Монгол Улсын олон улсын гэрээгээр тодорхойлсон хүний эрхийг хэрэгжүүлэх зорилгоор иргэд эвлэлдэн нэгдэх, төрийн бус байгууллагыг үүсгэн байгуулах болон төрийн бус байгууллагын үйл ажиллагаатай холбогдсон харилцааг зохицуулахад оршино” гэж хуульчилсан..

Монгол Улсын хуулиудад “2015-2030 онд Гамшгийн эрсдэлийг бууруулах Сендайн үйл ажиллагааны хүрээ” баримт бичгийн “гамшгийн эрсдэлийг удирдах засаглал болон бэлэн байдлын чадавхыг бэхжүүлэх, орон нутгийн засаг захиргаа, олон нийтийн оролцоог нэмэгдүүлэх” чиглэлийг сонгож, түншлэл, хамтын ажиллагааны уялдааг хангах, мэдээлэл солилцох, зөвлөлдөх, идэвхтэй үйл ажиллагаанд төрийн бус байгууллага, сайн дурынхны оролцоог хангах хүрээгээр хяналт, шинжилгээ, үнэлгээг гүйцэтгэлээ.

Д/д	Монгол улсад мөрдөгдөж байгаа хуулиуд	Түншлэл, хамтын ажиллагааны уялдааг хангах хүрээнд	мэдээлэл солилцох, зөвлөлдөх, идэвхтэй оролцооны хүрээнд	ТББ, сайн дурынхны оролцоог хангах хүрээнд	Хяналт, шинжилгээ үнэлгээний хүрээнд
1	Гамшгаас хамгаалах тухай хууль	+	+	+	+
2	Галын аюулгүй байдлын тухай хууль	+	+		+
3	Ус цаг уур, орчны хяналт шинжилгээний тухай хууль	+	+		
4	Ойн тухай хууль	+	+		
5	Эрүүл мэндийн тухай хууль	+	+	+	
6	Нийгмийн халамжийн тухай хууль	+	+		

⁹⁴ Төрийн бус байгууллагын тухай хууль. “Төрийн мэдээлэл” эмхэтгэл. №03. 1997.

7	Байгаль орчныг хамгаалах тухай хууль	+	+	+	
9	Донорын тухай хууль	+	+	+	
13	Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай	+	+		
14	МУЗН-ийн эрх зүйн байдлын тухай хууль	+	+	+	+
15	Залуучуудын хөгжлийн дэмжих тухай	+	+	+	
16	Хүүхэд хамгааллын тухай	+		+	

Хүснэгт 13., Гамшгаас хамгаалах үйл ажиллагаанд оролцоог хангах хүрээнд хуулиудад хийсэн шинжилгээ

Хүснэгт 13-т авч үзсэн хуулиудад орон нутгийн удирдлага, хуулийн этгээд, иргэн, сайн дурынхны оролцоо, хамтын ажиллагааны хүрээнд салбар, салбарын ашиг сонирхол, үйл ажиллагааны онцлогийг гаргасан нийтээр дагаж мөрдөх заалтууд тодорхой хэмжээгээр тусгалаа олж, цаашид салбар хоорондын түншлэлийн харилцаа, зохицуулалтад анхаарах хэрэгтэйг харуулж байна. Эндээс заалтуудын ихэнх нь урьдчилан сэргийлэх ажиллагаанд чиглэгдсэн байгаа тул бодлого үндсэндээ зөв зүйтэй байна гэж үзэх үндэслэлтэй боловч орчин үеийн гамшгаас хамгаалах менежментийн гол чиглэл болох гамшгийн эрсдэлийг бууруулах асуудлын зохицуулалт зөвхөн эрсдэлийг үнэлэхтэй холбоотой заалтуудаар хязгаарлагдсан байна.

Сүүлтийн үед олон улсын болон үндэсний бодлогын баримт бичгүүдэд гамшгаас хамгаалах үйл ажиллагаанд иргэний нийгэм-хувийн хэвшил- төрийн түншлэлийг бэхжүүлэх замаар үндэсний хөгжлийн бодлого, төлөвлөлт, хэрэгжилтэд хамаарал бүхий талуудын оролцоог хангасан зохистой тогтолцоог бүрдүүлэх зорилт чухал байр суурийг эзэлж байгаа болохоор судлагдаж байгаа сэдвийн хүрээнд Монгол Улсын хуулиудад нутгийн өөрөө удирдах байгууллага болон нутгийн захиргааны байгууллага, аж ахуйн нэгж байгууллага, иргэд, төрийн бус байгууллага, сайн дурынхны гамшгаас хамгаалах үйл ажиллагаанд оролцох, эрх, үүрэг, харилцан ажиллагааны уялдаа холбоотой заалтуудыг авч үзэж, шинжлэн судалж, дүгнэлт гаргахыг зорилоо.

Сүүлийн үед олон улсын болон үндэсний бодлогын баримт бичгүүдэд гамшгаас хамгаалах үйл ажиллагаанд иргэний нийгэм-хувийн хэвшил-төрийн түншлэлийг бэхжүүлэх замаар үндэсний хөгжлийн бодлого, төлөвлөлт, хэрэгжилтэд хамаарал бүхий талуудын оролцоог

хангасан зохистой тогтолцоог бүрдүүлэх зорилт чухал байр суурийг эзэлж байгаа болохоор судлагдаж байгаа сэдвийн хүрээнд гамшиг, эрүүл мэнд, байгаль орчин, нийгмийн халамжийн чиглэлийн Монгол Улсын хуулиудад нутгийн өөрөө удирдах байгууллага болон нутгийн захиргааны байгууллага, аж ахуйн нэгж байгууллага, иргэд, төрийн бус байгууллага, сайн дурынхны гамшгаас хамгаалах үйл ажиллагаанд оролцох, эрх, үүрэг, харилцан ажиллагааны уялдаа холбоотой заалтуудыг авч үзэж, шинжлэн судалж, дүгнэлт гаргахыг зорилоо.

Хоёр. Бодлогын баримт бичгийн шинжилгээ.

Бодлогын баримт бичгийн шинжилгээнд Монгол Улсын үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал, Батлан хамгаалах бодлогын үндэс, Гамшгаас хамгаалах талаар төрөөс баримтлах бодлого, Гамшгийн эрсдэлийг олон нийтийн оролцоотой бууруулах хөтөлбөрийн баримт бичиг, тэдгээрийн агуулгыг тусгасан бусад бодлогыг хамруулан авч үзлээ.

Монгол Улсын үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал:

Үндэсний аюулгүй байдлыг хангах тогтолцоо: “Үндэсний аюулгүй байдлыг хангах үйл ажиллагаанд иргэд, хувийн хэвшил, иргэний нийгмийн байгууллагын идэвх, оролцоог урамшуулж, хамтын ажиллагааны тодорхой арга хэлбэрийг бэхжүүлж, үр дүнг дээшлүүлнэ”, “гамшиг, гэнэтийн аюул, халдлагатай тэмцэх үндэсний чадавхыг дээшлүүлж, эрсдэлийг бууруулна”. Аюулгүй байдлыг хангах тусгайлсан чиг үүрэг бүхий байгууллагууд болон төрийн бусад байгууллага, онцгой нөхцөл байдал үүссэн үед хамтран ажиллах бэлэн байдлын түвшнийг шинэ шатанд гаргана”, “Монгол Улсын иргэд, иргэний нийгмийн байгууллагууд үндэсний аюулгүй байдлыг хангах тухай хууль тогтоомж, энэхүү үзэл баримтлалыг чанд мөрдлөг болгож, тэдгээрийг хэрэгжүүлэхэд идэвхтэй оролцоно” гэж заасан.

Монгол Улсын Батлан хамгаалах бодлогын үндэс:

“Монгол Улсын батлан хамгаалах бодлогын үндэс”⁹⁵-ийн судалгаа гамшгаас хамгаалах талаар тусгайлан заасан заалтад анхаарах шаардлагыг бий болгож байна. Энэ үүднээс батлан хамгаалах тогтолцоонд төр ба хувийн хэвшил, иргэний нийгмийн байгууллага, иргэн бүрийн бэлтгэл бэлэн байдлын хүрээнд “Монгол Улсын батлан хамгаалах тогтолцооны

⁹⁵ Монгол Улсын Их Хурлын тогтоол. Монгол Улсын Батлан хамгаалах бодлогын үндэс. “Төрийн мэдээлэл” эмхэтгэл. № 85. 2015.

үндэс нь төр, захиргааны байгууллагууд, нийт иргэний оролцоонд тулгуурласан орон нутгийн хамгаалалт, мэргэжлийн цэрэгт суурилсан зэвсэгт хүчин, нэгдмэл удирдлага, зохион байгуулалт, зохицуулалтын цогц мөн”, “төрийн захиргааны төв болон нутгийн захиргааны байгууллага, төрийн өмчийн ба хувийн хэвшлийн аж ахуйн нэгж, байгууллага, иргэн бүр хуульд заасан дайчилгааны даалгавраар хүлээсэн үүргээ биелүүлэх урьдчилсан бэлтгэлтэй байна”, “эх орноо батлан хамгаалах үйл хэрэгт иргэн бүрийн оролцоог хангаж, цэргийн алба хаах тогтолцоог боловсронгуй болгоно” гэж тусгасан нь батлан хамгаалах бодлогын нийгмийн чиглэл болон зэвсэгт хүчний үүрэг, түүнийг хөгжүүлэх чиглэлийн үйл ажиллагаанд тусгалаа олж, улс орны гамшгийн менежментийн асуудалд батлан хамгаалахын үүрэг, оролцоо чухал ач холбогдолтой бөгөөд оролцоо нь практик амьдралд орон нутгийн хамгаалалтаар дамжин хэрэгжих нь илүү үр дүнтэй байх боломж байна.

Гамшгийн эрсдэлийг олон нийтийн оролцоотой бууруулах үндэсний хөтөлбөр:

“Гамшгийн эрсдэлийг бууруулах олон нийтийн оролцоотой бууруулах үндэсний хөтөлбөр”⁹⁶ бодлогын баримт бичигт үндсэн таван зорилтыг тодорхойлсон. Үүнд: *нэгдүгээрт*, “Олон нийтийн оролцоонд тулгуурлан гамшгийн эрсдэлийг бууруулах эрх зүйн орчин, тогтолцоог бүрдүүлэх”, *хоёрдугаарт*, “Гамшгийн эрсдэлийг бууруулах үйл ажиллагааны төлөвлөлтөд олон нийтийн оролцоог хангах нөхцөлийг бүрдүүлэх”, *гуравдугаарт*, “Олон нийтийн оролцоонд тулгуурлан гамшгийн эрсдэлийг бууруулах үйл ажиллагааг төлөвлөх, хэрэгжүүлэх”, *дөрөвдүгээрт*, “Уур амьсгал, ус цаг уурын гаралтай аюулт үзэгдлээс урьдчилан сэргийлэх мэдээ, мэдээллийг шуурхай мэдээлэх тогтолцоог бэхжүүлэх”, *тавдугаарт*, “Уур амьсгалын өөрчлөлтөөс үүдэлтэй гамшгийн эрсдэлийг бууруулахад олон нийтийн оролцоо, идэвх, санаачилгыг дэмжих”, *зургаадугаарт*, “Уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох чадавхыг бэхжүүлэх” гэсэн нь “2015-2030 онд Гамшгийн эрсдэлийг бууруулах Сендайн үйл ажиллагааны хүрээ” баримт бичигт “Гамшгийн эрсдэлийн ойлголт, мэдлэгийг сайжруулах, хөрөнгө оруулалт хийх, гамшгийн эрсдэлийг удирдах засаглал болон бэлэн байдлын чадавхыг бэхжүүлэх, орон нутгийн засаг, захиргаа, олон нийтийн оролцоог

⁹⁶ Монгол Улсын Засгийн Газрын тогтоол. Гамшгийн эрсдэлийг олон нийтийн оролцоотой бууруулах үндэсний хөтөлбөр. “Төрийн мэдээлэл” эмхэтгэл. № 2015.

нэмэгдүүлэх, уур амьсгалын өөрчлөлтөөс үүдэлтэй гамшгийн эрсдэлийг бууруулах” үйл ажиллагааны үндсэн чиглэл, ”Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал”-ын “Иргэдийн амьдрах, ажиллах орчны аюулгүй байдлыг баталгаажуулах чухал үндэс болно”, мөн үзэл баримтлалын “Гамшгийн менежментийн тогтолцоог бэхжүүлж эмзэг байдлыг бууруулах ажлыг үндэсний хэмжээнд зохион байгуулж, төв, орон нутгийн төрийн байгууллага, мэргэжлийн байгууллага, хувийн хэвшил, иргэдийн оролцоог хангах” гэсэн заалтуудын агуулгыг бүрэн илэрхийлсэн байна.

“Алсын хараа 2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого.

“Алсын хараа 2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого”⁹⁷-ын зорилт 5.5-д “Иргэний нийгэм- хувийн хэвшил- төрийн түншлэлийг бэхжүүлэх замаар үндэсний хөгжлийн бодлого, төлөвлөлт, хэрэгжилтэд хамаарал бүхий талуудын оролцоог хангасан зохистой тогтолцоог бүрдүүлж, хүний эрхийг хангах үндэсний тогтолцоог бэхжүүлэх, хууль эрх зүйн орчныг боловсронгуй болгож, хүнийг эрхийг хангахад чиглэсэн олон талт түншлэлийг хөгжүүлэх үе болгох зорилт дэвшүүлж, төр, иргэний нийгэм, хувийн хэвшил хүний эрхийг хамгаалахад хамтарч ажиллах тогтолцоо төлөвшинө”, зорилт 7.3-д “Уламжлалт бус аюулын эрсдэлийг бууруулах, эрсдэлээс урьдчилан сэргийлэх, таслан зогсоох чадавхыг бэхжүүлж, хүн-нийгмийн амар тайван орчныг бүрдүүлж, уламжлалт бус аюулын хүчин зүйлсийн болзошгүй эрсдэлээс урьдчилан сэргийлэх, таслан зогсоох чадавхыг бэхжүүлж, төр, хувийн хэвшил, иргэний нийгмийн байгууллага, иргэдийн оролцоог нэмэгдүүлнэ” гэсэн зорилтууд дэвшүүлжээ.

Ногоон хөгжлийн бодлого.

“Ногоон хөгжлийн бодлого”⁹⁸-д “дэлхий нийтэд тулгараад байгаа уур амьсгалын өөрчлөлт, эдийн засаг, хүн амын хурдацтай өсөлт, хэрэглээ, үйлчилгээний хэт өсөлт, байгалийн нөөцийн хомсдол нь дэлхийн оршин тогтнолд эрсдэл учруулж байна. Байгальд ээлтэй хандлага, зөв дадлыг

⁹⁷ Монгол Улсын Их Хурлын тогтоол. Алсын хараа-2050 Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого.”Төрийн мэдээлэл” эмхэтгэл. № 52. 2020.

⁹⁸ Монгол Улсын Их Хурлын тогтоол. Ногоон хөгжлийн бодлого.”Төрийн мэдээлэл” эмхэтгэл. № 43. 2014.

төлөвшүүлэх, ногоон өсөлтийг хангахад иргэдийн оролцооны чухлыг дурдсан байдаг.

Газар хөдлөлтийн гамшгийн эрсдэлийг бууруулах үндэсний хөтөлбөр⁹⁹.

Хөтөлбөрийн зорилго нь Монгол орны нутаг дэвсгэрт учирч болзошгүй газар хөдлөлтийн гамшгаас урьдчилан сэргийлэх, хүчтэй газар хөдлөлтийн голомт бүхий бүс нутагт гамшгийн эрсдэлийг бууруулах, ашиглагдаж байгаа зарим барилга, байгууламжийн хийц, бүтээцийг хүчитгэх замаар эвдрэл, нуралтаас үүсэх хохирлыг багасгах, орон сууц, олон нийт, иргэн болон үйлдвэрийн барилга, зам гүүр, ус суваг, далан хаалт зэрэг байгууламж, инженерийн шугам сүлжээний аюулгүй байдлыг хангаж, байгалийн болзошгүй аюулаас урьдчилан сэргийлэхэд оршино. Олон нийтэд газар хөдлөлтийн гамшгаас урьдчилан сэргийлэх болон газар хөдлөлтийн гамшгийн үеийн авран хамгаалах сургалт зохион байгуулах, сурталчлах, гамшгийн хор холбогдлыг тайлбарлан таниулах; газар хөдлөлтийн гамшигт нэрвэгдсэн хүмүүст эмнэлгийн яаралтай тусламж үзүүлэх сургалт зохион байгуулах, газар хөдлөлтийн гамшгийн үед ажиллах, аврах, хор уршгийг арилгах, хойшлуулшгүй сэргээн босгох үйл ажиллагааны төлөвлөгөөг томоохон хот суурин газар бүрээр боловсруулж, гамшгаас хамгаалах бэлэн байдлыг дээшлүүлэх; гамшгаас хамгаалах алба, аймаг орон нутагт явуулдаг газар хөдлөлтийн гамшгаас урьдчилан сэргийлэх дадлага, сургалтад холбогдох мэргэжлийн байгууллагууд хамтран ажиллах, болзошгүй гамшгийн үед ажиллах хамтын ажиллагааг сайжруулж, газар хөдлөлтийн гамшигтай тэмцэх чадавхыг дээшлүүлэх; газар хөдлөлтийн гамшгийн үед аврах, хор уршгийг арилгах, хойшлуулшгүй сэргээн босгох ажилд шаардлагатай багаж хэрэгслийг буцалтгүй тусламж, гадаадын төсөл хөтөлбөрийн хүрээнд хамруулан шинэчлэх арга хэмжээ авах зэрэг арга хэмжээг хэрэгжүүлэхээр заажээ.

Өрхийн хөгжлийг дэмжих үндэсний хөтөлбөр.

Өрхийн хөгжлийг дэмжих үндэсний хөтөлбөр¹⁰⁰-т “олон нийтийн оролцоонд түшиглэсэн халамжийн үйлчилгээнд өрхийн гишүүдийг зохих журмын дагуу хамруулах”, амьдрах арга ухаанаа олоогүй болон итгэл

⁹⁹ Монгол Улсын Засгийн Газрын тогтоол. Газар хөдлөлтийн гамшгийн эрсдэлийг бууруулах үндэсний хөтөлбөр. “Төрийн мэдээлэл” эмхэтгэл. № 157. 2009.

¹⁰⁰ Монгол Улсын Их Хурлын тогтоол. Өрхийн хөгжлийг дэмжих үндэсний хөтөлбөр. “Төрийн мэдээлэл” эмхэтгэл. № 02. 2012.

алдарсны улмаас хөгжих идэвх санаачилга нь суларсан өрхийн тэргүүн, бусад насанд хүрсэн гишүүдийн залхуурал, архидалт, санаачилгагүй байдал зэрэг сөрөг зан үйлийг өөрчлөхөд туслах үйлчилгээг *мэргэжсэн төрийн бус байгууллагуудын* оролцоотойгоор зохион байгуулах”, хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд холбогдох бүх байгууллага, иргэдийн оролцоог хангах, хөрөнгийг үр ашигтай зарцуулах, иргэний нийгмийн зүгээс тавих хөндлөнгийн хяналтыг сайжруулах, төр, иргэний нийгэм, аж ахуйн нэгж, хувийн хэвшил, олон улсын байгууллага, хандивлагчдын дэмжлэгийг өргөжүүлэх механизмыг бүрдүүлэх”, ”хөтөлбөрт хамрагдсан өрхийн гишүүдийг чадавхжуулах, зан үйлийг өөрчлөхөд чиглэсэн ухуулга, сурталчилгаанд оролцуулах, түүнийг өөрсдийнх нь оролцоотой зохион байгуулах” зэрэг арга хэмжээ авах, төрийн бус байгууллагын оролцоотойгоор, “хөтөлбөрт хамрагдаж байгаа өрхөд Өрхийн хөгжлийн төлөвлөгөө боловсруулах, хэрэгжүүлэхэд нь туслах ажлыг гэрээгээр гүйцэтгэх” зэрэг арга хэмжээг авахаар тусгасан.

Бодлогын баримт бичгийг хэрэгжүүлэхэд бүх талын түншлэл, хамтын ажиллагааны чухлыг дурдаж, иргэний нийгэм ТББ, сайн дурынхны үйл ажиллагаа 7 бодлого, хөтөлбөрт, хяналт, шинжилгээ, үнэлгээний заалт 4 хөтөлбөрт тус тус тусгалаа олсон нь хөтөлбөрүүдийн үйл ажиллагааг хэрэгжүүлэх, уялдаа холбоог хангаж ажиллахад иргэний нийгмийн байр суурь хүлээн зөвшөөрч, ялангуяа Алсын хараа-2050, Мянганы хөгжлийн зорилтод суурилсан үндэсний хөгжлийн цогц бодлого, ногоон хөгжлийн бодлого, уур амьсгалын өөрчлөлтийн үндэсний хөтөлбөр, цөлжилттэй тэмцэх болон өрхийн хөгжлийг дэмжих хөтөлбөрт түлхүү хэрэгцээ шаардлага байна гэж дүгнэхээр байна.

3. Улсын Их Хурал, Засгийн Газрын тогтоол.

Монгол Улсын Их Хурлын 2016 оны 34 дүгээр тогтоолоор баталсан “Газар хөдлөлтийн гамшгаас урьдчилан сэргийлэх, эрсдэлийг бууруулах талаар авах арга хэмжээний тухай”, Монгол Улсын Засгийн Газрын 2017 оны 67 дугаар тогтоолоор баталсан “Газар хөдлөлтийн аюулаас урьдчилан сэргийлэх, таниулах өдөртэй болох тухай”, “Засгийн Газрын 2017 оны 355 дугаар тогтоолоор баталсан “Гамшгийн эрсдэлийг бууруулах Сендайн үйл ажиллагааны хүрээг Монгол Улсад хэрэгжүүлэх дунд хугацааны стратеги батлах тухай”, Монгол Улсын Засгийн Газрын 2018 оны 63 дугаар тогтоолоор баталсан “Гамшгийн эрсдэлийг бууруулах Үндэсний зөвлөлийн ажиллах журам, бүрэлдэхүүнийг батлах тухай”, Монгол Улсын Шадар

сайдын 2018 оны 23 дугаар тушаалаар баталсан “Гамшгийн эрсдэлийг бууруулах Сендайн үйл ажиллагааны хүрээг Монгол Улсад хэрэгжүүлэх дунд хугацааны стратегийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө батлах тухай”, Монгол Улсын Шадар сайдын 2018 оны 120 дугаар тушаалаар баталсан “Гамшгаас хамгаалах төлөвлөгөө боловсруулах заавар батлах тухай”, Засгийн Газрын 2011 оны 340 дүгээр тогтоолын 1-р хавсралтаар баталсан “Гамшгийн үед хүч хэрэгсэл дайчлан гаргах журам”, мөн тогтоолын 2 дугаар хавсралтын “Гамшгийн үед нүүлгэн шилжүүлэх журам”, Улсын Онцгой Комиссын Даргын 2020 оны 45 дугаар тушаалаар баталсан “Зорилтот бүлэг, эрсдэлт нөхцөлд байгаа иргэн, өрхөд хүнс, тэжээлийн дэмжлэг үзүүлэх, түгээх, халдвар хамгааллын дэглэм мөрдөх түр журам”, Улсын Их Хурлын 2016 оны 34 дүгээр тогтоолоор баталсан “Газар хөдлөлтийн гамшгаас урьдчилан сэргийлэх, эрсдэлийг бууруулах талаар авах зарим арга хэмжээний тухай”, Засгийн Газрын 2019 оны 1 дүгээр тогтоолоор баталсан “Гамшгийн хохирол, хэрэгцээний үнэлгээ хийх журам”, Шадар сайдын 2016 онд баталсан “Гамшгаас хамгаалах сайн дурын ажиллагааны нийтлэг журам”, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2019 оны А/130 дугаар тушаалаар баталсан “Залуучуудын сайн дурын ажлыг бүртгэх, баталгаажуулах журам”, түүнчлэн ОБЕГ-ын даргын 2016 оны А/185 тушаал “Гамшгаас хамгаалах сайн дурын ажиллагааны заавар” тус тус батлагдан мөрдөн ажиллаж байна.

*Газар хөдлөлтийн гамшгаас урьдчилан сэргийлэх, эрсдэлийг бууруулах талаар авах зарим арга хэмжээний тухай*¹⁰¹. Монгол Улсын Их Хурлын 2016 оны 34 дүгээр тогтоолоор баталсан “Газар хөдлөлтийн гамшгаас урьдчилан сэргийлэх, эрсдэлийг бууруулах талаар авах арга хэмжээний тухай” тогтоолд түншлэл, хамтын ажиллагаа, иргэд, олон нийтийн оролцоо, санхүүжилттэй холбоотой дөрвөн заалт байна. Үүний хоёр заалт нь иргэний нийгмийн байгууллагын үйл ажиллагаатай холбогдож байна.

*Гамшгийн үед хүч хэрэгсэл дайчлан гаргах журам*¹⁰² “Гамшгийн үед хүч хэрэгсэл дайчлан гаргах журам”-д гамшгаас хамгаалах дайчилгаанд

¹⁰¹ Монгол Улсын Их Хурлын тогтоол. Газар хөдлөлтийн гамшгаас урьдчилан сэргийлэх, эрсдэлийг бууруулах талаар авах зарим арга хэмжээний тухай. “Төрийн мэдээлэл” эмхэтгэл. № 42. 2016.

¹⁰² Монгол Улсын Засгийн Газрын тогтоол. Гамшгийн үед хүч хэрэгсэл дайчлан гаргах журам. “Төрийн мэдээлэл” эмхэтгэл. № 340. 2011

гамшгаас хамгаалах чиг үүрэг бүхий албад, аж ахуйн нэгж, байгууллага, дүйцүүлэх албаны алба хаагч, мэргэжлийн анги, иргэд болон сайн дурынхан хамрагдана”); гэж тусгасан.

*Гамшгийн үед нүүлгэн шилжүүлэх журам*¹⁰³-д “төрийн болон нутгийн захиргааны байгууллага, аж ахуйн нэгж байгууллага, иргэдэд гамшгаас хамгаалах дайчилгаа, нүүлгэн шилжүүлэлт явуулах шийдвэр гарсан тухай зарлах, гамшгийн хор уршгийг арилгасан тухай шийдвэрийг хэвлэл мэдээллийн хэрэгслээр дамжуулан нийтэд мэдээлэх”; “иргэдийн амьдрах нэн тэргүүний хэрэгцээ (орон байр, ус хоол хүнс, эмнэлгийн болон сэтгэл зүйн тусламж үзүүлэх, тэдний аюулгүй байдлыг хангах) бүх төрлийн хангалтыг зохион байгуулах; зэрэг нүүлгэн шилжүүлэх үеийн зохион байгуулалт, удирдлага, иргэд, аж ахуйн нэгж байгууллагын үүргийг тусгасан байна.

Зорилтот бүлэг, эрсдэлт нөхцөлд байгаа иргэн, өрхөд хүнс, тэжээлийн дэмжлэг үзүүлэх, халдвар хамгааллын дэглэм мөрдөх түр журам Уг журмаар зорилтот бүлэг, эрсдэлт нөхцөлд байгаа иргэн, өрхөд хүнс тэжээлийн дэмжлэг үзүүлэх, түгээх, халдвар хамгааллын дэглэмийг мөрдүүлэх, хяналт тавихтай холбоотой харилцааг зохицуулна. “Зорилтот бүлэг, эрсдэлт нөхцөлд байгаа иргэн, өрхөд хүнс, тэжээлийн дэмжлэг үзүүлэх, түгээх, халдвар хамгааллын дэглэм мөрдүүлэх арга хэмжээг аймаг, нийслэл, сум, дүүргийн Онцгой комисс, нутгийн захиргааны байгууллага, эрүүл мэнд, онцгой байдал, цагдаа, мэргэжлийн хяналтын байгууллага, гэр бүл, хүүхэд залуучуудын хөгжлийн байгууллага, Монголын улаан загалмай нийгэмлэг, олон улсын хүмүүнлэгийн байгууллага хамтран зохион байгуулна.” гэж тусгасан.

Монгол Улсын Шадар сайдын 2016 оны 34 дүгээр тушаалаар баталсан “Гамшгаас хамгаалах сайн дурын ажиллагааны нийтлэг журам”, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2019 оны 03 дугаар сарын 28 –ы өдрийн А/130 дугаар тушаалаар баталсан “Залуучуудын сайн дурын ажлыг бүртгэх, баталгаажуулах журам”-ыг хүснэгт 14-д харьцуулж авч үзье.

Журмын заалт	Монгол Улсын Шадар сайдын 2016 оны 34 дүгээр тушаалаар баталсан “Гамшгаас хамгаалах	Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2019 оны А/130 тоот тушаалаар баталсан “Залуучуудын
--------------	---	--

¹⁰³ Монгол Улсын Засгийн Газрын тогтоол. Гамшгийн үед хүч хэрэгсэл дайчлан гаргах журам. “Төрийн мэдээлэл” эмхэтгэл. № 340. 2011

	сайн дурын ажиллагааны нийтлэг журам”	сайн дурын ажлыг бүртгэх, баталгаажуулах журам”
Баримтлах зарчим	Хүмүүнлэг, энэрэнгүй шуурхай байх Хэрэглэгч, олон нийтийн эрх, ашгийн төлөө байх Ашгийн төлөө бус байх	Сайн дурын, хууль ёсны тэгш эрхийн зарчимд нийцсэн байх, нас, хүйс, Хүний эрх, эрх чөлөөг эрхэмлэж, хүнлэг, энэрэнгүй байх, хувь хүн, байгууллагын нууцыг чандална, Эв нэгдэл, хамтын ажиллагаанд суурилсан аюулгүй байдлыг хангах Ашгийн төлөө бус, уян хатан цагийн хуваарьтай байх зэрэг.
Үндсэн чиглэл	Гамшгаас урьдчилан сэргийлэх; Гамшгийн үед эрэн хайх, аврах, хор уршгийг арилгах үйл ажиллагаа; Гамшгийн дараах хүмүүнлэгийн тусламж, үйлчилгээ үзүүлэх сэргээн босгох үйл ажиллагаа; Хэрэглэгч олон нийтийн гамшгаас урьдчилан сэргийлэх чадварыг бэхжүүлэх үйл ажиллагаа;	Орчны бохирдол, цаг уурын өөрчлөлт, агаарын бохирдлыг бууруулах Гамшгаас хамгаалах, урьдчилан сэргийлэх Нийгмийн эрүүл мэндийг дэмжих, эрүүл зан үйл, дадал хэвшил төлөвшүүлэх Аливаа хүчирхийллийн хохирогч болсон хүүхэд, өсвөр үеийнхэн, залуучууд, иргэдэд туслах, нийгэм сэтгэл зүйн үйлчилгээ үзүүлэх, нөхөн сэргээх
Зохион байгуулалт	Сайн дурын ажилтан нь бие даасан болон хэсгийн зохион байгуулалтад орж, гамшгаас хамгаалах үйл ажиллагаанд оролцоно. Сайн дурын ажилтныг хөтөлбөрийн дагуу сургалтад хамруулж, гэрчилгээ, үнэмлэх олгоно. Сайн дурын хэсэг нь тухайн үйл ажиллагааг удирдан зохион байгуулж буй ОБА-ны албан тушаалтны дор үүрэг гүйцэтгэж, орон нутгийн Засаг даргад тайлагнана. Хэвлэл, мэдээллийн хэрэгслээр үйл ажиллагаагаа сурталчлах	Сайн дурын ажил хийх хүсэлтийг маягтын дагуу авч, тухайн орон нутгийн Залуучуудын төвд бүртгэнэ. Орон нутгийн Залуучуудын хөгжлийн төв сайн дурын ажил хийлгэх хүсэл, сонирхол бүхий талд холбон зуучилна. Залуучуудыг сайн дурын ажилд уриалах, сургалт, нөлөөллийн ажил зохион байгуулах, сайн дурын ажилтнуудын чадавхыг бэхжүүлэх зэрэг арга хэмжээг залуучуудын хөгжлийн төв гүйцэтгэнэ. Сайн дурын ажил гүйцэтгэсэн тухай тайланд тухайн ажлын зорилго, ач холбогдол, хугацаа, үр дүнг гэрэл зургаар баталгаажуулна. Хандив,

		тусламж авсан бол зарцуулалтын тайланг хавсаргана.
Сайн дурын ажилтны эрх, үүрэг, хориглох зүйл	<p><u>Сайн дурын ажилтан дараах эрх эдэлнэ.</u></p> <p>Гамшгаас хамгаалах сайн дурын ажиллагааны чиглэлээ сонгох</p> <p>Ажиллах нөхцөлөөр хангагдах</p> <p>Гамшиг, ослын бүсэд нэвтрэн үүрэг гүйцэтгэх</p> <p>Шаардлагатай мэдээ, мэдээлэл авах</p> <p>Аюулгүй байдал, хувийн мэдээллээ хамгаалуулах</p> <p>Эрүүл мэндийн хохирлоо нөхөн төлүүлэх</p> <p><u>Сайн дурын ажилтан нь дараах үүрэгтэй.</u></p> <p>Гамшгаас хамгаалах дайчилгаанд бэлэн байх, шаардлага гарсан тохиолдолд оролцох</p> <p>Гэрээ болон ажлын чиг үүргээ биелүүлэх</p> <p>Хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагааг сахих</p> <p><u>Хориглох зүйл:</u></p> <p>Гамшгаас хамгаалах үйл ажиллагааг тасалдуулах, хэвийн явуулах нөхцөлийг алдагдуулахад чиглэсэн арга хэмжээ зохион байгуулах,</p> <p>Улс төр, шашны үйл ажиллагаа явуулах, хуулиар хориглосон аливаа асуудлаар ухуулга, сурталчилгаа хийх,</p> <p>Ажлын чиг үүргээс гадуур байгууллагын эд хөрөнгө, техник хэрэгсэл, мэдээ, мэдээллийг хувийн зорилгоор ашиглах, завших</p> <p>Хувийн ашиг, сонирхлын зөрчил гаргах, үнэмлэх, бичиг</p>	<p><u>Сайн дурын ажилтан нь дараах эрх эдэлнэ.</u></p> <p>Сайн дурын ажлын чиглэлээ сонгох</p> <p>Өөрийн хүсэл эрмэлзэлд үндэслэн сайн дураар ажиллах эсэх шийдвэрийг гаргах</p> <p>Шаардлагатай мэдээ, мэдээллийг холбогдох албан тушаалтнаас авах</p> <p>Аюулгүй байдал, хувийн мэдээллээ хамгаалуулах</p> <p>Сайн дурын ажил гүйцэтгэсэн тухай лавлагаа авах</p> <p><u>Сайн дурын ажилтны хүлээх үүрэг:</u></p> <p>Бодит үнэн мэдээллийг олон нийтэд түгээх</p> <p>Олон нийтэд мэдээлэл түгээхдээ тухайн байгууллагаас зөвшөөрөл авах, хувь хүн, байгууллагын нэр хүндийг эрхэмлэх</p> <p>Өөрийн болон бусдын аюулгүй байдлыг хангах, бусдад туслах</p> <p>Холбогдох байгууллага, албан тушаалтанд ажлаа тайлагнах</p> <p>Хувь хүний болон нийгмийн ёс зүйн хэм хэмжээг сахих</p> <p><u>Хориглох зүйл:</u></p> <p>Бусдыг хүсээгүй байхад тусламж, дэмжлэг үзүүлэх,</p> <p>Улс төр, шашны үзлийг сурталчлах, хуулиар хориглосон аливаа асуудлаар ухуулга, сурталчилгаа, нөлөөллийн ажил хийх</p> <p>Хувийн ашиг, сонирхлын зөрчил гаргах, сайн дурын үйл ажиллагаанаас олсон орлого, хандивыг шамшигдуулах,</p> <p>Архи, тамхи, согтууруулах ундаа, сэтгэцэд нөлөөлөх эм бэлдмэл хэрэглэх, хадгалах, сурталчлах, бусдад санал болгох, дамжуулах,</p> <p>Хүчирхийллийн төрлүүдийг үйлдэх, сурталчлах, садар самуунд</p>

	<p>баримтыг хууль бусаар ашиглах Мансууруулах бодис, сэтгэцэд нөлөөлөх эм, бэлдмэл хэрэглэх,бусдад дамжуулах, гамшгаас хамгаалах үйл ажиллагаанд оролцох үедээ согтууруулах ундаа хэрэглэх, бүдүүлэг зан авир гаргах,</p>	<p>бусдыг уруу татах, мэдээллийг нуун дарагдуулах, Үндэслэлгүй, нотолгоогүй мэдээллийг олон нийтэд, нийгэмд санаатайгаар түгээх, олон нийтийг төөрөгдүүлэх, турхирах,</p>
<p>Сайн дурын ажилтны нийгмийн баталгаа</p>	<p>Сайн дурын ажилтан гамшгаас хамгаалах үйл ажиллагаанд оролцох үед хөдөлмөрийн чадвараа түр алдсан, хөгжлийн бэрхшээлтэй болсон, амь насаа алдсан тохиолдолд түүнд болон түүний гэр бүлд онцгой байдлын асуудал эрхэлсэн байгууллагын албан хаагчийн нэгэн адил тэтгэмж олгоно. Ажлаас чөлөөлөгдөн гамшгийн голомтод үүрэг гүйцэтгэсэн сайн дурын ажилтныг үндсэн ажлаа хийсэнд тооцож, тухайн байгууллага нь цалин хөлсийг нь хэвээр олгоно. Сайн дурын ажилтны үйл ажиллагаагаа явуулахад шаардагдах зардал, томилогдсон газарт очих, ирэх замын зардал, эмнэлгийн үзлэг, вакцинжуулалтад хамруулах зэрэг зайлшгүй гарах зардлыг тухайн орон нутгийн Засаг дарга хариуцна. Сайн дурын ажилтны байгуулсан гавьяа, зүтгэлийг үнэлж, төрийн болон төрийн бус байгууллага, олон нийтийн шагнал урамшуулал олгох, нийтэд алдаршуулан сурталчлах зэрэг арга хэмжээ авч хэрэгжүүлнэ. Сайн дурын ажилтанд гамшгаас хамгаалах үйл ажиллагаанд</p>	<p>Сайн дурын ажилтанд үзүүлэх дэмжлэг: Сайн дурын ажил гүйцэтгэж буй залуучуудыг залуучуудын асуудал эрхэлсэн төрийн, иргэний нийгмийн, олон улсын бүх шатны байгууллагууд, мэргэжил, арга зүйгээр дэмжин ажиллана. Сайн дурын ажлын цар хүрээ, гүйцэтгэл, нийгэмд үзүүлэх үр ашиг, нөлөө, гүйцэтгэлийг үнэлэн төрийн одон, медаль,салбарын болон бусад шагнал, урамшуулалд тодорхойлох үүргийг залуучуудыг асуудал эрхэлсэн бүх шатны төрийн байгууллага хариуцна. Тухайн сайн дурын ажлын зорилго, явц, үр дүнг олон нийтэд сурталчлан түгээх, дэлгэрүүлэх чиг үүргийг төрийн холбогдох байгууллага, албан тушаалтан давхар хариуцаж, залуучуудын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагатай хамтарч ажиллана. Сайн дурын ажил гүйцэтгэх явцдаа эрх ашиг нь зөрчигдсөн тохиолдолд түүний эрх ашгийг тухайн орон нутгийн залуучуудын асуудал эрхэлсэн төрийн байгууллага хамгаалах бөгөөд холбогдох байгууллага, албан тушаалтанд холбон зуучилна.</p>

	оролцсон ажлын үр дүнгээр дараах урамшуулал олгож болно. Үүнд: хоногийн хөдөлмөрийн хөлс, тээврийн хэрэгсэл ашигласан бол шатахууны зардал,хоол, унааны зардал, бусад зардал.	
Гамшгаас хамгаалах сайн дурын ажиллагааны санхүүжилт	Гамшгаас хамгаалах сайн дурын ажиллагааны санхүүжилтийг дараах эх үүсвэрээс бүрдүүлнэ. - Улсын болон орон нутгийн төсөв - Олон улсын байгууллага, хандивлагч орнуудын зээл, тусламж, төсөл, хөтөлбөрийн хөрөнгө - Төрийн болон төрийн бус байгууллага, аж ахуйн нэгж, иргэдийн санаачилгаар хуримтлагдсан тусламж, хандивын хөрөнгө - Бусад эх үүсвэр	

Хүснэгт 14., “Гамшгаас хамгаалах сайн дурын ажиллагааны нийтлэг журам”, “Залуучуудын сайн дурын ажлыг бүртгэх, баталгаажуулах журам” харьцуулалт

Хүснэгт 14-ээс үзэхэд “Гамшгаас хамгаалах сайн дурын ажиллагааны нийтлэг журам”, “Залуучуудын сайн дурын ажлыг бүртгэх, баталгаажуулах журам” харьцуулалтаас үзэхэд үйл ажиллагаанд баримтлах зарчим, үндсэн чиглэл, зохион байгуулалт, сайн дурын ажилтны эрх үүрэг, хориглох зүйл, нийгмийн баталгаа зэрэг асуудлууд зохих хэмжээгээр тусгагдаж, залуучуудын сайн дурын ажлыг бүртгэх, баталгаажуулах журамд санхүүгийн эх үүсвэрийг тусгаагүй, харин хувь хүний болон нийгмийн ёс зүйн хэм хэмжээг сахих гэж зайлшгүй байх ёстой асуудлыг тусгасан байна гэж дүгнэж байна. Залуучуудын сайн дурын ажлыг бүртгэх, баталгаажуулах журамд ажлын цагийг уян хатан байхаар тусгаж, аюулгүй байдлаа өөрөө хангаж ажиллах зэрэг харьцангуй ялгаатай заалтууд орсон нь залуучуудыг сайн дурын ажилд зөвхөн бүртгэх баталгаажуулах үйл явцын агуулгаар тайлбарлагдаж байна.

Сайн дурын ажилтны нийгмийн баталгааны хувьд гамшгаас хамгаалах сайн дурын ажиллагааны нийтлэг журамд тодорхой заалтууд

тусгагдаж, залуучуудын сайн дурын ажлыг бүртгэх, баталгаажуулах журамд “сайн дурын ажил гүйцэтгэх явцдаа эрх ашиг нь зөрчигдсөн тохиолдолд түүний эрх ашгийг тухайн орон нутгийн залуучуудын асуудал эрхэлсэн төрийн байгууллага хамгаалах бөгөөд холбогдох байгууллага, албан тушаалтанд холбон зуучилна” гэсэн нь тодорхойгүй бүрхэг заалт болсон байна гэж дүгнэж байна.

Онцгой байдлын ерөнхий газрын даргын 2018 оны А/185 дугаар тушаалаар батлагдсан “Гамшгаас хамгаалах сайн дурын ажиллагааны заавар”: Энэхүү зааварт төв орон нутгийн засаг, захиргаа, онцгой байдлын анги, байгууллагаас гамшгаас хамгаалах сайн дурын ажиллагааны нийтлэг журмыг хэрэгжүүлэх, гамшгаас хамгаалах сайн дурын ажиллагааг удирдлага, зохион байгуулалтаар хангаж ажиллахад энэхүү зааврыг мөрдлөг болгоно. Тус журамд орон нутгийн засаг захиргаа, онцгой байдлын байгууллага хамтран тухайн орон нутгийн сайн дурын ажиллагааны хэрэгцээ, шаардлагыг болон хэрэглэгч олон нийтийн гамшгаас урьдчилан сэргийлэх чадавхыг бэхжүүлэх ажлын хүрээнд тус тус нарийвчлан тодорхойлсон.

Гамшгаас хамгаалах сайн дурын хэсэг нь дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ. Үүнд:

- Гамшгаас хамгаалах арга хэмжээнд оролцох, бэлэн байдлыг хангах
- Гамшгаас урьдчилан сэргийлэх ажилд оролцох
- Эрэн хайх, аврах, хор уршгийг арилгах, сэргээн босгох арга хэмжээнд оролцох
- Гамшгийн аюулд нэрвэгдэгсдийг нүүлгэн шилжүүлэх, эмнэлгийн анхны шатны болон хүмүүнлэгийн тусламж үйлчилгээ үзүүлэхэд оролцох
- Ар тал, хангалтыг зохион байгуулахад оролцох

Мөн зааварт сайн дурын ажилтны ажлын чиг үүргийг тодорхойлох, сайн дурынхныг бүртгэх, гэрээ байгуулах, мэдээллийн сан бүрдүүлэх,гамшгаас хамгаалах сайн дурын хэсгийн бүтэц зохион байгуулалт, сургалт дадлагыг зохион байгуулах,сайн дурын ажилтны эзэмшвэл зохих мэдлэг, чадвар,гамшгаас хамгаалах сайн дурын хэсгийн хүлээх үүрэг,ажиллах нөхцөлийг хангах, гамшгаас хамгаалах арга хэмжээнд иргэд, олон нийтийн оролцоог хангах, сайн дурынхныг чөлөөлж, гэрээг цуцлах асуудлууд багтсан. Мөн зааврын хавсралтад сайн дурын ажилтны ажлын чиг үүрэг, бүртгэл, гэрээ,гамшгаас хамгаалах сайн дурын

хэсгийн тусгай тоноглол, хүн нэг бүрийн хэрэгслийн хангамжийн жишиг
нормын үлгэрчилсэн загварыг хавсаргасан.

2.2. Гамшгаас хамгаалахад сайн дурын үйл ажиллагааны өнөөгийн байдалд хийсэн шинжилгээ.

Гамшгаас хамгаалах сайн дурын үйл ажиллагааг: *нэгд*, сайн дурын үйл ажиллагааны талаар өмнө хийгдсэн баримт бичгийн судалгаа, *хоёрт*, Гамшгаас хамгаалахад сайн дурын хэсгийн судалгаа, *гуравт*, сайн дурын үйл ажиллагааны талаар авсан санал асуулгын судалгааны боловсруулалтын үр дүнгүүд дээр үндэслэн шинжиллээ.

2.2.1. Сайн дурын үйл ажиллагааны талаарх нөхцөл байдлыг үнэлсэн судалгааны үр дүн.

Монголын Сайн Дурын Байгууллагуудын Сүлжээ (NMVO), НҮБ-ын Сайн дурынхан (UNV) болон VSO-Хилийн чанад дахь Сайн Дурын Алба, Олон Улсын Байгууллага (VSO) хамтарсан судалгааны үр дүн дээрээ тулгуурлан “Монголын сайн дурын үйл ажиллагааны нөхцөл байдлын үнэлгээ ба зөвлөмж” баримт бичгийн гаргасан байна. Монгол Улсад сайн дурын үйл ажиллагааг дэмжих орчин бүрдүүлэхийн тулд өнөөгийн нөхцөл байдалд шинжилгээ хийж үнэн зөв бодитой, нэгдсэн ойлголтыг бий болгох улмаар цаашид авах арга хэмжээ болон хөгжлийн аргачлалаа тодорхойлох зорилгын үүднээс Монгол Улсын Ерөнхийлөгчийн Тамгын Газраас санаачлан сайн дурынхантай ажилладаг байгууллагууд, тухайлбал Монголын сайн дурын байгууллагуудын сүлжээ, НҮБ-ын сайн дурынхан (UNV) болон хилийн чанад дахь сайн дурын албатай хамтарч Сайн дурынхны Ажлын хэсэг байгуулж, хоёр жил орчим тогтмол уулзан ажиллаж бодлогын чиглэлүүдийг тодорхойлсон байна. Юуны өмнө сайн дурынхныг хөгжүүлэх дэд бүтцийг цогцоор нь авч үзэхийг чухалчилсан байна. Хөгжлийн дэд бүтцийг тодорхойлох нь сайн дурын үйлс хөгжин цэцэглэх тал бүрийн таатай орчныг бүрдүүлэх цогц бодлогын асуудал бөгөөд түүнд төрийн бодлого, хөтөлбөр, стратегийн чиглэлүүдээ тодорхойлж, санхүүгийн таатай орчныг бүрдүүлэх тухай асуудлууд ордог ажээ. Бодлогоо зөв тодорхойлохын тулд өнөөгийн нөхцөл байдалд шинжилгээ хийж хүрсэн ололт амжилт болон алдаа оноогоо дүгнэн үзэх хэрэгцээ бий болсон. Энэ үүднээс ажлын хэсгээс сайн дурын үйл ажиллагааны нөхцөл байдлын судалгааг зохион байгуулсан байна. Судалгаанд сайн дурын албан сектор болон албан бус бүлгүүдийн үйл ажиллагаа, иргэдийн санаачилга, оролцоог өргөн хүрээнд хамруулжээ

Монгол Улс дахь сайн дурын үйлсийн өнөөгийн нөхцөл байдлыг тодорхойлохын тулд 2012 оны 6 дугаар сард Сайн дурын үйл ажиллагааны нөхцөл байдлын судалгааг цахим шуудангаар болон бусад хэлбэрээр 79 байгууллага, 1000 оюутныг хамруулан зохион байгуулав. Түүнчлэн Монгол Улс дахь Сайн дурын үйлстэй холбоотой судалгаа, тайлан, хэрэгжиж байгаа төсөл, хөтөлбөрүүдийн талаарх танилцуулга, гарын авлага зэрэг мэдээллүүдийг судлахын зэрэгцээ, бусад орны баримталж байгаа бодлого, чиглэл, туршлагыг харьцуулан судалсан байна. Монгол Улс дахь сайн дурын үйлсийн өнөөгийн нөхцөл байдлын талаар хийсэн судалгаа, дүн шинжилгээний үр дүнгийн талаар иргэд, олон нийтэд мэдээлэх, тэдний санаа бодлыг сонсох зорилгоор 2012 оны 10 дугаар сарын 24-ний өдрийн Иргэний танхимд “ Сайн дурын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих” нээлттэй хэлэлцүүлгийг Монгол Улсын Ерөнхийлөгчийн Тамгын Газар, Монгол Улсын хөдөлмөрийн яам, НҮБ-ын Сайн дурынхан (UNV), Монголын сайн дурын байгууллагуудын сүлжээтэй хамтран зохион байгуулсан. Иргэний танхимд Сайн дурын үйлсийн талаар хийсэн нээлттэй хэлэлцүүлгийн үеэр гарсан санал, дүгнэлтүүдийг нэгтгэн Ажлын хэсгээс Зөвлөмж гаргасан ажээ. Нөхцөл байдлын үнэлгээ гурван бүлгээс бүрдэж байна.

Сайн дурын дэмжих орчин бүрдүүлэх талаар бусад орнуудын баримталж буй бодлого, чиглэл хэмээх нэгдүгээр бүлэгт: сайн дурынхныг дэмжих чиглэлээр бусад улс, орнуудын бодлого, стратеги, үйл ажиллагааны сайн туршлагыг судалж, шинжилгээ хийжээ. Чингэхдээ хэд хэдэн орнуудын бодлогын баримт бичигтэй танилцсаны зэрэгцээ, бусад орнуудад нийтлэгдсэн бодлогын баримт бичиг, илтгэл, тайлан, судалгаа, ялангуяа НҮБ-аас нийтлэн гаргасан баримт бичгүүдийг ашигласан байна. Бүлгийн эхний хэсэгт НҮБ-аас хэрэглэж ирсэн, сайн дурын үйл ажиллагаа, сайн дурынхан, төрийн бус байгууллага, иргэний нийгэм гэсэн нэршил нь хоорондоо харилцан уялдаатай болохыг тайлбарлажээ. Эдгээр нь бидний онолын хэсэгт авч үзсэнтэй адил үнэлэлт дүгнэлттэй байна. Цаашид сайн дурынхныг дэмжих орчин бүрдүүлэх гол хүчин зүйлс нь иргэний нийгэм, сайн дурынхантай ажилладаг байгууллагуудын чадавхыг бэхжүүлэх таатай орчин бүрдүүлэхэд шаардлагатай хөгжүүлэх дэд бүтцийг цогцоор нь хөгжүүлэх чиглэлийг дараах байдлаар тодорхойлсон байна. Үүнд:

- Сайн дурын үйл ажиллагааны талаар нэгдмэл ойлголт болон үнэлэмжтэй болох,

- Улс орны нийгэм эдийн засгийн хөгжилтэй уялдсан сайн дурын үйлс, сайн дурынхныг дэмжсэн бодлоготой болох, эрх зүйн орчныг бүрдүүлэх,

- Сайн дурынхныг зохицуулах үндэсний бүтцийг бүрдүүлэх,

- Сайн дурынхны хөгжлийн төвүүдийг Улаанбаатар хот болон хөдөө орон нутгуудад байгуулах,

- Сайн дурын нэгдсэн цахим хуудастай болох,

- Сайн дурын үйлсийг сурталчлах,

- Эдгээр чиглэлүүд нь өнөөдөр ч чухал хэвээр байгаа нь судалгаанаас харагдаж байна.

Монгол Улс дахь өнөөгийн нөхцөл байдалд хийсэн дүн шинжилгээ гэсэн хоёрдугаар бүлэгт: Монгол Улсын сайн дурынхны үйлстэй холбоотой материалууд, төсөл, хөтөлбөр, байгууллагын илтгэл тайлангуудад хийсэн судалгаа, шинжилгээний болон олон нийтийн дунд явуулсан судалгааны үр дүнг танилцуулсан байна. Түүнчлэн тухайн үеийн улс төр, эдийн засгийн нөхцөл байдал, сайн дурын үйлсийн шинж байдал, хууль эрх зүйн болон санхүүгийн орчин, өнгөрсөн хугацаанд хийгдсэн гол ажлууд, түүнээс авсан гол сургамжууд, сайн дурын үйлсийг хөгжүүлэхийн тулд цаашид авч хэрэгжүүлэх шаардлагатай алхмуудын үндэслэлийг гаргасан байна. Судалгаагаар:

- Монголын ард түмэн эрт дээрээс хөрш, саахалт айлдаа тусалж ирсэн сайхан ёс уламжлалтай. Улс орны уламжлал ёс заншилд суурилсан сайн үйлс нь улам бүр зохион байгуулагдан сайн дурын салбар болтлоо өргөжин хөгжсөнийг,

- Орчин үеийн хэлбэрээр зохион байгуулагдсан сайн дурын байгууллагууд нь нийгмийн тодорхой чиглэлээр зорилготой ажиллаж, үйл ажиллагааны хүрээгээ тэлсээр байгааг,

- Монголчуудын хувьд сайн дурын үйл ажиллагаанд оролцох сонирхол, хүсэл тэмүүлэл их байгааг онцолсон байна.

Ололтын зэрэгцээ судалгаанд хамрагдсан хүмүүсийн цөөнгүй хэсэг нь сайн дурын үйл ажиллагааны талаар ялангуяа энэ үйл ажиллагааны үр өгөөжийг төдийлөн ойлгоогүй байсан бөгөөд эндээс сайн дурын үйлс, түүний ач холбогдлыг олон нийтэд сурталчлах нь сайн дурын үйлсэд иргэдийн оролцоог нэмэгдүүлэх ихээхэн ач холбогдолтой нь харагдаж байжээ. Түүнчлэн сайн дурын үйл ажиллагааг зохицуулах нэгдсэн зохицуулалт болон хариуцсан төрийн байгууллага байхгүй байгаа нь

Монгол Улсад сайн дураараа ажиллахад тохиолдож буй гол бэрхшээл юм гэдгийг “Судалгаа2012” дүнгээс харагдаж байжээ. Уг асуудлыг шийдвэрлэхийн тулд нэн тэргүүнд Үндэсний сайн дурынхны төв байгуулах нь зүйтэй гэсэн зөвлөмж хэлэлцүүлгээс гарсныг онцлон дурдсан байна.

Иргэний танхимд зохион байгуулсан хэлэлцүүлэг, зөвлөмж гэсэн гуравдугаар бүлэгт нөхцөл байдлын үнэлгээний үр дүнд тулгуурлан Ажлын хэсгээс боловсруулсан "Монгол Улсад сайн дурын үйл ажиллагааны дэд бүтцийг хөгжүүлэх зөвлөмж"-ийн агуулгыг дэлгэрэнгүй тайлбарласан байна. Энэхүү зөвлөмжийг Монгол Улсын Ерөнхийлөгч, Улсын Их Хурал болон Засгийн газарт хандаж боловсруулсан байна. Зөвлөмжид сайн дурын үйлсийг дэмжих, хөгжих таатай орчин бүрдүүлэхэд шаардлагатай тэргүүлэх чиглэлүүдийг тодорхойлохын зэрэгцээ Засгийн газар, иргэний нийгэм, сайн дурынхны салбарын хамтран хийх ёстой ажлуудыг тодорхойлсон байна. Түүнчлэн үндэсний сайн дурынхныг дэмжих цогц бодлого боловсруулах асуудлыг гол чиглэлээ болгожээ. Чингэхдээ цогц бодлогыг дараах хэсгүүдээс бүрдүүлэхийг санал болгожээ. Үүнд:

- Сайн дурын үйл ажиллагааг хөгжүүлэх төрийн бодлогоо тодорхойлох. Сайн дурын үйл ажиллагааг хөгжүүлэх үндэсний хөтөлбөр, стратеги, үйл ажиллагааны төлөвлөгөө болон хэрэгжилтийг хянах мониторингийн тогтолцоог бүрдүүлэх.

- Сайн дурын үйл ажиллагааны тогтвортой санхүүжилтыг улсын төсөвт тусгадаг болох.

- Үндэсний ба орон нутгийн түвшинд сайн дурын үйл ажиллагааг зохицуулах бүтцийг институцчилах.

- Холбогдох хууль тогтоомжинд сайн дурынхан, сайн дурын үйл ажиллагаа, сайн дурын хөдөлмөр эрхлэлт, сайн дурын байгууллага гэсэн нэршлийг оруулах, нэгдсэн ойлголтыг болгох.

- Сайн дурын үйл ажиллагааг аль болох олон салбарт дэмжих зорилготой үнэлгээний аргачлалыг боловсруулан хэрэглэх.

Тухайн үеийн Иргэний танхимын хэлэлцүүлэгт Хөдөлмөрийн яамны зүгээс сайн дурын хөгжүүлэх таатай орчин бүрдүүлэх чиглэлээр шаардлагатай арга хэмжээг хэрэгжүүлэхийн төлөө бусад яам төрийн байгууллагууд, иргэний нийгэм, сайн дурынхантай ажилладаг бүхий л байгууллагуудтай үр дүнтэй хамтран ажиллахад бэлэн гэдгээ албан ёсоор мэдэгдсэн байна.

Аливаа асуудлыг шийдвэрлэхэд юуны өмнө гүнзгий судалсан, шинжлэх ухааны үндэслэлтэй ойлголтын суурь бааз шаардлагатай байдаг бөгөөд энэ шаардлага зөвхөн шинжлэх ухааны боловсруулалтад бус бас үндсэн томъёолол болон ойлголтын онолын үндэслэлтэй тодорхойлолтыг агуулсан норматив, эрх зүйн баримт бичгүүдэд хамаардаг ба зөвхөн онолын үндэслэлтэй тодорхойлолт л аливаа асуудалд харилцан ойлголцол болон нэгдсэн хандлага бий болгож чаддагийг үндэс болговол сайн дурынхан, тэдний үйл ажиллагааны талаарх ойлголтын агуулга, ач холбогдлыг харуулсан, бидний ажлын санал, зөвлөмж боловсруулахад чухал хэрэгтэй заалтууд энэхүү баримт бичигт цөөнгүй байгаа юм. Тухайлбал, Олон улсын сайн дурынхны жилийг зарласны 10 жилийн ойг 2011 онд тэмдэглэсэн арга хэмжээний мөрөөр НҮБ-ын Ерөнхий Ассемблейд оролцсон олон орны төлөөлөгчид сайн дурын үйлсийн шинж чанар, ач холбогдлыг дараах агуулгаар хүлээн зөвшөөрсөн:

- *"Сайн дурын үйлс нь хөгжлийг дан ганц эдийн засгийн үзүүлэлтээр үнэлж болохгүй гэдэгт үндэслэсэн стратегийн салшгүй бүрэлдэхүүн хэсэг болсон* (жишээ нь, ядуурлыг бууруулах, зохистой хөгжил, эрүүл мэнд, гамшгаас урьдчилан сэргийлэх, нийгмийн эв нэгдлийг дээшлүүлэх, нийгмийн гадуурхлыг арилгах чиглэлээр НҮБ-ын Мянганы хөгжлийн зорилтуудыг биелүүлэхэд сайн дурынхны үүрэг оролцоо үнэлшгүй их юм)" гэдгийг,

- Сайн дурын үйлсийн НҮБ-ын тодорхойлолтоор *"Сайн дурын үйл ажиллагаа нь нийгмийн оршин тогтнох үндэс болсон иргэдийн оролцоог сэдэлжүүлэх эх суурь"* бөгөөд Сайн дурын үйлс нь өөртөө туслах хөршийн бүлгүүдээс эхлээд зохион байгуулалттай нийгмийн тусламж үйлчилгээ хүргэх, олон нийтийг гэгээрүүлэх, нөлөөллийн ажилд оролцох зэргээр иргэний оролцооны олон хэлбэрүүдээр илэрнэ гэдгийг,

- НҮБ-ын Ерөнхий Ассемблейгаас сайн дурын үйлсийг өөрийн хүсэл зоригор, нийтийн сайн сайхны (хамт олон, нийгэмд болон сайн дурын ажилтанд өөрт нь тустай) төлөө, мөнгөн урамшлыг үл горилон хувь нэмрээ оруулж буй нийгэмшсэн зан үйл гэж тодорхойлсоныг,

- Сайн дурын үйлсийн НҮБ-ын Сайн дурынхны (UNV) тодорхойлолт: сайн дурын үйлсийг нийтлэг, олон нийтийг хамарсан, чөлөөт сонголт, чин хүсэл эрмэлзэл, оролцоо, эв нэгдэл дээр үндэслэсэн гэсэн шинж чанаруудтай хэмээн үздэг бөгөөд Сайн дурын үйлс нь улс орнуудад хөгжих үйл явцдаа иргэдээ татан оролцуулах хүчирхэг арга хэрэгсэл болдог Түүнчлэн, сайн дурын үйлс нь хөгжлийг хурдасгаж, шинж чанарыг нь

өөрчлөх чадвартай. Сайн дурын үйлс нь иргэд, хувь хүмүүсийн эв нэгдэл, итгэлцэл, харилцан ойлголцлыг бэхжүүлж, тэдний оролцоог нэмэгдүүлэх боломжийг бий болгосноороо нийгэмд болон сайн дурынханд аль алинд нь ашиг тусаа өгдөг юм. Сайн дурын үйлс нийгмийн тэгш оролцоог дэмжиж, зохистой хөгжлийн суурийг бүрдүүлдэгийг,

- Дэлхийн сайн дурын үйлс 2011 Тайланд дурдсанаар "сайн дурын үйлс нь хүн төвтэй хөгжлийн хөдөлгөх хүчин байдаг нийтлэг чанартай. Сайн дурын үйлсийн нэгэн чухал үүрэг нь нийгмийн сайн сайхан, хөгжил дэвшлийг хангахад оршдог." "Сайн дурын үйлс нь энх тайван, хөгжил, дэвшилд хүргэдэг төдийгүй нийгэм, олон нийт, хувь хүний амьдралд үр нөлөө үзүүлэх, тэднийг итгэлцэл, харилцан ойлголцлын шижмээр холбох онцлог чадвартай. Сайн дурын үйлс нь эерэг өөрчлөлт хийх, идэвхтэй хүчин байх боломжийг хүн бүхэнд олгодог. Сайн дурынхан хамтарсан ажиллагааг дэмжиж, хувь хүний болон нийгмийн сайн сайханд ашиг тусаа өгдөг. Идэвхтэй оролцоо нь энгийн ард иргэдийг эрх мэдэлжүүлдэг бөгөөд бүхий л түвшинд хамтын ажиллагаа, дэмжлэгээр хангагдсан нөхцөлд энэ нь бүр ч үр дүнтэй байдаг"¹⁰⁴-ийг,

- Сайн дурын үйлс нь нийгмийн баялгийн гол цөм болдог бөгөөд иргэний нийгэм дэхь ихэнх нийгэмшсэн үйл ажиллагааны суурь байдаг. Сайн дурын үйлс нь доороосоо ундрэн гардаг, тухайлбал иргэд үер, газар хөдлөлт, хээрийн түймэр зэрэг гамшгийн хохирогчдод туслахаар сайн санаагаараа оролцдог. Түүнчлэн, иргэний нийгмийн байгууллагуудаар дамжиж сайн дурын үйлс зохион байгуулалттай хэрэгждэг. Иргэний нийгмийн байгууллагууд нь олон төрөл хэлбэртэй бөгөөд янз бүрийн зорилтот бүлэгт үйлчилдэг. Гэхдээ тэд бүгд сайн дурын үйлс дээр үндэслэсэн байдгаараа нийтлэг юм. Хүмүүс Мянганы Хөгжлийн Зорилтод хамрагдсан чиглэлүүдээр сайн дураараа хувь нэмрээ оруулахаар төрийн бус байгууллагын эгнээнд нэгддэг. Бас тэдгээр байгууллагын удирдлагад хувь нэмрээ оруулахаар сайн дураар ажилладаг. Сайн дурын үйлс мөн дэлхийн өнцөг булан бүрт ажилладаг энгийн иргэдийн олон байгууллагын гишүүнчлэлээр илэрдэг¹⁰⁵-ийг,

- Иргэний нийгэм болон иргэний нийгмийн байгууллагын талаар НҮБ-ын Хөгжлийн Хөтөлбөрийн тодорхойлолт: "Иргэний нийгэм хамтын

¹⁰⁴ НҮБ-ын сайн дурынхны (ЦТЧУ) гүйцэтгэх зохицуулагч Флавия Пансиерийн 2011 оны Олон улсын сайн дурынхны өдрөөр хэлсэн үгээс.

¹⁰⁵ "Сайн дурынхныг дэмжих орчин бүрдүүлэх нь: Зөвлөмж", НҮБ-ын Сайн дурынхан (UNV).

зорилго, ашиг сонирхлоо үйл хэрэг болгоход нь хүмүүсийг нэгтгэдэг Иргэний нийгмийн оролцогчид нь ашиг олох, эрх мэдэл олохыг горилоогүй төрөөс ангид оролцогчид болно. Иргэний нийгмийн байгууллагууд нь төрийн болон ашгийн төлөөх хувийн хэвшлийн зэрэгцээ орших гурав дахь хэвшил болдог Иргэний нийгэм нь хамтран ажиллах, ухаан бодлоо уралдуулах талбар болдог ба үндэсний болон түүхэн нөхцөл байдлаас хамааран онцлог хэв маягтай байж болно. Иргэний нийгэм нь хөгжлийн үйл ажиллагаанд оролцдог байгууллагууд, зохион байгуулалтын бусад хэлбэрүүдийг, тухайлбал төрийн бус байгууллага, олон нийтэд түшиглэсэн байгууллага, үндэстэн ястан, тэднийг төлөөлсөн байгууллага, сургалт эрдэм шинжилгээний байгууллага, сэтгүүлчдийн нийгэмлэг, шашны болон буяны байгууллага, мэргэжлийн холбоод, үйлдвэрчний эвлэл, худалдааны нийгэмлэгүүд, мэргэжлийн гишүүнчлэлийн байгууллага, эмэгтэйчүүдийн болон нийгмийн хөдөлгөөн, дэмжигч байгууллага, эдгээр байгууллагын сүлжээ, эвслүүдийг багтаана. Иргэний нийгмийн байгууллагад олон нийтийн мэдээллийн хэрэгсэл, үндэстэн дамнасан корпорацууд хамаардаггүй” болох зэргийг хүлээн нэгдсэн ойлголтод хүрсэн байна.

2.2.2 Гамшгаас хамгаалах сайн дурын хэсгийн үйл ажиллагааны судалгаа.

Төв, орон нутгийн хэмжээнд үйл ажиллагаа явуулж байгаа гамшгаас хамгаалах сайн дурын хэсгийн нэгдсэн судалгааг аймгуудаар: хамрагдсан сумын тоо, сайн дурын хэсгийн гишүүдийн тоо, аймгуудын сумдын сайн дурын хэсгийн дундаж тоо, ажлын чиг үүрэг, үйл ажиллагаа явуулж буй хугацаа, сургалт явуулсан байдал, байгаа багаж хэрэгсэл зэрэг үзүүлэлтүүдээр харьцуулан хүснэгт №11-д үзүүлээ. Мөн Улаанбаатар хотын дүүргүүдэд байгуулагдсан сайн дурын хэсгийн судалгааг дээрхтэй адил үзүүлэлтүүдээр гаргаж (Хүснэгт 15-д) орууллаа.

№	Аймаг	Үзүүлэлтийн нэрс	Үзүүлэлтийн талаарх баримт
1.	Архангай	Сумдын тоо, СДХГ-ийн тоо, дундаж тоо	11, 161, 8-21
		Ажлын чиг үүрэг	Гал түймэр унтраах, эрэн хайх, анхны тусламж үзүүлэх
		Ажилласан хугацаа	1 жил 8 сар
		Сургалт явуулсан байдал	Аюулт үзэгдэл, ослоос урьдчилан сэргийлэх, анхны тусламж, нэрвэгдэгсдийг аврах, зөөвөрлөх 30 цаг.

		Багаж хэрэгсэл (Нэг хэсэгт)	Иж бүрэн хувцас 15 ком, гал унтраах анхан шатны иж бүрэн багаж хэрэгсэл 1 ком
2.	Баян-Өлгий	Сумдын тоо, СДХГ-ийн тоо, дундаж тоо	14, 159, 7-36
		Ажлын чиг үүрэг	Эрэн хайх, анхны тусламж үзүүлэх, урьдчилан сэргийлэх ажилд оролцох
		Ажилласан хугацаа	2 жил
		Сургалт явуулсан байдал	-
		Багаж хэрэгсэл (Нэг хэсэгт)	Эрүүл мэнд анхны тусламжийн иж бүрдэл -1 ком, хүрз-6, хөрөө-2, малтуур-3, Сүх-2, галын хор 2, аврах шат1, олс 2.
3.	Баянхонгор	Сумдын тоо, СДХГ-ийн тоо, дундаж тоо	2, 29, 14-15
		Ажлын чиг үүрэг	Гал түймэр унтраах, эрэн хайх, аврах, анхны тусламж үзүүлэх
		Ажилласан хугацаа	2 жил
		Сургалт явуулсан байдал	-
		Багаж хэрэгсэл (Нэг хэсэгт)	Гал үлээгч аппарат -4, галын цохиур, трос-15, төмөр хувин-10, хөрөө-10, сүх-2, царил-4, тармуур-4, Рло ус шүршигч-15, иж бүрэн хувцас-15, гар чийдэн 5, элсний хайрцаг- 4,
4.	Булган	Сумдын тоо, СДХГ-ийн тоо, дундаж тоо	16, 492, 9-60
		Ажлын чиг үүрэг	Гал түймэр унтраах, эрэн хайх
		Ажилласан хугацаа	11 сар
		Сургалт явуулсан байдал	Гамшгаас хамгаалах тухай хууль, сайн дурын ажиллах журам, 1 хэсэгт 2-6 цаг, Нийт 58 цаг.
		Багаж хэрэгсэл (Нэг хэсэгт)	Тээврийн хэрэгсэл-2, Бусад гар багаж, тросон шүүр, цохиур 1-12 ком Бүгд-132ш
5.	Говь-Алтай	Сумдын тоо, СДХ Г-ийн тоо, дундаж тоо	18, 124, 5-14
		Ажлын чиг үүрэг	Гамшгаас хамгаалах сайн дурын хэсгийн ажиллах журмын дагуу
		Ажилласан хугацаа	2 жил
		Сургалт явуулсан байдал	Гамшгаас хамгаалах сайн дурын хэсгийн ажиллах журам, үүрэг оролцоо. 2-8 цаг.

		Багаж хэрэгсэл (Нэг хэсэгт)	Дурдаагүй.
6.	Говьсүмбэр	Сумдын тоо, СДХГ-ийн тоо, дундаж тоо	3, 44, 14-16
		Ажлын чиг үүрэг	Гал түймэр унтраах, аврах, анхны тусламж үзүүлэх, аврах, хойшлуулшгүй сэргээх босгох ажилд оролцох
		Ажилласан хугацаа	10 сар
		Сургалт явуулсан байдал	ОБГ, МУЗН, Дэлхийн зөн хамтарсан 2 удаагийн сургалтад 88 иргэн хамрагдсан. 18 цаг
		Багаж хэрэгсэл (Нэг хэсэгт)	Галын хантааз-15, галын бүтээлэг-3, дамнуурга-1, үлээгч-3, хүрз-15, гөвүүр-10, савар, тармуур
7.	Дархан-Уул	Сумдын тоо, СДХГ-ийн тоо, дундаж тоо	4, 75, 15-30
		Ажлын чиг үүрэг	Гамшгаас хамгаалах, урьдчилан сэргийлэх, гал түймэртэй тэмцэх
		Ажилласан хугацаа	1 жил
		Сургалт явуулсан байдал	“Бэлэн бай” сургалт, Сайн дурын үйл ажиллагаа, үүрэг хариуцлагын тухай, 16 цаг
		Багаж хэрэгсэл (Нэг хэсэгт)	-
8.	Дорноговь	Сумдын тоо, СДХГ-ийн тоо, дундаж тоо	14, 124, 7-11
		Ажлын чиг үүрэг	Гамшгаас хамгаалах сайн дурын хэсгийн чиг үүргийн дагуу үйл ажиллагаа явуулах
		Ажилласан хугацаа	2 жил
		Сургалт явуулсан байдал	“Бэлэн бай” сургалт дадлага, Гамшгаас хамгаалах тухай хууль, “гал унтраах анхан шатны багаж хэрэгсэл”- тэй ажиллах заавар. 4 цаг
		Багаж хэрэгсэл (Нэг хэсэгт)	Тросон шүүр-11, гөвүүр-10, эсгий 2ш, хүрз-13ш, үлээгч аппарат-4ш, автомашин-1, үлээгч аппарат 4ш
9.	Дорнод	Сумдын тоо, СДХГ-ийн тоо, дундаж тоо	15, 211, 7-25
		Ажлын чиг үүрэг	Сайн дурын хэсгийн заавар журмын дагуу үйл ажиллагаа явуулах
		Ажилласан хугацаа	2 жил

		Сургалт явуулсан байдал	Бэлэн бай сургалт, дадлага, гал түймэр унтраах, анхны тусламж. 4 цаг
		Багаж хэрэгсэл (Нэг хэсэгт)	Машин-2, трактор-1, хүрз-12, олс-10, цахилгаан үүсгүүр-1, усны насос-1, үлээгч аппарат 20, гар цохиур-10, мотоцикл, носилк-3, олс-2, шат
10.	Дундговь	Сумдын тоо, СДХГ-ийн тоо, дундаж тоо	15, 161, 6-17
		Ажлын чиг үүрэг	Гал түймэр унтраах.
		Ажилласан хугацаа	1 жил
		Сургалт явуулсан байдал	Гамшиг, ослоос сэргийлэх, бэлэн байдал, анхны тусламж. 6 цаг
		Багаж хэрэгсэл (Нэг хэсэгт)	Усны машин, автомашин, мотоцикл, бусад багаж хэрэгсэл
11.	Завхан	Сумдын тоо, СДХГ-ийн тоо, дундаж тоо	15, 84, 5-7
		Ажлын чиг үүрэг	Гал түймэртэй тэмцэх сайн дурын хэсгийн журмын дагуу
		Ажилласан хугацаа	2 жил
		Сургалт явуулсан байдал	Сум орон нутагт объектын болон ой хээрийн түймэр гарсан нөхцөлд богино хугацаанд унтраах. 8 цаг
		Багаж хэрэгсэл (Нэг хэсэгт)	Мотопомп-1, сүх-2, хүрз-5, лоом-5, хувин-2, РЛО-2, цохиур-20, хатуу зөөлөн шланк, галын дэгээ-2, шүршигч-1, мотопомп-1, үлээгч-1
12.	Орхон	Сумдын тоо, СДХГ-ийн тоо, дундаж тоо	2, 30, 12-15
		Ажлын чиг үүрэг	Гамшгаас урьдчилан сэргийлэх, ой, хээрийн түймэр унтраах
		Ажилласан хугацаа	1 сар.
		Сургалт явуулсан байдал	Гамшгаас урьдчилан сэргийлэх дадлага, сургууль. 2 цаг.
		Багаж хэрэгсэл (Нэг хэсэгт)	Үлээгч аппарат-2, Анхны тусламжийн иж бүрдэл -20, троссон шүүр-10, РЛО, үүргэвч, мотопомп-, цохиур-5,
13.	Өвөрхангай	Сумдын тоо, СДХГ-ийн тоо, дундаж тоо	18, 248, 14-15
		Ажлын чиг үүрэг	Гамшгаас хамгаалах сайн дурын хэсгийн журмын дагуу
		Ажилласан хугацаа	7 сараас 2 жил

		Сургалт явуулсан байдал	Гамшгаас урьдчилан сэргийлэх, бэлэн байдал, анхны тусламж. Сард 1 удаа 4-16 цаг
		Багаж хэрэгсэл (Нэг хэсэгт)	Автомашин-1, сүх, хүрз, галын хор-11, хөрөө-2, малтуур- 4, тросон шүүр-5, цохиур-8, автомашин-1, Ковш-1, мотор-5, гар станц-3, жоотуу-3, усны машин-1, мотор-2,
14.	Өмнөговь	Сумдын тоо, СДХГ-ийн тоо, дундаж тоо	15, 273, 10-15
		Ажлын чиг үүрэг	Анхны тусламж, авран хамгаалах
		Ажилласан хугацаа	-
		Сургалт явуулсан байдал	Бэлэн бай, газар хөдлөлт, гал түймрийн аюулаас сэргийлэх. 6-12 цаг
		Багаж хэрэгсэл (Нэг хэсэгт)	Сум бүрд Фургон-1, машин-2, хүрз, лоом-20, жоотуу-20, малтуур-10, чанга яригч-2, цахилгаан мотор-2, майхан-1 хувцас 15 ком, үлээгч аппарат-5, галын хор-3, олс-3, шат-2, цахилгаан мотор- 4, мотопомп, майхан гэх мэт.
15.	Сүхбаатар	Сумдын тоо, СДХГ-ийн тоо, дундаж тоо	13, 141, 9-12
		Ажлын чиг үүрэг	Эрэн хайх аврах, анхны тусламж үзүүлэх
		Ажилласан хугацаа	2 жил
		Сургалт явуулсан байдал	Сайн дурын ажиллах журам, галын аюул, гамшгаас урьдчилан сэргийлэх арга хэмжээ. 4-8 цаг
		Багаж хэрэгсэл (Нэг хэсэгт)	Сум бүрд Үлээгч аппарат, тоссон шүүр, 15-20 хүний багаж хэрэгсэл, автомашин, мотоцикл, Фургон автомашин
16.	Сэлэнгэ	Сумдын тоо, СДХГ-ийн тоо, дундаж тоо	15, 225, 15
		Ажлын чиг үүрэг	Гал түймэр унтраах
		Ажилласан хугацаа	-
		Сургалт явуулсан байдал	Ой хээрийн түймрээс хамгаалах, унтраах, тэмцэх арга зүй, хариуцлага, “ойн нөхөрлөл”-ийн үүрэг, багаж хэрэгслэлийн үзлэг судалгаа, дадлага. Нэг хэсэгт 3 цаг.

		Багаж хэрэгсэл (Нэг хэсэгт)	Хэсэг бүрд Галын хор-1, дамнуурга-5, үлээгч-1, усны сав 1тн, хөрөө-15, шүүр-15, хүрз-10, гөвүүр-20, автомашин, хувийн үүргэвч, иж бүрдэл (15 хүний) Анхны Тусламжийн цүнх 15 ком, даралтын хоолой гэх мэт
17.	Төв	Сумдын тоо, СДХГ-ийн тоо, дундаж тоо	6, 52, 4-24
		Ажлын чиг үүрэг	Ой хээрийн гал түймэр унтраах
		Ажилласан хугацаа	1.4 жил
		Сургалт явуулсан байдал	Бэлэн бай багц сургалт, гал түймэр унтраах. 3-15 цаг
		Багаж хэрэгсэл (Нэг хэсэгт)	Хэсэг тус бүрд Үлээгч аппарат,моторт хөрөө, гар хөрөө,савар, хүрз, шүүр, автомашин, усны сав, мотопомп, цахилгаан үүсгүүр нийт 38 ширхэг.
18.	Увс	Сумдын тоо, СДХГ-ийн тоо, дундаж тоо	19, 266, 14
		Ажлын чиг үүрэг	Гал унтраах, эрэн хайх, аврах, анхны тусламж
		Ажилласан хугацаа	2.5 жил
		Сургалт явуулсан байдал	Гал түймэр, үер усны гамшгаас урьдчилан сэргийлэх. Нэг хэсэгт 2-22 цаг
		Багаж хэрэгсэл (Нэг хэсэгт)	Үлээгч аппарат-4, ус шүршигч-2, мотопомп-1, усны сав, сүх-20, жоотуу-10, шүүр-25, цохиур-30, хүрз-10, автомашин-1
19.	Ховд	Сумдын тоо, СДХ Г-ийн тоо, дундаж тоо	15, 198, 9-15
		Ажлын чиг үүрэг	Гамшиг ослын үед мэдээлэл хүргэх, эрэн хайх, дайчилгаанд явах, гал унтраах, үер усны хамгаалалт хийх, нүүлгэн шилжүүлэх
		Ажилласан хугацаа	2 жил
		Сургалт явуулсан байдал	Гамшиг, ослоос эд хөрөнгө, хүний амь нас аврах, эрэн хайх, аврах, хор уршгийг арилгах. 2-24 цаг.
		Багаж хэрэгсэл (Нэг хэсэгт)	Сум бүрд бие бүрэлдэхүүний иж бүрэн хувцас-15 ком,усны сав 1тн, мотопомп-2, хүрз- 20, зээтүү-10 тармуур15, гөвүүр-20, тросон шүүр-

			15, Фургон машин-1, жоотуу-10, GPS,
20.	Хэнтий	Сумдын тоо, СДХГ-ийн тоо, дундаж тоо	23, 1542, 8-440
		Ажлын чиг үүрэг	Гамшгаас Хамгаалах тухай болон галын аюулгүй байдлын тухай хууль, Ойн тухай хууль, мэргэжлийн ангийн дүрэмд заасан үүрэг хариуцлагын тухай
		Ажилласан хугацаа	10 сар
		Сургалт явуулсан байдал	Гамшгаас урьдчилан сэргийлэх, авран хамгаалах,эрэн хайх, хойшлуулшгүй сэргээн босгох үйл ажиллагаа, анхны тусламж, “Бэлэн бай” багц сургалт. 3 сар
		Багаж хэрэгсэл (Нэг хэсэгт)	Сум бүрд мотопомп-1, шүүр -25, цохиур-25-80, үлээгч аппарат-10,жоотуу-3, сүх-5, гар хөрөө-10, моторт хөрөө-4, цахилгаан хөрөө-1, тросон шүүр-27,
21.	Хөвсгөл	Сумдын тоо, СДХГ-ийн тоо, дундаж тоо	14, 172, 8-15
		Ажлын чиг үүрэг	Гал түймэр унтраах сайн дурын хэсэг.
		Ажилласан хугацаа	8 сараас 1.9 жил
		Сургалт явуулсан байдал	Гамшгаас урьдчилан сэргийлэх, эрэн хайх, аврах, хойшлуулшгүй сэргээн босгох хөтөлбөрөөр. Нэг хэсэгт 4-8 цаг
		Багаж хэрэгсэл (Нэг хэсэгт)	Аврах олс-20м, галын хор-2, дамнуурга-2, аврах шат-1, хүрз-5, Рло,эмийн сан-4,аяны хүрз-2, дуут дохио-1,чиргүүлтэй усны сав-1, жоотуу -15,усны сав-20,эмийн сан-4, хүн нэг бүрийн хувцас, хэрэглэл, өртөнг ухагч -20, богино долгионы станц гэх мэт.
Нийт тоо: хамрагдсан сум ба гишүүд			263 ба 4841

Хүснэгт 15., Төв, орон нутгийн хэмжээнд үйл ажиллагаа явуулж байгаа гамшгаас хамгаалах сайн дурын хэсгийн судалгаа /2020 оны 07 дугаар сарын 09-ний байдлаар

№	Дүүрэг	Үзүүлэлтийн нэрс	Үзүүлэлтийн талаарх баримт
1.	Багахангай	Хорооны тоо, СДХ Г-ийн тоо, дундаж тоо	2, 20, 10

		Ажлын чиг үүрэг	Хүн, малын гоц халдварт өвчин, цасан болон шороон шуурга, техникийн холбогдолтой осол объектын болон ой хээрийн түймэр
		Ажилласан хугацаа	1 жил 8 сар
		Сургалт явуулсан байдал	-
		Багаж хэрэгсэл (Нэг хэсэгт)	Хөдөлмөр хамгааллын хувцас 16 ш, анхны тусламжийн иж бүрдэл 1 ком, Носилка 1ш, Аврах хантааз 1ш, Аврах цагариг 1ш, Хүрз 10ш, Хөрөө 2ш, Лантуу 1ш, олс 50м.
2.	Баянгол	Хорооны тоо, СДХГ-ийн тоо, дундаж тоо	1, 5
		Ажлын чиг үүрэг	Гамшгаас хамгаалах сайн дурын үйл ажиллагааг дүүргийн хэмжээнд зохион байгуулах,гамшгаас урьдчилан сэргийлэх хөтөлбөр хэрэгжүүлэх
		Ажилласан хугацаа	4 сар
		Сургалт явуулсан байдал	Гамшиг, осол гал түймрийн аюулаас урьдчилан сэргийлэх,
		Багаж хэрэгсэл (Нэг хэсэгт)	Анхны Тусламжийн иж бүрдэл - 1 ком, Шүгэл 2, Гар чийдэн 2, Чанга яригч 2.
3.	Хан-Уул	Хорооны тоо, СДХГ-ийн тоо, дундаж тоо	1, 6
		Ажлын чиг үүрэг	Гамшгаас урьдчилан сэргийлэх, эрсдэлийг бууруулах, эрэн хайх, аврах,хор уршгийг арилгах, гамшгийн дараах хүмүүнлэгийн тусламж, сэргээн босгох ажиллагаа
		Ажилласан хугацаа	-
		Сургалт явуулсан байдал	Гамшгийн тухай ойлголт, гамшгаас хамгаалах сайн дурын ажиллагааны нийтлэг журам. 2 цаг
		Багаж хэрэгсэл (Нэг хэсэгт)	Помп 1, Цахилгаан үүсгүүр1, Троссон шүүр 10, гөвүүр 10

4.	Сонгинохайрхан	Хорооны тоо, СДХГ-ийн тоо, дундаж тоо	1, 10
		Ажлын чиг үүрэг	-
		Ажилласан хугацаа	-
		Сургалт явуулсан байдал	-
		Багаж хэрэгсэл (Нэг хэсэгт)	Тээврийн хэрэгсэл-2, Бусад гар багаж, тросон шүүр, цохиур, 1-12 ком Бүгд-132ш
5.	Сүхбаатар	Хорооны тоо, СДХГ-ийн тоо, дундаж тоо	20, 200, 20
		Ажлын чиг үүрэг	Аврах гал унтраах бүлэг, Анхны тусламж үзүүлэх бүлэг, Хэв журам сахиулах бүлэг, Эрэн хайх, аврах бүлэг, Нүүлгэн шилжүүлэх бүлэг
		Ажилласан хугацаа	1 жил
		Сургалт явуулсан байдал	Гамшгийн эрсдэлийн судалгаа, гал түймэр, газар хөдлөлтийн аюулаас урьдчилан сэргийлэх, анхны тусламж үзүүлэх сайн дурын үйл ажиллагааны талаар
		Багаж хэрэгсэл (Нэг хэсэгт)	Анхны тусламжийн иж бүрдэл, Автомашин 1, Гар чийдэн 5, Хүрз 5, Жоотуу 5, Гал унтраагуур 2, Эмийн сан хон бүрд, Чанга яригч 5, Элсний хувин 10
Нийт тоо: Хамрагдсан дүүрэг ба гишүүд			25, 241

Хүснэгт 16., Улаанбаатар хотын дүүргүүдийн сайн дурын хэсгийн судалгаа

Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.4, Гамшгаас хамгаалах тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.1.10, 25.2, Монгол Улсын Шадар сайдын 2016 оны 34 дүгээр тушаалаар батлагдсан “Гамшгаас хамгаалах сайн дурын ажиллагааны нийтлэг журам”-ын 5.1 дэх хэсэгт заасныг тус тус үндэслэн ОБЕГ-ын Даргын 2016 оны 6 дугаар сарын 24-ний А/185 тоот тушаалын хавсралтаар батлагдсан “Гамшгаас хамгаалах сайн дурын ажиллагааны заавар”-ын дагуу төв, орон нутгийн хэмжээнд үйл ажиллагаа явуулах гамшгаас хамгаалах сайн дурын хэсэг (2020 оны 7-р сарын 20-ний байдлаар) **21 аймгийн 263 суманд 263 хэсгийн 4841 сайн дурын ажилтан, Нийслэлийн Багахангай, Баянгол, Хан-Уул, Сүхбаатар зэрэг 4 дүүргийн 25 хорооны нутаг дэвсгэрт 25**

хэсгийн 241 сайн дурын ажилтан бүгд 288 хэсгийн 5082 сайн дурын ажилтан тухайн орон нутгийн Засаг даргын шийдвэрээр байгуулагдаж 1 сараас 2,5 жилийн хугацаанд үйл ажиллагаа явуулж байна.

Дээрх хүснэгтийн харьцуулсан үзүүлэлтүүдээс дараах дүгнэлтүүд хийх боломжтой байна. Үүнд:

1 Тухайн орон нутагт байгуулагдсан сайн дурын хэсгүүдийн ихэнх нь өөрийн орон нутаг тохиолддог аюулт үзэгдлийн онцлогт тохирсон үйл ажиллагааны чиглэлийг тодорхойлсны зэрэгцээ зарим нь гамшгаас хамгаалах тухай, галын аюулгүй байдлын тухай, ойн тухай хууль, мэргэжлийн ангийн дүрэм болон гамшгаас хамгаалах сайн дурын хэсгийн журамд заасан чиг үүргийг мөрдлөг болгосон байна. Тиймээс гамшгаас хамгаалах, гамшиг, гал түймрийн аюулаас урьдчилан сэргийлэх сургалт сурталчилгаа явуулах, гал түймэр унтраах, эрэн хайх, аврах, хойшлуулшгүй сэргээн босгох ажилд оролцох, анхны тусламж үзүүлэх зэрэг чиг үүрэгтэй байна.

2 Хамгийн цөөн хэсэг, гишүүдийн тоотой аймагт Баянхонгор аймаг орж байна. Тухайн аймаг Шинэжинст, Баянлиг гэсэн 2 суманд тус бүр 14-15 хүнтэй 2 хэсэг байгуулсан бол, хамгийн олон хэсэг, гишүүдтэй аймаг нь Хэнтий аймаг 18 сум, 5 тосгонд нийт 23 хэсгийн 1542 гишүүдтэй байгаа бөгөөд хэсгүүдийг дунджаар 8-440 хүний бүрэлдэхүүнтэй байгуулжээ.

3 Сайн дурын хэсгийн гишүүдийн сургагдсан байдлын хувьд өөрсдийн тодорхойлсон чиг үүрэгтэйгээ нийцүүлэн Гамшгийн тухай хууль, Галын аюулгүй байдлын тухай, Ойн тухай зэрэг хуулиуд, байгалийн гамшиг, аюулт үзэгдэл, ослоос урьдчилан сэргийлэх, гал түймэр унтраах, эрэн хайх, аврах, хойшлуулшгүй сэргээн босгох , анхны тусламж үзүүлэх, “Бэлэн бай” зэрэг сургалт дадлага явуулсны зэрэгцээ гамшгаас хамгаалах сайн дурын ажиллах журам, сайн дурынхны үүрэг оролцоо зэрэг 10 гаруй сэдвээр жилд 2 удаа 2-16 цагийн сургалт хийсэн байна. Гэхдээ байгуулагдаад хоёр жил болж байгаа ч сургалт огт хийгээгүй байдал Баян-Өлгий болон Баянхонгор аймгуудад ажиглагдаж байна. Нийслэл Улаанбаатар хотын хувьд Багахангай дүүрэг Хүн, малын гоц халдварт өвчин, цасан болон шороон шуурга, техникийн холбогдолтой осол объектын болон ой хээрийн түймэр зэрэг өөрийн онцлогт нийцсэн үйл ажиллагааны чиглэлийг тодорхойлсон боловч энэ үүргийнхээ дагуу сургалт зохион байгуулаагүй байна.

4 Багаж хэрэгсэл, хувийн хамгаалах хэрэгслийн тухайд гамшгаас хамгаалах сайн дурын хэсгийн тусгай тоноглол, хүн нэг бүрийн хэрэгслийн хангамжийн жишиг нормын дагуу байж болох хамгийн бага хангамжийн нормын хэмжээнд 12 төрлийн 45ш багаж хэрэгслэл байхаас ихэнх аймаг хангалтгүй дүнтэй гарч, харин Өмнөговь аймгийн 15 сумын 273 гишүүнтэй 15 хэсэгт 11 төрлийн 47ш багаж хэрэгсэл байгаа нь бусад орон нутагтай харьцуулахад өндөр байна. Хүн нэг бүрийн хамгаалалтын хувцас, гутал, уутан хөнжил, эвхдэг гудас хоолны сав зэрэг хангалтыг цогцоор нь хангасан хэсэг байхгүй байгаа нь судалгаанаас харагдаж байна.

Аймгийн нэр	Сумын тоо		Гишүүдийн тоо		Сургалтын цаг		Сургалтад хамрагдсан хүний тоо	
	2020	2022	2020	2022	2020	2022	2020	2022
Архангай	11	19	161	279	30	70	161	264
Баян-Өлгий	14	14	159	147	-	42	-	258
Баянхонгор	2	10	29	124	12	45	29	137
Булган	16	17	492	869	68	69	492	901
Говь-Алтай	18	18	124	124	66	-	67	-
Говьсүмбэр	3	3	44	68	16	20	29	172
Дархан-Уул	4	4	75	60	64	24	75	60
Дорноговь	10	14	124	120	56	64	124	120
Дорнод	15	14	241	502	-	56	-	498
Дундговь	15	15	161	90	60	32	161	48
Завхан	15	24	84	176	98	120	84	176
Орхон	2	2	30	30	4	2	30	18
Өвөрхангай	18	19	248	328	167	40	208	1250
Өмнөговь	15	15	273	259	150	72	273	418
Сүхбаатар	13	13	141	141	82	84	141	141
Сэлэнгэ	15	15	225	225	45	60	225	225
Төв	6	6	52	36	30	32	52	104
Увс	19	19	266	266	132	42	266	266
Ховд	15	16	198	229	59	48	198	731
Хэнтий	23	22	1542	902	69	114	1542	799
Хөвсгөл	14	20	172	172	-	87	-	669
Дүн	263	299	4841	5147	1208	1123	4157	7255

Хүснэгт 17., Төв орон нутгийн хэмжээнд үйл ажиллагаа явуулж байгаа гамшгаас хамгаалах сайн дурын хэсгийн 2020, 2020 оны үзүүлэлтийн харьцуулалт

Гамшгаас хамгаалах сайн дурын хэсгийн 2020 оны тоон үзүүлэлтийг 2022 оныхтой харьцуулсан дүнгээс харахад Архангай аймаг 2022 онд

шинээр 8 суманд сумын засаг даргын захирамжаар 8 хэсгийг 118 гишүүнтэй байгуулсан, Баянхонгор аймаг сайн дурын хэсгийн тоог 8-аар, гишүүдийн тоог 95 хүнээр нэмэгдүүлсэн, Завхан аймаг хэсгийн тоог 9-өөр гишүүдийн тоог 92 хүнээр нэмэгдүүлсэн нь орон нутагт сайн дурынхны хэсэг байгуулах, үйл ажиллагааг нь дэмжих асуудлыг төлөвлөлт, зохион байгуулалт, төсвийн хүрээнд шат дараалалтай хийж байгаа сайн тал харагдаж байна.

Сайн дурын хэсгийн гишүүдэд зориулсан мэргэжлийн сургалтыг гамшгаас хамгаалах арга хэмжээнд оролцох бэлэн байдлыг хангах, гамшгаас урьдчилан сэргийлэх, эрэн хайх, аврах, хор уршгийг арилгах, сэргээн босгох арга хэмжээнд оролцох, Гамшгаас хамгаалах тухай хууль, галын аюулгүй байдлын тухай сэдвээр 2020 онд 21 аймгийн 263 хэсгийн 4841 хүнд 1208 цагийн сургалт хийсэн бол 2022 онд 299 хэсгийн 5147 хүнд 1123 цагийн сургалт хийж, сургалтын цагийн 85 цагаар нэмэгдүүлж, сургалтад хамруулсан хүний тоог 2020 оныг 2022 онтой харьцуулахад Өвөрхангай аймаг 1042 хүн, Ховд аймаг 533 хүн, Булган аймаг 405 хүнээр тус тус нэмэгдүүлсэн бол Дундговь аймаг 113 хүнээр буурсан дүнтэй байна.

Дүүргийн нэр	Хорооны тоо		Гишүүдийн тоо		Сургалтын цаг		Сургалтад хамрагдсан хүний тоо	
	2020	2022	2020	2022	2020	2022	2020	2022
Багануур	-	2	-	35	-	14	-	35
Багахангай	2	1	20	30	5	5	20	30
Баянгол	1	5	5	50	4	4	5	50
Баянзүрх	-	8	-	80	-	16	-	80
Налайх	-	1	-	17	-	-	-	17
Сонгинохайрхан	1	20	10	200	-	4	10	200
Хан-Уул	1	5	6	50	2	2	6	50
Чингэлтэй	-	6	-	60	-	8	-	60
Сүхбаатар	20	20	200	200	102	30	200	200
Дүн	25	68	241	722	113	84	241	722

Хүснэгт 18., Улаанбаатар хотын дүүргийн сайн дурын хэсгийн тоон үзүүлэлтийн харьцуулалт (2020, 2022 он)

2020 онд нийслэлд 5 дүүрэгт 25 хэсэг 241 гишүүнтэй байсан бол 2022 онд 9 дүүрэгт 68 хэсэгт 722 гишүүнтэй болж нэмэгдэж, хэсгийн тоо 43, гишүүдийн тоо 481 хүнээр нэмэгдэж, гишүүдэд зориулсан мэргэжлийн

сургалтыг 2-16 цагийн хугацаатай хийсэн нь дүүрэг бүрд харилцан адилгүй байгаа нь харагдаж байна.

Хүснэгт 18-д төв, орон нутагт байгуулагдсан сайн дурын хэсгийн зохион байгуулалт, сургалт, хангалтын өнөөгийн байдлыг авч үзэж дараах дүгнэлтийг хийж байна. Үүнд:

Хүн амын тоо, нягтаршил, гамшиг, аюулт үзэгдэл, ослын тоо хэмжээ, давтамжаас хамаарч сайн дурын хэсгийн гишүүдийн тоог зааж өгч, мэргэшүүлэх сургалтын хөтөлбөрийг боловсронгуй болгох, ялангуяа 1,4 сая орчим хүн амтай Улаанбаатар хотын дүүргүүдийн сайн дурын хэсгийн тоо, гишүүдийн тоог тухайн орон нутгийн гамшиг, ослын тоо, давтамжтай уялдуулж нэмэгдүүлэх, үйлдвэр аж ахуйн газар, их дээд сургуулиудад зохион байгуулалттай сайн дурын хэсгийн тоог нэмэгдүүлэхийг бодлогоор дэмжих хэрэгцээ, шаардлага байна гэж үзэж байна.

2.2.3. Гамшгаас хамгаалахад сайн дурын үйл ажиллагааны талаар авсан санал, асуулга, боловсруулалтын үр дүн

Гамшгаас хамгаалахад сайн дурын үйл ажиллагааны талаарх санал асуулгад МУЗН-ийн харьяа аймаг, дүүргийн УЗХ-ны гамшгаас урьдчилан сэргийлэх, нэрвэгдэгсдэд тусламж үзүүлэх чиглэлээр сургаж бэлтгэгдсэн, үйл ажиллагаанд оролцогч 150 сайн дурын идэвхтнүүдийг хамруулан сайн дурын идэвхтний оролцоо, ажлын гүйцэтгэлд нөлөөлөх хүчин зүйлийн судалгааг *нэгд*, сайн дурын идэвхтний мэдлэг, *хоёрт*, сайн дурын идэвхтний ур чадвар, *гуравт*, сайн дурын идэвхтний туршлага, *гэсэн 3 хүчин зүйлийг таамаглал болгон дэвшүүлж*, чиглэл тус бүрд нь нөлөөлөх хүчин зүйлсийг илэрхийлсэн 8-11 асуулгаар асуулга явуулсан болно. (асуулгын агуулга, түүнийг бөглөх зааварчилгааг хавсралтаар үзүүлсэн). Монголын Улаан Загалмай Нийгэмлэгийн сайн дурын идэвхтнүүдээс авсан чанарын судалгааны асуулгын үр дүнг SPSS-25.0 болон SMART-3.0 программаар тус тус боловсруулсан.

Ашигласан программ хангамжийн талаар зарим тайлбар хийхэд: Smart PLS бол хэсэгчилсэн хамгийн бага квадрат (PLS) замыг загварчлах аргыг ашиглан хэлбэлзэлд суурилсан бүтцийн тэгшитгэлийн загварчлалыг (SEM) график хэрэглэгчийг холбох программ хангамж юм. PLS-SEM алгоритм ашиглан далд хувьсагч бүхий замын загварыг тооцоолохоос гадна программ хангамж нь стандарт үр дүнгийн үнэлгээний шалгуурыг (жишээлбэл, хэмжих загвар, бүтцийн загвар, тохирох чанар) тооцдог. Энэ

нь нэмэлт статистик шинжилгээг (жишээлбэл, баталгаат дүн шинжилгээ, ач холбогдол- гүйцэтгэлийн шинжилгээ, сигментчилэл, олон бүлэг) гаргадаг. PLS замын загвар нь бидний судалгааны үр дүн, чанарыг үнэлдэг ба үнэлгээнд ашигладаг үндсэн шалгуурууд, тэдгээрийн системчилсэн хэрэглээг нэгтгэн дүгнэх боломжтой. Дотоод тогтвортой байдлыг найдвартай байдлаар тодорхойлон гаргана. Дотоод тогтвортой байдлын уламжлалт шалгуур бол Cronbach's alpha бөгөөд ажиглагдсан индикаторын хувьсагчдын харилцан хамаарал дээр үндэслэн найдвартай байдлын үнэлгээг өгдөг. Хүчин зүйлийн конвергентын хүчин төгөлдөр байдлыг үнэлэхийн тулд судлаачид индикаторын гаднах ачаалал ба дундаж хэлбэлзлийг авч үздэг. Гаднах ачаалал өндөр байх нь холбогдох үзүүлэлтүүд нь нийтлэг шинж чанартай байхыг харуулж байна. Гаднах ачааллын хэмжээг индикаторын найдвартай байдал гэж нэрлэдэг. Бүх үзүүлэлтийн гаднах ачаалал хамгийн багадаа 0.708 ба түүнээс дээш байхаар стандартчилагдсан. Харин далд хувьсагч нь индикатор бүрийн хэлбэлзлийн ихээхэн хэсгийг, ихэвчлэн дор хаяж 50% байхаар тайлбарлах ёстой. Энэ нь индикаторын гаднах ачаалал 0.708-с дээш байх ёстой гэсэн үг бөгөөд квадрат (0.708²) нь 0.50- тай тэнцүү байна. Ихэнх тохиолдолд 0.70-ыг 0.708-тэй ойрхон гэж үздэг.

Судлаачид нийгмийн шинжлэх ухааны судалгаанд гаднын сул ачааллыг (<0.70) байхаар (ялангуяа шинээр боловсруулсан хэмжээсийг ашиглаж байх үед) тооцно. Энэ нь 0.70-0.90 байвал хангалттай, 0.60-0.70 байвал тохиромжтой, 0.60-аас доош байвал дутагдалтай тал ажигдлаа гэж үздэг.

Дундаж хэлбэлзэл нь үзүүлэлтийн ижил логикийг ашигласнаар <0.50 байвал алдаанд илүү их хэлбэлзэл байхаар, 0.50 ба түүнээс дээш байвал дунджаар хүчин зүйлийн үзүүлэлтийн хэлбэлзэл хэвийн байхаар тус тус тооцно. Өөрөөр хэлбэл, 0.50-аас бага байвал хүчин зүйлийн үзүүлэлт сул байгааг илэрхийлнэ. Далд хувьсагчийн хамаарлын шинжилгээ нь индикаторын гаднах ачаалал 1.00 дээр тогтсоныг заах ба энэ нь “хэзээ 1-тэй ойролцоо хамааралтай вэ?” гэдгийг харуулна.

МУЗН-ийн Сайн дурын идэвхтнүүдээс авсан судалгааны үр дүнгийн боловсруулалт. Хэмжил зүйн үр дүнг зураг 5-д болон хүснэгт 19-д тус тус үзүүллээ.




Зураг 5., Сайн дурын идэвхтний оролцоо, ажлын гүйцэтгэлд нөлөөлөх хүчин зүйл

Таамаглал-1: Сайн дурын идэвхтний мэдлэг сайн дурын идэвхтний оролцоо, ажлын гүйцэтгэлд эергээр нөлөөлнө.

Таамаглал-2: Сайн дурын идэвхтний ур чадвар сайн дурын идэвхтний оролцоо, ажлын гүйцэтгэлд эергээр нөлөөлнө.

Таамаглал-3: Сайн дурын идэвхтний ажлын туршлага сайн дурын идэвхтний оролцоо, ажлын гүйцэтгэлд эергээр нөлөөлнө.

Судалгааны ажлын сайн дурын ажилтны оролцоо, ажлын гүйцэтгэлд нөлөөлөх хүчин зүйлийн шинжилгээ:



Тайлбар: know-сайн дурын идэвхтний мэдлэг, skills-сайн дурын идэвхтний ур чадвар, exper-сайн дурын идэвхтний ажлын туршлага Enga-сайн дурын идэвхтний оролцоо, ажлын гүйцэтгэл

Зураг 6., Сайн дурын идэвхтний оролцоо, ажлын гүйцэтгэлд нөлөөлөх хүчин зүйлийн хамаарлын шинжилгээ

Хэмжил зүйн шинжилгээний үр дүн нь энэхүү судалгааны ажлын хамгийн чухал бөгөөд судалгааны үр дүнг боловсруулах, харьцуулах, шинжлэх, бататгах, дүгнэх хэсэг юм. Уг шинжилгээгээр далд хувьсагч бүр ажлын гүйцэтгэлд хэрхэн нөлөөлж байгааг харуулж, хүчин зүйлс тус бүрийн үр дүнг гаргасан болно. Кронпа альфа буюу тогтвортой байдал нь далд хувьсагчдын багц үзүүлэлт хоорондоо хэрхэн уялдаатай байгааг илэрхийлнэ.

Загварын хувьсагчид	Далд хувьсагч	Хүчин зүйлийн үр дүн	Кронпа	Найдвартай байдал	Дундаж
Сайн дурын идэвхтний мэдлэг	Гамшгийн өмнөх үеийн сургалтад хамрагдсан байдал know-1	0.832	0.930	0.942	0.672
	Гамшгийн үед авах арга хэмжээний сургалтад хамрагдсан байдал know-2	0.824			
	Гамшгийн дараах үеийн сургалтад оролцсон байдал know-3	0.774			
	Мэдлэгээ байнга дээшлүүлэх байдал know-4	0.838			
	Олон Улсын туршлагаас суралцах байдал know-5	0.803			
	Мэдлэгээ хуваалцдаг байдал know-6	0.844			
	Сургалт зохион байгуулсан байдал know-7	0.745			
	Гамшгийн үеийн ёс зүйн хэм хэмжээг мөрдөж ажилладаг эсэх know-8	0.888			
Сайн дурын идэвхтний ур чадвар	Бие биеэсээ байнга суралцаж, ур чадвараа ахиулдаг байдал skils-1	0.778	0.931	0.942	0.618
	Үндсэн мэргэжлээс дутуугүй гамшгийн үед туслах ур чадвартай эсэх skils-2	0.831			

	Хувийн манлайлал skils-3	0.817			
	Гадаад хэлний ур чадвар skils-4	0.660			
	Эрүүл мэнд болон анхны тусламж үйлчилгээ үзүүлэх ур чадвар skils-5	0.824			
	Сайн дурынхны ур чадварыг хөгжүүлэх сургалт шаардлагатай эсэх skils -6	0.768			
	Хөрвөж ажиллах чадвар (халамж үйлчилгээ) skils -7	0.760			
	Сэтгэл зүйн тусламж үзүүлэх ур чадвар skils-8	0.802			
	Анхны Тусламжийн Нөхөрлөлийн гишүүн эсэх skils-9	0.793			
	Анхны Тусламжийн нөхөрлөлийн уралдаанд оролцсон байдал skils-10	0.813			
Сайн дурын идэвхтний ажлын туршлага	Туршлагаа бусдад түгээн дэлгэрүүлдэг байдал expeг -1	0.766	0.927	0.939	0.584
	Давтан сургалтаар туршлагаа ахиулсан байдал expeг-2	0.838			
	Үйл ажиллагаанаас суралцаж туршлага хуримтлуулсан байдал expeг -3	0.809			
	Олон Улсын туршлагаас суралцаж туршлага хуримтлуулсан байдал expeг -4	0.779			
	Бусадтай туршлага хуваалцах, солилцох байдал expeг-5	0.834			
	Гамшгийн ажлаас хамаарч бусадтай харилцах байдал expeг -6	0.807			
	Багаар ажиллах явцад бие биеийнхээ саналыг хүлээн зөвшөөрдөг байдал expeг -7	0.786			
	Мэдээллийн түргэн шуурхай байдал expeг-8	0.663			
	Харилцаа хандлага төлөвшүүлэх сургалтад хамрагдсан байдал expeг -9	0.771			
	Цахим орчин ашиглах байдал Know-10	0.629			

	Цахим орчинд өөрийн үзэл бодлоо илэрхийлэх байдал exper-11	0.693			
Сайн дурын идэвхтний оролцоо, ажлын гүйцэтгэл	Сургалтад оролцох саналаа илэрхийлэх байдал enga-1	0.633	0.922	0.934	0.566
	Салбар дундын хамтын ажиллагаанд оролцдог байдал enga-2	0.751			
	Тулгамдсан асуудлыг шийдвэрлүүлэхэд саналаа илэрхийлэх байдал enga -3	0.758			
	Шаардлагатай үед өөр ажлын хэсэгт шилжиж ажиллах байдал enga -4	0.747			
	Шийдвэр гаргалтад оролцдог байдал enga -5	0.799			
	Хурал зөвлөгөөнд оролцож саналаа илэрхийлэх байдал enga -6	0.780			
	Багийн ажлыг хүлээн зөвшөөрдөг байдал enga -7	0.700			
	Ажлын гүйцэтгэлийг үнэлдэг байдал enga -8	0.598			
	Ажлын гүйцэтгэлээс авах сэтгэл ханамж enga -9	0.828			
	Ажлын гүйцэтгэлд таны үүрэг, оролцоо enga -10	0.829			

Тайлбар: know-сайн дурын идэвхтний мэдлэг, skills-сайн дурын идэвхтний ур чадвар, exper-сайн дурын идэвхтний ажлын туршлага Enga-сайн дурын идэвхтний оролцоо, ажлын гүйцэтгэл

Хүснэгт 19., Сайн дурын идэвхтний оролцоо, ажлын гүйцэтгэлд нөлөөлөх хүчин зүйлийн хэмжил зүйн шинжилгээний үр дүн

Дээрх хэмжил зүйн үзүүлэлтүүд дээр үндэслэн Монголын Улаан Загалмай Нийгэмлэгийн сайн дурын идэвхтнүүдээс авсан чанарын судалгааны боловсруулалтыг хийж, сайн дурын идэвхтний оролцоо, ажлын гүйцэтгэлд нөлөөлөх хүчин зүйлийн хэмжил зүйн шинжилгээний үр дүнг дараах байдлаар нэгтгэн дүгнэж байна. Үүнд:

Нэг: Сайн дурын идэвхтний мэдлэг хувьсагчийн нийт 8 далд хувьсагчийн үр дүн 0.745-0.888 хооронд хэлбэлзэж байна:

- Хамгийн их утга (хангалттай) бүхий үр дүнгээс харахад сайн дурын идэвхтнүүд гамшгийн үеийн ёс зүйн хэм хэмжээг мөрдөж ажилладаг эсэх 0.888, бусдад мэдлэгээ түгээдэг байдал 0.844, мэдлэгээ байнга ахиулах байдал 0.838 тус тус байна. Эндээс сайн дурын идэвхтний гамшгийн үед үйл ажиллагаандаа мөрдөх ёс зүйн хэм хэмжээ, мэдлэгээ бусдад түгээдэг байдал, өөрийн олж авсан мэдлэгээ байнга дээшлүүлж байдаг үзүүлэлт сайн байгааг харуулж байна.

- Хамгийн бага утга (хангалтгүй) бүхий үр дүн нь өөрөө сургалт зохион байгуулсан байдал 0.745, гамшгийн дараах үеийн сургалтад оролцсон байдал 0.774, олон улсын туршлагаас суралцсан байдал 0.803 тус тус байгаа нь сургалт зохион байгуулах, гамшгийн дараах нөхөн сэргээх шатны мэдлэг, олон улсын туршлагаас суралцах байдалд бага үнэлгээг нийтлэг өгч байгаа нь эдгээр далд хувьсагчид оролцогчдын хувьд мэдээлэл багатай, хүлээлт бага байгааг илэрхийлж байна гэж дүгнэх боломжтой.

- Сайн дурын идэвхтний мэдлэгийн хүчин зүйлийн хувьд, далд хувьсагчид хэрхэн хоорондоо уялдан багц болж байгааг Кронпа- альфа утгаар шалгасан. Ийнхүү сайн дурынхны мэдлэгийг илэрхийлэхүйц нийт 8 далд хувьсагчийн хоорондын уялдаа Кронпа-альфа утга 0.930 гарсан нь далд хувьсагчид хоорондоо маш сайн уялдаж байгаа үр дүн гарсан.

- Сайн дурын идэвхтний мэдлэгийн далд хувьсагчдын нийлмэл найдвартай байдлын утга 0.942 байгаа нь хувьсагчид хоорондын нийлмэл утга санаа агуулсан, найдвартай байдлыг илтгэх үр дүн маш сайн байна. Дундаж хэлбэлзлийн утга нь 0.672 байгаа нь сайн дурын идэвхтний мэдлэг сайн байгааг харуулж байна.

Хоёр: Сайн дурын идэвхтний ур чадварын хүчин зүйлийн үр дүн 0.660-0.831 хооронд хэлбэлзэж байна:

- Хамгийн их утга бүхий үр дүнгээс харахад гамшгаас хамгаалах үйл ажиллагаанд оролцож буй сайн дурын идэвхтний үүрэг хариуцлага хүлээх ур чадвар 0.831, сайн дурын идэвхтнүүдийн бусдад нөлөөлөх манлайлал 0.817, анхны тусламжийн нөхөрлөлийн уралдаан тэмцээнд оролцож дадлагажсан ур чадвар 0.813 байгаа нь гамшгаас хамгаалах үйл ажиллагаанд оролцож байгаа сайн дурын идэвхтнүүдийн ажлын ур чадвар, хувийн зохион байгуулалт, хариуцлагатай байдал, бусдад нөлөөлөх манлайлах байдалд судалгаанд оролцогчид сайн үнэлгээ өгсөн нь эдгээр далд хувьсагчдад өгүүлж буй үзүүлэлтүүд сайн байна гэж дүгнэх боломжийг бүрдүүлээ.

- Хамгийн бага үр дүнг үзүүлж буй далд хувьсагчийн хувьд, сайн дурын идэвхтнүүдэд шаардлагатай үед гадаад хэлний ур чадварын түвшин 0.660 гарсан нь хангалтгүй дүнг үзүүлж байна. Хөрвөж ажиллах чадвар тухайлбал, халамж үйлчилгээ, сэтгэл зүйн тусламж үйлчилгээ үзүүлэх ур чадварын түвшин 0.760 байгаа нь сайн дурын идэвхтнүүд гадаад хэлний мэдлэг, багт хөрвөж ажиллах ур чадвараа дээшлүүлэх шаардлагатай байгааг харуулсан үр дүн гэж дүгнэж байна. Хойно үзүүлсэн хамаарлын шинжилгээний дүнгээс харахад сайн дурын идэвхтний мэдлэг, сайн дурын идэвхтний ур чадвар хоорондоо 0.836 үр дүнтэйгээр хамгийн их хамааралтай байгааг илтгэж байна.

- Сайн дурын идэвхтний ур чадварын 10 далд хувьсагчийн хоорондын уялдаа Кронпа-альфа утга 0.931 гарсан нь далд хувьсагчид хоорондоо маш сайн уялдаж байгааг, нийлмэл найдвартай байдлын утга 0.942 байгаа нь хувьсагчдын хоорондын уялдаа маш сайн, дундаж хэлбэлзлийн утга 0.618 байгаа нь сайн дурын идэвхтний ур чадвар сайн байгааг илэрхийлж байна гэж дүгнэх боломжтой.

Гурав: Сайн дурын идэвхтний ажлын туршлагын хүчин зүйлийн үр дүн 0.629- 0.838 хооронд хэлбэлзэж байна:

- Хамгийн их утга бүхий үр дүнгээс харахад, сайн дурын идэвхтний сургалт, дадлагад хамрагдаж туршлага хуримтлуулсан байдал 0.838, туршлагаа бусадтай хуваалцах, мэдээлэл солилцох байдал 0.834, оролцож байсан үйл ажиллагаанаасаа туршлага хуримтлуулсан байдал 0.807 тус тус байгаа нь эдгээр далд хувьсагчид оролцогчдоос сайн үнэлгээг авч байгааг илтгэж байна.

- Хамгийн бага үр дүнг харахад мэдээлэл авахад цахим орчин ашигладаг байдал 0.629, шаардлагатай мэдээлэл түргэн шуурхай хүргэгддэг байдал 0.663 байгаа нь мэдээллийн талаар цахим орчинд өөрийн үзэл бодлоо илэрхийлэх байдал хангалтгүйг харуулж байна. Далд хувьсагчид хоорондоо маш сайн уялдаж байгааг илэрхийлэх байдал 0.693 байгаа нь эдгээр далд хувьсагчид хангалтгүй байгааг илэрхийлж байна.

- Сайн дурын идэвхтнүүдийн ажлын туршлагын 11 далд хувьсагчийн хоорондын уялдаа Кронпа- альфа утга 0.927 гарсан нь далд хувьсагчид хоорондоо маш сайн уялдаж байгааг, нийлмэл найдвартай байдлын утга 0.939 байгаа нь хувьсагчдын хоорондын уялдаа маш сайн, дундаж хэлбэлзлийн утга 0.584 байгаа нь сайн дурын идэвхтнүүдийн ажлын туршлага сайн байгааг илэрхийлж байна гэж дүгнэх боломжтой.

Дөрөв: Сайн дурын идэвхтний оролцоо, ажлын гүйцэтгэлийн хүчин зүйлийн үр дүн 0.598- 0.829 хооронд хэлбэлзэж байна:

- Хамгийн их утга бүхий үр дүнгээс харахад багийн ажлын гүйцэтгэлд оролцоо, хувь нэмэр нөлөөлөх байдал 0.829, ажлын гүйцэтгэлээс авах сэтгэл ханамж 0.828, шийдвэр гаргалтад оролцдог байдал 0.799 тус тус байгаа нь эдгээр далд хувьсагчид оролцогчдоос сайн үнэлгээг авч байгааг илтгэж байна.

- Хамгийн бага үр дүнг сайн дурын идэвхтний урамшуулал 0.598, өөрийн үзэл бодол, санал хүсэлтээ анхан болон дунд шатны хороонд илэрхийлэх байдал 0.633, салбар дундын хамтын ажиллагаанд оролцох байдал 0.751 байгаа нь эдгээр далд хувьсагчид хангалтгүй байгааг илэрхийлж байна.

- Сайн дурын идэвхтний оролцоо, ажлын гүйцэтгэлийн 10 далд хувьсагчийн хоорондын уялдаа Кронпа-альфа утга 0.922 гарсан нь далд хувьсагчид хоорондоо маш сайн уялдаж байгааг, нийлмэл найдвартай байдлын утга 0.934 байгаа нь хувьсагчдын хоорондын уялдаа маш сайн, дундаж хэлбэлзлийн утга 0.566 байгаа нь сайн дурын идэвхтний оролцоо, ажлын гүйцэтгэл сайн байна гэж дүгнэх боломжтой байгаа ч сургалтад оролцох саналаа анхан болон дунд шатны хороонд санал болгодог байдал 0.633 гарсан нь хангалтгүй, багийн ажлыг хүлээн зөвшөөрдөг байдал 0.700 гарсан нь хангалтгүй, ажлын гүйцэтгэлийг үнэлдэг байдал 0.598 гарсан нь мөн хангалтгүй үнэлгээ үзүүлсэн байна. Харин сайн дурын идэвхтний мэдлэг, сайн дурын идэвхтний оролцоо, ажлын гүйцэтгэл хоёрын харилцан хамаарал хамгийн бага 0.551 үзүүлэлттэй гарсан нь сайн дурын идэвхтний оролцоонд туршлага, ур чадвар хоёр илүү хэрэгцээтэй байгааг харуулж байна.

Судалгаанд ашигласан далд хувьсагчдын хувьд олон улсын эрдэмтдийн ижил төстэй хувьсагчийг агуулсан судалгааны ажлуудад харьцуулалт хийн судлахад ихэнх үр дүн хангалттай гарсан байсан. Харин эдгээр үзүүлэлт 0.7 гэсэн үр дүнд хүрэхгүй байгаа нь сайн дурын идэвхтний оролцоо, ажлын гүйцэтгэл хангалтгүй байна гэж дүгнэж байна. Иймээс эдгээр хувьсагчдын агуулгыг илэрхийлэх үзүүлэлт дээр цаашид анхааран ажиллах шаардлагатай нь харагдаж байна.


Үзүүлэлт	Сайн дурын идэвхтний туршлага	Сайн дурын идэвхтний мэдлэг	Сайн дурын идэвхтний оролцоо,	Сайн дурын идэвхтний ур чадвар
----------	-------------------------------	-----------------------------	-------------------------------	--------------------------------

			ажлын гүйцэтгэл	
Сайн дурын идэвхтний туршлага	0.764			
Сайн дурын идэвхтний мэдлэг	0.734	0.819		
Сайн дурын идэвхтний оролцоо, ажлын гүйцэтгэл	0.819	0.551	0.752	
Сайн дурын идэвхтний ур чадвар	0.832	0.836	0.713	0.786

Хүснэгт 20. Далд хувьсагчийн хамаарлын шинжилгээний үр дүн

Судалгааны ажлын хамаарлын үр дүнгээс харахад, Сайн дурын идэвхтний туршлага өөр хоорондоо 0.764, сайн дурын идэвхтний туршлага сайн дурын идэвхтний мэдлэгтэй 0.734, сайн дурын идэвхтний туршлага сайн дурын идэвхтний оролцоо, ажлын гүйцэтгэлтэй 0.819, сайн дурын идэвхтний туршлага сайн дурын идэвхтний ур чадвартай 0.83- тус тус хамааралтай байгаа нь 0.5-аас дээш хамаарч байгаа тул хамаарал сайтай байна гэж дүгнэж байна.

Сайн дурын идэвхтний мэдлэг өөр хоорондоо 0.819, сайн дурын идэвхтний мэдлэг оролцоо, ажлын гүйцэтгэлтэй 0.551, сайн дурын идэвхтний мэдлэг сайн дурын идэвхтний ур чадвартай 0.836 хамааралтай байгаа нь бүх үр дүн 0.5-аас дээш байгаа тул хамаарал сайтай байна гэж дүгнэж байна. Сайн дурын идэвхтний оролцоо, ажлын гүйцэтгэл өөр хоорондоо 0.752, сайн дурын идэвхтний оролцоо, ажлын гүйцэтгэл сайн дурын идэвхтний ур чадвартай 0.786 хамааралтай байгаа нь 0.5-аас дээш байгаа тул хамаарал сайтай байна гэж дүгнэж байна.



Тайлбар: know-сайн дурын идэвхтний мэдлэг, skills-сайн дурын идэвхтний ур чадвар, exper-сайн дурын идэвхтний ажлын туршлага Enga-сайн дурын идэвхтний оролцоо, ажлын гүйцэтгэл

Зураг 7., Замын шинжилгээний үр дүн /Bootstrapping/

ТААМАГЛАЛУУД	Эх утга	Дундаж утга	Стандарт хазайлт	T статистик	П үнэ цэнэ	ҮР ДҮН
Сайн дурын идэвхтний мэдлэг → Сайн дурын идэвхтний оролцоо, ажлын гүйцэтгэл	0.763	0.782	0.161	4.737	0.000	Батлагдсан
Сайн дурын идэвхтний ур чадвар → Сайн дурын идэвхтний оролцоо, ажлын гүйцэтгэл	-0.249	-0.234	0.123	2.028	0.043	Батлагдсан
Сайн дурын идэвхтний ажлын туршлага → Сайн дурын идэвхтний оролцоо, ажлын гүйцэтгэл	0.287	0.264	0.201	1.432	0.153	Батлагдсанг үй

Хүснэгт 21., Замын шинжилгээний үр дүн

Замын шинжилгээний боловсруулалтаас харахад, Сайн дурын идэвхтний мэдлэг нь сайн дурын идэвхтний оролцоо, ажлын гүйцэтгэлд нөлөөлнө гэсэн таамаглалын хувьд, эх утга 0.763, дундаж утгын үр дүн 0.782, стандарт хазайлт 0.161, Т статистик утга 4.737, П үнэ цэнэ 0.000 үр дүнтэй байж таамаглал батлагдлаа.

Сайн дурын идэвхтний ур чадвар нь сайн дурын идэвхтний оролцоо, ажлын гүйцэтгэлд нөлөөлнө гэсэн таамаглалын хувьд, эх утга -0.249, дундаж утгын үр дүн -0.234, стандарт хазайлт 0.123, Т статистик утга 2.028, П үнэ цэнэ 0.043 үр дүнтэй байж таамаглал батлагдлаа.

Сайн дурын идэвхтний ажлын туршлага нь сайн дурын идэвхтний оролцоо, ажлын гүйцэтгэлд нөлөөлнө гэсэн таамаглалын хувьд, эх утга 0.287, дундаж утгын үр дүн 0.264, стандарт хазайлт 0.201, Т статистик утга 1.432, П үнэ цэнэ 0.153 үр дүнтэй байж таамаглал батлагдсангүй.

Судалгааны ажлын замын шинжилгээний үр дүнгээс нэгтгэсэн дүгнэлт гаргахад, сайн дурын идэвхтний мэдлэг, ур чадвар нь нь сайн дурын идэвхтний оролцоо, ажлын гүйцэтгэлд эергээр нөлөөлж; сайн дурын идэвхтний ажлын туршлага нь сайн дурын идэвхтний оролцоо, ажлын гүйцэтгэлд сөрөг нөлөөллөө. Иймээс сайн дурын идэвхтний ажлын туршлагыг эерэг нөлөөлөлтэй болгож дээшлүүлэхийн тулд бага үнэлгээтэй үр дүн гарсан далд хувьсагчид анхаарал хандуулж, мэдээлэл түргэн шуурхай хүргэгдэх байдал, мэдээллийг цахим орчноос авах байдал, өөрийн үзэл бодлоо бусадтайгаа илэн далангүй илэрхийлж туршлага солилцох байдал зэрэгт анхаарах хэрэгтэй байна.

Санал асуулгын үр дүнгийн судалгааг нөхцөл байдлын үнэлгээний баримтын шинжилгээний үр дүн болон гамшгаас хамгаалах сайн дурын хэсгийн судалгааны үр дүнгүүдтэй харьцуулан дараах дүгнэлт хийж болох байна. Үүнд:

1 Судалгаанд хамрагдсан 150 сайн дурын идэвхтний 70% нь эмэгтэй, 30% нь эрэгтэй байв. Боловсролын хувьд бакалавр 94% байгаа нь боловсрол өндөр байгааг харуулж байна. Энэ нь боловсролын салбараар дамжуулан сайн дурын үйл ажиллагааг идэвхжүүлэх том боломж байгааг харуулж байна.

2 Сайн дурын идэвхтний оролцоо, ажлын гүйцэтгэлд нэгдүгээрт сайн дурын идэвхтний мэдлэг, хоёрдугаарт сайн дурын идэвхтний ур чадвар, гуравдугаарт сайн дурын идэвхтний ажлын туршлага бүгд эергээр

нөлөөлнө гэсэн дүгнэлт гарч байна. Энэ нь сайн дурын үйлс нь улс орнуудад хөгжих үйл явцдаа иргэдээ татан оролцуулах хүчирхэг арга хэрэгсэл болдог, түүнчлэн, сайн дурын үйлс нь хөгжлийг хурдасгаж, шинж чанарыг нь өөрчлөх чадвартай байдаг талаар нөхцөл байдлын үнэлгээнд өгсөн дүгнэлтийг улам бататгаж байна..

3 Сайн дурын идэвхтний мэдлэгийн хүчин зүйлээс гамшгийн өмнөх,гамшгийн үед, гамшгийн дараах үеийн сургалтад хамрагдсан байдал, өөрөө сургалт зохион байгуулсан байдал, олон улсын туршлагаас суралцаж мэдлэгээ ахиулдаг байдал зэрэг гол гол далд хувьсагчийн үр дүн 0.745-0.888 хооронд хэлбэлзэж, кронпа альфа утгын үр дүн 0.642 байгаа нь бүгд сайн үр дүнтэй гарсан нь эдгээр хүчин зүйлсэд өндөр ач холбогдол өгч байх ёстойг харуулж байна. Түүнчлэн сайн дурын үйлсийн нийтлэг, олон нийтийг хамарсан, чөлөөт сонголт, чин хүсэл эрмэлзэл, оролцоо, эв нэгдэл дээр үндэслэсэн зэрэг шинж чанаруудтай эдгээр хүчин зүйлс нягт уялдах болно..

4 Сайн дурын идэвхтний ур чадварын хүчин зүйлээс ур чадвараа ахиулдаг байдал,сайн дурынхны ур чадварыг хөгжүүлэх сургалт шаардлагатай эсэх, анхны тусламж үзүүлэх чадвар, хөрвөж ажиллах чадвар зэрэг далд хувьсагчийн үр дүн 0.660- 0.831 хооронд хэлбэлзэж, Кронпа альфа утгын үр дүн 0.931 бүх далд хувьсагч сайн үр дүнтэй гарсан.*Харин шаардлагатай үед гадаад хэлний ур чадвар 0.660 гарсан нь хангалтгүй дүн үзүүлж байна.* Хамаарлын шинжилгээний дүнгээс харахад сайн дурын идэвхтний мэдлэг, сайн дурын идэвхтний ур чадвар хоорондоо 0.836 үр дүнтэйгээр хамгийн их хамааралтай байгааг илтгэж байна. Цаашид гадаад хэлний мэдлэгийг дээшлүүлэх, олон улсын туршлагаас суралцах боломжийг нэмэгдүүлэх шаардлага байгааг анхаарах нь зүйтэй байна.

5 Сайн дурын идэвхтний ажлын туршлагын далд хувьсагчийн дундаж утгын үр дүн 0.584 байгаа нь далд хувьсагч бүгд сайн үр дүнтэй,хувьсагчийн дундаж утга 0.5 үнэлгээнээс өндөр гарч,ерөнхий дундаж үнэлгээ сайн байгааг илтгэсэн ч *шаардлагатай үед мэдээлэл шуурхай хүргэгддэг байдал 0.663 гарсан нь хангалтгүй байна. Мөн мэдээллийг авахад цахим орчин ашигладаг бадал 0.629 гарсан нь хангалтгүй,мэдээллийн талаар цахимд өөрийн үзэл бодлоо илэрхийлэх байдал 0.693 гарсан нь бас хангалтгүй үнэлгээ өгөхөөр үр дүн гарч байна.* Сургалт сурталчилгааны ажлын давтамжийг нэмэгдүүлэх, цахим орчинд ажиллах ур чадварыг нэмэгдүүлж интернэт ашиглах орчныг сайжруулж

бодлогоор дэмжих нь чухал болох нь дээрх үр дүн болон гамшгаас хамгаалах сайн дурын хэсгийн судалгаанаас харагдаж байна.

6 Сайн дурын идэвхтний оролцоо, ажлын гүйцэтгэлийн хүчин зүйлээс бүх далд хувьсагч сайн үр дүн илгэсэн ч *сургалтад оролцох саналаа анхан болон дунд шатны хороонд санал болгодог байдал 0.633 гарсан нь хангалтгүй, багийн ажлыг хүлээн зөвшөөрдөг байдал 0.700 гарсан нь хангалтгүй, ажлын гүйцэтгэлийг үнэлдэг байдал 0.598 гарсан нь мөн хангалтгүй үнэлгээ үзүүлсэн байна.* Сайн дурын идэвхтнүүдийг сургах, давтан сургах сургалтын хөтөлбөрийг шинэчлэх, нас насныханд зориулсан дадлага сургуулилт, уралдаан тэмцээний дүрэм, журам, шагналын санг нэмэгдүүлэх шаардлага байгааг нөхцөл байдлын судалгаа болон гамшгаас хамгаалах хэсгийн судалгаа давхар харуулж байна.

Хоёрдугаар бүлгийн дүгнэлт

Гамшгаас хамгаалахад сайн дурынхны үйл ажиллагааны оролцооны өнөөгийн байдлын шинжилгээг гамшгаас хамгаалахад сайн дурынхны үйл ажиллагааны эрх зүйн зохицуулалтын шинжилгээ болон үйл ажиллагааны шинжилгээ гэсэн хоёр чиглэлээр гүйцэтгэж, судалгааны үр дүнд тодорхой дүгнэлтүүд хийлээ. Үүнд:

Нэг. Гамшгаас хамгаалахад сайн дурынхны үйл ажиллагааны эрх зүйн зохицуулалтын шинжилгээний үр дүн.

Сайн дурын үйл ажиллагааны эрх зүйн зохицуулалтын шинжилгээг Монгол Улсын үндсэн хууль, түүнд нийцүүлэн гаргасан хууль болон хуулийн заалттай нийцүүлэн боловсруулагдсан бодлогын баримт бичиг, түүнийг хэрэгжүүлэхэд чиглэсэн бусад эрх зүйн акт гэсэн гурван чиглэлээр хийж дараах дүгнэлтэд хүрлээ. Үүнд:

Нэгд. Үндсэн хууль болон түүнтэй нийцүүлэн гаргасан бусад хуулийн заалтуудын хувьд.

1 Монгол Улсын 1992 оны Үндсэн хуулиас 2020 оныг дуустал хугацаанд батлагдсан, одоо хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа хуулиас гамшгаас хамгаалах үйл ажиллагаанд талуудын оролцоог хангахтай холбоотой зүйл, заалтыг тусгасан нийтээр дагаж мөрдөх 12 хуулийг сонгон авч судлахад талууд гэх орон нутгийн өөрөө удирдах болон захиргааны байгууллага, хуулийн этгээд, аж ахуйн нэгж байгууллага, иргэд, олон нийт, аж ахуйн нэгж, ТББ, сайн дурынхан гамшгаас хамгаалах үйл ажиллагаанд чухал оролцоотой болох нь харагдаж байна.

2 Бүх шатны засаг дарга сум баг, хороонд нутгийн иргэдэд түшиглэн гамшгаас хамгаалах сайн дурын хэсгийг байгуулж, иргэд аж ахуйн нэгж, төрийн бус байгууллагын оролцоог хангаж, нутаг дэвсгэрийн хэмжээнд гамшгаас хамгаалах арга хэмжээг төлөвлөх, санхүүжүүлэх, удирдах, хэрэгжүүлэх үүрэг гүйцэтгэхээр хуульчилсан байна.

Хоёрт. Бодлогын баримт бичгийн шинжилгээний хувьд :

Монгол Улсын үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал, Батлан хамгаалах бодлогын үндэс, Гамшгаас хамгаалах талаар төрөөс баримтлах бодлогын баримт бичиг, тэдгээрийн агуулгыг тусгасан бодлогыг шинжлэхэд:

1 Монгол Улсын үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалд эх оронч үндэсний үзлийг дээдлэх зарчмын хүрээнд иргэдийн оролцооны ач холбогдлыг тусгасан заалт 1, соёл иргэншлийн аюулгүй байдал, дотоод аюулгүй байдал, хүний аюулгүй байдал, хүрээлэн буй орчны аюулгүй байдал, мэдээллийн аюулгүй байдал, үндэсний аюулгүй байдлыг хангах тогтолцоонд иргэд, хувийн хэвшил, иргэний нийгмийн байгууллагын оролцоог хангаж, гамшиг, гэнэтийн аюул, халдлагатай тэмцэх үндэсний чадавхыг дээшлүүлж, иргэд, олон нийтийн оролцоог хангах 22 заалт тусгалаа олжээ.

2 Монгол Улсын Батлан хамгаалах бодлогын үндэс баримт бичигт төр ба хувийн хэвшлийн байгууллага, иргэн бүрийн оролцооны талаар 4 заалт тусгаж, гамшгийн үед аврах, хор уршгийг арилгах, сэргээн босгох, олон улсын хүмүүнлэгийн тусламжийн үйл ажиллагаанд талуудын оролцоог хангах нь иргэн бүрийн үүрэг гэж заасан.

3 Гамшгаас хамгаалахад иргэд, сайн дурын үйл ажиллагааны асуудлыг тусгасан бусад бодлогын баримт бичгийн шинжилгээг бүх салбарын дагаж мөрдөх, хөгжлийн бодлого, хөтөлбөр болон тухайн салбарын голлох үүрэг, оролцоотой бодлого гэсэн хоёр чиглэлээр гүйцэтгэлээ. Нийтээр дагаж мөрдөх бодлого хөтөлбөрт “Алсын хараа-2050”, “Ногоон хөгжлийн бодлого”, “Өрхийн хөгжлийг дэмжих” зэрэг хөтөлбөрүүдэд иргэд, олон нийтийн үүрэг оролцоо их байгаа боловч, эдгээр хөтөлбөрийн талаарх сурталчилгаа, олон нийтийн мэдлэг, ойлголт тааруу, хэрэгжилт нь удаан явцтай байна гэж үзэж байна.

Хоёр. Гамшгаас хамгаалахад сайн дурынхны үйл ажиллагааны оролцооны өнөөгийн байдлын шинжилгээ.

Гамшгаас хамгаалахад сайн дурынхны үйл ажиллагааны оролцооны өнөөгийн байдлын шинжилгээг *нэгд*, гамшгаас хамгаалахад сайн дурынхны үйл ажиллагааны оролцооны талаар өмнө хийгдсэн баримт бичгийн судалгаа, *хоёрт*, гамшгаас хамгаалахад сайн дурынхны хэсгийн судалгаа, *гуравт*, гамшгаас хамгаалахад сайн дурынхны үйл ажиллагааны оролцооны талаар авсан санал асуулгын судалгааны боловсруулалтын үр дүнгүүд дээр үндэслэн шинжиллээ.

Нэгд. Гамшгаас хамгаалахад сайн дурынхны үйл ажиллагааны оролцооны өмнө хийгдсэн баримт бичгийн судалгааны үр дүнгийн хувьд:

Монголын Сайн Дурын Байгууллагуудын Сүлжээ (NMVO), НҮБ-ын Сайн дурынхан (UNV) болон Хилийн чанад дахь Сайн Дурын Алба, Олон

Улсын Байгууллага (VSO) хамтарч “Монгол Улс дахь сайн дурын үйлсийн өнөөгийн нөхцөл байдлыг тодорхойлохын тулд 2012 оны 6 дугаар сард Сайн дурын үйл ажиллагааны нөхцөл байдлын судалгааг цахим шуудангаар болон бусад хэлбэрээр 79 байгууллага, 1000 оюутныг хамруулан зохион байгуулж, сайн дурын үйл ажиллагаатай холбоотой судалгаа, тайлан, хэрэгжиж байгаа төсөл, хөтөлбөрүүдийн талаарх танилцуулга, гарын авлага зэрэг мэдээлэлүүдийг судлахын зэрэгцээ, бусад орны баримталж байгаа бодлого, чиглэл, туршлагыг харьцуулан судалж, Монгол Улсын Ерөнхийлөгчийн Тамгын Газар, Монгол Улсын хөдөлмөрийн яам, НҮБ-ын Сайн дурынхан (UNV), Монголын сайн дурын байгууллагуудын сүлжээтэй хамтран нээлттэй хэлэлцүүлэг зохион байгуулж, гурван бүлгээс бүрдсэн нөхцөл байдлын үнэлгээний зөвлөмж гаргасан.

1. Сайн дурынхныг дэмжих орчин бүрдүүлэх талаар бусад орнуудын баримталж буй бодлого, чиглэлийн хувьд: сайн дурынхныг дэмжих орчин бүрдүүлэх гол хүчин зүйлс нь иргэний нийгэм, сайн дурынхантай ажилладаг байгууллагуудын чадавхыг бэхжүүлэх таатай орчин бүрдүүлэхэд шаардлагатай дэд бүтцийг цогцоор нь хөгжүүлэх чиглэлийг дараах байдлаар тодорхойлсон байна. Үүнд:

- Сайн дурын үйл ажиллагааны талаар нэгдмэл ойлголт болон үнэлэмжтэй болох,
- Улс орны нийгэм эдийн засгийн хөгжилтэй уялдсан сайн дурын үйлс, сайн дурынхныг дэмжсэн бодлоготой болох, эрх зүйн орчинг бүрдүүлэх,
- Сайн дурынхныг зохицуулах үндэсний бүтцийг бүрдүүлэх,
- Сайн дурынхны хөгжлийн төвүүдийг Улаанбаатар хот болон хөдөө орон нутгуудад байгуулах,
- Сайн дурын нэгдсэн цахим хуудастай болох,
- Сайн дурын үйлсийг сурталчлах.
- Эдгээр чиглэлүүд нь өнөөдөр ч хэрэгжилтээ олоогүй, чухал хэвээр байгаа нь судалгаанаас харагдаж байна.

2. Монгол Улсын гамшгаас хамгаалахад сайн дурын оролцооны өнөөгийн нөхцөл байдалд хийсэн дүн шинжилгээний үр дүнд:

- Монголын ард түмэн эрт дээрээс хөрш, саахалт айлдаа тусалж ирсэн сайхан ёс уламжлалтай. Улс орны уламжлал ёс заншилд суурилсан сайн үйлс нь улам бүр зохион байгуулагдан сайн дурын салбар болтлоо өргөжин хөгжсөнийг,

- Орчин үеийн хэлбэрээр зохион байгуулагдсан сайн дурын байгууллагууд нь нийгмийн тодорхой чиглэлээр зорилготой ажиллаж, үйл ажиллагааны хүрээгээ тэлсээр байгааг,
- Монголчуудын хувьд сайн дурын үйл ажиллагаанд оролцох сонирхол, хүсэл тэмүүлэл их байгааг онцолсон байна.

Ололтын зэрэгцээ судалгаанд хамрагдсан хүмүүсийн цөөнгүй хэсэг нь сайн дурын үйл ажиллагааны талаар ялангуяа энэ үйл ажиллагааны үр өгөөжийг төдийлөн ойлгоогүй байсан бөгөөд эндээс сайн дурын үйлс, түүний ач холбогдлыг олон нийтэд сурталчлах нь сайн дурын үйлсэд иргэдийн оролцоог нэмэгдүүлэх ихээхэн ач холбогдолтой нь харагдаж байжээ.

3. Иргэний танхимд зохион байгуулсан хэлэлцүүлэг, зөвлөмж гэсэн гуравдугаар бүлэгт нөхцөл байдлын үнэлгээний үр дүнд тулгуурлан "Монгол Улсад сайн дурын үйл ажиллагааны дэд бүтцийг, хөгжүүлэх "Зөвлөмж"-ийг Монгол Улсын Ерөнхийлөгч, Улсын Их Хурал болон Засгийн газарт хандан боловсруулж, үндэсний сайн дурынхныг дэмжих цогц бодлого боловсруулах асуудлыг гол чиглэлээ болгон, дараах хэсгүүдээс бүрдүүлэхийг санал болгожээ. Үүнд:

- Сайн дурын үйл ажиллагааг хөгжүүлэх төрийн бодлогоо тодорхойлох. Сайн дурын үйл ажиллагааг хөгжүүлэх үндэсний хөтөлбөр, стратеги, үйл ажиллагааны төлөвлөгөө болон хэрэгжилтийг хянах мониторингийн тогтолцоог бүрдүүлэх.
- Сайн дурын үйл ажиллагааны тогтвортой санхүүжилтыг улсын төсөвт тусгадаг болох.
- Үндэсний ба орон нутгийн түвшинд сайн дурын үйл ажиллагааг зохицуулах бүтцийг институцчилах.
- Холбогдох хууль тогтоомжинд сайн дурынхан, сайн дурын үйл ажиллагаа, сайн дурын хөдөлмөр эрхлэлт, сайн дурын байгууллага гэсэн нэршлийг оруулах, нэгдсэн ойлголтыг бий болгох.
- Сайн дурын үйл ажиллагааг аль болох олон салбарт дэмжих зорилготой үнэлгээний аргачлалыг боловсруулан хэрэглэх зэрэг асуудлууд багтсан байна.

Хоёр. Гамшгаас хамгаалахад сайн дурынхны хэсгийн үйл ажиллагааны судалгааны үр дүнгийн хувьд:

1 Гамшгаас хамгаалах сайн дурын хэсгийн үйл ажиллагааны эрх зүйн үндсийг Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8,4, Гамшгаас хамгаалах тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.1.10, 25.2, Монгол Улсын Шадар сайдын 2016 оны 34 дүгээр тушаалаар батлагдсан “Гамшгаас хамгаалах сайн дурын ажиллагааны нийтлэг журам”, ОБЕГ-ын Даргын 2016 оны 6 дугаар сарын 24-ний А/185 тоот тушаалаар батлагдсан “Гамшгаас хамгаалах сайн дурын ажиллагааны заавар” тус тус бүрдүүлж байна.

2 Төв, орон нутгийн хэмжээнд үйл ажиллагаа явуулах гамшгаас хамгаалах сайн дурын хэсэг (2020 оны 7-р сарын 20-ний байдлаар) 21 аймгийн 259 суманд 259 хэсгийн 4631 сайн дурын ажилтан, Нийслэлийн Багахангай, Баянгол, Хан-Уул, Сүхбаатар зэрэг 4 дүүргийн 25 хорооны нутаг дэвсгэрт 25 хэсгийн 419 сайн дурын ажилтан бүгд 284 хэсгийн 5050 сайн дурын ажилтан тухайн орон нутгийн Засаг даргын шийдвэрээр байгуулагдаж 1 сараас 2,5 жилийн хугацаанд үйл ажиллагаа явуулж байна.

3 Хамгийн цөөн хэсэг, гишүүдийн тоотой аймгийн тоонд Баянхонгор аймаг орж байна. Тухайн аймаг Шинэжинст, Баянлиг гэсэн 2 суманд тус бүр 14-15 хүнтэй хэсэг байгуулсан бол, хамгийн олон хэсэг, гишүүдтэй аймгийн тоонд Хэнтий аймаг 18 сум, 5 тосгонд нийт 23 хэсгийн 1542 гишүүдтэй байгаа бөгөөд хэсгүүдийг дунджаар 8-440 хүний бүрэлдэхүүнтэй байгуулжээ. Нийслэлийн хамгийн их хүнтэй, гэр хороолол ихтэй Баянзүрх дүүрэгт нэг ч хэсэг байгуулагдаагүй, Сонгинохайрхан дүүрэгт нэг л хэсэг байгуулагдсан байгаа нь аймаг, дүүрэгт байгуулагдсан сайн дурын хэсгийн бүрэлдэхүүний тоо, хүчин чадал, харилцан адилгүй байгаа нь судалгаанаас харагдаж байна. Харин сайн тал нь бүх хэсгүүд тухайн орон нутгийн Засаг Даргын захирамж, тушаалаар батлагдсан, сайн дурын хэсгийн гишүүдийн мэдээлэл, холбогдох утасны дугаар зэргийг судалгаанд тусгажээ.

4 Сайн дурын хэсгийн гишүүдийн сургагдсан байдлын хувьд өөрсдийн тодорхойлсон чиг үүрэгтэйгээ нийцүүлэн Гамшгийн тухай хууль, Галын аюулгүй байдлын тухай, Ойн тухай зэрэг хуулиуд, байгалийн гамшиг, аюулт үзэгдэл, ослоос урьдчилан сэргийлэх, гал түймэр унтраах, эрэн хайх, аврах, хойшлуулшгүй сэргээн босгох, анхны тусламж үзүүлэх, “Бэлэн бай” зэрэг сургалт дадлага явуулсны зэрэгцээ гамшгаас хамгаалах сайн дурын ажиллах журам, сайн дурынхны үүрэг оролцоо зэрэг 10 гаруй сэдвээр жилд 2 удаа 2-16 цагийн сургалт хийсэн байна. Гэхдээ байгуулагдаад хоёр жил болж байгаа ч сургалт огт хийгээгүй байдал Баян-

Өлгий болон Баянхонгор аймгуудад ажиглагдаж байна. Нийслэл Улаанбаатар хотын хувьд Багахангай дүүргийн сайн дурын хэсэг хүн, малын гоц халдварт өвчин, цасан болон шороон шуурга, техникийн холбогдолтой осол, объектын болон ой хээрийн түймэр зэрэг өөрийн онцлогт нийцсэн үйл ажиллагааны чиглэлийг тодорхойлсон боловч энэ үүргийнхээ дагуу сургалт зохион байгуулаагүй байна.

5 Багаж хэрэгсэл, хувийн хамгаалах хэрэгслийн тухайд гамшгаас хамгаалах сайн дурын хэсгийн тусгай тоноглол, хүн нэг бүрийн хэрэгслийн хангамжийн жишиг нормын дагуу байж болох хамгийн бага хангамжийн нормын хэмжээнд 12 төрлийн 45ш багаж хэрэгслэл байхаас Өмнөговь аймгаас бусад аймаг хангалтгүй дүнтэй байна. Хүн нэг бүрийн хамгаалалтын хувцас, гутал, уутан хөнжил, эвхдэг гудас хоолны сав зэрэг хангалтыг цогцоор нь хангасан хэсэг байхгүй байгаа нь судалгаанаас харагдаж байна.

6 Төв, орон нутагт байгуулагдсан сайн дурын хэсгийн өнөөгийн байдлын шинжлэн судлахад сайн дурын хэсгийн бүрэлдэхүүний тоо, хүчин чадал, харьцангуй зөрүүтэй, сургалт, бэлэн байдал, материаллаг хангалт жигд бус, тушаал, зааврын биелэлт удаан байгаа нь судалгаанаас харагдаж байна.

Гурав. Гамшгаас хамгаалахад сайн дурын үйл ажиллагааны талаар авсан санал, асуулга, боловсруулалтын үр дүнгийн хувьд:

Гамшгаас хамгаалахад сайн дурын үйл ажиллагааны талаарх санал асуулгад МУЗН-ийн харьяа аймаг, дүүргийн УЗХ-ны гамшгаас урьдчилан сэргийлэх, нэрвэгдэгсдэд тусламж үзүүлэх чиглэлээр сургаж бэлтгэгдсэн, үйл ажиллагаанд оролцогч сайн дурын идэвхтнүүдийг хамруулан, сайн дурын идэвхтний оролцоо, ажлын гүйцэтгэлд нөлөөлөх хүчин зүйлийн судалгаа хийж дараах дүгнэлтүүдэд хүрлээ. Үүнд:

1 Сайн дурын идэвхтний мэдлэгийн хүчин зүйлээс гамшгийн өмнөх, гамшгийн үед, гамшгийн дараах үеийн сургалтад хамрагдсан байдал, өөрөө сургалт зохион байгуулсан байдал, олон улсын туршлагаас суралцаж мэдлэгээ ахиулдаг байдал зэрэг гол гол далд хувьсагчийн үр дүн 0.745-0.888 хооронд хэлбэлзэж, кронпа альфа утгын үр дүн 0.642 байгаа нь бүгд сайн үр дүнтэй гарсан нь эдгээр хүчин зүйлсэд өндөр ач холбогдол өгч байх ёстойг харуулж байна. Түүнчлэн сайн дурын үйлсийн нийтлэг, олон нийтийг хамарсан, чөлөөт сонголт, чин хүсэл эрмэлзэл, оролцоо, эв нэгдэл

дээр үндэслэсэн зэрэг шинж чанаруудтай эдгээр хүчин зүйлс нягт уялдах болно.

2 Сайн дурын идэвхтний ур чадварын хүчин зүйлээс ур чадвараа ахиулдаг байдал, сайн дурынхны ур чадварыг хөгжүүлэх сургалт шаардлагатай эсэх, анхны тусламж үзүүлэх чадвар, хөрвөж ажиллах чадвар зэрэг далд хувьсагчийн үр дүн 0.660- 0.831 хооронд хэлбэлзэж, Кронпа альфа утгын үр дүн 0.931 бүх далд хувьсагч сайн үр дүнтэй гарсан. *Харин шаардлагатай үед гадаад хэлний ур чадвар 0.660 гарсан нь хангалтгүй дүн үзүүлж байна.* Хамаарлын шинжилгээний дүнгээс харахад сайн дурын идэвхтний мэдлэг, сайн дурын идэвхтний ур чадвар хоорондоо 0.836 үр дүнтэйгээр хамгийн их хамааралтай байгааг илтгэж байна. Цаашид гадаад хэлний мэдлэгийг дээшлүүлэх, олон улсын туршлагаас суралцах боломжийг нэмэгдүүлэх шаардлага байгааг анхаарах нь зүйтэй байна.

3 Сайн дурын идэвхтний ажлын туршлагын далд хувьсагчийн дундаж утгын үр дүн 0.584 байгаа нь далд хувьсагч бүгд сайн үр дүнтэй, хувьсагчийн дундаж утга 0.5 үнэлгээнээс өндөр гарч, ерөнхий дундаж үнэлгээ сайн байгааг илтгэсэн ч *шаардлагатай үед мэдээлэл шуурхай хүргэгддэг байдал 0.663 гарсан нь хангалтгүй байна.* Мөн *мэдээллийг авахад цахим орчин ашигладаг бадал 0.629 гарсан нь хангалтгүй, мэдээллийн талаар цахимд өөрийн үзэл бодлоо илэрхийлэх байдал 0.693 гарсан нь бас хангалтгүй үнэлгээ өгөхөөр үр дүн гарч байна.* Сургалт сурталчилгааны ажлын давтамжийг нэмэгдүүлэх, цахим орчинд ажиллах ур чадварыг нэмэгдүүлж интернэт ашиглах орчныг сайжруулж бодлогоор дэмжих нь чухал болох нь дээрх үр дүн болон гамшгаас хамгаалах сайн дурын хэсгийн судалгаанаас харагдаж байна.

4 Сайн дурын идэвхтний оролцоо, ажлын гүйцэтгэлийн хүчин зүйлээс бүх далд хувьсагч сайн үр дүн илгэсэн ч *сургалтад оролцох саналаа анхан болон дунд шатны хороонд санал болгодог байдал 0.633 гарсан нь хангалтгүй, багийн ажлыг хүлээн зөвшөөрдөг байдал 0.700 гарсан нь хангалтгүй, ажлын гүйцэтгэлийг үнэлдэг байдал 0.598 гарсан нь мөн хангалтгүй үнэлгээ үзүүлсэн байна.* Сайн дурын идэвхтнүүдийг сургах, давтан сургах сургалтын хөтөлбөрийг шинэчлэх, нас насныханд зориулсан дадлага сургуулилт, уралдаан тэмцээний дүрэм, журам, шагналын санг нэмэгдүүлэх шаардлага байгааг нөхцөл байдлын судалгаа болон гамшгаас хамгаалах хэсгийн судалгаа давхар харуулж байна.

ГУРАВДУГААР БҮЛЭГ. ГАМШГААС ХАМГААЛАХАД САЙН ДУРЫНХНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРОЛЦООГ НЭМЭГДҮҮЛЭХ АРГА ЗАМ

3.1. Гамшгаас хамгаалахад сайн дурынхны үйл ажиллагааны эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгох боломж.

Олон улсын туршлагаас үзэхэд дэлхий даяар олон сая сайн дурынхан орон нутгийн түвшинд засаглалд хувь нэмрээ оруулж байна. Засгийн газрын орон нутагтаа шийдвэр гаргалт болон оролцоог дэмжсэн механизмыг бий болгохын зэрэгцээ сайн дурынхан бодлого боловсруулах, тэдний амьдралд шууд нөлөөлөх асуудлуудыг шийдвэрлэхэд оролцох нь ихсэж байна. Зарим орон нутгийн сайн дурынхан дангаараа засаглалын үйл явцыг илүү олныг хамарсан болгохын төлөө ажилладаг бол зарим нь үндэсний хэмжээний болон олон улсын ИНБ-ууд гэх мэт гаднын оролцогчидтой нэгдэж, зарим нь сүлжээ байгуулж, мөн зарим хэсэг нь орон нутгийн засаг захиргааны байгууллагуудтай хамтарч ажилладаг.

Тиймээс сайн дурын үйлсийг хөгжүүлэх таатай улс төр, эрх зүйн орчин бүрдүүлэхэд түүний хэрэгжүүлэлтэд чиглэсэн гол асуултуудыг урьдчилан өөрсдөөсөө асуух шаардлагатай байдаг. Тухайлбал:

- Бодлого, хууль тогтоомжтой болсон хойноо тэднийг ямар хугацаанд хэрэгжүүлэх шаардлагатай вэ?
- Хэрэгжилтийг хэн хариуцах вэ?
- Үндэсний сайн дурын үйлсийг зохицуулах механизм ямар байх вэ?
- Төрийн байгууллагууд болон сайн дурынхны оролцоотой байгууллагуудын хамтарсан ажиллагааг зохицуулалтаар хангах нэгжийг шинээр байгуулах буюу томилох шаардлага байна уу?
- Тэр нь төрийн байгууллага байх уу, Иргэний нийгмийн байгууллага байх уу?
- Сайн дурынхантай ажилладаг байгууллагуудад санхүүгийн ямар хэлбэрийн дэмжлэг үзүүлэх хэрэгтэй вэ?
- Сайн дурынханд хамаатай ямар хууль, тогтоомжууд байдаг вэ?
- Сайн дурынханд хамааралтай ямар хуулиуд үйлчилж байна вэ?
- Сайн дурын үйлсийг дэмжихийн тулд одоогийн хуулиудад ямар нэмэлт өөрчлөлт оруулах шаардлагатай вэ? эсвэл сайн дурын үйл ажиллагааны тухай хууль шинээр гаргах шаардлагатай юу? гэх зэрэг.

Ийм асуудалд хариулт өгөхөд чиглэсэн дэмжлэг үзүүлэх “Монгол Улс дахь Сайн дурын үйл ажиллагааны үндэсний хөтөлбөрийн үзэл баримтлал” гэсэн зөвлөмж бичгийг боловсруулж Монгол дахь НҮБ-ын Хөгжлийн Хөтөлбөр батламжлан гаргасан. Энэхүү үзэл баримтлалын төслийг манай улсад сайн дурын ажиллагааны Үндэсний хөтөлбөр, бодлого, хууль тогтоомжийг боловсруулахад удирдамж болгохоор боловсруулсан байна.

Энэхүү зөвлөмж бичиг нь дараах агуулгаар боловсруулагдсан байна.
Үүнд:

Оршил,

1. Сайн дурын ажиллагааны Үндэсний хөтөлбөрийн зорилго, цар хүрээ.

11. Үзэл баримтлалын гол санаа болон нэр томъёоны тодорхойлолт

- 1 Сайн дурын ажиллагааны зарчим ба үйл ажиллагаа,
- 2 Сайн дурынхан,
- 3 Сайн дурынхны оролцоотой байгууллагууд,
- 4 Сайн дурынхныг дэмжигч байгууллагууд.

11.1. Сайн дурынхны Үндэсний хөтөлбөрийн менежмент

- 5 Сайн дураар ажиллах нөхцөл,
- 6 Оролцогч талуудын гэрээгээр хүлээх үүрэг, эрх, харилцааны зарчим,
- 7 Сайн дураар ажиллах эрмэлзэл сонирхол, эдлэх хөнгөлөлт урамшуулал,
- 8 Сайн дурынхныг ажил үүрэгт нийцүүлэн дайчлах ажиллагаа болон мэдээлэл, мэдлэгийн сан,
- 9 Сайн дурынхны ажиллагааны менежмент, ажиллагааны баталгаа, хяналт болон үнэлгээ.

IV. Сайн дурынхны зохицуулалтын Үндэсний механизмын зохион байгуулалт

- 10 Сайн дурынхны журам, зохицуулалтын үндэсний бүтэц болон санхүүжилтийн механизм

V. Хэрэгжүүлэх стратеги.

VI. Хавсралт 1. Сайн дурынхны үндэсний албадын мэдээллийн хуудас.

VII. Хавсралт 2. Сайн дурын ажиллагааны үндэсний хууль тогтоомжийн дүн шинжилгээний хүснэгт.

Зөвлөмж нь албан ёсны сайн дурын ажиллагаа явуулах орчинг бүрдүүлэх, байгууллагын ажиллагаанаас гадуур иргэний идэвхтэй оролцоог дэмжихэд чиглэгдсэн сайн дурын ажиллагааны бүх хэлбэрийг хөгжүүлэх зорилготой бөгөөд Монгол Улсад хийсэн Сайн дурын ажиллагааны судалгааны дүн, хэрэгжиж буй сайн дурын ажиллагаа, туршлага болон олон улсын ажиллагааны бүтэц, харьцуулсан дүн шинжилгээ, бусад орны тэргүүн туршлагад тулгуурлан боловсруулагдсан байна.

Түүнчлэн НҮБ-ын дэмжлэгтэй холбогдсон сайн дурын ажиллагааны талаар цаашид эрх зүйн орчныг боловсронгуй болгоход баримтлах шаардлагатай дүгнэлт, санаануудыг оруулсан байна. Үүнд:

Нэгд. Иргэний оролцоо, ард иргэдэд төвлөрсөн нийгмийн хөгжилтэй нягт уялдаатай сайн дурын ажиллагааны ач холбогдлын талаар:

- Сайн дурын ажиллагаа болон ард иргэдэд чиглэсэн үндэсний хөгжилд иргэний нийгмийн оролцоог нэмэгдүүлэх нь НҮБ-ын Хөгжилийн Тусламжийн Тогтолцооны /НҮБХТТ/ тулгуур асуудал ба “хэрэгжиж буй бүх хөтөлбөржсөн арга хэмжээнд иргэний нийгмийн үүргийг өндөржүүлэх, хөгжил болон хүний эрхийн асуудлаар төр засагтай хийж буй хэлэлцээг дэмжих, Монгол дахь НҮБ-ын баг нь иргэний нийгмийн байгууллагуудтай тогтоосон нягт хамтын ажиллагаанд тулгуурлан албан ёсны болон албан бус зөвлөлдөх механизмыг хөгжүүлэх, хөгжилд иргэний өргөн оролцоо, ялангуяа хүүхэд залуучуудын оролцоог нэмэгдүүлэхэд хүчин чармайлт гаргана, НҮБ нь сайн дурын ажиллагааг иргэдийн хөгжилд хувь нэмэр оруулах, олон нийтийн албыг сайжруулах арга хэрэгсэл хэмээн үзэж дэмжлэг туслалцаа үзүүлнэ”

- Хөгжилд нийгмийн оролцоог нэмэгдүүлэх үүрэгт сайн дурын ажиллагааг “засаглал дахь оролцоог нэмэгдүүлэх, ард иргэдэд нийцсэн үр дүнд хүрэх маш өргөн цар хүрээтэй “ салбар хэмээн тодорхойлсон.

- “Сайн дурын болон иргэний нийгмийн ажиллагаанд оролцох нь орон нутгийн, улсын, дэлхийн төрөл бүрийн зорилгод хүрэх боломжийг нээж байгааг хүлээн зөвшөөрөх нь чухал. Сайн дурын болон иргэний

нийгмийн ажиллагаанд оролцсоноор нийтийн эрх ашиг, эв нэгдэл, хүйсийн тэгш эрх, ялгаварлан гадуурхахаас татгалзах, энх тайван зэрэг нийтийн зарчмыг мөрдөхөд хувь нэмэр оруулна”

Хоёрт. Сайн дурын ажиллагааны үндэсний хөтөлбөрийг боловсруулахад нөлөөлөх хүчин зүйлсийн талаар:

- Сайн дурын ажиллагааны үндэсний хөтөлбөрийг боловсруулахад: *сайн дурын ажиллагаа явуулах боломжийг олгох, ажиллагааны менежментийг хангах, ард иргэдийн оролцоо нэмэгдсэнээр үндэсний хөгжлийн үйл явцад нөлөөлөх зэрэг гурван гол хүчин зүйлсийг онцолсон. Мөн ихэнх тохиолдолд иргэний нийгмийн оролцоо нь орон нутгийн болон улсын хэмжээнд сайн дурын ажиллагаанд оролцох нөхцөл орчинг хэрхэн бүрдүүлснээс шалтгаалдаг болохыг тэмдэглэсэн.*

- Төр засаг нь сайн дурын ерөнхий, тэр дундаа хөгжилд дэмжлэг үзүүлэх ажиллагааг эрчимжүүлэх үүднээс ажиллагааны хөтөлбөрийн зорилго, төлөвлөлт, нөөцийн зарцуулалтыг тодорхойлсон үндэсний хөтөлбөрийн бодлогыг боловсруулсан байх шаардлагатай бөгөөд сайн дурын ажиллагаа нь үндэсний хөгжлийн тэргүүлэх чиглэл, стратегид тусгалаа олж, хууль тогтоомжоор хамгаалагдсан байх ёстойг заасан. НҮБ-ын 60/134 тогтоолын дагуу төр засаг нь сайн дурын ажиллагааны стратеги, бүтцийг хэрэгжүүлэх тодрохой төсвийг улсын төсөвт суулгасан байх ёстой бөгөөд ажиллагааны тогтолцоог бүрдүүлэхэд дэмжлэг үзүүлж, хөтөлбөрүүд хөгжлийн үйл явцад хэрхэн нөлөөлж байгаад хяналт тавьж үнэлгээ хийнэ.

- Сайн дурын болон иргэний оролцоо нь орон нутгийн, улсын болон дэлхийн зорилтуудыг хэрэгжүүлэхэд хувь нэмэр оруулахын сацуу иргэний нийгмийн хөгжилд ихээхэн ач холбогдолтой. Иргэний нийгмийн байгууллагууд нь сайн дурын ажиллагаа, иргэний оролцоог хүлээн зөвшөөрч, үнэлсэн, дэмжлэг үзүүлэхэд чиглэгдсэн үйл ажиллагааг явуулж таатай орчинг бүрдүүлэх ёстой. Түүнчлэн иргэний нийгэм нь сайн дурынханд түшиглэн ажилладаг байгууллагуудын хооронд мэдээлэл болон ажлын туршлага солилцох, хамтран ажиллах чиглэлийг тодорхойлоход тусалцаа үзүүлэхийн зэрэгцээ олон нийтийн байгууллагуудын зүгээс сайн дурын ажиллагааг дэмжих, хөтөлбөрийг амжилттай хэрэгжүүлэх боловсон хүчнээр хангахад анхаарна.

- Хувийн хэвшлийн салбарын амжилт, олон нийтийн итгэл ч нийгмийн болон орчны тогтвортой байдлаас ихээхэн шалтгаална. Бүхий л

компаниуд өөрсдийн ажилтнуудыг сайн дурын ажиллагааны хөтөлбөрт оролцуулах нь бизнесийн нийгмийн хариуцлагын стратегийг хэрэгжүүлэх, хөгжил болон нийгмийн шинэчлэлд хувь нэмэр оруулах үндэс болно.

Эдгээр хөтөлбөрүүд нь уян хатан байж ажилтнууд сайн дурын ажиллагаанд оролцох нөхцөл боломжийг хангах, тэдний мэдлэгийг нэмэгдүүлэх замаар нийгмийн оролцоог идэвхжүүлэх үүрэгтэй. Шинэ ажилтан авахдаа сайн дурын ажиллагаанд оролцох шалгуурыг хэрэглэж болно. Компаниуд нь төр засгийн болон иргэний нийгмийн байгууллагуудтай түншлэл тогтоон сайн дурын ажиллагааны төвүүд байгуулах зэрэг санаачлагаар орон нутгийн болон бусад байгууллагуудад сайн дурынхан ажиллах боломжийг нэмэгдүүлнэ.

Иймд сайн дурын үйл ажиллагааны эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгох боломжийг *нэгд*, сайн дурын үйл ажиллагаа ба засаглалын бодлогын харилцан уялдааг сайжруулах арга зам, *хоёрт*, хууль эрх зүйн орчныг сайжруулах боломж гэсэн хоёр чиглэлээр тодорхойллоо. Чингэхдээ “[Засаглал бол] улс үндэстний ажил хэргийг жолоодох, улс төр, эдийн засаг, захиргааны эрх мэдлийг хэрэгжүүлэх явдал бөгөөд энэ нь иргэд, тэдний бүлгүүд ашиг сонирхол, өөр хоорондын ялгаатай байдлаа илэрхийлэх, хуулиар олгогдсон эрх, үүргээ хэрэгжүүлэх механизм, үйл явц, харилцаа, байгууллаас бүрдэнэ”¹⁰⁶ гэсэн ойлголтыг засаглалын үндэс болголоо.

Мөн сайн дурын үйлсийн үр өгөөжийг дараах гурван чиглэлээр тодорхойлсон байдгийг засаглалын хүрээнд анхаарах нь зүйтэй гэж үзсэн болно. Үүнд:

- *Сайн дурынхныг хүлээн авагч байгууллагууд хүртэх ач тус*: хүлээн авагч байгууллагын чадавхийг бэхжүүлэх, нарийн мэргэжлийн туслалцаа үзүүлэх чиглэлээр сайн дурынхны тус нэмэр ахиу байдаг гэж үзсэн. Сайн дурынхан тухайн байгууллагын үйл ажиллагааг "хөндлөнгийн нүдээр" харснаараа шинэ санаа оруулах ач холбогдолтойн дээр сайн санаагаар тусалж байгаа үлгэр дууриаллаараа орон тооны ажилтнуудыг сэдэлжүүлдэг байна. Олон улсын сайн дурынхан тэдгээрийн гадаад хэлний чадварыг сайжруулахад тус дэм болохын зэрэгцээ , чин сэтгэлээр ажиллах эрмэлзлэлийг өдөөж өгдөг.

- *Нийгэм, орон нутгийн ард иргэд хүртэх ач тус*: орон нутгийн

¹⁰⁶ НҮБ-ын Хөгжлийн Хөтөлбөр 1997.

сайн дурынхан зорилтот бүлгүүдээ сайн мэддэгийн хувьд тэдэнд хүрч ажиллахад дөхөмтэй байдаг. Сайн дурынхан тухайн орон нутгийн оршин суугч байгаа тохиолдолд хүмүүстэй харилцах боломж нь гаднаас ирсэн ажилтнаас илүү байдаг. Орон нутгийн хүн амын шууд оролцоог идэвхжүүлэх нь орон нутгийн хөгжлийн хөтөлбөрт олон нийтийн өөриймсөг хандлагыг бий болгож, татан оролцуулахад тус нэмэртэй.

- *Сайн дурынханд хүртэх ач тус:* сайн дурын үйл ажиллагаанд оролцсоноороо мэдлэгээ дээшлүүлж, шинэ ур чадвар эзэмшиж, амьдралын туршлага сууж, ажилд орох боломж нь дээшилдэг байна.

А. Сайн дурын үйл ажиллагаа ба засаглалын бодлогын харилцан уялдааг сайжруулах арга зам.

Сайн дурын үйл ажиллагаа ба засаглалын бодлогын харилцан уялдааг сайжруулах нь нэг чухал шийдэл байх болно. Үүний тулд дараах хамаарлыг харгалзан үзэх хэрэгтэй юм. Үүнд:

- Үндэсний түвшинд сайн дурынхан хөгжлийн үйл явцыг дэмжих нөөц боломж нь үндэсний засгийн газар сайн дурынхны оролцоо болон санаачилгыг дэмжсэн орчин, орон зайг бүрдүүлэх хүсэл зоригоос хамаардгийг,

- Сайн дурын үйл хэрэг нь нийгэмд итгэлцэл үүсгэх, нийгмийн оролцоог нэмэгдүүлэх, үндсэн үйлчилгээг сайжруулах болон хүний хөгжлийг хурдасгах дэмжлэг болдгийг,

- Сайн дурынхан болон сайн дурын үйл хэрэг нь үг хэлэх, холбоо байгуулах эрх чөлөө, улс төрийн хүчтэй хэлэлцүүлэг хийх боломж нөхцөлийг бүрдүүлсэн сайн сайхан ашиг тус авчирдгийг,

- Сайн дурын үйл хэрэг нь сайн засаглалын үндсэн тулгуурууд болох дуу хоолой болон оролцоо, хариуцлагын тогтолцоо, хариу үзүүлэх байдал буюу хүсэлт хэрэгцээг сонсож, хөтөлбөр үйл ажиллагаандаа тусгаж ажиллах байдлыг бий болгоход шаардлагатай ур чадвар, мэдлэг, мэргэшлийг авчрах нэмэлт нөөц, дамжуулагч болсноор хөгжлийн бусад шийдэл, нөөц бололцоог гүйцэлдүүлж байдгийг,

- Бүх хүний эрхийг дээдэлсэн орчныг бий болгох нь сайн дурын үйл хэргээр дамжуулан эерэг хөгжил, энх тайванд хувь нэмэр оруулах боломжийг нэмэгдүүлдэг бөгөөд тогтвортой хөгжилд иргэдийн эерэг оролцоог нэмэгдүүлэх боломжтой орчныг бий болгох нь амжилтын нэн чухал хэсэг гэдгийг,

- Засгийн газар сайн дурын үйл хэргийг энх тайван, хөгжлийн төлөө хөшүүрэг болгон ашиглах санаачилгыг гаргаснаар сайн дурын ихэнх ажиллагаа нь уригдсан орон зайд¹⁰⁷ явагддагийг,

- Сайн дурынхан болон сайн дурын үйл ажиллагаанд илүү олон хүмүүсийн албан (олон улсын сайн дурын ажиллагааг оруулан) болон албан бус байдлаар, орон нутгаас олон улсын хүртэлх бүх түвшинд, бүх хэлбэрийн оролцоо нь засаглалыг сайжруулахын тулд сайн дурынхны эрх, хэрэгцээг ойлгох, сайн дурын ажлыг нөөцөөр хангах, дэмжих, идэвхтэй оролцох арга замуудыг олж хэрэгжүүлэхийг шаарддагийг.

- Орон нутгийн түвшин дэх сайн дурын үйл ажиллагаа нь засаглалын үйл явцыг илүү олныг хамарсан, оролцооны болгохын тулд орон нутгийн засаг захиргаатай эсвэл олон улсын иргэний нийгмийн байгууллагуудтай (ИНБ-ууд) хамтран ажиллахад эмзэг бүлгийнхэн болон нийт ард иргэдийн чадавхыг бэхжүүлдгийг тооцох шаардлагатай.

Засаглалын үйл ажиллагаа, бодлого, стратегийг бэхжүүлэх болон хөгжлийн бодлого, үйл явцыг хэлэлцэхэд нэн чухал доорх гол санаануудыг хөгжил болон сайн дурын үйл ажиллагааны логик холбоонд засаглалын бодлогын хүрээнд авч үзэх нь бас нэг шийдэл мөн. Үүнд:

1. Орон нутгийн түвшин дэх сайн дурын үйл хэрэг нь ард иргэдийн чадавхыг бэхжүүлдэг нь засаглалын үйл ажиллагаа ба хөгжлийн бодлого боловсруулахад ач холбогдолтой байх болно. Ач холбогдол нь:

- Орон нутгийн түвшин дэх сайн дурын үйл ажиллагаа нь засаглалын үйл явцыг илүү олныг хамарсан, оролцооны болгохын тулд орон нутгийн засаг захиргаатай эсвэл олон улсын иргэний нийгмийн байгууллагуудтай (ИНБ-ууд) хамтран ажиллахад эмзэг бүлгийнхэн болон нийт ард иргэдийн чадавхыг бэхжүүлдэг.

¹⁰⁷ Сайн дурынхан нээлттэй буюу уригдсан орон зайд оролцож эсвэл өөрсдөө хаалттай орон зайг нээж, мөн шинээр өөрсдийн ажиллах орон зайг бий болгох гэх мэт олон замаар оролцож буй тодорхой арга, стратегиудыг онцгойлон жишээ татаж оруулав. Уригдсан орон зай гэдэг нь засаглалын оролцогч талууд нь иргэд болон ашиг тус хүртэгчдийг үйл ажиллагаанд оролцохыг урихыг хэлнэ. Хаалттай орон зай гэдэг нь оролцох боломжийг тодорхой шаардлага хангасан хэсэг бүлэг, хүмүүс тодорхойлдог орон зайг хэлнэ. Шаардсан орон зай гэдэг нь эрх мэдэл багатай эсвэл эмзэг бүлгийн хүмүүс нийгмийн хөдөлгөөнөөр, орон нутгийн холбоод эсвэл хэсэг хүмүүс сайн дурын үндсэн дээр цугларч асуудлыг хэлэлцэх, мэтгэлцэх, эсэргүүцэх гэх мэтээр өөрсдийн үйл ажиллагааны орон зайг шаардсан эсвэл албан бусаар бий болгосон орон зай юм. Хүмүүс санаачилгыг гартаа авсан үед оролцооны ихэнх хэсэг нь шаардсан орон зайд өрнөдөг. Дараа дараачийн шатандаа арга хэмжээнүүд нь харин уригдсан орон зайд шилжих нь бий. Аль ч тохиолдолд сайн дурынхан өөрсдийн уригдсан болон шаардсан орон зай дахь үйл ажиллагаагаараа хаалттай орон зай дахь шийдвэр гаргалтад нөлөөлөхийг эрмэлздэг.

- Оролцоо нь хязгаарлагдсан бүлгийнхэн, ялангуяа эмэгтэйчүүдийн хувьд дуу хоолой болон оролцоогоо хүчтэйгээр илэрхийлэх шинэ, нэмэлт сувгууд нь тэдний хэрэгцээ шаардлагыг анхаарлын төвд аваачиж, нөөцийг тэдний онцгой хэрэгцээнд зориулан хуваарилахад ихээхэн нэмэр болдог зэргээр илэрнэ.

2. Үндэсний засгийн газрууд сайн дурын үйл ажиллагаанд зориулж илүү их орон зайг бий болгосноороо нийгмийн оролцоог нэмэгдүүлэх нь засаглалын үйл ажиллагаа ба хөгжлийн бодлого боловсруулахад ач холбогдолтой байх болно. Ач холбогдол нь:

- Үндэсний засгийн газар сайн дурын үйл ажиллагааны илүү их орон зайг бий болгосноор нийгмийн оролцоо нэмэгдэж, нийгэм хөгжлийн үр дүн сайжирч, саадгүй явагдах үйлчилгээнд хүрэх болно. Үг хэлэх, нэгдэх, улс төрийн мэтгэлцээн хийх эрх чөлөөтэй үед сайн дурынхан болон сайн дурын үйл хэргийн оролцоо хамгийн үр дүнтэй байж чаддаг.
- Блог, хяналтын платформ, социал медиа гэх мэт мэдээлэл харилцааны технологи нь сайн дурынхныг эх сурвалжаас нь цаг үеийн мэдээг шууд авч чадах гол мэдээллийн хэрэгслүүдтэй холбогдож, дуу хоолой, санал бодлоо илэрхийлэх шинэ замыг олох боломжийг олгодог зэргээр илэрнэ.

3. Олон улсын сайн дурынхны сүлжээ нь дуу хоолой болон оролцоо, хариуцлагын тогтолцоо, хариу үзүүлэх байдлыг дэмжих нь засаглалын үйл ажиллагаа ба хөгжлийн бодлого боловсруулахад ач холбогдолтой байх болно. Ач холбогдол нь:

- Олон улсын сайн дурынхны сүлжээ нь орон нутгийн, үндэсний, олон улсын түвшний орон зайнуудыг холбож төрөл бүрийн стратеги ашиглаж дуу хоолой болон оролцоо, хариуцлагын тогтолцоо, хариу үзүүлэх байдлыг дэмжиж байдаг.
- Үүнийг боломжтой болгоход технологи чухал үүрэг гүйцэтгэнэ. Жишээ нь: сайн дурынхныг богино хугацаанд өргөн хүрээнд хамруулах, хамтрал холбоод байгуулах, мэдлэг туршлагаа хуваалцах, бүх түвшний засаглалын оролцогч талуудыг оролцуулах гэх мэт. Харин хүний оролцох эрхийн тэгш бус байдлыг анхаарч, оролцоо нь хамгийн ихээр хязгаарлагдсан иргэдийг хэлэлцүүлэгт оролцуулах талаар хэлэлцэх шаардлагатай байдаг зэргээр илэрнэ.

4. 2015 оноос хойших хугацааны тогтвортой хөгжлийн зорилтуудыг хэрэгжүүлэхэд шаардлагатай нөөц боломжуудыг татан оруулахад сайн дурын үйл хэрэг нь үнэтэй хувь нэмэр болох нь засаглалын үйл ажиллагаа ба хөгжлийн бодлого боловсруулахад ач холбогдолтой байх болно. Ач холбогдол нь:

- Сайн дурын үйл хэрэг нь талуудын санал бодлыг нэгтгэх, 2015 оноос хойших хугацааны хөгжлийн хөтөлбөрийг хэрэгжүүлэх, хянахад шаардлагатай бүх боломжийг нэгтгэхэд хүчирхэг нөөц боломж болдог.
- Нэмэгдэж буй оролцоо нь ИНБ-ууд, хувийн хэвшил, засаглал болон үйлчилгээ хүргэх явцад чухал үүрэгтэй этгээдүүд зэрэг засаглалын оролцогч талуудаас илүү хариу үзүүлдэг байхыг шаарддаг зэргээр илэрнэ.

Үүнийг хэрэгжүүлэхийн тулд сайн дурын үйл хэрэгт боломж, орон зайг нээж өгөхөд өргөн хүрээний стратеги, засаглалын өөр өөр түвшин дэх хамтын ажиллагаа, холбоод шаардлагатай.

Орон нутгийн түвшинд сайн дурын үйл хэрэг нь өөрийн гэсэн хүндрэл бэрхшээлтэй тулгардгийг засаглалын бодлогод анхаарах хэрэгтэй болно. Тийм хүндрэл бэрхшээл нь:

- Засгийн газрын зүгээс ялангуяа энэ түвшинд ачааны хүндийг сайн дурынханд даатгах эрсдэл байдаг.
- Үүнээс гадна оролцооны орон зай дахь зонхилох бүлэглэлүүдийн давамгайлал нь шийдвэр гаргалт дахь тэгш бус байдлыг бууруулах гэхээсээ илүүтэйгээр улам өөгшүүлдэг тал байдаг.
- Зарим бэлгэдлийн чанартай оролцооны механизм нь шийдвэр гаргах бодит эрх мэдэлгүй байдаг.
- Зарим сайн дурынхан үзэл бодлоо илэрхийлсний төлөө дарамт шахалттай нүүр тулгарах тохиолдол байдаг зэрэгт оршиж байна.

Эдгээр асуудлыг үл харгалзан орон нутгийн сайн дурын үйл хэрэг нь үйлчилгээг өргөжүүлж сайжруулах, чадамжийг бий болгох, эмзэг бүлгийнхний дуу хоолойг нэмэгдүүлэх, орон нутгийн мэдлэгийг нэгтгэх, хүчний тэнцвэртэй байдлыг хангах, олон ургалч үзлийг дэмжих боломжтой гэдгийг баримтууд харуулж байна.

Дараах тодорхой зорилтуудыг дэвшүүлэн ажиллах нь засаглал бодлогыг сайн дурын үйл ажиллагаагаар дэмжүүлэх чухал механизм байж болох юм. Үүнд:

Сайн дурын үйл ажиллагааг олон нийтээр дэмжүүлэх зорилт:

- сайн дурын үйл ажиллагааг дэмжих компани т ажлыг зохин байгуулах,
- хэвлэл, мэдээллийн байгууллагатай байнгын харилцаа тогтоох,
- сайн дурынхны өдрийг тэмдэглэх.

Боловсролын системд сайн дурын үйл ажиллагааг дэмжих тогтолцоог бий болгох зорилт:

- бага болон дунд сургуулийн хөтөлбөрт сайн дурын үйл ажиллагааны мэдлэг олгох асуудлыг оруулах,
- оюутнуудыг сайн дурын үйл ажиллагаанд оролцох механизмыг их дээд сургуулиудад бий болгох,
- сайн дурын үйл ажиллагааг дэмжих хөгжүүлэх стратегийг боловсруулах,
- залуучуудын дунд сайн дурын үйл ажиллагаанд оролцох эрмэлзлийг хөгжүүлэх.

Иргэний нийгмийн сайн дурын үйл ажиллагаанд оролцох түвшнийг дээшлүүлэх зорилт:

- Иргэний нийгмийн сайн дурын үйл ажиллагаанд оролцох боломжийн талаарх мэдээллийн солилцоог өргөжүүлэх,
- Иргэний нийгмийн байгууллагуудын сайн дурынхантай ажиллах, ашиглах чадавхыг хөгжүүлэх,
- Сайн дурын үйл ажиллагааны дэд бүтцийг хөгжүүлэх, (сайн дурын үйл ажиллагааны болон мэдээллийн төвүүд, эрдэм шинжилгээ, мэдээллийн сан).

Сайн дурын үйл ажиллагааг дэмжих институцийн системийг бий болгох зорилт:

- Сайн дурын ажиллагааг хөгжүүлэх Үндэсний зөвлөлийг байгуулах,
- Хуулийн заалтын хэрэгжилт, үйл ажиллагаанд мониторинг, үнэлгээ хийх,

- Сайн дурын үйл ажиллагааг дэмжих, хөгжүүлэх төсөл, хөтөлбөрт санхүүгийн туслалцаа үзүүлэх,
- Төрийн байгууллагуудын сайн дурынхантай ажиллах чадавхыг нэмэгдүүлэх,

Энэ бүхнийг өргөн утгаар нь авч үзсэнээр иргэдийн дуу хоолой болон оролцоог нэмэгдүүлэн, илүү хариуцлагатай, илүү хариу үзүүлдэг засаглалыг бий болгож чадна.

Сайн дурынхны талаарх засаглалын бодлогыг сайжруулсны үр дүнд:

- Засгийн газар сайн дурынхны оролцоог сайжруулах тогтолцоо бий болгосон үедээ сайн дурын үйл ажиллагааны хүчийг системтэйгээр хөшүүрэг болгож, сайн дурынхныг улсын хөгжлийн төлөвлөгөө дэх чухал салбаруудад санаачилгатай оролцуулах боломжийг олгоно.
- Технологийн шинэ боломжийг бодлогоор дэмжих нь сайн дурынхан, жирийн иргэдийн хувьд мэдээллийг цаг тухайд нь олон нийтийн дундаас боловсруулах, мэдээлэх боломжийг бий болгож, өөрсдийн вэбсайт, блог дээр үзэл бодлоо илэрхийлэх, мэдээ оруулах замаар мэдээллийн орон зайд нэгдэх, иргэдийн дан ганц уламжлалт мэдээллийн хэрэгслээс хараат байдлыг багасгах болж, зарим тохиолдолд уламжлалт хэвлэл мэдээллийн хэрэгслүүдэд өөрсдийн орон зайг хадгалж үлдэх, илүү хариуцлагатай, үнэн зөв мэдээлэл түгээх шаардлагыг бий болгоно.
- Үндэсний түвшин дэх сайн дурынхны санаачилгын амжилтын гол түлхүүр нь тэдгээр санаачилгыг сонсож, хариу үзүүлдэг засгийн газар болно. Зарим тохиолдолд уг хөдөлгөөнүүд нь засгийн газрыг илүү хариу үзүүлдэг байлгахад шаардлагатай улс төрийн шахалт үзүүлдэг бол бусад үед сайн дурынхны санаачилгууд нь тэдгээр санал санаачилгыг дэмжиж нааштайгаар хүлээн авах засгийн газрын үед хэрэгждэг учраас сайн дурынхны хамгийн амжилттай санаачилгын нууц нь засгийн газартай тодорхой хүрээнд, хэдий тэднийг буруушааж, шүүмжилсэн ч хамтарч ажилладаг болно.
- Засгийн газар, нийгмийн нөлөө бүхий бүлгүүд, элитүүдийн хариу үзүүлэх байдал нь иргэдийн оролцоог дэмжсэн орчныг болон олны дуу хоолойг сонсох нөхцөлийг бий болгоход тэр дундаа

хамгийн ихээр хохирсон иргэдийн дуу хоолойг хүргэж, удаан хугацааны энх тайвныг бий болгож, нийгмийн зөрчлийг арилгахад нөлөөлнө.

- Засгийн газар болон иргэний нийгмийн хооронд хамтын ажиллагаа нь хууль эрх зүй болон бүтцийн өөрчлөлтийг амжилттай нутагшуулах хүчин зүйл болно
- Засгийн газар болон ИНБ-ууд хоорондын найрсаг түншлэл нь засгийн газрын бодлогыг хэрэгжүүлэх чадварыг сайжруулахад сайн дурынхан оролцох сувгийг нээж өгнө.

Сайн дурынхны талаарх тоон үзүүлэлт, статистик мэдээ тун дутмаг байгаа ба ойрын ирээдүйд сайн дурын үйл хэргийн ач холбогдлыг бүрэн дүүрэн таниулж мэдүүлэхэд: *нэн түрүүний бэрхшээл* нь дэлхийн өнцөг булан бүрд буй сайн дурын үйл хэргийн хязгааргүй хүрээ, ялгаатай байдлыг тодруулж, тодорхойлох шаардлага, *хоёрдугаарт*, уг олон янзын сайн дурын үйл хэргийн хэмжээ, цар хүрээг тоон үзүүлэлтээр илэрхийлэх хэрэгцээ, *гуравдугаарт*, эдгээрийн хоорондын ялгаа, өвөрмөц байдал, нарийн уялдаа холбоог тус тусын нөхцөлд чанарын кэйс судалгаагаар дамжуулан олж мэдэх шаардлага байна. Энэ бүхнийг хийж гүйцэтгэхэд илүү их судалгаа, тоон болон өөр өөр орны соёл заншилд сайн дурын үйл хэргийг хэрхэн тодорхойлж, хэрэгжүүлж буй талаарх чанарын мэдээлэл цуглуулах тууштай хүчин чармайлт, бодлогын шинжилгээ хэрэгтэй болно.

Б. Хууль эрх зүйн орчныг сайжруулах боломж.

Хоёрдугаар бүлэгт авч үзсэнчлэн 2001 онд “Олон улсын сайн дурынхны жил” зарлахаас өмнө ихэнх улсуудад сайн дурын ажлын нийгэм, эдийн засагт үзүүлдэг хувь нэмрийг бүрэн таниагүй, хууль эрхзүйн зохицуулалтыг бүрдүүлээгүй байсан ба сайн дурын үйл ажиллагааг зохицуулсан хууль эрхзүйн орчин бүрдүүлсэн хэдхэн улс байсан. Харин олон улсын ТББ-уудын 2001 оны нэгдсэн үйл ажиллагааны үр дүнд олон улсын засгийн газруудын сайн дурын ажлын талаар баримтлах бодлого, чиглэлд онцгой ахиц, дэвшил гарсан бөгөөд оны эцэс гэхэд 125 улсад Үндэсний сайн дурын ажлын хороо байгуулагдаж, өөр өөрийн улсад сайн дурын ажлыг хуульчлах, эрхзүйн орчныг бүрдүүлэх ажлыг зохион байгуулж эхэлсэн. Өдгөө 70 гаруй улс сайн дурын ажлын талаар баримтлах бодлого, хууль эрх зүйн акттай болоод байна.

Хууль эрх зүйн орчин, тодорхой бүтцийг тогтвортой сайн бүрдүүлсэн оронд дараах асуудлуудыг тодорхой болгосон байдаг байна. Үүнд:

- Сайн дурын ажлыг тодорхой болгосон заалтууд.
- Байгууллагуудад сайн дурын ажлын талаар мэдээлэх үүрэг хүлээлгэсэн байдал: тухайлбал: сайн дурын ажил гэж юу болох тодорхойлолт, сайн дурынхны нийгмийн зорилго, хууль эрх зүйн статус болон хамрагдаж болох даатгалууд, санхүүжилтийн боломж гэх зэргийн мэдээллийг хүргэх үүрэгтэй.
- Сайн дурынхны үүрэг болон зохион байгуулалт.
- Сайн дурынхны хамрагдах ёстой даатгалууд.
- Хөдөлмөрийн хуулийн зохицуулалтын холбогдох заалтууд.
- Сайн дурынханд хуулиар зөвшөөрөгдсөн эрхүүд: тухайлбал сайн дурын ажлын үед гаргасан зардлыг нөхөн төлөх зохицуулалт..
- Онцгой нөхцөлүүд: ажилгүй, тэтгэвэрт гарсан, нийгмийн халамж авдаг хүмүүс, ахмадын асрамжийн газарт амьдардаг ахмад настнууд гэх мэт сайн дурынханд үзүүлэх хөнгөлөлтүүд гэх мэт асуудлууд орно.

Монгол Улсын хувьд Үндсэн хуульд “Эх орондоо хүмүүнлэг, иргэний, ардчилсан нийгэм цогцлуулан хөгжүүлэхийг эрхэм зорилго болгоно”¹⁰⁸ гэж иргэний нийгмийн үндэс болсон хувь хүний үндсэн эрх (нийгмийн болон өөрсдийн ашиг сонирхол, үзэл бодлын үүднээс нам, олон нийтийн бусад байгууллага байгуулах, сайн дураараа эвлэлдэн нэгдэх эрх) -ийг төрөөс дээгүүр, түүний эрх мэдлийг хязгаарлах хүчин чадалтай дээд хэм хэмжээ болгож тусгасан.

Иргэдийн энэхүү үндсэн эрхийг хэрэгжүүлэх эрх зүйн орчныг бүрдүүлэх үүднээс УИХ-аас 1997 онд Төрийн бус байгууллагын тухай хуулийг батлан гаргасан. Энэхүү хууль нь хэдийгээр иргэдийн эвлэлдэн нэгдэх эрхийг хэрэгжүүлэх зорилгоор батлагдсан боловч тус хуулийн бүтцээс үзэхэд төрийн бус байгууллага байгуулах, татан буулгах болон түүний дотоод бүтэц зохион байгуулалттай холбоотой асуудлыг хамгийн ерөнхий байдлаар зохицуулсан шинжтэй, өөрөөр хэлбэл иргэний нийгмийн үйл ажиллагааг зохицуулах, дэмжих тухайд зохицуулалт байхгүй, харин зөвхөн байгууллага талаас нь тодорхойлсон хууль болсон. Иймд төрийн бус байгууллагын тухай хууль тогтоомжийг иргэний байгууллыг хөгжүүлэх,

¹⁰⁸ Монгол Улсын Үндсэн хууль. Оршил хэсэг. “Төрийн мэдээлэл” эмхэтгэл. №01.1992.

түүний хөгжлийг дэмжсэн үзэл баримтлалаар өөрчлөх шаардлага чухлаар тавигдаж байна гэсэн дүгнэлтийг хууль зүйн хүрээлэнгийн судалгаанд¹⁰⁹ хийсэн байна.

Мөн судалгаанд сайн дурын үйл ажиллагааны эрх зүйн орчны хувьд:

- Үндэсний бодлого, стратеги, эрх зүй, санхүүгийн орчин хангалттай хэмжээнд бүрдээгүй,

- Засгийн газарт сайн дурын үйл ажиллагааг хөгжүүлэх асуудлыг хариуцсан бүтэц байхгүй,

- Сайн дурынхныг хүлээн авах байгууллагуудыг сайн дурынхантай холбох, сайн дурын үйл ажиллагаанд оролцох боломжийн талаар мэдээлэл түгээх чиг үүрэг бүхий үндэсний хэмжээний төв, зохицуулагч байгууллага бий болоогүй,

- Олон улсын туршлагаар сайн дурын үйлсийг бодлогоор дэмжлэг үзүүлдэг хууль тогтоомжуудаас нийгмийн даатгал, татвар, иргэний хариуцлага, гадаадын иргэдийн эрх зүйн байдал, хөдөлмөрийн зэрэг хууль шийдвэрлэх ач холбогдолтой байдаг атал манайд зөвхөн “төрийн бус байгууллагаас төрийн зорилгыг хэрэгжүүлэх ажлын хүрээнд эрхлэх нийтэд тустай үйл ажиллагаа” болон төрийн байгууллага ба төрийн бус байгууллага хоорондын хамтын ажиллагаа; төрийн бус байгууллагад “Нийтэд тустай байгууллага”-ын статус олгох зарчим болон “Нийтэд тустай байгууллагын үйл ажиллагаа; Нийтэд тустай ажиллагаа дахь төрийн удирдлага; Нийтэд тустай үйл ажиллагааны Хороо, түүний үйл ажиллагаа гэсэн үндсэн асуудлуудыг зохицуулсан болохыг онцлон тэмдэглэсэн байна.

Монгол Улсын хууль тогтоомжийг 2020 он хүртэл боловсронгуй болгох үндсэн чиглэлд¹¹⁰ ТББ-тай холбоотой эрх зүйн цогц шинэчлэл нэн шаардлагатайг харгалзан “Төрд хяналт тавихад төрийн бус байгууллагын хараат бус байдал, тэгш оролцоо, зөвшилцлийг хангах замаар иргэний нийгмийн төлөвшлийг дэмжих эрх зүйн орчныг боловсронгуй болгох”¹¹¹, Нийтэд тустай үйл ажиллагаа, түүнд дэмжлэг үзүүлэхтэй холбогдсон харилцааг зохицуулах замаар иргэдийн эвлэлдэн нэгдэх эрхийг дэмжихийн зэрэгцээ нийтийн сайн сайхны төлөө явуулж байгаа үйл ажиллагааны ач

¹⁰⁹ “Нийтэд тустай үйл ажиллагаа, сайн дурын үйл ажиллагааны үр нөлөөтэй эрх зүйн зохицуулалт” судалгаа. Хууль зүйн үндэсний төв. 2013

¹¹⁰ Монгол Улсын хууль тогтоомжийг 2020 он хүртэл боловсронгуй болгох үндсэн чиглэл 136 дахь зорилт.

¹¹¹ Монгол Улсын Их хурлын 2017 оны 01 дүгээр сарын 11- ний өдрийн 11 дүгээр тогтоол

холбогдлыг иргэдэд таниулах, энэ үзэл санаа, соёлыг нийгэмд төлөвшүүлэх, төрийн зүгээс үзүүлэх дэмжлэгийн төрөл, хэлбэрийг тодорхойлох”¹¹², төрийн зарим чиг үүргийг иргэний нийгмийн байгууллага, мэргэжлийн холбоодоор гүйцэтгүүлэх бодлогыг хэрэгжүүлэх эрх зүйн орчин бүрдүүлэх”¹¹³ зорилтыг дэвшүүлсэн байна.

Дээрх зорилтыг хангахын тулд Төрийн бус байгууллагын тухай хуулийг шинэчлэхээс гадна Нийтэд тустай үйл ажиллагааны тухай, Төрийн зарим чиг үүргийг гэрээгээр гүйцэтгүүлэх тухай хуулиуд боловсруулахаар төлөвлөснийг нэгтгэн Ашгийн төлөө бус хуулийн этгээдийн тухай хуулийн төслийг Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2017 оны 10 дугаар сарын 12-ны өдрийн А/257 дугаар тушаалаар байгуулсан ажлын хэсэг боловсруулсан байна. Ажлын хэсгийн нийт гишүүдийн 40 хувь нь төрийн бус байгууллагын төлөөлөл байсан байна. Гэсэн хэдий ч энэхүү хуулийн төсөлд сайн дурын ажилтны эрх, үүрэг, сайн дурын үйл ажиллагааны зохицуулалт бүрэн тусах нөхцөл бүрдээгүй байна.

Тиймээс 2018 онд УИХ-ын гишүүн Д.Оюунхорол Сайн дурын үйл ажиллагааг дэмжих тухай хуулийг санаачлан төсөл боловсруулсан байна.

Энэхүү хуулийн зорилго нь тогтвортой хөгжил, хүний эрх, энх тайван, аюулгүй байдлын үндэсний болон орон нутгийн бодлого төлөвлөлт, хэрэгжилтэд иргэний нийгмийн болон сайн дурын үйл ажиллагааг дэмжих, олон нийтэд түгээн дэлгэрүүлэх, сайн дурын үйл ажиллагаатай холбоотой харилцааг зохицуулахад оршихоор тодорхойлогдсон байна.

Энэ нь бидний өмнө санал болгож буй засаглалын бодлогыг сайжруулах асуудлууд болон эрх зүйн орчныг боловсронгуй болгох чиглэлтэй нийцэж байна. Тиймээс бид энэхүү хуулийн төслийг сайжруулах чиглэлээр санал боловсрууллаа. Саналыг өмнөх төслийн холбогдох зүйл, заалтуудын хувьд томъёолон, үндэслэл, тайлбар гаргалгааг хийлээ. Үүнд:

1 УИХ-ын гишүүн асан Д.Оюунхоролын 2018 онд санаачлан боловсруулсан “Сайн дурын үйл ажиллагааг дэмжих тухай” хуулийн төслийн зорилго нь тогтвортой хөгжил, хүний эрх, энх тайван, аюулгүй байдлын үндэсний болон орон нутгийн бодлого төлөвлөлт, хэрэгжилтэд иргэний нийгмийн болон сайн дурын үйл ажиллагааг дэмжих, олон нийтэд

¹¹² Монгол Улсын Их хурлын 2017 оны 01 дүгээр сарын 11- ний өдрийн 11 дүгээр тогтоол, 143 дахь зорилт.

¹¹³ Мөн тэнд. 137 дахь зорилт.

түгээн дэлгэрүүлэх, сайн дурын үйл ажиллагаатай холбоотой харилцааг зохицуулахад оршихоор тодорхойлогдсон нь бидний өмнө санал болгож буй засаглалын бодлогыг сайжруулах асуудлууд болон эрх зүйн орчныг боловсронгуй болгох чиглэлтэй нийцэж байна.

2 Бид өөрсдийн судалгааны үр дүнд тулгуурлан дээрх хуулийн төслийг сайжруулах чиглэлээр санал боловсрууллаа. Чингэхдээ Хуулийн 2 дугаар зүйл. *Сайн дурын үйл ажиллагааг дэмжих тухай хууль тогтоомж гэсэн зүйлийн 2.1 заалтад “Гамшигаас хамгаалах тухай хууль” гэж нэмж оруулах.* 3.1. Энэ хуульд хэрэглэсэн дараах нэр томъёог дор дурдсан утгаар ойлгоно гэсэнд 3.1.1-ыг гамшигаас хамгаалах үйл ажиллагаа гэсэн ойлголтоор өргөтгөн найруулах ба 3.1.4 заалтыг өөрчлөн томъёолох нэмэлт оруулах: 4 дүгээр зүйл. *Сайн дурын үйл ажиллагааны зарчим гэсэнд 4.1.9, 4.1.10 нэмэлт оруулах:* 9 дүгээр зүйл. *Сайн дурын ажилтны эрх, үүрэг: Сайн дурын ажилтан дараах эрхийг эдэлнэ гэсэн заалтад 9.1.9, 9.1.10, 9.1.11, 9.1.12, 9.1.13, 9.1.14 нэмэлт оруулах:* 9.2. *Сайн дурын ажилтан дараах үүрэг хүлээнэ гэсэн заалтад 9.2.6, 9.2.7, 9.2.8, 9.2.9, 9.2.10, 9.2.11 нэмэлт оруулах:* 10 дугаар зүйл. *Сайн дурын үйл ажиллагаа зохион байгуулагчийн эрх, үүрэг гэсэн зүйлд 10.9, 10.10, 10.11, 10.12 нэмэлт заалт оруулах саналыг судалгааны үндсэн дээр боловсрууллаа. (Хавсралтад үзүүлэв.)*

3.2 Гамшгаас хамгаалахад сайн дурынхны үйл ажиллагааны оролцоог нэмэгдүүлэх зарим арга зам

Гамшгаас хамгаалахад сайн дурынхны үйл ажиллагааны оролцоог нэмэгдүүлэхэд тулгамдаж буй асуудал, цаашид хүрэхээр зорьж буй зорилго, хэрэгжүүлэх стратеги, үр дүнгийн үзүүлэлтийг SWOT шинжилгээ ашиглан тодорхойлох замаар тухайн салбарт 10-аас дээш жил ажилласан мэргэжилтэн, судлаачдын оролцоотойгоор гамшгаас хамгаалах үйл ажиллагааны дотоод хүчин зүйлсийн давуу тал (Strength) ба сул тал (Weakness), гадаад хүчин зүйлсийн боломж (Opportunities), ба аюул (Threats) жагсаалтыг матрицаар нэгтгэн гаргах замаар гүйцэтгэнэ. Хоёрдугаар бүлэгт Гамшгаас хамгаалахад сайн дурынхны оролцооны өнөөгийн байдалд хийсэн замын шинжилгээний боловсруулалтаас сайн дурын идэвхтний мэдлэг, ур чадвар нь сайн дурын идэвхтний оролцоо, ажлын гүйцэтгэлд нөлөөлөхөөр батлагдсан учраас хувьсагчдаас давуу тал, сайн дурын идэвхтний ажлын туршлага хуримтлагдсан байдлын хувьсагч нараас сул талын хүчин зүйлээр авч, нийт 12 хүчин зүйлийг сонгон авсан болно.

Гамшгаас хамгаалахад сайн дурынхны үйл ажиллагааны оролцоонд нөлөөлөх дотоод-6, гадаад-6 гол хүчин зүйлийн үзүүлэлтийг сонгож авав. (Хүснэгт 22)-д харуулав.

А.Дотоод хүчин зүйлс		Б.Гадаад хүчин зүйлс	
Давуу тал (S)	Сул тал (W)	Таатай нөхцөл (O)	Таагүй нөхцөл (T)
I. Гамшгаас хамгаалах үйл ажиллагааны сайн дурынхны мэдлэг ур чадвар	IV. Гамшгаас хамгаалах үйл ажиллагаанд оролцох сайн дурынхны урамшуулал	I. Гамшгаас хамгаалах үйл ажиллагааны сайн дурынхны хамтын ажиллагаа	IV. Гамшгаас хамгаалах үйл ажиллагааны сайн дурынхны мэргэшүүлэх сургалт
II. Гамшгаас хамгаалах үйл ажиллагаанд оролцох сайн дурынхны хүсэл эрмэлзэл	V. Гамшгийн үйл ажиллагаанд сайн дурынхны оролцооны үед санхүү төсөв	II. Гамшгаас хамгаалах үйл ажиллагааны сайн дурынхны туршлага хуримтлагдсан байдал	V. Сайн дурынхны оролцооны үед гамшгийн үеийн хөрөнгө, санхүүгийн дэмжлэг, хангалт
III. Сайн дурынхны гамшгаас хамгаалах үйл	VI. Гамшгийн үйл ажиллагаанд сайн дурынхны оролцооны эрх	III. Гамшгаас хамгаалах үйл ажиллагааны сайн дурынхны	VI. Сайн дурынхны оролцоог нэмэгдүүлэхэд

ажиллагаанд оролцох үеийн ёс зүйн хэм хэмжээ	зүйн зохицуулалт, түүний шинэчлэлт	оролцоог нэмэгдүүлэх шаардлага, хэрэгцээ	тохиолддог саад бэрхшээл
--	------------------------------------	--	--------------------------

Хүснэгт 22., Гамшгаас хамгаалах сайн дурынхны оролцооны шинжилгээ. Гадаад, дотоод хүчин зүйл. (давуу тал, сул тал)

Хүснэгт 22-д дотоод хүчин зүйлийн давуу талд – Гамшгаас хамгаалах үйл ажиллагааны сайн дурынхны мэдлэг ур чадвар, Гамшгаас хамгаалах үйл ажиллагаанд оролцох сайн дурынхны хүсэл эрмэлзэл, Сайн дурынхны гамшгаас хамгаалах үйл ажиллагаанд оролцох үеийн ёс зүйн хэм хэмжээ, Сул талд; Гамшгаас хамгаалах үйл ажиллагаанд оролцох сайн дурынхны урамшуулал муу, Гамшгийн үйл ажиллагаанд сайн дурынхны оролцооны үед санхүү төсөв, Гамшгийн үйл ажиллагаанд сайн дурынхны оролцооны эрх зүйн зохицуулалт, түүний шинэчлэлт гэсэн үзүүлэлтүүдийг сонгож авсан байна. Харин гадаад хүчин зүйлийн таатай нөхцөлөөр – Гамшгаас хамгаалах үйл ажиллагааны сайн дурынхны хамтын ажиллагаа, Гамшгаас хамгаалах үйл ажиллагааны сайн дурынхны туршлага хуримтлагдсан байдал, Гамшгаас хамгаалах үйл ажиллагааны сайн дурынхны оролцоог нэмэгдүүлэх шаардлага, хэрэгцээ таагүй нөхцөлийг илэрхийлэхээр Гамшгаас хамгаалах үйл ажиллагааны сайн дурынхны мэргэшүүлэх сургалт, Сайн дурынхны оролцооны үед гамшгийн үеийн хөрөнгө, санхүүгийн дэмжлэг, хангалт, Сайн дурынхны оролцоог нэмэгдүүлэхэд тохиолддог саад бэрхшээл гэсэн үзүүлэлтийг тус тус сонгож авсан.

Гамшгаас хамгаалах сайн дурын үйл ажиллагаанд нөлөөлөх гадаад, дотоод орчны хүчин зүйлийн үзүүлэлтүүдийг үнэлэх

Дээр сонгож авсан дотоод, гадаад хүчин зүйлийн үзүүлэлтийг туршлагатай, экспертүүдээр үнэлүүлж, үнэлгээний матрицыг доорх томъёогоор тооцож дотоод, гадаад хүчин зүйлийн нийцтэй байдлын харьцааг тодорхойлж хүснэгтээр харуулав.

Хүчин зүйлийн үнэлгээний матрицыг $(A) = \begin{pmatrix} 1 & a_{1,2} & \dots & a_{1,n} \\ a_{2,1} & 1 & \dots & a_{2,n} \\ \dots & \dots & \dots & \dots \\ a_{n,1} & a_{n,2} & \dots & 1 \end{pmatrix}$ гэж

ТЭМДЭГЛЭВЭЛ: $CR = \frac{CI}{RI}$; $CI = \frac{L_{max} - n}{n - 1}$; $L_{max} = \sum_i \left(\frac{PA_i}{PV_i} \right)$; $PV_i = \sum_j \left(\frac{a_{i,j}}{a_{j,i}} \right)$;

$$PA_i = \sum_j (a_{i,j} \cdot PV_j); \quad (i = 1 \div n); \text{ томъёогоор тооцно.}$$

PV	0.178	0.21	0.268	0.155	0.067	0.123			
№	I	II	III	IV	V	VI	PV	PA	PA/PV
I	1	0.8	0.8	1.5	3	1	0.1778	1.0918	6.1391
II	1	1	1	1.3	4	1.3	0.2096	1.2934	6.1703
III	1.33	1	1	1.3	4	4	0.2677	1.6816	6.2829
IV	0.67	0.75	0.8	1	3	1	0.1546	0.9552	6.1783
V	0.33	0.25	0.3	0.3	1	1	0.0669	0.4204	6.2829
VI	1	0.75	0.3	1	1	1	0.1234	0.7469	6.0543
SUM	5.33	4.5	4	6.5	16	9.33	1	Lmax=	6.1846
								CI=	0.0369
								CR=	0.0298

Хүснэгт 23., Дотоод хүчин зүйлсийн үнэлгээний матриц

PV	0.19	0.218	0.127	0.165	0.175	0.126			
№	I	II	III	IV	V	VI	PV	PA	PA/PV
I	1	1.17	1	1.4	1	1.5	0.19	1.1652	6.1338
II	0.86	1	2	1.33	1.33	2	0.2175	1.3387	6.154
III	1	0.5	1	0.67	0.67	1	0.127	0.7779	6.1278
IV	0.71	0.75	1.5	1	1	1.5	0.1654	1.0176	6.1515
V	1	0.75	1.5	1	1	1.5	0.1745	1.0719	6.1421
VI	0.67	0.5	1	0.67	1	1	0.1256	0.7728	6.1524
SUM	5.24	4.67	8	6.07	6	8.5	1	Lmax=	6.1436
								CI=	0.0287
								CR=	0.0232

Хүснэгт 24., Гадаад хүчин зүйлсийн үнэлгээний матриц

Хүснэгт 23-д үзүүлсэн тооцооллын үр дүнгээс дүгнэлт хийхэд дотоод хүчин зүйлийг илэрхийлэх 6 чухал үзүүлэлтээс хамгийн их эерэг нөлөө үзүүлэх Сайн дурынхны гамшгаас хамгаалах үйл ажиллагаанд оролцох үеийн ёс зүйн хэм хэмжээ-26.7 хувь, Гамшгаас хамгаалах үйл ажиллагаанд оролцох сайн дурынхны хүсэл эрмэлзэл- 20.9 хувь, Гамшгаас хамгаалах үйл ажиллагааны сайн дурынхны мэдлэг ур чадвар- 17.7 хувь, сөрөг нөлөөтэй нь Гамшгаас хамгаалах үйл ажиллагаанд оролцох сайн дурынхны урамшуулал-15.4 хувь, Гамшгийн үйл ажиллагаанд сайн дурынхны оролцооны эрх зүйн зохицуулалт, түүний шинэчлэлт- 12.3 хувь,

Гамшгийн үйл ажиллагаанд сайн дурынхны оролцооны үед санхүү төсөв-6.7 хувь тус тус гарчээ.

Хүснэгт 24-д Гадаад 6 хүчин зүйлээс шийдвэрлэх эерэг нөлөө үзүүлэх нь Гамшгаас хамгаалах үйл ажиллагааны сайн дурынхны туршлага хуримтлагдсан байдал– 21.7 хувь, Гамшгаас хамгаалах үйл ажиллагааны сайн дурынхны хамтын ажиллагаа- 19.0 хувь, Гамшгаас хамгаалах үйл ажиллагааны сайн дурынхны оролцоог нэмэгдүүлэх шаардлага, хэрэгцээ- 12.7 хувь, сөрөг нөлөө үзүүлэх нь Сайн дурынхны оролцооны үед гамшгийн үеийн хөрөнгө, санхүүгийн дэмжлэг, хангалт- 17.4 хувь, Гамшгаас хамгаалах үйл ажиллагааны сайн дурынхны мэргэшүүлэх сургалт- 16.5 хувь, Сайн дурынхны оролцоог нэмэгдүүлэхэд тохиолддог саад бэрхшээл- 12.5 хувь гэж тус тус үнэлэгдсэн байна.

Хүчин зүйлийн нийцтэй байдлын харьцааны үнэлгээ $CR \leq 0.1$ байвал хүчин зүйлсийн сонголтыг хамгийн оновчтой байна гэж үздэг¹¹⁴ судлаачдын үнэлгээтэй харьцуулж үзэхэд бидний судалгаанаас дотоод хүчин зүйлийн нийцтэй байдлын харьцаа нь $CR=0.0298$, гадаад хүчин зүйлийнх $CR=0.0232$ гарсан тул хүчин зүйлийн сонголт оновчтой болох нь тогтоогдож байна.

Дээр сонгосон дотоод, гадаад хүчин зүйлийн шалгуур үзүүлэлтээр ач холбогдлын үнэлгээний онооны дээд үнэлгээг илэрхийлэв. Шалгуур үзүүлэлтийн суурь оноор 2020 оны гүйцэтгэлийг, ойрынх 2024 он, дунд хугацааны 2028 он, хэтийн 2032 оныг тус тус сонгож авав. Энэхүү хүчин зүйлийн шалгуур үзүүлэлтийн хамгийн их утгад харьцуулсан коэффициентын дундаж утгыг тодорхойлохдоо тухайн үзүүлэлтийн нөлөөллийн ач холбогдлын үнэлгээ ($PV - priority vector$)-гээр жинлэж дараах томъёогоор тооцож үр дүнгүүдийг хүснэгтээр харуулав.

Хамгийн их утгад харьцуулсан коэффициентын матрицыг

$$(B) = \begin{pmatrix} b_{1,1} & b_{1,2} & b_{1,3} & b_{1,4} \\ b_{2,1} & b_{2,2} & b_{2,3} & b_{2,4} \\ \dots & \dots & \dots & \dots \\ b_{n,1} & b_{n,2} & b_{n,3} & b_{n,4} \end{pmatrix} \text{ гэж тэмдэглэвэл}$$

$$\text{коэффициентын дунжийг } \bar{b}_j = \sum_i (b_{i,j} \cdot PV_i); \quad j = 1,4;$$

¹¹⁴Пүрэв Б, Бакей А, Нямбат Л, 2011

$$\text{Ерөнхий дунджийг } \bar{B} = \frac{\sum_j \bar{b}_j}{4},$$

Ерөнхий дунджаас холдсон хазайлтыг $IC(EC) = \bar{b}_j - \bar{B}; j = 144;$ томъёогоор тодорхойлж, график байгуулсан. Зураг 7-д Х тэнхлэгт дотоод хүчин зүйлийн давуу ба сул талуудыг, У тэнхлэгт гадаад хүчин зүйлийн таатай, таагүй нөхцөлийг тоон утгаар илэрхийлсэн.

	Нэгж	Мах	2020	2024	2028	2032
I.Гамшгаас хамгаалах үйл ажиллагааны сайн дурынхны мэдлэг ур чадвар	оноо	7	3	4	5	6
II.Гамшгаас хамгаалах үйл ажиллагаанд оролцох сайн дурынхны хүсэл эрмэлзэл	оноо	7	4	5	5.5	6
III.Сайн дурынхны гамшгаас хамгаалах үйл ажиллагаанд оролцох үеийн ёс зүйн хэм хэмжээ	оноо	7	4	5	5.5	6
IV.Гамшгаас хамгаалах үйл ажиллагаанд оролцох сайн дурынхны урамшуулал	оноо	7	2	3	4	4.5
V.Гамшгийн үйл ажиллагаанд сайн дурынхны оролцооны үед санхүү төсөв	оноо	7	1	2	3	3.5
VI.Гамшгийн үйл ажиллагаанд сайн дурынхны оролцооны эрх зүйн зохицуулалт, түүний шинэчлэлт	оноо	7	3	4	5	6

Хүснэгт 25., Дотоод хүчин зүйлийн үнэлгээний матриц (2020-2032 он)

	PV	2020/max	2024/max	2028/max	2032/max	
I	0.1778	0.4286	0.5714	0.7143	0.8571	
II	0.2096	0.5714	0.7143	0.7857	0.8571	
III	0.2677	0.5714	0.7143	0.7857	0.8571	
IV	0.1546	0.2857	0.4286	0.5714	0.6429	
V	0.0669	0.1429	0.2857	0.4286	0.5000	
VI	0.1234	0.4286	0.5714	0.7143	0.8571	
	Ж.дундаж	0.4555	0.5984	0.7072	0.8001	0.6403

	IC	-0.1848	-0.0419	0.0669	0.1598	
--	----	---------	---------	--------	--------	--


Хүснэгт 26., Хамгийн их утгад харьцуулсан коэффициент

	Нэгж	max	2020	2024	2028	2032
I. Гамшгаас хамгаалах үйл ажиллагааны сайн дурынхны хамтын ажиллагаа	оноо	7	3	3.5	4	5
II. Гамшгаас хамгаалах үйл ажиллагааны сайн дурынхны туршлага хуримтлагдсан байдал	оноо	7	4	4.5	5	5.5
III. Гамшгаас хамгаалах үйл ажиллагааны сайн дурынхны оролцоог нэмэгдүүлэх шаардлага, хэрэгцээ	оноо	7	2	6	4	5
IV. Гамшгаас хамгаалах үйл ажиллагааны сайн дурынхны мэргэшүүлэх сургалт	оноо	7	3	4	5	6
V. Сайн дурынхны оролцооны үед гамшгийн үеийн хөрөнгө, санхүүгийн дэмжлэг, хангалт	оноо	7	3	4	4.5	5
VI. Сайн дурынхны оролцоог нэмэгдүүлэхэд тохиолддог саад бэрхшээл	оноо	7	2	3	4	4.5

Хүснэгт 27., Гадаад хүчин зүйлийн үнэлгээний матриц (2020-2032он)

	PV	2020/max	2024/max	2028/max	2032/max	
I	0.1900	0.4286	0.5000	0.5714	0.7143	
II	0.2175	0.5714	0.6429	0.7143	0.7857	
III	0.1270	0.2857	0.8571	0.5714	0.7143	
IV	0.1654	0.4286	0.5714	0.7143	0.8571	
V	0.1745	0.4286	0.5714	0.6429	0.7143	
VI	0.1256	0.2857	0.4286	0.5714	0.6429	
	Ж.дундаж	0.4236	0.5917	0.6386	0.7445	0.5996
	EC	-0.1760	-0.0079	0.0390	0.1449	

Хүснэгт 28., Хамгийн их утгад харьцуулсан коэффициент



Зураг 7., Гаргал, дотоод хүчин зүйлийн үнэлгээ, үр дүнгийн график

Хүснэгтэд үзүүлсэн тооцооллын үр дүн болон график зураглалаас харахад эдгээр хүчин зүйлсийн үнэлэмж 2020 он х,у (-0.18,-0.17) гэсэн цэгийн огтлол дээр байна. Энэ нь гамшгаас хамгаалах үйл ажиллагаанд оролцогч сайн дурынхны хувьд хүчин зүйлийн эерэг нөлөөлөл сул, өөрөөр хэлбэл Гамшгаас хамгаалах үйл ажиллагаанд оролцох сайн дурынхны урамшуулал, Гамшгийн үйл ажиллагаанд сайн дурынхны оролцооны эрх зүйн зохицуулалт, түүний шинэчлэлт, Гамшгийн үйл ажиллагаанд сайн дурынхны оролцооны үед санхүү төсөв муу байна. Мөн Сайн дурынхны оролцоог нэмэгдүүлэхэд тохиолддог саад бэрхшээл, Сайн дурынхны оролцооны үед гамшгийн үеийн хөрөнгө, санхүүгийн дэмжлэг, хангалт, Гамшгаас хамгаалах үйл ажиллагааны сайн дурынхны мэргэшүүлэх сургалт дутмаг байгааг харуулж байна.

Дотоод хүчин зүйлийн өнөөгийн төлөв байдлын матрицаар Гамшгаас хамгаалах үйл ажиллагааны сайн дурынхны мэдлэг ур чадвар гэсэн хүчин зүйл 2020 оны байдлаар 3 баллын суурь үнэлгээтэй, нөлөөллийн ач холбогдлын үнэлгээ 0.1778; Гамшгаас хамгаалах үйл ажиллагаанд оролцох сайн дурынхны хүсэл эрмэлзэл 4 баллын суурь үнэлгээтэй, нөлөөллийн ач холбогдлын үнэлгээ 0.2096; Сайн дурынхны гамшгаас хамгаалах үйл ажиллагаанд оролцох үеийн ёс зүйн хэм хэмжээ 4 баллын суурь үнэлгээтэй, нөлөөллийн ач холбогдлын үнэлгээ 0.2677; дотоод хүчин зүйлийн сул тал болох Гамшгаас хамгаалах үйл ажиллагаанд оролцох сайн дурынхны урамшуулал гэсэн үзүүлэлт 2 баллын суурь

үнэлгээтэй, нөлөөллийн ач холбогдлын үнэлгээ 0.1546; . Гамшгийн үйл ажиллагаанд сайн дурынхны оролцооны үед санхүү төсөв 1 баллын суурь үнэлгээтэй, нөлөөллийн ач холбогдлын үнэлгээ 0.0669; Гамшгийн үйл ажиллагаанд сайн дурынхны оролцооны эрх зүйн зохицуулалт, түүний шинэчлэлт 3 баллын суурь үнэлгээтэй, нөлөөллийн ач холбогдлын үнэлгээ 0.1234 буюу нөлөөллийн суурь үнэлгээний нийлбэрийг томъёогоор тооцоолон үзэхэд нийлбэр (A)=1,0 гарч батлагдлаа.

Гадаад хүчин зүйлийн өнөөгийн төлөв байдлын матрицаас харахад Гамшгаас хамгаалах үйл ажиллагааны сайн дурынхны хамтын ажиллагаа гэсэн хүчин зүйл 2020 буюу суурь оны байдлаар 3 баллын суурь үнэлгээтэй, нөлөөллийн ач холбогдлын үнэлгээ 0.1900; Гамшгаас хамгаалах үйл ажиллагааны сайн дурынхны туршлага хуримтлагдсан байдал 4 баллын суурь үнэлгээтэй, нөлөөллийн ач холбогдлын үнэлгээ 0.2175; Гамшгаас хамгаалах үйл ажиллагааны сайн дурынхны оролцоог нэмэгдүүлэх шаардлага, хэрэгцээ 2 баллын суурь үнэлгээтэй, нөлөөллийн ач холбогдлын үнэлгээ 0.1270; гадаад хүчин зүйлийн аюул занал болох Гамшгаас хамгаалах үйл ажиллагааны сайн дурынхны мэргэшүүлэх сургалт гэсэн үзүүлэлт 3 баллын суурь үнэлгээтэй, нөлөөллийн ач холбогдлын үнэлгээ 0.1654; Сайн дурынхны оролцооны үед гамшгийн үеийн хөрөнгө, санхүүгийн дэмжлэг, хангалт гэсэн үзүүлэлт 3 баллын суурь үнэлгээтэй, нөлөөллийн ач холбогдлын үнэлгээ 0.1745 Сайн дурынхны оролцоог нэмэгдүүлэхэд тохиолддог саад бэрхшээл гэсэн үзүүлэлт 2 баллын суурь үнэлгээтэй, нөлөөллийн ач холбогдлын үнэлгээ 0.1256 буюу 12.5 хувь нөлөөллийн суурь үнэлгээний нийлбэрийг томъёогоор тооцоолон үзэхэд нийлбэр (A)=1.0 гарч батлагдлаа.

Монгол Улсын гамшгаас хамгаалах сайн дурын үйл ажиллагааны өнөөгийн төлөв байдалд нөлөөлж буй хүчин зүйлсийн өнөөгийн түвшнийг суурь он буюу 2020 оны байдлаар үнэлсэн үнэлгээнд тулгуурлан давуу тал болон боломжоо бүрэн ашиглах, сул тал болон таагүй нөхцөлөө дээд хэмжээгээр бууруулж чадах бодит нөхцөлөө тооцоолон үр дүнгийн боловсруулалт хийлээ. Ингэхдээ өнөөгийн төлөв байдлын түвшнийг 2024, 2028, 2032 онд нэмэгдүүлэх таамаглал, зорилт дэвшүүлэн, хүчин зүйлс тус бүрийг ямар нэгжээр ахиулах боломж байгааг тодорхойлох зорилт тавьсан. Гадаад дотоод хүчин зүйлд нөлөөлөх шалгуур үзүүлэлтүүдийн 2020 оны гүйцэтгэлийг авч, 2024 онд хүрэх түвшнийг ойрын, 2028 оны таамаглалыг

дунд хугацааны, 2032 оны таамаглалыг хэтийн төлөвлөгөө байхаар тус тус тооцлоо.

Монгол Улсын гамшгаас хамгаалах сайн дурын үйл ажиллагааны өнөөгийн төлөв байдлын судалгааны дүнд нөлөөлөх хүчин зүйлсийн нөлөөллийн үзүүлэлтүүдийг нэмэгдүүлснээр хүрч болох үр дүнг дараах байдлаар тодорхойлж байна. Үүнд:

- 2024 он хүртэл дотоод хүчин зүйлсийн үнэлгээг 0.7 нэгжээр, гадаад хүчин зүйлсийн үнэлгээг 1.1 нэгжээр нэмэгдүүлэхэд Монгол Улсын гамшгаас хамгаалах үйл ажиллагааны ерөнхий үнэлгээ 8.7 нэгжээр нэмэгдэж 68,9 хувь болно.

- 2024 – 2028 онд дотоод хүчин зүйлийн үнэлгээг 0.5 нэгжээр, гадаад хүчин зүйлийн үнэлгээг нэгжээр мөн 0.7 нэгжээр тус тус нэмэгдүүлэхэд Монгол Улсын гамшгаас хамгаалах үйл ажиллагааны ерөнхий үнэлгээ 10.0 нэгжээр нэмэгдэж 75.6 хувь болохоор байна.

- 2028 – 2032 онд дотоод хүчин зүйлийн үнэлгээг 0.7 нэгжээр, гадаад хүчин зүйлийн үнэлгээг 0.8 нэгжээр тус тус нэмэгдүүлэхэд Монгол Улсын гамшгаас хамгаалах үйл ажиллагааны ерөнхий үнэлгээ 11.2 нэгжээр нэмэгдэж 85.7 хувь болж Монгол Улсын гамшгаас хамгаалах үйл ажиллагаа хангалттай түвшинд хүрч сайжрах ерөнхий хандлага байж болох байна.

1. Дотоод хүчин зүйлсийн давуу тал болон гадаад хүчин зүйлсийн боломжийг ашиглан гамшгаас хамгаалах үйл ажиллагаа дахь сайн дурынхны оролцоог нэмэгдүүлэх боломжийг 2024 он хүртэл сайжруулах богино хугацааны стратегийн зорилтын хувьд:

- Гамшгаас хамгаалах үйл ажиллагааны сайн дурынхны хамтын ажиллагаа болон сайн дурынхны мэдлэг, ур чадварыг сайжруулахад тулгуурлан сайн дурынхны оролцоог нэмэгдүүлж, гамшгаас хамгаалах чадавхыг сайжруулах,
- Гамшгаас хамгаалах сайн дурынхны хүсэл эрмэлзэл, гамшгаас хамгаалах үйл ажиллагаанд сайн дурынхны оролцоог нэмэгдүүлэх хэрэгцээ, шаардлага дээр тулгуурлан сайн дурынхны эрх зүйн орчныг боловсронгуй болгох,
- Гамшгаас хамгаалах сайн дурынхны мэдлэг, ур чадварын дээшлүүлэлт, давуу нөхцөл дээр тулгуурлан сайн дурынхны менежментийг боловсронгуй болгох шаардлагыг хангах,
- Сайн дурынхны гамшгаас хамгаалах үйл ажиллагаанд оролцох үеийн ёс зүйн хэм хэмжээг сахих сайн дурынхны хамтын

ажиллагаатай уялдуулан сайн дурынхны нэр хүндийг өсгөх, нөлөөллийн ажлыг сайжруулах,

2. Дотоод хүчин зүйлийн давуу талыг ашиглан, гадаад хүчин зүйлсийн таагүй нөхцөлийг арилгах болон гадаад хүчин зүйлсийн боломжийг ашиглан дотоод хүчин зүйлсийн сул талыг арилгах замаар гамшгаас хамгаалах үйл ажиллагаанд сайн дурынхны оролцоог нэмэгдүүлэх 2028 он хүртэл хэрэгжүүлэх стратегийн зорилтын хувьд:

- Гамшгаас хамгаалах сайн дурынхны мэдлэг, ур чадварт тулгуурлан Олон Улсын болон бүс нутгийн, үндэсний болон орон нутгийн хэмжээнд гамшгаас урьдчилан сэргийлэх сургалт, сурталчилгааны ажилд түлхүү анхаарч, бүх талын түншлэл хамтын ажиллагааг өргөжүүлэн хөрөнгө, санхүүгийн асуудлыг шийдвэрлэж ажиллах,
- Гамшгаас хамгаалах ажилд сайн дурынхны оролцох хүсэл, эрмэлзэлд тулгуурлан төрөл бүрийн мэргэшүүлэх сургалтын агуулга, хөтөлбөрийг боловсронгуй болгож, практикт хэрэглэх,
- Гамшгаас хамгаалах үйл ажиллагаанд сайн дурынхны баримтлах ёс зүйн хэм хэмжээн дээр тулгуурлан сайн дурынхны оролцоог нэмэгдүүлэхэд тохиолддог саад бэрхшээлийг даван туулах арга замыг эрэлхийлж, төр, хувийн хэвшил, аж ахуйн нэгж байгууллагатай хамтран ажиллах
- Гамшгаас хамгаалах үйл ажиллагаа дахь сайн дурынхны хамтын ажиллагаа дээр тулгуурлан сайн дурынхны урамшууллын механизмыг боловсронгуй болгох,
- Гамшгаас хамгаалах үйл ажиллагаанд сайн дурынхны туршлага хуримтлуулсан байдалд үндэслэн санхүү, төсөвтэй холбоотой асуудлыг шийдвэрлэх,
- Гамшгаас хамгаалах үйл ажиллагаанд сайн дурынхны оролцоог нэмэгдүүлэх шаардлагад тулгуурлан эрх зүйн таатай орчин бүрдүүлэх.

3. Дотоод хүчин зүйлийн сул талыг арилгаж, гадаад хүчин зүйлийн аюулыг зайлуулах замаар 2032 он хүртэл урт хугацааны стратегийн хувь:

- Гамшгаас хамгаалах үйл ажиллагаанд оролцох оролцоо бүх нийтийн үйлс болсон байх
- Монгол дахь сайн дурын үйл ажиллагааны хууль эрх зүйн орчин, дэд бүтэц, үйл ажиллагааны чиглэл дундаас дээш түвшний улсуудын эгнээнд орсон байх.

- Гамшгаас хамгаалах сайн дурын үйл ажиллагааны түвшин Олон Улсын хэмжээнд хүлээн зөвшөөгдсөн байх.

Ийм стратегийг хэрэгжүүлэхэд бүх хүмүүсийн оролцоо хэрэгтэй. Ер нь олон улсын туршлагаас үзэхэд сайн дурынхны үйл ажиллагаа нь бараг бүх насны хүн ам, нийгэм, эдийн засгийн бүлгийг хамардаг. Үүний зэрэгцээ залуучуудын сайн дурынхны оролцоог сайн дурынхны хөдөлгөөнийг хөгжүүлэх үндсэн хүчин зүйл гэж нэрлэдэг. Залуу нас бол соёл, оюуны, нөхөн үржихүйн, нийгмийн аль ч улсын эдийн засгийн нөөц. Залуусыг сайн дурынхны нөөц гэж нэрлэгддэг энэхүү үйл ажиллагааг хэрэгжүүлэх гол төлөөлөгч гэж үздэг¹¹⁵.

Саяхныг хүртэл сайн дурынхны ажил хийх боломжийг дээд боловсролд бүрэн ашиглаж чадаагүй. Их сургуулийн хамгийн чухал чиг үүргүүдийн нэг бол ирээдүйн удирдагчид, ёс зүйтэй багийн тоглогчдыг бүрдүүлэх явдал гэдэгтэй олон хүн санал нэгдэнэ гэдэгт итгэлтэй байна. Дээд боловсролын хөтөлбөрийн чиг үүргийн нэг бол манлайлалд хувь нэмрээ оруулахад бэлэн, удирдлагын шийдвэр гаргахад бэлэн, нийтлэг ёс суртахууны зарчмуудыг удирдан чиглүүлдэг хариуцлагатай иргэдийг төлөвшүүлэх явдал юм.

Их сургуулийн туршлагын нэг хэсэг болох сайн дурынхны ажил нь бие даан шийдвэр гаргахад бэлэн байдлыг бүрдүүлдэг, манлайлах чанарыг хөгжүүлж, хувь хүний өсөлтөд чухал ач холбогдолтой, нийгмийн төлөвшилд тусалдаг.

Их сургуулийн түвшинд сайн дурынхны ажил нь оюутнуудын хичээлээс гадуурх бусад төрлийн үйл ажиллагаанаас илүү үнэ цэнэтэй, боломжит хувилбар мөн. Оюутан их сургуулийн үйл ажиллагаанд хэдий чинээ их цаг зарцуулж, энэ үйл ажиллагаанд илүү их хамрагдах тусам түүний оролцоо өндөр байдаг.

Олон улсын шинжлэх ухаан, практикийн янз бүрийн эх сурвалжийн¹¹⁶ судалгаанд үндэслэн энэхүү ойлголтыг дараахь тодорхойлолтыг өгч болно: “Их сургууль, ажилтнууд, оюутнууд, нийгмийн

¹¹⁵ Волонтерское движение в вузе: история, теория, практика : материалы международной научно-практической конференции, 1-3 июня 2012 г. / [отв. ред.: Е.В. Великанова]. – Тамбов : Издательство ТГУ, 2012. – 151 с

¹¹⁶ Adler, PA and Goggin, J. What Do We Mean By Civic Engagement? Journal of Transformative Education. No. 3. 2005. – P. 236-253.

харилцан ашигтай хамтын ажиллагаа, үйл явдалд үр өгөөжтэй оролцох замаар оюутны идэвхтэй суралцахад хувь нэмэр оруулах боломжтой” тодорхойлолт өгөгдсөн байдгийг тэмдэглэх нь зүйтэй юм.

Их, дээд сургууль, коллежид оюутны оролцоог судлах нь сүүлийн арван жилд түгээмэл болж байна: онолчид сургалтын чанар, үр дүн нь тухайн оюутан ямар үйл ажиллагаанд хэрхэн оролцсон, суралцахыг хэр сонирхож, хэрхэн суралцахаас хамаарна гэж дүгнэх хандлага ихсэж байна. Өнөөдөр оюутны оролцоо нь их сургуулийн зохистой, сэтгэл ханамжтай туршлагын гол үзүүлэлт гэж тооцогдож байна. Судлаачид оюутны нийгэмлэгтэй байх, жижиг бүлгүүдээр ажиллах, оюутнуудаар удирдуулсан төсөл хэрэгжүүлэх, сайн дурынхны үйл ажиллагаагаар суралцах, үндэсний болон олон улсын богино хугацааны санаачилгад оролцох зэргийг онцолсон байдаг. Сайн дурынхны ажилд их сургуулийн удирдлага, багш, оюутнууд, тэдний эцэг эх, аспирантууд, төгсөгчид хамтран оролцох нь боломжит чадварыг хөгжүүлэх, оюутны зан чанарыг хөгжүүлэх, санаачилга, хариуцлага, хөдөлмөрч байдлыг хөгжүүлэх үр дүнтэй арга юм. Ж.Брам, М.Рихонен нарын судалгаагаар их сургуулийнхаа дэмжлэгтэйгээр сайн дурынхны ажилтан болсон оюутнууд бие даан сайн дурынхны ажил хийдэг оюутнуудаас илүү их боломж олддог нь тогтоогджээ¹¹⁷.

Үндэсний аюулгүй байдлыг хангах үйл ажиллагааны “эх оронч үндэсний үзлийг дээдлэх” зарчмыг хэрэгжүүлэх замаар сайн дурынхныг бэлтгэхэд дээрх хандлага, өөрөөр хэлбэл сайн дурынхныг бэлтгэх боловсролын байгууллага, оюутны оролцоо маш чухал байна. Энэхүү зарчим нь “Монгол Улсын иргэн бүрийн үндэсний үнэт зүйлээрээ бахархагч, тэдгээрийг хайрлан хамгаалагч, тээн хөгжүүлэгч байх эх оронч үндэсний үзэл, улс үндэснийхээ ирээдүйн сайн сайхны төлөө хувь нэмрээ оруулахыг эрмэлзсэн идэвхтэй үйл ажиллагаа нь үндэсний аюулгүй байдлыг хангах бодлого, үйл ажиллагааны эх үндэс болно” гэсэн агуулгатай бөгөөд манай иргэдийн сайн дурынхны хөдөлгөөнөөр дамжин эх оронч үндэсний үзлээ дээдэлж байгаа байдлыг корона вирусын халдварын үеийн сайн дурынхны ажиллагаа ба бусад улсын туршлагаас харж болно.

¹¹⁷ . Braime, John & Ruohonen, Minna. Exploring Impacts of Volunteering on University Students in London. January 2011. URL: http://www.ncl.ac.uk/careers/assets/documents/student_volunteering_survey2011.pdf (дата обращения: 16.04.2015).

Манай улсын сайн дурынхны ажилтантай “ажиллах” тогтолцоо туйлын сул, Онцгой байдлын байгууллага, МУЗН-ээс л сайн дурынхны ажилтнуудыг цөөн тоогоор сургаж, бэлтгэхээс биш бодлогын хэмжээнд ач холбогдлыг ойлгодоггүй, тоодоггүй явж ирсэн. Үүний хамгийн том сургамжийг цар тахлын үеэр мэдэрсэн. Цаг наргүй цар тахалтай тэмцсэн эмч, эмнэлгийн ажилтнууд туйлдаж, олноороо халдвар тээгч болсон. Эмч нар эрсдэлд орсноор эрүүл мэндийн салбар ажиллах хүчний дутагдалд орж халдварын тархалт, нас баралт улам нэмэгдсэн. Ерөөс өвчтөнийг эмчлэх эмч нар байхгүй л бол хөрөнгө мөнгө байгаад нэмэргүй нь ойлгогдсон. Мөн хатуу хол хорионы үеэр иргэдэд хяналт тавьж буй онцгой, цагдаа гээд хүчний байгууллагынхан хүрэлцээ муутайгаас сонсогчдыг дайчлахаас аргагүйд хүрсэн. Хөл хорионы үеэр “мөрдөстэй” байгууллагын ажилчдыг цаг наргүй ажиллуулж байгаа ч хүрэлцээ муугаас үр дүн муутай байгааг нийтээрээ харж мэдэрсэн.

Хэрэв манай улс цар тахал дэгдсэн энэ онцгой цаг үед төр дангаараа хариуцаад хүч хүрэхгүй учраас сайн дурынхны хувь нэмрийг хүлээн зөвшөөрч, нийгмийн эрэлт хэрэгцээг хангахад төрийн чиг үүргийг нөхөн гүйцэтгэх, төрийн хүрч чадаагүй хэсэгт хүрч, үр дүнтэй үйлчлэх жишгийг дагаж гамшигтай тэмцэх “армидаа” сайн дурынхныг дайчилсан бол өнөөгийнх шиг олон мянган хүн халдвар тээж, иргэдийнхээ амь насыг дээсэн дөрөөн дээрээ аваачихгүй байлаа.

Гэтэл Тайландын тосгоны эрүүл мэндийн сайн дурынхны ажилтнууд цар тахалтай хийж буй тэмцэлд маш чухал үүрэг гүйцэтгэснээр халдварын тархалтыг богино хугацаанд хумьжээ. Эрүүл мэндийн ажилтнуудынхаа хүчийг нөөцөлж, иргэдэд хүрч ажиллахын тулд орон нутгийн иргэдийг татан оролцуулж, тосгоны эрүүл мэндийн сайн дурынхны ажилтнуудын хөтөлбөрийг санаачлан эхлүүлсэн байна. Тус улсад 1055000 орчим эрүүл мэндийн сайн дурынхны ажилтан байгаагийн 15 мянга гаруй нь нийслэл Бангкок хотод ажилласан. Сайн дурынхны ажилтан бүр 10 хүртэлх өрхийг хариуцаж, хатуу хөл хорионы үед иргэдийн орж, гарч байгаа хөдөлгөөнийг хяналтад байлгаж, тосгоны айл өрхүүдийг байнга эргэж тойрч, биеийн халууныг нь хэмжин, эмнэлгийн зөвлөгөө өгөхийн зэрэгцээ сэрэмжлүүлэг мэдээллийг түгээн тайлбарлах үүрэгтэй ажиллажээ. Зарим улс оронд эмнэлгийн түргэн тусламжийн машинаар халдвар авсан хүмүүсийг зөөхөд сайн дурынхныг дайчилж байгаа бол

ихэнх орон хүнсний багц тараах, түргэвчилсэн оношлуураар шинжилгээ авахад сайн дурынхны дэмжлэгийг авсан байдаг.

Их, дээд сургуулийг түшиглэсэн сайн дурынхны талаарх бодлогыг сайжруулах замаар гамшгаас хамгаалах үйл ажиллагааны дээрх стратегийн үр дүнд хүрэхийн тулд дараах арга хэмжээнүүдэд зайлшгүй ач холбогдол өгч, хэрэгжүүлэхийг санал болгож байна. Үүнд:

Нэгд. “Үндэсний аюулгүй байдлыг хангах нь төрийн анхдагч үүрэг бөгөөд иргэдээ аюулгүй байдлын асуудлаар өргөн мэдээлэл, мэдлэгтэй байх, аюулгүй байдлыг хангах үйл хэрэгт хувь нэмрээ оруулах боломжоор хангах хамтран ажиллахад төр онцгой анхаарна” гэсэн төр, иргэний хамтын ажиллагааны зарчмыг баримтлан дараах асуудлуудад бодлогоо чиглүүлэх шаардлагатай:

- Төр нь төрийн янз бүрийн бүтцээр дамжуулан сайн дурынхны үйл ажиллагааны талаар төрийн бодлогыг боловсруулж, хэрэгжүүлэх боломжтой. Чингэхдээ *нэгд*, сайн дурынхны байгууллагуудын төрөлжсөн холбоод нь аливаа нийтлэг зорилгод хүрэхийн тулд хүчин чармайлтаа нэгтгэж, харилцан ашигтай хамтын ажиллагааг хөгжүүлэх сонирхолтой байдаг тулгуурлах, *хоёрт*, зарим улс оронд амжилттай хэрэгжиж байгаа туршлагад үндэслэх. Тухайлбал, Казахстан дахь Сорос-Казахстан Сайн дурынхны Хаус; Их Британи дахь Сайн дурынхны үйл ажиллагааны үндэсний төв; Ирланд дахь сайн дурынхны үйл ажиллагааг хөгжүүлэх үндэсний агентлаг, ОХУ-ын Оросын 30 бүс нутгаас 50 гаруй төрөлжсөн сайн дурынхны төвүүдийг нэгтгэсэн Сайн дурынхны төвүүдийн холбоо (AVC) зэргийг нэрлэж болох байна.

- Сайн дурынхтай ажилладаг байгууллагуудын чадавхыг бэхжүүлэх таатай орчин бүрдүүлэхэд шаардлагатай дэд бүтцийг цогцоор нь хөгжүүлэх чиглэлийг 2012 онд тодорхойлсон талаар 2.2 дугаар зүйлд авч үзсэн, энэ хэрэгцээ шаардлага өнөөдөр ч хэвээр хадгалагдаж байна. Тухайлбал:

- Сайн дурынхны үйл ажиллагааны талаар нэгдмэл ойлголт болон үнэлэмжтэй болох. Сайн дурынхны үйлс болон түүний ач холбогдлын талаар нэгдмэл ойлголттой болохын тулд: *нэгд*, олон нийтийн хэлэлцүүлэг, ярилцлага өрнүүлэх, сайн дурынхны үйлсийг баримтжуулан түгээх, *хоёрт*, сайн дурынхны үйлсийн судалгаа, дүн шинжилгээ, загвар боловсруулах, шилдэг туршлагыг дэлгэрүүлэх (жишээ нь, сайн дурынхны үйлсийн иж бүрэн судалгаа шинжилгээ хийх, сайн дурынхны салбарын шинж байдлыг тодорхойлох, мэдээллийн сан бүрдүүлэх, сайн дурынхныхнаас нийгэм-

эдийн засгийн хөгжилд оруулсан хувь нэмрийг хэмжих гэх мэт), *гуравт*, сайн дурынхны үйлсийн ач холбогдлын талаар мэдээлэл түгээх.

- Улс орны нийгэм эдийн засгийн хөгжилтэй уялдсан сайн дурынхны үйлс, сайн дурынхныг дэмжсэн бодлоготой болох, эрх зүйн орчныг бүрдүүлэх. Эрх зүйн орчныг боловсронгуй болгохтой холбогдсон саналыг 2.1 дүгээр зүйлд боловсруулсан.

- Сайн дурынхныг зохицуулах үндэсний бүтцийг бүрдүүлэх. Үндэсний сайн дурынхны үйл ажиллагааг зохицуулах бүтцийг бүрдүүлэхийн тулд *нэгдүгээрт*, **үндэсний** төв ба орон нутгийн түвшний оролцогчид, иргэний нийгэм, сайн дурынхны байгууллагууд, сургалт, эрдэм шинжилгээний байгууллагууд, хэвлэл мэдээлэл, хувийн хэвшлийн байгууллагуудын хэн нь юу хийх ёстой вэ? гэдгийг тодруулах шаардлагатай, *хоёрдугаарт*, төрийн одоогийн бүтэц, механизмыг авч үзэхийн зэрэгцээ салбарууд дахь сайн дурынхны үйлсийг ямар байгууллага хариуцаж, хэрхэн зохицуулах вэ? гэдгийг шийдвэрлэх хэрэгтэй.

- Сайн дурынхны хөгжлийн төвүүдийг Улаанбаатар хот болон хөдөө орон нутгуудад байгуулах. Сайн дурынхны хөгжлийн үндэсний төвийг нийслэл хотод, харин бүсийн болон орон нутгийн төвүүдийг аймгийн төвүүдэд байгуулж болно. Эхлээд залуучуудын сайн дурынхны хөгжлийн төвийг байгуулан туршиж байгаад өргөжүүлж болох юм. Сайн дурынхны хөгжлийн төв нь: *нэгд*, сайн дурынхны үйл ажиллагааг дэмжих, сурталчлах, *хоёрт*, иргэний нийгэм, сайн дурынхны байгууллагуудын сүлжээ үүсгэх, *гуравт*, сайн дурынхны үйл ажиллагааны талаар мэдээлэл цуглуулах, түгээх, сургалт зохион байгуулах, *дөрөвт*, сайн дурынхныг захиалагч байгууллагуудыг сайн дурынхныхантай холбох үйлчилгээ явуулах зэргээр бодлого, хууль, тогтоомжуудыг хэрэгжүүлэх бүтэц болон ажиллах боломжтой.

- Сайн дурынхны нэгдсэн цахим хуудастай болох. Интернэтэд сайн дурынхны үйлсийн үндэсний цахим хуудас нээж сайн дурынхныг төрөл бүрийн салбарын сайн дурынхныхантай холбох, мэдээлэл, мэдлэгээр хангах суурь болгон ашиглах боломжтой.

- Сайн дурынхны үйлсийг сурталчлах. Энэ хүрээнд: 12 сарын 5-нд олон улсын сайн дурынхныхны өдрийг тэмдэглэх; сайн дурынхны үйлсийг хэвлэл мэдээллийн хэрэгслээр сурталчлах, сайн дурынхны үйлсийг сурталчлах талаар хэвлэл мэдээллийнхэнд сургалт зохион байгуулах; мэдээлэл сурталчилгааны аян зохион байгуулах; сайн дурынхны үйлсийг үндэсний сургалтын хөтөлбөрт суулгах; ЕБС-д сайн дурынхны талаар

сургалтын хөтөлбөр оруулах; олон орны төлөөлөгчдийг урьж оролцуулан "Сайн дурынхны үйлсийн дэлхий нийтийн чуулга" уулзалтыг эх орондоо зохион байгуулах; сайн дурынхны удирдлагын сургалт, чадавх бэхжүүлэх хөтөлбөр, сайн дурынхны үйлсийн онцгой жишээнүүдийн судалгаа, шилдэг туршлагын талаар мэдээлэл цуглуулах, чиглэл бүрийн сайн дурынхны оролцоотой байгууллага, сайн дурынхны ажиллагаанд оролцох боломжийн талаар мэдээллийн сан бүрдүүлэх; сайн дурынхны үйл ажиллагааны товхимол гаргаж хуулийн зохистой хэрэгжилтэд дэмжлэг үзүүлэх зэрэг арга хэмжээнүүдийг хэрэгжүүлэх хэрэгтэй юм..

- Сайн дурынхны нийтээр хүлээн зөвшөөрөгдсөн нийгмийн хандлага, өөрөөр хэлбэл, нийгмийн гурван салбарын загварт суурилдаг болохыг анхаарах нь зүйтэй юм. Үүнд: *эхний салбарт* төрийн бүтэц (олон нийтийн), *хоёрдугаарт* арилжааны аж ахуйн нэгж (бизнесийн салбар), *гурав дахь нь* ашгийн бус төрийн бус байгууллагууд (ТББ) байна. Эдгээрээс ТББ-ын үйл ажиллагаа нь сайн дурынхны тусламж үзүүлэх санаан дээр суурилдаг тул сайн дурынхны ажиллах нөхцөлийг бүрдүүлэхэд чухал ач холбогдолтой байна.

Хоёрт. “Монгол Улсын иргэн бүрийн үндэсний үнэт зүйлсээрээ бахархагч, тэдгээрийг хайрлан хамгаалагч, тээн хөгжүүлэгч байх эх оронч үндэсний үзэл, улс, үндэснийхээ ирээдүйн сайн сайхны төлөө хувь нэмрээ оруулахыг эрмэлзсэн идэвхтэй үйл ажиллагаа нь үндэсний аюулгүй байдлыг хангах бодлого, үйл ажиллагааны эх үндэс болно” гэсэн үндэсний аюулгүй байдлын үйл ажиллагааны “эх оронч үндэсний үзлийг дээдлэх” зарчмыг баримтлан сайн дурынхны үйл ажиллагаанд боловсролын салбарыг зохион байгуулалттайгаар хамруулахад бодлогоо чиглүүлэх:

- Их, дээд сургуулиудад сайн дурынхны үйл ажиллагааг зохион байгуулах санаачилгыг өрнүүлэх хэрэгтэй. Чингэхдээ сайн дурынхны үйл ажиллагааг зохион байгуулах санаачилга хоёр чиглэлтэй байж болохыг тооцож ажиллах. Үүнд: *нэгд*, санаачилга "Дээрээс" - их сургуулийн захиргаа, төрийн байгууллага эсвэл бизнесээс гарч болно. "Дээрээс" санал санаачилгыг олон нийтэд хүлээн зөвшөөрүүлэх асуудал тулгардаг тул санаачлагчид, тэдний үүсгэн байгуулсан сайн дурынхны байгууллагууд, сайн дурынхны үйл ажиллагааны үр дүнг мэдээлэх, онцлох, танилцуулах, оролцох сэдэл төрүүлэх чиглэлээр олон нийттэй хамтран ажиллах шаардлага гарна, *хоёрт*, санаачилга "Доороос" - залуучуудын төлөөлөгчдөөс гарч болно. "Доороос дээш" сайн дурынхныг бүрдүүлэхдээ

сайн дурынхны чадавхаар нийгмийн асуудлыг хамтран шийдвэрлэх үр дүнтэй механизмыг бий болгож, хөгжүүлэхийг чухалчлах хэрэгтэй. Оюутны сайн дурынхны үйл ажиллагаа янз бүрийн түвшний хяналттай байж болно. Тэдэнд дэмжлэг шаардагдана гэдгийг мартах ёсгүй. Их, дээд сургуулиудын хувьд оюутнуудыг сайн дурынхны ажилд татан оролцуулахаас гадна тэднийг авч үлдэх нь чухал бөгөөд үүнтэй холбогдуулан сайн дурынхныг "хадгалах" шаардлага тулгарна. Судлаачдын үзэж байгаагаар оюутны сайн дурынхны үйл ажиллагааны явцад захиргааны болон сурган хүмүүжүүлэх ажлын аргуудыг оюутны санаачилга, өөрийгөө зохион байгуулах, өөрийгөө удирдах механизмтай хослуулснаар хамгийн их үр дүнд хүрэх боломж байгааг анхаарах хэрэгтэй юм.

- Боловсролын байгууллагуудад сайн дурынхны үйл ажиллагааг хөгжүүлэх, түүнд залуучуудыг татан оролцуулах асуудлыг боловсролын салбарын шийдвэрлэх бодлого болгох нь сайн дурынхны хөгжлийг дэмжих, бидний өмнө төлөвлөсөн сайн дурынхныхан дээр тулгуурлан гамшгаас хамгаалах үйл ажиллагааг сайжруулах стратегийг хэрэгжүүлэх нэг чухал механизм болно. Чингэхдээ боловсролын бодлого, мэргэжлийн сургалт, түүнчлэн их сургуулийн бодлого, стратегид: *нэгд*, хүн амын янз бүрийн ангиллын хувьд орон нутгийн болон үндэсний түвшинд их сургуулийн таатай имижийг бий болгох; *хоёрт*, залуучуудын нийгмийн идэвхийг нэмэгдүүлэх замаар орон нутаг, улс орны нийгэм, эдийн засгийн хөгжлийг дэмжих; *гуравт*, нийгэмд тустай сайн дурынхны үйл ажиллагааг хөгжүүлэх чиглэлээр их сургуулиудад тавигдах орчин үеийн шаардлагыг олон улсын туршлага дээр үндэслэн бий болгох, дагаж мөрдөх; *дөрөвт*, хотын захиргаа, бизнесийн нийгэмлэг, олон нийттэй түншлэлийн хөтөлбөрүүдийг бий болгон хэрэгжүүлэх нь ач холбогдолтой арга хэмжээ байх болно.

- Сайн дурынхныхантай ажиллахад учирч болзошгүй саад бэрхшээлийг арилгахын тулд дэмжлэгийн бүхий л боломжит хэлбэрийг ашиглах шаардлагатай. Үүнд дараах хэлбэрүүдийг ашиглаж болох юм:

- янз бүрийн хэлбэрийн сургалт (сургалт, семинар, тусгай курс гэх мэт);
- байгууллагад цалинтай албан тушаалд ажилд орох боломж;
- шаардлагатай зардлыг нөхөн төлөх (унааны, хоолны гэх мэт);
- аюулгүй байдал (хөдөлмөр, амь нас, ослын даатгал гэх мэт);
- хөдөлмөрийг хүлээн зөвшөөрөх, орон нутагт нийгмийн харилцаанд имиж бүрдүүлэх;

- Албан бус нөхцөл байдалд амралт, багаар ажиллах зэрэг болно.

- Дэмжлэгийн бас нэг хэлбэр бол сайн дурынхны туршлагыг харгалзан үзэх явдал юм. Сайн дурынхны менежмент дэх ажил-үйлдвэрлэлийн системийн чухал хэсэг бол сайн дурынхны ажилтны ажлын чанар, үргэлжлэх хугацааны бүртгэл хөтлөх явдал юм. Орос улсын туршлагаас үзэхэд сайн дурынхны ажилтны үндсэн баримт бичиг болох сайн дурынхны ажилтны хувийн тэмдэглэл үүнд зориулагдсан байдаг байна. Энэ нь сайн дурынхны ажилтны "ажлын" туршлага, түүний урамшуулал, нэмэлт сургалтын талаарх мэдээллийг агуулсан; сайн дурынхны ажилтны бичгээр гаргасан өргөдөл, иргэний үнэмлэхийн үндсэн дээр олгосон, энэхүү баримт бичиг нь агуулгын хувьд ажлын "туршлага"-ыг харуулах бөгөөд сайн дурынхны томоохон төслүүдэд оролцох өргөн боломжийг нээж өгнө.

Гуравт. Сайн дурынхны хөдөлгөөнийг системтэй хөгжүүлэхэд юу саад болж байгааг авч үзэх зайлшгүй шаардлага тулгарахыг бидний өмнөх бүлэгт хийсэн судалгаа харуулсан билээ. Мөн авч үзэж буй үзэгдлийн олон талт шинж чанараас шалтгаалан бүх тулгамдсан асуудлын талаар бүрэн дүн шинжилгээ хийхэд маш төвөгтэй байх болно. Шинжилгээний объект нь их дээд сургууль, байгууллагад суурилсан ердийн сайн дурынхны байгууллагууд байх тохиолдолд тулгарч болзошгүй зарим бэрхшээлийг дараах байдлаар тодорхойлж болно. Байж болох хувилбарыг хүснэгтэд үзүүлээ.

Тулгамдсан асуудлын төрөл	Тулгамдсан асуудлын агуулга
Технологийн	- батлагдсан технологи, батлагдсан ажлын схем, олон нийттэй харилцах алгоритм дутмаг - ядрахаас урьдчилан сэргийлэх хөтөлбөр, сайн дурынхны ажилтныг хадгалах хөтөлбөр дутмаг
Боловсон хүчний	- сайн дурынхны штаб дахь захиргааны удирдлага ба удирдаж буй нэгжүүдийн хоорондын нарийн төвөгтэй, ойлгомжгүй харилцааны зөрчилдөөн үүсгэгч хүчин зүйл - байгууллага дахь удирдагчид болон сайн дурынхны бүлгүүдийн хооронд үүрэг хариуцлага, эрх мэдлийн хуваарилалт тодорхой бус байна. - сайн дурынхны дадлага хийх нөхцөл байдалд мэргэшсэн шийдвэр гаргах боловсон хүчний ур чадвар хангалтгүй, мэргэжилтэн дутагдалтай;
Зохион байгуулалтын	- гадаад орчны эргэх холбоон дээр үндэслэхгүйгээр зорилгоо тодорхойлох, шийдвэр гаргах хаалттай систем

	- дотоод болон гадаад орчны өөрчлөлтөд хурдан хариу үйлдэл үзүүлэх чадваргүй, зохион байгуулалтын бүтцийн уян хатан бус байдал
Харилцаа холбооны	- шаардлагатай мэдээлэл дутмаг, цаг тухайд нь мэдээлэл солилцох, үйл ажиллагааг хянах, хянах чадваргүй байх - ололт амжилтын тунхаглал хангалтгүй, хэвлэл мэдээллийн хэрэгслээр нэвтрэх асуудал, сайн дурынхны бүлгүүдийн үйл ажиллагааны сурталчилгаа дутмаг. - сайн дурынхны нийгэмлэгт хамтран ажиллагсадтайгаа зохисгүй өрсөлдөөн байгаа, мэргэжлийн ур чадвар дутмаг.
Урамшууллын	- анхны оролцооны дараа сайн дурынхны гадагш урсах, дахин оролцохыг хадгалах үйл явцад хүндрэл гардаг - нутгийн хүн амын урам зориг дутмаг, боломжит ивээн тэтгэгч эсвэл сайн дурынхны үйлчилгээний хэрэглэгчдийн сонирхолгүй байх - орон нутгийн удирдлагуудын дэмжлэг дутмаг, сайн дурынхны ажилд харилцан ашигтай тусламж үзүүлэх
Дасан зохицох	- ажилчдын шинэ нөхцөлд дасан зохицоход бэлэн бус байдал, хүсэл байхгүй байдал; - байгууллагын стратеги, зарчим, компанийн соёлын стандартыг ажилтнууд хүлээн зөвшөөрөхгүй байх

Хүснэгт 28., Сайн дурынхны байгууллагын үйл ажиллагааны тулгамдсан асуудлуудын төрөл, агуулгын байж болох хувилбар

Эдгээр бүх бэрхшээлтэй асуудал нь удирдлагын шинж чанартай, түүнээс хамааралтай байгаа тул сайн дурынхны үйлсийн удирдлагын тогтолцоог сайжруулах замаар шийдвэрлэх боломжтой.

Тулгамдсан асуудлуудыг шийдвэрлэсний үр дүнд боловсролын байгууллагуудад дараах боломж бий болно. Үүнд:

- Сайн дурынхны ажил хийснээр оюутнууд зорилтот бүлгүүдтэй их, дээд сургуулийн харилцааг хөгжүүлэхэд хувь нэмрээ оруулах боломжтой. Залуучууд, оюутнуудын сайн дурынхны үйл ажиллагаа сайн дурынхны байгууллагуудыг үр дүнтэй сурталчлахад хувь нэмрээ оруулж, шинэ оролцогчдод зөвлөгөө өгөх боломжтой¹¹⁸.

- Салбарын мэргэжилтнүүд сайн дурынхны ажлыг боловсролын үйл явцад нэвтрүүлэх санааг дэмждэг¹¹⁹ бөгөөд үүний зэрэгцээ оюутнуудын

¹¹⁸ Russell Commission 2005. A National Framework for Youth Action and Engagement. URL: http://vinspired.com/uploads/admin_assets/datas/146/original/Russell_Commission_summary.pdf (дата обращения 01.12.2015)

¹¹⁹ Социальная ответственность: вызовы времени»: студенческое волонтерство должно быть тесно связано с учебным процессом. URL: <https://www.asi.org.ru/news/uchastniki->

сайн дурынхны үйл ажиллагааг мэргэшүүлэх нь чухал бөгөөд ингэснээр нийгмийн үйл ажиллагаа нь залуучуудад мэргэжлийн ур чадвараа дээшлүүлэхэд туслах боломжтой болно.

- Мэргэжлийн ур чадвараа дээшлүүлэх байр суурьтай нийцэж байгаа оюутнуудыг сайн дурынхны үйл ажиллагаанд татан оролцуулах, янз бүрийн салбарын багш нарт ашиглах боломжтой болж, "үйлчилгээний сургалт" боловсролын арга зүй нэвтэрнэ. Үүний мөн чанар нь тухайн сэдвийг судлах бүх хугацаанд боловсролын үйл явцыг практиктай хослуулах боломж бүрдэж буй явдалд оршино.

- Сайн дурынхны ажилд суурилсан судалгааны практик нь их дээд сургуулиуд болон гаднын аж ахуйн нэгжүүдийн хамтын ажиллагааны харилцан ашиг тусыг нэмэгдүүлж, оюутны сурлагын амжилтад ихээхэн хувь нэмэр оруулна. Түүгээр ч зогсохгүй сургалтын үр дүнд амжилттай нөлөөлж буй сайн дурынхны хөтөлбөрүүд нь оюутнуудыг мэргэжлийн амьдралдаа сайн дурынхны үйлсийг үргэлжлүүлэхэд түлхэц болдог.

- Сайн дурынхны хөдөлгөөнд оюутнуудын идэвхтэй оролцох нь түүний мэргэжлийн хөгжлийн нэг хүчин зүйл төдийгүй орчин улсынхаа үндсэн үнэт зүйл, уламжлалыг өөртөө шингээх үйл явцын үндсэн хүчин зүйл болдог.

- Сайн дурынхны үйл ажиллагаа нь хариуцлагатай иргэн төлөвшүүлэх, идэвхтэй, бүтээлч зан чанарыг төлөвшүүлэх, тусламж хэрэгтэй байгаа хүмүүст туслах ерөнхий зорилтыг биелүүлэх үйл явцыг төлөвшүүлнэ. Сайн дурынхны үйл ажиллагааны эдгээр шинж чанарууд нь боловсролын тогтолцооны боловсролын үйл явцын зорилго, зорилтуудтай нягт холбоотой байдаг тул олон тооны сайн дурынхны нийгэмлэгүүд дээд боловсролын байгууллагуудын үндсэн дээр зохион байгуулагдах боломж нээгдэнэ.

- Сурган хүмүүжүүлэх үүднээс сайн дурынхны үйл ажиллагаа нь сэтгэлзүйн болон сурган хүмүүжүүлэх чухал чадамжтай бөгөөд энэ нь юуны түрүүнд боловсрол, хүмүүжлийн болон хөгжлийн чиг үүргийг хэрэгжүүлэхэд илэрнэ. Тиймээс оюутан залуучуудыг сайн дурынхны үйл ажиллагааг хөгжүүлэх “санаачилгын цөм” болгох, боловсролын байгууллагуудын үйл ажиллагааг зохицуулах хүрээнд сайн дурынхны үйл ажиллагааг хөгжүүлэх боломж бий болно үзэж байна.

Олон улсын туршлагаас үзэхэд сайн дурынхны ажилтнуудыг ажиллуулдаг бизнесүүд их сургуулийн оюутнуудыг цаг хугацаа, авьяас чадвар, урам зоригийн үнэ цэнтэй эх сурвалж гэж үздэг байна. Оюутан сайн дурынхны ажилтнууд эрчимтэй ажлын хугацаа эсвэл олон тооны туслах шаардлагатай төслүүдэд маш их тустай байж болдог байна. Хэрэглэгчид их дээд сургууль, коллежийн холбогдох хэлтэстэй холбоо барьснаар олон зуун сайн дурынхны ажилтнуудтай маш хурдан холбогдож болох бөгөөд энэ нь бусад сайн дурынхны нийгэмлэгтэй холбоо тогтооход тэр бүр боломжгүй байдаг ажээ. Зарим судлаачийн судалгаагаар оюутнуудын 40% нь янз бүрийн буяны болон сайн дурынхны төслүүдэд аль хэдийн хамрагдсан байдаг байна.¹²⁰

Гэсэн хэдий ч санаачилгыг хэрэгжүүлэх амжилт нь оюутнуудын сайн дурынхны нийгэмлэгийн оршин тогтнох зохион байгуулалтын талаас ихээхэн хамаардаг. Өнөө үед сайн дурынхны салбарын менежерүүдийн үүрэг бол залуучуудын хөдөлгөөнд оролцох оновчтой хэлбэрийг санал болгох явдал юм. Орчин үеийн шаардлагад нийцсэн менежментийн хэлбэрийг нэвтрүүлэх хэрэгцээ нь дээд боловсролын байгууллагын үйл ажиллагаа, түүнчлэн нийгмийн практикт байдаг. Яаралтай асуудлыг шийдвэрлэх нь багш нарын мэргэжлийн ур чадвар, боловсролын байгууллагуудын нөөц, оюутнуудын сайн дурынхны чадавхыг хослуулсан үр дүнтэй зохион байгуулалтын бүтцийг бий болгохоос бүрэн хамаарна. Ийм зохион байгуулалтын бүтцийн үүргийг боловсролын байгууллагуудад суурилсан сайн дурынхны төвүүд гүйцэтгэж болох юм..

Стратегийн төсөөллийн өнцгөөс харилцах бүлгийн хүрээлэлтэй байнгын харилцан ажиллагаанд байх сайн дурынхны байгууллагын гол хэрэгцээг ойлгох нь чухал юм.


Сайн дурынхны хүрээний түншлэл нь нийгмийн ач холбогдол бүхий үүргүүдийг шийдвэрлэхийн тулд сайн дурынхны хөдөлгөөний оролцогчдын богино болон урт хугацааны харилцан ажиллагааны хэлбэрүүдийн цогцыг өөртөө агуулж байдаг. Түншлэлийн холбоо болон төрийн дэмжлэгийн тусламжтайгаар сайн дурынхны байгууллагын ажиллагааны боловсон хүчний, материал-техникийн, норматив-эрх зүйн,

¹²⁰ Волонтерство и трудоустройство. URL:<http://career.ru/article/17929>(дата обращения 01.12.2015)

мэдээллийн хангалтыг багтаасан шаардлагатай дэд бүтцийн сүлжээ бий болно.

Сайн дурынхны санаачилгыг хэрэгжүүлэх нь зөвхөн сайн дурынхныхан, нийгэм, төр ба бизнесийн өөрсдийнх нь ухамсартай, сайн дурынхны, сонирхсон оролцооны үед тогтвортой байж чадна. Үүнтэй холбоотойгоор сайн дурынхны төслийн хүрээнд салбар дундын харилцан ажиллагааны механизмуудыг авч үзэж байх шаардлагатай юм.

Судалгааны ажилдаа сайн дурынхны ажиллагааг явуулахад суурь болох орчны ойлголтын санал болгож буй зураглалыг зураг дээр үзүүлээ.




Зураг 8. Сайн дурынхны үйл ажиллагааг удирдах, хамтын ажиллагааны бүдүүвч

Зураг 8 дээр үзүүлсэн бүдүүвчээс Их, дээд сургуулийн сайн дурынхны байгууллагын удирдлагын хамтын ажиллагааны олон талт харилцаа нь дээд боловсролын байгууллагаар дамжуулан Сайн дурынхны үйл ажиллагааг зохицуулах байгууллага болон Орон нутгийн захиргаа, залуучуудын байгууллагатай бодлого, үйл ажиллагаагаа уялдуулахын зэрэгцээ ивээн тэтгэгч түншүүдтэй шууд хамтран ажиллах шаардлагатай хариу болно. Түүнчлэн сайн дурынхны үйл ажиллагаа /төсөл/-аар дамжуулан Сайн дурынхны үйлчилгээ хүртэгсдэд үйлчилгээ үзүүлж, тэдний сэтгэл ханамжийн байдалтай эргэх холбоогоор холбогдоно. Мөн явуулж буй сайн дурынхны үйл ажиллагаа нь Орон нутгийн нийгэмлэгт дэмжлэг болохын зэрэгцээ Нийгэмд чиглэсэн төрийн бус байгууллагатай харилцан ажиллах механизм болно.

Судалгааны үр дүнд үндэслэн сайн дурынхны хөдөлгөөнийг зохион байгуулагчид болон оролцогчдын хоорондын харилцаа холбоог бэхжүүлэх нь сайн дурынхны салбарын хөгжлийн асуудлыг шийдвэрлэхэд нэн тэргүүний зорилт гэж үзэж байна.

Их сургуулийн зохион байгуулалттай сайн дурынхны үйл ажиллагаанд хамтын ажиллагааны харилцан үйлчлэлийн загварыг ашигласнаар бүх талуудын ашиг сонирхлыг зохицуулах боломжтой юм. Бидний санал болгож буй концепцийн загвар нь М.Шерийн оновчтой түншлэлийн загвар¹²¹ -ийн Монгол Улсын их дээд сургуулиудын орчин үеийн сайн дурынхны хөдөлгөөнд чиглэсэн төсөөлөл юм (Зураг 8). Уг загварыг сайн дурынхны санаачилгыг удирдах чухал арга гэж үзэж байна. Урьдчилан тодорхойлсон үүрэг, үйлдэл, хүлээлттэй ажиллахын оронд энэ загвар нь сайн дурынхны үйлчилгээ үзүүлэхэд хэн оролцох, оролцогчдын бүлэг тус бүр ямар үүрэг гүйцэтгэхийг тодорхойлохын тулд тухайн нөхцөл байдлын өвөрмөц нөхцөл байдлыг харгалзан үздэг. Сайн дурынхны менежерүүд бодлого, хөтөлбөр боловсруулахдаа бүх нөлөөлөх хүчин зүйлс болон голлох харилцах бүлгүүдийн санаа бодлыг ойлгосны үр дүнд шийдвэр гаргах хамгийн бодитой мэдээллийг ашиглах боломжийг олгох уян хатан байр суурь баримтлах ёстой.

¹²¹ Sherr, Michael E. (2008) Social Work With Volunteers. Baylor University. –P. 93-104



Зураг 9., Сайн дурынхны үйл ажиллагааны оролцоо, түншлэлийн загвар

Санал болгож буй загвар хоёр үндсэн бүрэлдэхүүн хэсгээс бүрдэнэ: *нэгд*, нөхцөл байдлыг үнэлэх журам, *хоёрт*, түншлэлийн оновчтой хэлбэрт хүрэх цаашдын зам юм

Загварын эхний хэсэг болох контекстийн үнэлгээ нь нөхцөл байдлын тохиргоог тодорхойлдог зохион байгуулалт, соёл, нийгэм, эдийн засгийн хүчин зүйлсийг ойлгохын тулд гадаад, дотоод олон эх сурвалжаас мэдээлэл цуглуулах цогц үйл явц юм. Үүнд нийгмийн тулгамдсан асуудлыг тодорхойлох, газарзүйн болон хүн ам зүйн нөхцөл байдлыг тодорхойлох, улс төрийн уур амьсгалыг үнэлэх, нийгмийн үйлчилгээний хүртээмжийг үнэлэх, сайн дурынхны нөөцийн хүртээмжийг үнэлэх зэрэг харилцан уялдаатай зургаан үе шат багтдаг.

Хоёр дахь бүрэлдэхүүн хэсэгт үнэлгээний үе шатыг дагаж оновчтой түншлэлийг бий болгохын тулд харилцан уялдаатай хэд хэдэн алхмуудыг хийхийг санал болгож байна:

- 1 хэн оролцох ёстойг тодорхойлох;

- 2 боломжит оролцогчдын ашиг сонирхлыг үнэлэх;
- 3 үндсэн зорилго, зорилтыг боловсруулах;
- 4 стратеги боловсруулах, хариуцах чиглэлийг тодорхойлох;
- 5 үйл ажиллагааны төлөвлөгөөг хэрэгжүүлэх;
- 6 хамтын ажиллагааны явцын болон дараах ахиц дэвшлийг үнэлэх.

Санал болгож буй загвар нийгмийн ажлын үндсэн практикт нийцэж байгаа боловч ялгаа нь удирдлагын үйл явцыг хэрэгжүүлэх хандлагад тодорхойлсонд оршиж байгаа болно. Энэхүү үзэл бодол нь сайн дурынхны төслүүдийг төлөвлөх, хэрэгжүүлэх явцад асуудлыг хэрхэн, хэн шийдвэрлэх ёстой талаар урьдчилж төсөөлж байсан ойлголтыг хойшлуулахыг дэмждэг.

Хамгийн оновчтой түншлэлийн харилцааны байгуулалт нь сайн дурынхны байгууллагуудад үүсэх: сайн дурынхныг оролцуулах ямар сувгийг илүүд үзэх вэ, шинэ **сайн** дурынхныханд ямар ур чадвар дутаж байна вэ, багийн гишүүдийг барьж байхын тулд хэрхэн холбоотой байх вэ зэрэг нийтлэг асуултуудын хариултыг өгөх эхний болон дараагийн байнгын мониторингийг багтаана. Янз бүрийн тохиолдлуудад үнэлгээ нь удирдах үүрэг болон туслах үүргийг тодорхой тохиолдол бүрийн хувьд хамгийн сайн загвараар хуваарилах тийм түншлэлийн ялгавартай төрлүүдэд хүргэж болно.

Эмпирик шинжилгээний үр дүнг харгалзан загварыг байгуулах ерөнхий чиглэлийг дараах зарчмаар тогтоов. Үүнд:

1 Интеграцийн зарчим: нэгтгэх нь бүх төрлийн удирдлагын болон холбооны ажиллагааг зохицуулах замаар байгууллагын дотоод бүтэц болон зохион байгуулах салбаруудын холбооны агуулгыг хөндөнө.

2 Өргөтгөх зарчим: Энэ зарчим нь түүнийг хялбаршуулсан эсвэл илүү төвөгтэй, олон талт агуулгат янз бүрийн масштабд авч үзэх боломжийг олгодог системийн шинж чанарыг ойлгоно;

3 Мэдээллийн хүрээнд мэдээллийн урсгалыг ил тод удирдахад үндэслэсэн ил тод байдлын зарчим: Нээлттэй байдал, үзэгчидтэй итгэлцсэн харилцан үйлчлэл нь төрийн бус байгууллагуудын үйл ажиллагаанд чухал ач холбогдолтой бөгөөд сонирхогч талуудад мэдээлэл хүртээмжтэй байх явдлыг хангах зарчим.

Загварын бүх түвшнийг практикт нэвтрүүлж, түүнд хуримтлагдсан чадавхыг хэрэгжүүлэх нь сайн дурынхны байгууллагын бүх төрлийн

удирдлага, харилцааны үйл ажиллагааг уялдуулах, харилцан тохиролцсон үйл ажиллагааг ирээдүйд бие даасан, зохицуулалтгүй байдлаас илүү үр дүнтэй харилцан үйлчлэлийн шугамууд. бий болгох замаар синергетик үр нөлөөг олж авах явдал юм.

Сайн дурынхны үйл ажиллагаанд талуудын ашиг сонирхлыг зохицуулах арга замын хувьд дараах саналыг дэвгүүлж байна. Үүнд:

I. Гадаад орчин. *Гадаад орчинтой харилцах байгууллагын үндсэн шинж чанарыг хөгжүүлэх.*

Сайн дурынхны байгууллагын хувьд тэмдэглэсэн орон зайд зохицуулсан нөлөөллийн үед нэг байдлаас нөгөө байдал руу шилжих шинж болох гаргасан шийдвэрт үнэнч байх, уян хатан дасан зохицох чадвар зэрэг хэд хэдэн шинжийг эзэмшиж байх нь чухал юм. Байгууллагуудын үйл ажиллагаа нь хувь хүмүүсийн үзэл бодлоор бус, харин аливаа байгууллагыг нэгтгэсэн институцийн орчинд тодорхойлогддог. Тиймээс зохимжтой үйл ажиллагааны хэм хэмжээг сайн дурынхны байгууллагуудын дотоодод бий болгодоггүй, харин анхлан гаднын төлөөлөгчид тогтоодог.

Байгууллагын зан үйлийг стандарт журмаас эхлээд гэрчилгээжүүлэх, төрийн бодлогод нийцүүлэх хүртэлх хууль ёсны элементүүдээр удирдах боломж бүрдэнэ. Эдгээр элементүүдийг нэвтрүүлэх нь байгууллагын оршин тогтнох чадварыг нэмэгдүүлнэ.

Түншүүд. *Янз бүрийн намуудын төлөөллийн уулзалтыг зохион байгуулж, замын зураглалыг бий болгоход түншүүдийн оролцоог хангах.* Энэ нь урьдчилан таамаглах, төлөвлөхөд учир дутагдалтай, логигоор үл нийцэх байдлыг тодорхойлох, эрсдэл, аюул заналыг тооцох, үзэл баримтлал, стратеги, хөгжлийн сценарыг боловсруулах боломжийг олгодог. Замын зураглалын арга нь хугацааны хэмжээсийг ашиглан зангилгаа цэгүүдээр төслийн удирдлагын төлөвлөгөөг бий болгоход оршино. Ийм уулзалтын үеэр харилцаа холбоог жигдэлж, бүсийн болон орон нутгийн гүйцэтгэх засаглалын төлөөлөгчидтэй харилцаа холбоо тогтоож, шинжээчдийн нийгэмлэгтэй харилцах үндэс суурийг бүрдүүлнэ.

Үйлчлүүлэгчид. *Сайн дурынхны тусламж авагчидтай хамтын ажиллагаа тогтоох.* Сайн дурынхны тусламж авагч нь тэдний ашиг сонирхолд сайн дурынхны үйл ажиллагаа хийгдэж байгаа хувь хүн эсвэл нийгмийн бүлэг юм. Тиймээс сайн дурынхны ажлыг тодорхой хүмүүст туслах болон байгууллага - хуулийн этгээдэд үнэ төлбөргүй үйлчилгээ

үзүүлэх гэж хуваах боломжтой байдаг. *Эхнийх* нь бие даасан хэрэглэгчид, нийгмийн тусламж шаардлагатай иргэд; *хоёрдугаарх* нь төрийн, хотын, ашгийн бус байгууллагууд юм. Үйлчилгээний үйлчлүүлэгчдийн хэрэгцээг хангахын тулд сайн дурынхны үйл ажиллагааг дүрэм журмын дагуу санал хүсэлтийг цуглуулж, дүн шинжилгээ хийж, нээлттэй тайлан бэлтгэх нь чухал. Ажлын алдаа дутагдлыг арилгахын тулд ашиг хүртэгчдийн сэтгэл ханамжийг судлах хэрэгтэй. Хэрэглэгчийн харилцааг хөгжүүлэх, хадгалах нь байгууллагын өсөлт, оршин тогтноход чухал ач холбогдолтой байна.

Сүүлийн үед сайн дурынхны байгууллага буюу ашгийн бус байгууллагуудын хувьд бусад төрлийн бизнесийн нэгэн адил зорилгод чиглэсэн харилцагчийн харилцааны менежментийн ач холбогдол чухал болохыг судлаачид онцолж байна. Үүний зэрэгцээ, онолчид арилжааны салбарын технологийг ТББ-уудын хэрэгцээнд нийцүүлэн өөрчлөхөд хүндрэлтэй байдгийг хүлээн зөвшөөрдөг. Тиймээс бид хурдан хөгжиж буй сайн дурынхны салбарт ашиглах менежментийн туршлагын хувьд хэрэглэгчийн харилцааны менежментийн системийн талаар ярих боломжтой байж болох юм.

Хэрэглэгчийн харилцааны менежмент систем нь өргөн утгаараа бүх философийн төв нь үйлчлүүлэгч гэсэн үндсэн дээр байгууллагын одоогийн болон боломжит үйлчлүүлэгчидтэй харилцах харилцааг зохицуулах арга барил юм. Энэхүү хандлага нь үйлчлүүлэгчийн чиг баримжаа гэсэн ойлголттой нягт холбоотой байдаг ба үйлчлүүлэгчдийн үнэнч хандлагыг олж авахын тулд ашигладаг хэрэгсэл юм.

Сайн дурынхны үйлчилгээний үнэнч хэрэглэгчдийг тухайн үйлчилгээг хэрэглэсний үр дүнд эерэг туршлага олж авсан хүмүүс гэж үзэх нь зүйтэй бөгөөд ингэснээр тэд бусад байгууллагад ижил төстэй шийдлүүдийг эрэлхийлэхгүйгээр тодорхой хугацааны туршид байгууллагад үнэнч хэвээр үлддэг. Сайн дурынхны санаачилга, санхүүжилтэд шинэ оролцогчдыг татах, байгууллагын сурталчлагч байх болно.

Үйл ажиллагааны үр нөлөө нь нийгмийн сайн дурынхны үйлчилгээний захиалга бий болгох чадвартай салшгүй холбоотой юм. Байгууллагын удирдлагын аппаратыг зөвхөн одоо байгаа дэг журмыг хангахаас гадна дараагийн, "хойшлогдсон" дарааллыг бий болгохын тулд тохируулсан байх ёстой. Ирж буй хүсэлтэд хариу өгөхөөс гадна ашгийн бус байгууллага, нийгмийн үйлчлүүлэгчдийг хайж олох нь чухал юм. Энэ үйл

явцад тухайн бүс нутгийн боловсролын байгууллагуудын нийгмийн үүрэг, их дээд сургуулиудыг соёлын амьдралын бусад субъектуудтай нягт уялдуулах ажил хэрэгжиж байна.

II. Дотоод орчин.

Бүтэц. *Сайн дурынхны үйл ажиллагааны оновчтой зохион байгуулалт, эрх зүйн хэлбэр, удирдлагын зохион байгуулалтын бүтцийг сонгох.* Их сургуулийн нөхцөлд сайн дурынхны хөдөлгөөнийг зохион байгуулах янз бүрийн хэлбэрийн санаа нь хөгжлийн хилийг өргөжүүлдэг бол бүх боловсролын байгууллагуудын ижил төрлийн бүтэц нь сайн дурынхны хэсгийн зохион байгуулалтын хөгжлийг хязгаарлах болно. Судлаачид янз бүрийн мэргэшсэн нийгмийн тогтолцооны оролцогчдыг зохицуулах асуудлыг шийдвэрлэх боломжийг олгодог менежментийн янз бүрийн хэлбэрүүдийн хослолыг ихээхэн сонирхож байна.

Удирдлагын нийтлэг зарчмуудын зэрэгцээ менежментийн янз бүрийн аргуудыг (зохион байгуулалт, захиргааны, эдийн засаг, нийгэмсэтгэл зүйн) хослуулсан арилжааны бус онцлог шинж чанартай зарчмуудыг томъёолсон болно

Сайн дурынхныхан. *Шийдвэр гаргах, сайн дурынхны хөтөлбөр боловсруулахад сайн дурынхны оролцоо* (Хавсралт 7). Удирдлагын асуудлыг дотроос нь шийдвэрлэх нь "субъект-объект" парадигмын хэд хэдэн хязгаарлалтыг даван туулахтай холбоотой юм. "Субъект-субъект" парадигмд хэсэгчлэн шилжих нь сайн дурынхны үйл ажиллагааны талаар эргэцүүлэн бодох талбарыг өргөжүүлж, практикт удирдагчдын сайн дурынхны ажилтнуудтай хийх ажлын гүнзгийрүүлсэн хэлбэрийн илрэл байх болно (Хавсралт 6). Оролцогч бүрийн талаарх мэдээллийг тууштай цуглуулах, түүний үнэ цэний чиг баримжааг оношлох, тухайн объектын талаарх олж авсан мэдлэгийг удирдлагын хэрэгсэл, үйл ажиллагааны онцлогтой уялдуулахыг харгалзан үзнэ. Сайн дурынхныг зорилтот бүлэгт элсүүлэх нь харилцааны гол мессежийг хүлээн авагчдын сэдэл, хувийн зорилготой уялдуулахын тулд зохион байгуулагчдын стратегийг боломжит сайн дурынхны хүсэлд нийцүүлэн тохируулахыг шаарддаг.

Төслийн үйл ажиллагааны эхлэл. Сайн дурынхны тусламжийг нэг удаагийн үйл ажиллагаа, мөн урт хугацааны төсөл хэлбэрээр үзүүлэх боломжтой. Төслийг санаачлагч нь асуудлыг тодорхойлохоос эхлэх ёстой - хувь хүн эсвэл хэсэг хүмүүс, хот, муж улсын хангагдаагүй хэрэгцээ.

Төслийн санааг боловсруулах контурын дагуух хөдөлгөөн нь санааг нэгэн зэрэг хөгжүүлэх (ерөнхий алсын хараагаас төслийн зорилгыг тайлбарлах, өөрөөр хэлбэл хүлээгдэж буй үр дүн) болон асуудлыг ойлгох (мэдэгдлээс тодорхой чанарын болон тоон тодорхойлолт). Эхлэх үе шатанд гарсан ажлын үр дүн нь төслийг хэрэгжүүлэх, заасан асуудлыг шийдвэрлэхэд хэрхэн туслах талаар тодорхой дүрсэлсэн байх ёстой.

Зорилтот тусламжид хамрагдах. Сайн дурынхны нөөцийг ашигласнаар асуудлыг шийдэх гарц үнэхээр боломжтой эсэхийг ойлгох нь чухал уу?, Сайн дурынхны тоо, ур чадвар, оюуны болон бүтээлч байдлын түвшин ямар байх ёстой вэ? , Залуучууд өөрсдөө энэ асуудлыг хэрхэн дүгнэж байна вэ? гэх зэрэг асуултад хариулт хэрэгтэй. Ихэнхдээ залуучууд сайн дурынхны төслийг эхлүүлэхэд ноцтой саад болж байгаа зүйл бол нөхцөл байдлын асуудлын мөн чанарыг сайн мэддэггүй явдал юм. Зорилтот оролцоо нь төслийн хүрээнд олон төрлийн бүтээлч инновацыг бий болгож, сайн дурынхныхан өөрсдийн асуудлыг шийдвэрлэх механизмыг санал болгож, хэрэгжүүлэх боломжийг олгодог бөгөөд сайн дурынхныхан өөрсдийн нийгэмд хэрэгтэй гэдгийг мэдэрдэг.

Сайн дурынхныг урамшуулах тогтолцоог хөгжүүлэх. Сайн дурынхныг урамшуулах асуудалд дэвшилттэй чиглэлүүдийн нэг бол боловсролын систем юм. Боловсролын эсвэл үйлдвэрлэлийн практикт мэргэжлийн сургалтын чиглэлээр сайн дурынхны үйл ажиллагааг бүртгэлжүүлэх нь ач холбогдолтой. Оюутнуудын хувьд янз бүрийн урам зоригийн арга хэрэгслийг ашиглах, үнэ цэний шинэ хэв маягийг бий болгох, ялангуяа үнэ төлбөргүй мэдлэг олж авах, гадаад хэл сурах боломжийг сурталчлах явдал юм. Сайн дурынхны ажилтны хувийн сэдлийг хүлээн зөвшөөрөх нь чухал юм. Сайн дурынхны ажилтны хувийн сэдлийг боловсруулсан сэдлийн хэмжээс дээр үндэслэн турших замаар тогтоож болно. Сайн дурынхны сэдлийн хэмжээс дээр үндэслэн турших замаар тогтоож болно (Хүснэгт 29).

№	Сайн дурынхны оролцооны сэдэл	Баталгаажуулсан зөвшөөрсөн үнэлгээ. 5–“Бүрэн санал нийлсэн”, 1-“Огт санал нийлээгүй”				
1.	Хэрэгцээтэй зүйл хийх, ач холбогдол бүхий төсөлд хувь нэмэр оруулахыг хүсэж оролцож байна.	5	4	3	2	1

2.	Арга хэмжээ улс орон, орон нутаг, хот, боловсролын салбарт ашигтай тул оролцож байна.	5	4	3	2	1
3.	Би асуудлыг зөв өнцгөөс харж, бусад хүмүүст туслахыг хүсдэг учраас оролцдог.	5	4	3	2	1
4.	Би улс орон, бүс нутаг, хот, их сургуулиараа бахархаж, олон улсын, холбооны, хотын түвшинд төлөөлөхийг хүсэж байгаа учраас оролцож байна.	5	4	3	2	1
5.	Би улс орон, бүс нутаг, хот, их сургуулийнхаа нэр хүндийг өндөрт өргөж явахыг чухалчилдаг учраас оролцож байна.	5	4	3	2	1
6.	Шинэ танилтай болох, сонирхолтой хүмүүстэй танилцах боломжтой учраас би оролцдог.	5	4	3	2	1
7.	Мэргэжлийн холбоо, харилцааг бий болгох, хөгжүүлэх зорилгоор оролцож байна.	5	4	3	2	1
8.	Олны танил болон алдар хүндтэй харахын тулд оролцож байна.	5	4	3	2	1
9.	Би өөрийнхөө ур чадварыг сорих боломж гэж үзсэн учраас оролцож байна	5	4	3	2	1
10	Би шинэ туршлага олж авах, ур чадвараа хөгжүүлэхийг хүсэж байгаа учраас оролцдог	5	4	3	2	1
11	Энэ нь анкет дээр байгаа сайн үзүүлэлт, бас ажил олоход тусалдаг учраас би оролцож байна.	5	4	3	2	1
12	Би ололт амжилтаа үнэлж, ажлынхаа талархлыг хүлээж авдаг учраас оролцдог	5	4	3	2	1
13	Найз нөхөд, танилууд маань сайн дурынхныхан учраас би оролцдог	5	4	3	2	1
14	Миний сурдаг/ажлын газрын захиргаа намайг урамшуулдаг учраас би оролцдог	5	4	3	2	1
15	Би чөлөөт цаг ихтэй учраас оролцдог	5	4	3	2	1
16	Эргэн тойрондоо сонирхол, хүндэтгэлийг төрүүлдэг учраас би оролцдог.	5	4	3	2	1
17	Хувь хүний манлайллыг хөгжүүлэх, багийг удирдахад оролцдог учраас оролцож байна.	5	4	3	2	1
18	Би сайн дурынхны ялгарах дүрэмт хувцас, материал хэрэглэлээр хангагддаг учраас оролцдог	5	4	3	2	1
19	Үйл ажиллагаа явагдах газруудад нэвтрэхийн тулд оролцож, мега арга хэмжээнд оролцдог	5	4	3	2	1
20	Би бэлэг дурсгалын зүйл, дурсамж, эд зүйлс, гарын үсэг авахаар оролцдог	5	4	3	2	1

Хүснэгт 29. Сайн дурынхны сэдлийн үнэлгээний хэмжээс

Хүлээн авсан үр дүн нь тухайн байгууллагын сайн дурынхны ажилтан бүрийн чадавхыг уян хатан үнэлж, оролцох хувийн сэдэл дээр үндэслэн урамшуулах боломжийг олгоно. Сайн дурынхны ажлыг залуучуудын чөлөөт цагаа өнгөрөөх үйл ажиллагаа гэж үзэх нь орчин үеийн хандлагад нийцэж байгаа бөгөөд энэ үзэгдлийн талаарх шинжлэх ухааны ойлголтыг нийгэмд чиглэсэн төрийн бус байгууллагуудын үйл ажиллагааны хүрээнээс сайн дурынхны үйл ажиллагааны өргөн хүрээний талбар руу шилжүүлж байна.

Хүлээн авсан үр дүн нь тухайн байгууллагын сайн дурынхны ажилтан бүрийн чадавхыг уян хатан үнэлж, оролцох хувийн сэдэл дээр үндэслэн урамшуулах боломжийг олгоно. Сайн дурынхны ажлыг залуучуудын чөлөөт цагаа өнгөрөөх үйл ажиллагаа гэж үзэх нь орчин үеийн хандлагад нийцэж байгаа бөгөөд энэ үзэгдлийн талаарх шинжлэх ухааны ойлголтыг нийгэмд чиглэсэн төрийн бус байгууллагуудын үйл ажиллагааны хүрээнээс сайн дурынхны үйл ажиллагааны өргөн хүрээний талбар руу шилжүүлж байна.

Үйл явдалд суурилсан сайн дурынхны үйл ажиллагааг хөгжүүлэх нь дээд боловсролын байгууллагуудад сайн дурынхны хөдөлгөөнийг зохион байгуулах хэтийн төлөвийг тодорхойлдог бөгөөд энэ нь зохион байгуулалттай хэлбэрийг олж авч, нийгмийн ач холбогдолтой асуудлыг шийдвэрлэхэд оюутны оролцоо чухлыг хүлээн зөвшөөрч байна.

Зохион байгуулагчидтай холбоо барьж сайн дурынхны байгууллагын үйлчилгээнд сайн дурынхны ажилтнуудыг татах үндэслэлтэй. Энэ хүрээнд янз бүрийн хэмжээний арга хэмжээ зохион байгуулахад сайн дурынхныг татан оролцуулах хэрэгцээг оношлох логикийг томъёолсон болно. Сайн дурынхны хөдөлгөөний өнөөгийн байдалд хяналт тавих ажлыг *бүлгийн байгууллага, тэдгээрийн сайн дурынхныхан, үйлчилгээний үйлчлүүлэгчид* гэсэн сайн дурынхны хөдөлгөөний олон нийтийн гурван бүлгийн хүрээнд санал асуулгын хэлбэрээр судалгаа явуулж тодорхойлж болно.

Өнөөгийн байдлаар манай улсад:

- **“Сайн хүн сайн нийгэм” ТББ.** Тус байгууллагын зорилго нийгмийн сайн сайхны төлөө оюутан залуусын нийгмийн оролцоог нэмэгдүүлж, тухайн бүс нутагт тулгамдаж байгаа асуудлыг иргэдийн

өөрсдийнх нь оролцоотойгоор шийдвэрлэхэд туслах болон дэмжлэг үзүүлэх юм.

- **“Сайн дурынхны хөгжлийн төв”**. 2009 онд залуучуудын санаачилгаар байгуулагдсан бөгөөд нийгмийн бүхий л салбарт сайн дурынхны оролцоо, хувь нэмрийг нэмэгдүүлэх үндсэн зорилготой. Сайн дурынхны хөгжлийн төвийн нэг үйл ажиллагаа нь бүртгэлтэй сайн дурынхны ажилтнуудаа бусад байгууллагуудтай холбож, хооронд нь гүүр болон ажилладаг.

- **“My Club” ТББ**. Тус байгууллага 2006 оны 12-р сарын 17-ны өдөр оюутны сайн дурынхны клуб хэлбэрээр байгуулагдаж байсан бөгөөд одоо нийгэмдээ үйлчлэх ТББ болсон. “Үндсэн үйл ажиллагаа нь 4-10 сард явагддаг ба долоо хоног бүрийн бямба гарагт мод усалдаг байна.

- **“МОНЭС” ТББ**. Тус байгууллагын зорилго нь эмэгтэйчүүдийн эрхийг дээдлэн хамгаалж, тэднийг хүчирхэгжүүлэхдээ шударга, эрх тэгш, ил тод зарчмын хэрэгжилтийг үндэсний болон орон нутгийн түвшинд сайжруулах, үүндээ эмэгтэйчүүдийн бүтээлч оролцоо, дуу хоолойг нэмэгдүүлэн манлайлах явдал байна.

- **YFU (Youth For Understanding)**. YFU (Youth For Understanding) нь өсвөр үеийнхэнд өөрчлөгдөн шинэчлэгдэж, улс үндэстнүүдийн хоорондын харилцан хамаарал өдрөөс өдөрт нэмэгдэж буй дэлхий ертөнцөд өөрийгөө сорин амьдрах чадвартай, хариуцлагатай иргэн болон төлөвшихөд нь тус дэм болох үндсэн зорилготой.

- **“Пи Эм Ай Монгол Чаптэр”** Пи Эм Ай Монгол Чаптэр” нь сайн дурынхны ажилтнуудтай үргэлж хамтран ажиллахыг эрэлхийлсээр ирсэн ба төслийн удирдлагын чиглэлээр тэргүүлэхийг хүсэгч хүн болгонд “Пи Эм Ай Монгол Чаптэр”-ийн хаалга нээлттэй тул Сар бүр зохион байгуулагддаг үйл ажиллагааны багийн гишүүн, жил бүр зохион байгуулагддаг олон улсын бага хурлын багийн гишүүн, Чаптерийн маркетинг үндсэн үйл ажиллагааны багийн гишүүн, Олон талт хамтын ажиллагааны багийн гишүүн, Чаптерийн гишүүнд чиглэсэн үйл ажиллагааг дэмжих багийн гишүүн, Мэргэжлийн ур чадвар хөгжүүлэх үйл ажиллагааны багийн гишүүн зэрэг үйл ажиллагаануудыг дэмжин ажиллах сайн дурынхны ажилтнууд болох боломж байна.

Эдгээр байгууллагад санал болгосон сайн дурын ажилтны сэдлийг тогтоох хүснэгтээр сайн дурынхны ажилтнуудынх нь талаар судалгаа хийж болохын зэрэгцээ санал болгосон Сайн дурынхны үйл ажиллагааны

оролцоо, түншлэлийн загвараар бусад салбар, үйлчлүүлэгчидтэй хамтран ажиллах боломжийг нэмэгдүүлэх арга замыг тодорхойлж болно.

Гуравдугаар бүлгийн дүгнэлт

Сайн дурын үйл ажиллагааны эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгох боломжийн хувьд:

Сайн дурын үйл ажиллагааны эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгох боломжийг *нэгд*, сайн дурын үйл ажиллагаа ба засаглалын бодлогын харилцан уялдааг сайжруулах арга зам, *хоёрт*, хууль эрх зүйн орчныг сайжруулах боломж гэсэн хоёр чиглэлээр тодорхойллоо.

Судалгааны үр дүнд дараах дүгнэлт хийлээ:

Нэг. Сайн дурын үйл ажиллагаа ба засаглалын бодлогын харилцан уялдааг сайжруулах арга замын хувьд:

1 Засаглал бол улс үндэстний ажил хэргийг жолоодох, улс төр, эдийн засаг, захиргааны эрх мэдлийг хэрэгжүүлэх явдал бөгөөд энэ нь иргэд, тэдний бүлгүүд ашиг сонирхол, өөр хоорондын ялгаатай байдлаа илэрхийлэх, хуулиар олгогдсон эрх, үүргээ хэрэгжүүлэх механизм, үйл явц, харилцаа, байгууллаас бүрдэнэ” гэсэн ойлголтыг засаглалын үндэс болголоо.

2 Засгийн газар сайн дурынхны оролцоог сайжруулах тогтолцоо бий болгосон үедээ сайн дурын үйл ажиллагааны хүчийг системтэйгээр хөшүүрэг болгох, технологийн шинэ боломжийг ашиглан мэдээллийн орон зайд нэгдэх, сайн дурынхны санаачилгыг сонсож, хариу үзүүлэх, иргэдийн оролцоог дэмжсэн орчныг болон олны дуу хоолойг сонсох нөхцөлийг бий болгох, Засгийн газар болон иргэний нийгмийн хооронд хамтын ажиллагааны хууль эрх зүй болон бүтцийн өөрчлөлтийг амжилттай нутагшуулж, сайн дурынхан оролцох сувгийг нээж өгөх болно.

3 Засаглалын үйл ажиллагаа, бодлого, стратегийг бэхжүүлэх болон хөгжлийн бодлого, үйл явцыг хэлэлцэхэд *нэгд*, засаглалын үйл явцыг илүү олныг хамарсан, оролцооны болгохын тулд орон нутгийн засаг захиргаатай эсвэл олон улсын иргэний нийгмийн байгууллагуудтай хамтран ажиллах замаар эмзэг бүлгийнхэн болон нийт ард иргэдийн чадавхыг бэхжүүлэх, *хоёрт*, оролцоо нь хязгаарлагдмал бүлгийнхний хувьд дуу хоолой болон оролцоогоо илэрхийлэх шинэ, нэмэлт сувгуудыг нээж тэдний хэрэгцээ шаардлагыг анхаарлын төвд аваачиж, нөөцийг тэдний онцгой хэрэгцээнд зориулан хуваарилах замаар хөгжил болон сайн дурын үйл ажиллагааны логик холбоонд засаглалын бодлогыг авч үзэх нь чухал шийдэл байх болно.

4 2015 оноос хойших хугацааны тогтвортой хөгжлийн зорилтуудыг хэрэгжүүлэхэд шаардлагатай нөөц боломжуудыг татан оруулахад сайн дурын үйл хэрэг нь үнэтэй хувь нэмэр болох нь засаглалын үйл ажиллагаа ба хөгжлийн бодлого боловсруулахад: нэгд, сайн дурын үйл хэрэг нь талуудын санал бодлыг нэгтгэх, 2015 оноос хойших хугацааны хөгжлийн хөтөлбөрийг хэрэгжүүлэх, хянахад шаардлагатай бүх боломжийг нэгтгэхэд хүчирхэг нөөц боломж болох, хоёрт, сайн дурын нэмэгдэж буй оролцоо нь ИНБ-ууд, хувийн хэвшил, засаглал болон үйлчилгээ хүргэх явцад чухал үүрэгтэй этгээдүүд зэрэг засаглалын оролцогч талуудаас илүү хариу үзүүлдэг байхыг шаардах ач холбогдолтой байх болно.

5 Орон нутгийн түвшинд сайн дурын үйл хэрэг нь: нэгд, Засгийн газрын зүгээс ялангуяа энэ түвшинд ачааны хүндийг сайн дурынханд даатгах, хоёрт, оролцооны орон зай дахь зонхилох бүлэглэлүүдийн давамгайлал нь шийдвэр гаргалт дахь тэгш бус байдлыг бууруулах гэхээсээ илүүтэйгээр улам өөгшүүлэх, гуравт, зарим бэлгэдлийн чанартай оролцооны механизм нь шийдвэр гаргах бодит эрх мэдэлгүй байх, дөрөвт, зарим сайн дурынхан үзэл бодлоо илэрхийлсний төлөө дарамт шахалттай нүүр тулгарах тохиолдол байх зэрэг өөрийн гэсэн **хүндрэл бэрхиээлтэй тулгардгийг засаглалын бодлогод анхаарах хэрэгтэй** болно.

6 Нэгд, сайн дурын үйл ажиллагааг олон нийтээр дэмжүүлэх зорилт / сайн дурын үйл ажиллагааг дэмжих компаниг ажлыг зохин байгуулах, хэвлэл, мэдээллийн байгууллагатай байнгын харилцаа тогтоох, сайн дурынхны өдрийг тэмдэглэх/, хоёрт, боловсролын системд сайн дурын үйл ажиллагааг дэмжих тогтолцоог бий болгох зорилт /бага болон дунд сургуулийн хөтөлбөрт сайн дурын үйл ажиллагааны мэдлэг олгох асуудлыг оруулах, оюутнуудыг сайн дурын үйл ажиллагаанд оролцох механизмыг их дээд сургуулиудад бий болгох, сайн дурын үйл ажиллагааг дэмжих хөгжүүлэх стратегийг боловсруулах, залуучуудын дунд сайн дурын үйл ажиллагаанд оролцох эрмэлзлийг хөгжүүлэх./, гуравт, иргэний нийгмийн сайн дурын үйл ажиллагаанд оролцох түвшнийг дээшлүүлэх зорилт /иргэний нийгмийн сайн дурын үйл ажиллагаанд оролцох боломжийн талаарх мэдээллийн солилцоог өргөжүүлэх, иргэний нийгмийн байгууллагуудын сайн дурынхантай ажиллах, ашиглах чадавхыг хөгжүүлэх, сайн дурын үйл ажиллагааны дэд бүтцийг хөгжүүлэх/, дөрөвт, сайн дурын үйл ажиллагааг дэмжих институцийн системийг бий болгох зорилт / сайн дурын ажиллагааг хөгжүүлэх Үндэсний зөвлөлийг байгуулах, хуулийн заалтын хэрэгжилт, үйл ажиллагаанд мониторинг, үнэлгээ хийх,

сайн дурын үйл ажиллагааг дэмжих, хөгжүүлэх төсөл, хөтөлбөрт санхүүгийн туслалцаа үзүүлэх, төрийн байгууллагуудын сайн дурынхантай ажиллах чадавхыг нэмэгдүүлэх/ *зэрэг тодорхой зорилтуудыг дэвшүүлэн ажиллах нь засаглал бодлогыг сайн дурын үйл ажиллагаагаар дэмжүүлэх чухал механизм байх болно.*

7 *Сайн дурынхны талаарх засаглалын бодлогыг сайжруулсны үр дүнд: нэгд*, Засгийн газар сайн дурынхны оролцоог сайжруулах тогтолцоо бий болгосон үедээ сайн дурын үйл ажиллагааны хүчийг системтэйгээр хөшүүрэг болгож, сайн дурынхныг улсын хөгжлийн төлөвлөгөө дэх чухал салбаруудад санаачилгатай оролцуулах боломжийг олгоно., *хоёрт*, технологийн шинэ боломжийг бодлогоор дэмжих нь сайн дурынхан, жирийн иргэдийн хувьд мэдээллийг цаг тухайд нь олон нийтийн дундаас боловсруулах, мэдээлэх боломжийг бий болгож, өөрсдийн вэбсайт, блог дээр үзэл бодлоо илэрхийлэх, мэдээ оруулах замаар мэдээллийн орон зайд нэгдэх, иргэдийн дан ганц уламжлалт мэдээллийн хэрэгслээс хараат байдлыг багасгах болж, зарим тохиолдолд уламжлалт хэвлэл мэдээллийн хэрэгслүүдэд өөрсдийн орон зайг хадгалж үлдэх, илүү хариуцлагатай, үнэн зөв мэдээлэл түгээх шаардлагыг бий болгоно., *гуравт*, Үндэсний түвшин дэх сайн дурынхны санаачилгын амжилтын гол түлхүүр нь тэдгээр санаачилгыг сонсож, хариу үзүүлдэг засгийн газар болно. Зарим тохиолдолд уг хөдөлгөөнүүд нь засгийн газрыг илүү хариу үзүүлдэг байлгахад шаардлагатай улс төрийн шахалт үзүүлдэг бол бусад үед сайн дурынхны санаачилгууд нь тэдгээр санал санаачилгыг дэмжиж нааштайгаар хүлээн авах засгийн газрын үед хэрэгждэг учраас сайн дурынхны хамгийн амжилттай санаачилгын нууц нь засгийн газартай тодорхой хүрээнд, хэдий тэднийг буруушааж, шүүмжилсэн ч хамтарч ажилладаг болно., *дөрөвт*, Засгийн газар, нийгмийн нөлөө бүхий бүлгүүд, элитүүдийн хариу үзүүлэх байдал нь иргэдийн оролцоог дэмжсэн орчныг болон олны дуу хоолойг сонсох нөхцөлийг бий болгоход тэр дундаа хамгийн ихээр хохирсон иргэдийн дуу хоолойг хүргэж, удаан хугацааны энх тайвныг бий болгож, нийгмийн зөрчлийг арилгахад нөлөөлнө., *тавд*, Засгийн газар болон иргэний нийгмийн хооронд хамтын ажиллагаа нь хууль эрх зүй болон бүтцийн өөрчлөлтийг амжилттай нутагшуулах хүчин зүйл болно., *зургаад*, Засгийн газар болон ИНБ-ууд хоорондын найрсаг түншлэл нь засгийн газрын бодлогыг хэрэгжүүлэх чадварыг сайжруулахад сайн дурынхан оролцох сувгийг нээж өгнө.

Хоёр. Хууль эрх зүйн орчныг сайжруулах боломжийн хувьд:

1. Судалгаанаас харахад манай улсад өнөөдрийн байдлаар Үндэсний бодлого, стратеги, эрх зүй, санхүүгийн орчин хангалттай хэмжээнд бүрдээгүй, Засгийн газарт сайн дурын үйл ажиллагааг хөгжүүлэх асуудлыг хариуцсан бүтэц байхгүй, сайн дурынхныг хүлээн авах байгууллагуудыг сайн дурынхантай холбох, сайн дурын үйл ажиллагаанд оролцох боломжийн талаар мэдээлэл түгээх чиг үүрэг бүхий үндэсний хэмжээний төв, зохицуулагч байгууллага бий болоогүй байна.

2. Хууль эрх зүйн орчин, тодорхой бүтцийг тогтвортой сайн бүрдүүлсэн улс оронд: нэгд, сайн дурын ажлыг тодорхой болгосон заалтууд, хоёрт, байгууллагуудад сайн дурын ажлын талаар мэдээлэх үүрэг хүлээлгэсэн байдал, гуравт, Сайн дурынхны үүрэг болон зохион байгуулалт, дөрөвт, сайн дурынхны хамрагдах ёстой даатгалууд, тавд, хөдөлмөрийн хуулийн зохицуулалтын холбогдох заалтууд, зургаад, сайн дурынханд хуулиар зөвшөөрөгдсөн эрхүүд: тухайлбал сайн дурын ажлын үед гаргасан зардлыг нөхөн төлөх зохицуулалт, долоод, ажилгүй, тэтгэвэрт гарсан, нийгмийн халамж авдаг хүмүүс, ахмадын асрамжийн газарт амьдардаг ахмад настнууд гэх мэт сайн дурынханд үзүүлэх хөнгөлөлтүүд зэрэг асуудлуудыг тодорхой болгосон байдаг байна.

3. УИХ-ын гишүүн асан Д.Оюунхоролын 2018 онд санаачлан боловсруулсан “Сайн дурын үйл ажиллагааг дэмжих тухай” хуулийн төслийн зорилго нь тогтвортой хөгжил, хүний эрх, энх тайван, аюулгүй байдлын үндэсний болон орон нутгийн бодлого төлөвлөлт, хэрэгжилтэд иргэний нийгмийн болон сайн дурын үйл ажиллагааг дэмжих, олон нийтэд түгээн дэлгэрүүлэх, сайн дурын үйл ажиллагаатай холбоотой харилцааг зохицуулахад оршихоор тодорхойлогдсон нь бидний өмнө санал болгож буй засаглалын бодлогыг сайжруулах асуудлууд болон эрх зүйн орчныг боловсронгуй болгох чиглэлтэй нийцэж байна.

4. Бид өөрсдийн судалгааны үр дүнд тулгуурлан дээрх хуулийн төслийг сайжруулах чиглэлээр санал боловсрууллаа. Чингэхдээ Хуулийн 2 дугаар зүйл. *Сайн дурын үйл ажиллагааг дэмжих тухай хууль тогтоомж гэсэн зүйлийн 2.1 заалтад “Гамшгаас хамгаалах тухай хууль” гэж нэмж оруулах.* 3.1. Энэ хуульд хэрэглэсэн дараах нэр томъёог дор дурдсан утгаар ойлгоно гэсэнд 3.1.1-ыг гамшгаас хамгаалах үйл ажиллагаа гэсэн ойлголтоор өргөтгөн найруулах ба 3.1.4 заалтыг өөрчлөн томъёолох нэмэлт оруулах: 4 дүгээр зүйл. *Сайн дурын үйл ажиллагааны зарчим гэсэнд 4.1.9, 4.1.10 нэмэлт оруулах:* 9 дүгээр зүйл. *Сайн дурын ажилтны эрх, үүрэг: Сайн*

дурын ажилтан дараах эрхийг эдэлнэ гэсэн заалтад 9.1.9, 9.1.10, 9.1.11, 9.1.12, 9.1.13, 9.1.14 нэмэлт оруулах: 9.2. Сайн дурын ажилтан дараах үүрэг хүлээнэ гэсэн заалтад 9.2.6, 9.2.7, 9.2.8, 9.2.9, 9.2.10, 9.2.11 нэмэлт оруулах: 10 дугаар зүйл. Сайн дурын үйл ажиллагаа зохион байгуулагчийн эрх, үүрэг гэсэн зүйлд 10.9, 10.10, 10.11, 10.12 нэмэлт заалт оруулах: саналыг судалгааны үндсэн дээр боловсрууллаа.

5. Эдгээр саналыг хуульд оруулснаар сургагдаагүй, зохион байгуулалтгүй сайн дурынхны оролцоо нь зохион байгуулалттай тусламжийн үйл ажиллагаанд сөргөөр нөлөөлөх, өөрсдөө эрсдэх, гамшигт өртөгсдөд очих нөөцийн хэмжээ буурахаас сэргийлж, мөн нөгөө талаар сайн дурынхны мэдлэг, ур чадвар, нөөц, сүлжээ, урам зоригийг зөв удирдан зохион байгуулснаар онцгой байдал, гамшгийн менежментийг хамгийн өндөр үр дүнд хүргэх боломжтой болгоно гэж үзэж байна. Түүнчлэн Гамшгаас хамгаалах үйл ажиллагаа бүх иргэдийн оролцоонд тулгуурладаг, тиймээс сайн дурын ажилтан бүхэн тодорхой сургалтад хамрагдсаны үндсэн дээр гамшгаас хамгаалах үйл ажиллагаанд оролцох боломж бий болгоход хуулийн төсөлд оруулсан санал чиглэхийн зэрэгцээ нийгмийн сайн сайхны төлөө, тогтвортой хөгжлийн төлөө сайн дурынхны оруулж буй хувь нэмэр гамшгаас хамгаалах үйлсэд хувь нэмэр болдог үзэл санааг агуулж байгаа болно.

Сайн дурынхны үүрэг, оролцоог нэмэгдүүлэх зарим арга замын хувьд:

Сайн дурынхны үүрэг, оролцоог нэмэгдүүлэх зарим арга замыг *нэгд*, Монгол Улсын гамшгаас хамгаалах үйл ажиллагааны өнөөгийн төлөв байдлын судалгааны дүнд нөлөөлөх хүчин зүйлсийн нөлөөллийн үзүүлэлтүүдийг нэмэгдүүлснээр хүрч болох үр дүнгийн стратеги, *хоёрт*, энэхүү стратегийг хэрэгжүүлэх боломжийг тодорхойлох замаар боловсрууллаа.

Судалгааны үр дүнд дараах дүгнэлтүүд хийлээ. Үүнд:

1 Гамшгаас хамгаалах үйл ажиллагаанд сайн дурынхны үүрэг, оролцоог нэмэгдүүлэх зарим арга замын тухайд тухайн салбарт харьцангуй олон жил ажилласан мэдлэг, боловсрол бүхий бодлого боловсруулагч, бодлого хэрэгжүүлэгч эрдэмтэн, судлаачдыг сонгон оролцуулж гамшгаас хамгаалах үйл ажиллагаанд сайн дурынхны оролцоо, ажлын гүйцэтгэлд нөлөөлж байгаа 12 хүчин зүйлүүдийн нөлөөллийн талаар тэдний өгсөн үнэлгээний математик дунджийг үндэслэн SWOT шинжилгээний шатлан

судлах АНР аргыг ашиглан программаар тооцоолон үр дүнд боловсруулалт хийлээ.

2 Тооцооллын шалгуур үзүүлэлтүүдийн суурь оноор 2020 оны гүйцэтгэлийг авч, 2024 оны хүрэх түвшнийг ойрын, 2028 оны таамаглалыг дунд хугацааны, 2032 оны таамаглалыг хэгийн зорилгоор тус тус авч, таамаглалыг тодорхой тоон үзүүлэлтээр төсөөлсөн нь стратегийн төлөвлөлтийг тодорхой үр дүнд суурилан хийх боломжийг олгосон.

3 Гамшгаас хамгаалах үйл ажиллагаанд сайн дурынхны оролцоонд нөлөөлөх хүчин зүйлсийн нөлөөллийн үзүүлэлтүүдийг 2024 он хүртэл дотоод хүчин зүйлсийн үнэлгээг 0.7 нэгжээр, гадаад хүчин зүйлсийн үнэлгээг 1.1 нэгжээр нэмэгдүүлэхэд Монгол Улсын гамшгаас хамгаалах үйл ажиллагааны ерөнхий үнэлгээ 8.7 нэгжээр нэмэгдэж 68,9 %, 2024 – 2028 онд дотоод хүчин зүйлийн үнэлгээг 0.5 нэгжээр, гадаад хүчин зүйлийн үнэлгээг нэгжээр мөн 0.7 нэгжээр тус тус нэмэгдүүлэхэд Монгол Улсын гамшгаас хамгаалах үйл ажиллагааны ерөнхий үнэлгээ 10.0 нэгжээр нэмэгдэж 75.6 %, 2028 – 2032 онд дотоод хүчин зүйлийн үнэлгээг 0.7 нэгжээр, гадаад хүчин зүйлийн үнэлгээг 0.8 нэгжээр тус тус нэмэгдүүлэхэд Монгол Улсын гамшгаас хамгаалах үйл ажиллагааны ерөнхий үнэлгээ 11.2 нэгжээр нэмэгдэж 85.7 % болж, сайн дурынхны оролцоо өсөн нэмэгдэх ерөнхий хандлага байгааг тогтоож, стратегийг график зураглалаар байгууллаа.

4 Сайн дурын байгууллагын үйл ажиллагааны тулгамдсан асуудлуудын агуулгын байж болох хувилбарыг технологийн, боловсон хүчний, зохион байгуулалтын, харилцаа холбооны, урамшууллын болон дасан зохицох гэсэн төрлүүдээр боловсруулж, тэр нь удирдлагын шинж чанартай, түүнээс хамааралтай байгаа тул сайн дурын үйлсийн удирдлагын тогтолцоог сайжруулах замаар шийдвэрлэх боломжтойг үндэслэсэн.

5 Судалгааны ажилдаа нэгд, Сайн дурын үйл ажиллагааг зохицуулах байгууллага болон Орон нутгийн захиргаа, залуучуудын байгууллагатай бодлого, үйл ажиллагаагаа уялдуулахын зэрэгцээ ивээн тэтгэгч түншүүдтэй шууд хамтран ажиллах шаардлагатайг харуулсан сайн дурын ажиллагааг явуулахад суурь болох орчны ойлголтын зураглалыг хоёрт, Сайн дурын үйл ажиллагааны оролцоо, түншлэлийн: нөхцөл байдлыг үнэлэх журам ба түншлэлийн оновчтой хэлбэрт хүрэх цаашдын замыг тодорхойлсон хоёр үндсэн бүрэлдэхүүн хэсэг бүхий загварыг тус тус санал болгосон.

6 Үндэсний аюулгүй байдлыг хангах үйл ажиллагааны “эх оронч үндэсний үзлийг дээдлэх” зарчмыг хэрэгжүүлэх замаар сайн дурынхныг бэлтгэхэд боловсролын байгууллага, оюутны оролцоо маш чухлаар тавигдаж байгааг онцолж, сайн дурынхны хөдөлгөөнийг зохион байгуулагчид болон оролцогчдын хоорондын харилцаа холбоог бэхжүүлэх нь сайн дурынхны салбарын хөгжлийн асуудлыг шийдвэрлэхэд нэн тэргүүний зорилт болохыг эдгээр загварт онцлон үзсэн.

7 Үндэсний аюулгүй байдлыг хангах үйл ажиллагааны “эх оронч үндэсний үзлийг дээдлэх” зарчмыг хэрэгжүүлэх замаар сайн дурынхныг бэлтгэхэд боловсролын байгууллага, оюутны оролцоо маш чухлаар тавигдаж байгааг онцолж, сайн дурынхны хөдөлгөөнийг зохион байгуулагчид болон оролцогчдын хоорондын харилцаа холбоог бэхжүүлэх нь сайн дурынхны салбарын хөгжлийн асуудлыг шийдвэрлэхэд нэн тэргүүний зорилт бөгөөд Их сургуулийн түвшинд сайн дурынхны ажил нь оюутнуудын хичээлээс гадуурх бусад төрлийн үйл ажиллагаанаас илүү үнэ цэнтэй, боломжит хувилбар гэж үзлээ. Их, дээд сургуулийн зохион байгуулалттай сайн дурынхны үйл ажиллагаанд хамтын ажиллагааны харилцан үйлчлэлийн эдгээр загварыг ашигласнаар бүх талуудын ашиг сонирхлыг зохицуулах боломжтой юм.

8 Сайн дурын ажилтны хувийн сэдлийг хүлээн зөвшөөрөх нь чухал болохыг үндэс болгон Сайн дурын ажилтны хувийн сэдлийг тодорхойлох хэмжээсийг боловсруулсан ба тэдний хувийн сэдлийг сэдлийн хэмжээс дээр үндэслэн турших замаар тогтоож болно .

ЕРӨНХИЙ ДҮГНЭЛТ

Энэхүү судалгааны ажлаараа дараах асуудлуудыг боловсруулан, хамгаалалтад оруулахаар дэвшүүлсэн болно. Үүнд:

1 Сайн дурын үйл ажиллагааны онол, арга зүй, олон улсын туршлагыг судалсан үр дүн.

2 Монгол Улс дахь сайн дурын үйл ажиллагааны өнөөгийн байдлын шинжилгээний үр дүн.

3 Сайн дурынхны оролцоог нэмэгдүүлэх арга зам.

Гамшгаас хамгаалах сайн дурын үйл ажиллагааг сайн дурын үйл ажиллагаа гэсэн нийгмийн хүрээг бүхэлд нь хамарсан цогц системийн ойлголтын хүрээнд өргөн утгаар нь авч үзэж, судалгаа, шинжилгээний ажлаа боловсрууллаа.

1 Судалгааны ажлын нэгдүгээрт бүлэгт; Сайн дурын үйл ажиллагааны мөн чанар, зарчмыг тодорхойлох онол арга зүйн судалгааг: *нэгд*, сайн дурын үйл ажиллагааны үндсэн ойлголтууд, *хоёрт*, сайн дурын үйл ажиллагааны үүсэл хөгжил ба орчин үе, *гуравт*, гамшгаас хамгаалах сайн дурын үйл ажиллагааны онцлог, *дөрөвт*, сайн дурын үйл ажиллагаанд баримтлах зарчим зэрэг асуудлын логик уялдааны хүрээнд авч үзлээ. Сайн дурын үйл ажиллагаа нь цалин авдаггүй, өөрийн санаачилга, чөлөөт сонголт, сайн дурын үндсэн дээр, олон нийтийн ашиг, тусын тулд, ямарваа албадлага, шахалтгүйгээр, хувь хүний сонирхол байхгүй, хугацааны хувьд харилцан адилгүй шинж чанарыг агуулж байна. 2001 оны эцэст 125 улсад Үндэсний сайн дурын ажлын хороо байгуулагдаж, өөр өөрийн улсад сайн дурын ажлыг хуульчлах, эрх зүйн орчныг бүрдүүлэх ажлыг зохион байгуулж, 70 гаруй улсад сайн дурын ажлын талаар баримтлах бодлого, хууль эрх зүйн актууд батлагджээ.

2 Судалгааны ажлын хоёрдугаар бүлэгт; Гамшгаас хамгаалах үйл ажиллагаанд оролцогч талуудын эрх зүйн зохицуулалтын өнөөгийн байдлын дүн шинжилгээг Монгол Улсын Үндсэн хууль, түүнд нийцүүлэн гаргасан хууль болон хуулийн заалттай нийцүүлэн боловсруулагдсан бодлогын баримт бичиг, түүнийг хэрэгжүүлэх бусад эрх зүйн акт гэсэн гурван чиглэлээр гүйцэтгэхэд гамшгаас хамгаалах үйл ажиллагаанд талуудын оролцоог хангахтай холбоотой зүйл, заалтыг тусгасан нийтээр дагаж мөрдөх 22 хуулийг сонгон авч судлахад иргэдийн үүргийг тодорхойлсон 74 заалт буюу 20,2%, Төрийн бус байгууллага, сайн

дурынхны үүргийг тодорхойлсон 42 заалт буюу 12,9% тус тус байгаа нь иргэд, олон нийт, ТББ, сайн дурынхан гамшгаас хамгаалах үйл ажиллагаанд чухал оролцоотой болохыг харуулж байна гэж дүгнэлээ.

Гамшгаас хамгаалахад сайн дурын үйл ажиллагааны өнөөгийн байдлын шинжилгээг *нэгд*, сайн дурын үйл ажиллагааны талаар өмнө хийгдсэн баримт бичгийн судалгаа, *хоёрт*, гамшгаас хамгаалах сайн дурын хэсгийн судалгаа, *гуравт*, сайн дурын үйл ажиллагааны талаар авсан санал асуулгын судалгааны боловсруулалтын үр дүнгүүд дээр үндэслэн шинжиллээ.

Төв, орон нутгийн хэмжээнд үйл ажиллагаа явуулах гамшгаас хамгаалах сайн дурын хэсэг (2020 оны 7 дугаар сарын 20-ны байдлаар) 21 аймгийн 259 суманд 259 хэсгийн 4631 сайн дурын ажилтан, Нийслэлийн Багахангай, Баянгол, Хан-Уул, Сүхбаатар зэрэг 4 дүүргийн 25 хорооны нутаг дэвсгэрт 25 хэсгийн 419 сайн дурын ажилтан бүгд 284 хэсгийн 5050 сайн дурын ажилтан тухайн орон нутгийн Засаг даргын шийдвэрээр байгуулагдаж 1сараас 2,5 жилийн хугацаанд үйл ажиллагаа явуулж байгаа өнөөгийн нөхцөл байдлыг судлахад сайн дурын хэсгийн бүрэлдэхүүний тоо, хүчин чадал, харьцангуй зөрүүтэй, сургалт, бэлэн байдал, материаллаг хангалт жигд бус, тушаал, зааврын биелэлт удаан байгаа нь судалгаанаас харагдаж байна.

Гамшгаас хамгаалах үйл ажиллагаанд оролцогч МУЗН-ийн сайн дурын идэвхтнүүдээс санал, асуулга авч, судалгааны асуулгын үр дүнг SPSS-25.0 болон SMART-3.0 программаар тус тус боловсруулсан. Судалгааны үр дүнгийн хувьд; Сайн дурын идэвхтнүүдийн гамшгаас хамгаалах сургалтад хамрагдсан байдал, мэдлэг, ур чадвар, олон улсын туршлагаас суралцах байдал, анхны тусламж үзүүлэх чадвар зэрэг үзүүлэлтүүд хангалттай, харин мэдээллийн шуурхай байдал, цахим орчныг ашиглах байдал хангалтгүй дүн үзүүлж байгаа нь цаашид авах арга хэмжээг тодорхойлж өглөө гэж дүгнэж болохоор байна.

3.Судалгааны ажлын гуравдугаар бүлэгт; Сайн дурын үйл ажиллагааны эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгох боломжийг *нэгд*, сайн дурын үйл ажиллагаа ба засаглалын бодлогын харилцан уялдааг сайжруулах арга зам, *хоёрт*, хууль эрх зүйн орчныг сайжруулах боломж гэсэн хоёр чиглэлээр тодорхойллоо.

2018 онд УИХ-ын гишүүн Д.Оюунхорол “Сайн дурын үйл ажиллагааг дэмжих тухай” хуулийг санаачлан төсөл боловсруулсан байна.

Энэхүү хуулийн зорилго нь тогтвортой хөгжил, хүний эрх, энх тайван, аюулгүй байдлын үндэсний болон орон нутгийн бодлого төлөвлөлт, хэрэгжилтэд иргэний нийгмийн болон сайн дурын үйл ажиллагааг дэмжих, олон нийтэд түгээн дэлгэрүүлэх, сайн дурын үйл ажиллагаатай холбоотой харилцааг зохицуулахад оршихоор тодорхойлогдсон байна. Энэ нь бидний өмнө санал болгож буй засаглалын бодлогыг сайжруулах асуудлууд болон эрх зүйн орчныг боловсронгуй болгох чиглэлтэй нийцэж байгаа тул тус хуулийн төслийн заалтуудад нэмэлт өөрчлөлт оруулах саналаа судалгааны ажлын түвшинд боловсрууллаа.

Мөн Их, дээд сургуулийн зохион байгуулалттай сайн дурынхны үйл ажиллагаанд хамтын ажиллагааны харилцан үйлчлэлийн загварыг ашигласнаар бүх талуудын ашиг сонирхлыг зохицуулах боломжтой гэж үзэж, М.Шерийн оновчтой түншлэлийн загвар¹²² -ын дагуу концепцийн загвар боловсрууллаа.

Гамшгаас хамгаалах үйл ажиллагаанд сайн дурынхны үүрэг, оролцоог нэмэгдүүлэх зарим арга замын тухайд тухайн салбарт харьцангуй олон жил ажилласан мэдлэг, боловсрол бүхий бодлого боловсруулагч, бодлого хэрэгжүүлэгч эрдэмтэн, судлаачдыг сонгон оролцуулж гамшгаас хамгаалах үйл ажиллагаанд сайн дурынхны оролцоо, ажлын гүйцэтгэлд нөлөөлж байгаа 12 хүчин зүйлүүдийн нөлөөллийн талаар тэдний өгсөн үнэлгээний математик дунджийг үндэслэн SWOT шинжилгээний шатлан судлах АНР аргыг ашиглан программаар тооцоолон үр дүнд боловсруулалт хийж дараах дүгнэлтүүдэд хүрлээ.

4. *Гамшгаас хамгаалах үйл ажиллагаанд сайн дурынхан оролцоог нэмэгдүүлэх боломжийн тухайд:* Гамшгаас хамгаалах үйл ажиллагаанд сайн дурынхны оролцооны эрх зүйн зохицуулалт, түүний шинэчлэлийн асуудал, сайн дурын үйл ажиллагааны санхүү төсөв, хангалт, урамшуулал, сайн дурынхны мэргэшүүлэх сургалтыг боловсронгуй болгох замаар сайн дурынхны оролцоог нэмэгдүүлэх боломж байгаа нь харагдлаа.

Гамшгаас хамгаалах үйл ажиллагаанд сайн дурынхны оролцоонд нөлөөлөх хүчин зүйлсийн нөлөөллийн үзүүлэлтүүдийг 2024 он хүртэл дотоод хүчин зүйлсийн үнэлгээг 0.7 нэгжээр, гадаад хүчин зүйлсийн үнэлгээг 1.1 нэгжээр нэмэгдүүлэхэд Монгол Улсын гамшгаас хамгаалах

¹²² Sherr, Michael E. (2008) Social Work With Volunteers. Baylor University.–P. 93-104 дэх тал.

үйл ажиллагааны ерөнхий үнэлгээ 8.7 нэгжээр нэмэгдэж 68,9 %, 2024 – 2028 онд дотоод хүчин зүйлийн үнэлгээг 0.5 нэгжээр, гадаад хүчин зүйлийн үнэлгээг нэгжээр мөн 0.7 нэгжээр тус тус нэмэгдүүлэхэд Монгол Улсын гамшгаас хамгаалах үйл ажиллагааны ерөнхий үнэлгээ 10.0 нэгжээр нэмэгдэж 75.6 %, 2028 – 2032 онд дотоод хүчин зүйлийн үнэлгээг 0.7 нэгжээр, гадаад хүчин зүйлийн үнэлгээг 0.8 нэгжээр тус тус нэмэгдүүлэхэд Монгол Улсын гамшгаас хамгаалах үйл ажиллагааны ерөнхий үнэлгээ 11.2 нэгжээр нэмэгдэж 85.7 % болж, сайн дурынхны оролцоо өсөн нэмэгдэх ерөнхий хандлага байна.

АНР шинжилгээ, боловсруулалтаар дотоод хүчин зүйлсийн давуу тал болон гадаад хүчин зүйлсийн боломжийг бүрэн ашиглах, дотоод хүчин зүйлсийн сул тал болон гадаад хүчин зүйлсийн таагүй хүчин зүйлс буюу аюулыг арилгах замаар гамшгаас хамгаалах үйл ажиллагаанд сайн дурынхны оролцоог хангах богино, дунд, урт хугацааны стратегиудын зорилтуудыг тодорхойлсон.

САНАЛ, ЗӨВЛӨМЖ.

Бидний өмнө санал болгож буй засаглалын бодлогыг сайжруулах асуудлууд болон эрх зүйн орчныг боловсронгуй болгох чиглэлтэй нийцэж байна. Тиймээс бид “Сайн дурын үйл ажиллагааг дэмжих тухай” хуулийн төслийг сайжруулах чиглэлээр санал боловсрууллаа. Саналыг төслийн холбогдох зүйл, заалтуудын хувьд томъёолол, үндэслэл, тайлбар гаргалгааг хийсний дараа хуулийн төслийг хавсралт №.д бүхлээр нь санал болголоо. Үүнд:

1. 2 дугаар зүйл. Сайн дурын үйл ажиллагааг дэмжих тухай хууль тогтоомж гэсэн үйлийн 2.1 заалтад “Гамшгаас хамгаалах тухай хууль” гэж нэмж оруулах.

- Сайн дурын үйл ажиллагааг дэмжих тухай хууль тогтоомж нь Монгол Улсын Үндсэн хууль, Иргэний хууль, Гамшгаас хамгаалах тухай хууль, Төрийн бус байгууллагын тухай хууль, Компанийн тухай хууль, энэ хууль болон тэдгээртэй нийцүүлэн гаргасан хууль тогтоомжийн бусад актаас бүрдэнэ.

2. 3.1. Энэ хуульд хэрэглэсэн дараах нэр томъёог дор дурдсан утгаар ойлгоно гэсэнд 3.1.1-ыг гамшгаас хамгаалах үйл ажиллагаа гэсэн ойлголтоор өргөтгөн найруулах ба 3.1.4 заалтыг өөрчлөн томъёолох нэмэлт оруулах:

- 3.1.1. “сайн дурын үйл ажиллагаа” гэж иргэн, аж ахуйн нэгж, байгууллагаас нийгэм, улс, үндэстэн, хүн төрөлхтний сайн сайхны төлөө сайн дурын үндсэн дээр цаг хугацаа, хүчин чармайлт гарган, үнэ төлбөргүй явуулж байгаа ажлыг, “гамшгаас хамгаалах сайн дурын үйл ажиллагаа” гэж сайн дурын үйл ажиллагааны онцлог хэлбэрийг;
- 3.1.5. “сайн дурын хэсэг” гэж гамшгаас хамгаалах сайн дурын үйл ажиллагаанд оролцохоор зохих сургалтад хамрагдсан иргэдийг,

3. 4 дүгээр зүйл. Сайн дурын үйл ажиллагааны зарчим гэсэнд 4.1.9, 4.1.10 нэмэлт оруулах:

- 4.1. Сайн дурын үйл ажиллагаанд дараах зарчмыг баримтална:
- 4.1.9. гамшгаас хамгаалах сайн дурын үйл ажиллагаа нь мэргэжлийн нэгдмэл удирдлагатай байх,
- 4.1.10. гамшгаас хамгаалах сайн дурын үйл ажиллагаа нь шинжлэх ухаан, дэвшилтэд техник, технологи, инновацал тулгуурласан байх.

4. 9 дүгээр зүйл. Сайн дурын ажилтны эрх, үүрэг. Сайн дурын ажилтан дараах эрхийг эдэлнэ гэсэн заалтад 9.1.9, 9.1.10, 9.1.11, 9.1.12, 9.1.13, 9.1.14 нэмэлт оруулах:

- Сайн дурын ажилтан дараах эрхийг эдэлнэ. Үүнд:
 - ✓ 9.1.9. шашин шүтлэг, хувийн онцлог, эрх чөлөө, албан тушаалын байдлаар ялгаварлан гадуурхагдахгүй байх;
 - ✓ 9.1.10 сайн дурын ажилтан мөн болохыг нь гэрчлэх баримт бичиг эзэмших; ажил үүргээ гүйцэтгэхэд шаардлагатай анхан шатны болон явцын хэрэгцээт материал, тусламж, зөвлөгөө, сургалт, мэдээллээр хангуулах;
 - ✓ 9.1.11 гамшгаас хамгаалах сургалтад хамрагдах;
 - ✓ 9.1.12 гамшгаас хамгаалах үйл ажиллагаанд оролцохдоо шаардагдах багаж, хэрэгсэл, хүнсээр хангагдах,
 - ✓ 9.1.13 батлагдсан журмыг дагуу гамшгаас хамгаалах үйл ажиллагааны зардал, урамшуулал авах,

5. 9.2. Сайн дурын ажилтан дараах үүрэг хүлээнэ гэсэн заалтад 9.2.6, 9.2.7, 9.2.8, 9.2.9, 9.2.10, 9.2.11 нэмэлт оруулах:

- 9.2. Сайн дурын ажилтан дараах үүрэг хүлээнэ. Үүнд:
 - ✓ 9.2.6 үйл ажиллагаа эрхэлж байх явцад ашиг хонжоо олохоос татгалзах,
 - ✓ 9.2.7 үйл ажиллагаагаа холбогдох хууль, тогтоомж, мэргэжлийн болоод ёс суртахууны журам, хүлээн авч буй байгууллагын дүрэмд нийцүүлэн гүйцэтгэх;
 - ✓ 9.2.8 бусдын эрүүл мэнд, амь нас, биеийн бүтэн байдалд сөрөг нөлөөтэй үүргийг биелүүлэхээс татгалзах,
 - ✓ 9.2.9 өгсөн үүрэг даалгавар хохирол учруулах магадлалтай байвал үүрэг даалгавар өгсөн хүнд энэ тухай мэдэгдэх,
 - ✓ 9.2.10 үйл ажиллагаа хөгжүүлэх зорилгоор өгсөн заавар, зөвлөмжийг биелүүлэх,
 - ✓ 9.2.11 гамшгийн болон аюулын нөхцөл байдлын талаар холбогдох байгууллагад үнэн зөв, бодит шуурхай мэдээлэл өгөх.

6. 10 дугаар зүйл. Сайн дурын үйл ажиллагаа зохион байгуулагчийн эрх, үүрэг гэсэн зүйлд 10.9, 10.10, 10.11, 10.12 нэмэлт заалт оруулах:

- 10 дугаар зүйл. Сайн дурын үйл ажиллагаа зохион байгуулагчийн эрх, үүрэг

- ✓ 10.9 сайн дурын ажилтнуудыг ажиллах үүргээ гүйцэтгэхэд шаардлагатай материал хэрэгслээр хангах;
- ✓ 10.10. мэргэжлийн өвчин, ажлын ослын даатгал олгох, харилцан тохирсон бол эрүүл мэндийн даатгал, тахир дутуугийн тэтгэлэг олгох;
- ✓ 10.11. сайн дурын ажилтны хүсэлтээр гэрээний дагуу гүйцэтгэсэн ажил, ажлын чанарын талаар бичгээр үнэлгээ гаргаж өгөх;
- ✓ 10.12. сайн дурын ажилтан нь байгалийн гамшгийн үед үүрэг гүйцэтгэж байгаа тохиолдолд сайн дурын ажилтны ослын болон эрүүл мэндийн даатгалыг хариуцах.

Эрх зүйн зохицуулалтын, тухайлбал засаглалын бодлого, сайн дурын үйл ажиллагааны тухай хуулийн төсөлд оруулах саналын үндэслэл”... улс орныхоо ирээдүйн сайн сайхны төлөө хувь нэмрээ оруулахыг эрмэлзсэн иргэний идэвхтэй үйл ажиллагаа нь үндэсний аюулгүй байдлыг хангах бодлого, үйл ажиллагааны эх үндэс болох” тул тэдний оролцоог цогц болгоход чиглэсэн. Гамшгаас хамгаалах үйл ажиллагаа бүх иргэдийн оролцоонд тулгуурладаг, тиймээс сайн дурын ажилтан бүхэн тодорхой сургалтад хамрагдсаны үндсэн дээр гамшгаас хамгаалах үйл ажиллагаанд оролцох боломж бий болгоход хуулийн төсөлд оруулж санал чиглэхийн зэрэгцээ нийгмийн сайн сайхны төлөө, тогтвортой хөгжлийн төлөө сайн дурынхны оруулж буй хувь нэмэр гамшгаас хамгаалах үйлсэд хувь нэмэр болдог үзэл санааг агуулж байгаа болно.

Гамшгийн тусламж, үйлчилгээнд иргэд оролцох нь зайлшгүй тул, гамшгийн тусламж зохион байгуулдаг байгууллагууд эдгээр *сайн дурынхны оролцоог урьдчилан төлөвлөх, сургаж бэлтгэж бэлэн байдал хангах ёстой байдаг*. Саналыг хуульд оруулснаар сургагдаагүй, зохион байгуулалтгүй сайн дурынхны оролцоо нь зохион байгуулалттай тусламжийн үйл ажиллагаанд сөргөөр нөлөөлөх, өөрсдөө эрсдэх, гамшигт өртөгсдөд очих нөөцийн хэмжээ буурахаас сэргийлж чадна. Мөн нөгөө талаар сайн дурынхны мэдлэг, ур чадвар, нөөц, сүлжээ, урам зоригийг зөв удирдан зохион байгуулснаар онцгой байдал, гамшгийн менежментийг хамгийн өндөр үр дүнд хүргэх боломжтой болгоно.

ЭХ СУРВАЛЖИЙН ЖАГСААЛТ

Нэг. Хууль

1. Монгол Улсын Үндсэн хууль. “Төрийн мэдээлэл” эмхэтгэл. № 01. 1992.
2. Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хууль. “Төрийн мэдээлэл” эмхэтгэл № 22. 2012.
3. Байгаль орчныг хамгаалах тухай хууль. “Төрийн мэдээлэл” эмхэтгэл. № 05-06 1995
4. Галын аюулгүй байдлын тухай хууль.”Төрийн мэдээлэл”. эмхэтгэл № 07.2017.
5. Гамшгаас хамгаалах тухай хууль. “Төрийн мэдээлэл” эмхэтгэл. № 07. 2017.
6. Донорын тухай хууль. “Төрийн мэдээлэл” № ..2018
7. Залуучуудын хөгжлийг дэмжих тухай хууль “Төрийн мэдээлэл” № ..2017
8. Монголын Улаан Загалмай Нийгэмлэгийн эрх зүйн байдлын тухай хууль. “Төрийн мэдээлэл” эмхэтгэл № 5. 2016.
9. Ойн тухай хууль. “Төрийн мэдээлэл” эмхэтгэл № 22. 2012.
10. Үндэсний аюулгүй байдлын тухай хууль. “Төрийн мэдээлэл” эмхэтгэл № 3. 2002.
11. Төрийн бус байгууллагын тухай хууль. “Төрийн мэдээлэл” эмхэтгэл. № 1997.
12. Эрүүл мэндийн тухай хууль. “Төрийн мэдээлэл” эмхэтгэл № 2011.

Хоёр. Улсын Их Хурал, Засгийн Газрын тогтоол

13. Монгол Улсын Их Хурлын тогтоол. Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал. “Төрийн мэдээлэл” эмхэтгэл. № 48. 2010.
14. Монгол Улсын Их Хурлын тогтоол. Алсын хараа-2050 Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого. “Төрийн мэдээлэл” эмхэтгэл. № 52. 2020.
15. Монгол Улсын Их Хурлын тогтоол. Монгол Улсын Батлан хамгаалах бодлогын үндэс. “төрийн мэдээлэл” эмхэтгэл. № 85. 2015.
16. Монгол Улсын Их Хурлын тогтоол. Ногоон хөгжлийн бодлого. “Төрийн мэдээлэл” эмхэтгэл. № 43. 2014.
17. Монгол Улсын Их Хурлын тогтоол. Монгол Улсын мянганы хөгжлийн зорилгод суурилсан үндэсний хөгжлийн цогц бодлого. “Төрийн мэдээлэл” эмхэтгэл. № 12. 2008.
18. Монгол Улсын Их Хурлын тогтоол Өрхийн хөгжлийг дэмжих үндэсний хөтөлбөр. “Төрийн мэдээлэл” эмхэтгэл. № 2. 2012.
19. Монгол Улсын Их Хурлын тогтоол. Цөлжилттэй тэмцэх үндэсний хөтөлбөр. “ төрийн мэдээлэл” эмхэтгэл. № 90. 2010.
20. Монгол Улсын Их Хурлын тогтоол. Төрөөс эрүүл мэндийн талаар баримтлах бодлого. “Төрийн мэдээлэл” эмхэтгэл. № 24. 2017.
21. Монгол Улсын Их Хурлын тогтоол. Төрөөс боловсролын талаар баримтлах бодлого. “Төрийн мэдээлэл” эмхэтгэл. № 12. 2015.

22. Монгол Улсын Засгийн газрын тогтоол. Газар хөдлөлтийн аюулаас урьдчилан сэргийлэх, таниулах өдөртэй болох тухай. “Төрийн мэдээлэл” эмхэтгэл № 67. 2017.
23. Монгол Улсын Засгийн газрын тогтоол. Газар хөдлөлтийн гамшгийн эрсдэлийг бууруулах үндэсний хөтөлбөр. “Төрийн мэдээлэл” эмхэтгэл № 157. 2009.
24. Монгол Улсын Засгийн газрын тогтоол. Газар хөдлөлтийн гамшгаас хамгаалах зарим арга хэмжээний тухай. “Төрийн мэдээлэл” эмхэтгэл № 195. 2011
25. Монгол Улсын Засгийн газрын тогтоол. Гамшгийн үед хүч хэрэгсэл дайчлан гаргах журам. “Төрийн мэдээлэл”. № 340. 2011.
26. Монгол Улсын Засгийн газрын тогтоол. Гамшгийн эрсдэлийг бууруулах Сендайн үйл ажиллагааны хүрээг Монгол Улсад хэрэгжүүлэх дунд хугацааны стратеги батлах тухай. “Төрийн мэдээлэл”. № 355. 2017.
27. Монгол Улсын Засгийн газрын тогтоол. Гамшгийн хохирол, хэрэгцээний үнэлгээг хийх журам. “Төрийн мэдээлэл” № 2019.
28. Монгол Улсын Засгийн газрын тогтоол. Өрхийн хөгжлийг дэмжих үндэсний хөтөлбөр. “Төрийн мэдээлэл” эмхэтгэл № 2012.
29. Монгол Улсын Засгийн газрын тогтоол. Гамшгийн эрсдэлийг бууруулах Үндэсний зөвлөлийн ажиллах журам, бүрэлдэхүүнийг батлах тухай. “Төрийн мэдээлэл”. № 63. 2018.
30. Монгол Улсын шадар сайдын тушаал. Гамшгаас хамгаалах сайн дурын ажиллагааны нийтлэг журам. 1 2017.

Гурав. Сайдын болон агентлагийн даргын тушаал

31. Хөдөлмөр, нийгэм хамгааллын сайдын тушаал. Залуучуудын сайн дурын ажлыг бүртгэх, баталгаажуулах журам. А/130. 2019.
32. ОБЕГ-ын Даргын тушаал. Олон нийтэд суурилсан гамшгийн эрсдэлийг бууруулах дэд хөтөлбөр. № 2013.

Дөрөв. Сурах бичиг, ном, гарын авлага, нэг сэдэвт бүтээл.

33. Хууль зүйн үндэсний хүрээлэн. “Нийтэд тустай, сайн дурын үйл ажиллагааны үр нөлөөтэй эрх зүйн зохицуулалт” судалгаа. 2013. УБ.
34. Монгол Улс дахь Сайн дурын ажиллагааны Үндэсний хөтөлбөрийн үзэл баримтлал Зөвлөмж бичиг. 2013.
35. Ч. Сосормаа. Төрийн бус байгууллагын менежмент. (гарын авлага) УБ. 2017.
36. Монгол хэлний их тайлбар толь
37. ОУУЗ, УХСН-үүдийн Холбоо, Онцгой байдлын үеийн сайн дурын ажиллагаа, Онцгой байдлын үед сайн дурын идэвхтнийг удирдан чиглүүлэх гарын авлага, бх
38. Дэлхийн сайн дурын үйл ажиллагааны төлөв байдал. 2015. Засаглалыг өөрчлөх нь.

39. Монголын сайн дурын үйл ажиллагааны нөхцөл байдлын үнэлгээ ба зөвлөмж. УБ. 2012.
40. “Сайн дурын үйл ажиллагааг зохицуулж буй хууль болон бодлого” НҮБ-ын сайн дурын байгууллагын судалгааны тайлан 2009.
41. МУЗН. Улаан Загалмайн сайн дурын идэвхтэн. (гарын авлага). УБ.2012.
42. Английн УЗН. Асрамжлагч сайн дурынхны гарын авлага. УБ. 2011.
43. МУЗН-ийн баримт бичгийн эмхэтгэл. УБ. 2021.
44. Ярианаас үйл ажиллагаанд: Хёогогийн үйл ажиллагааны хүрээг өргөжүүлэх удирдамж. УБ.2008. 164-р тал.
45. ОУУЗ, УХСН-үүдийн Холбоо. Олон нийтэд тулгуурласан нийгэм сэтгэл зүйн дэмжлэг. (сургагч багшийн ном). УБ. 2020.
46. ОБЕГ, Дэлхийн зөн ОУБ Өсвөрийн аврагч бүлгийн сурагчийн гарын авлага. УБ. 2015.
47. ОУУЗ, УХСН-үүдийн Холбоо Сайн дурын авлагагүй, цусны доноруудыг элсүүлэх үйлсэд амжилт олох нь. УБ. 2003.
48. ОУУЗ, УХСН-үүийн Холбоо, МУЗН Олон нийтэд тулгуурласан эрүүл мэнд, анхны тусламж (гарын авлага). УБ.2010.
49. Финляндын УЗН, МУЗН Олон нийтэд тулгуурласан нийгэм сэтгэл зүйн дэмжлэг үзүүлэх нь. УБ. 2011.
50. А.Оюунгэрэл. (МУЗН). Оролцооны аргаар судалгаа явуулах. (сайн дурын идэвхтнүүдэд зориулсан гарын авлага). УБ. 2003.
51. ОУУЗ, УХСН-үүдийн Холбоо. Онцгой үеийн үнэлгээ хийх аргачлал. Уб. 2008.
52. ОУУЗ, УХСН-үүдийн Холбоо. ОУУЗ, УХС Хөдөлгөөн болон ТББ-ын Гамшгийн тусламжийн үеийн мөрдөх Ёс зүйн дүрэм. УБ. 2010.
53. Гамшиг Судлалын хүрээлэн. Судалгааны ажлын эмхэтгэл. УБ. 2020.
54. НҮБ-ын Хүүхдийн сан, Хүүхдийн төлөө Үндэсний газар. Монгол дахь зуд болон бусад гамшгийн нөлөөлөлд буй хүүхдэд нийгэм сэтгэл зүйн дэмжлэг үзүүлэх нь (эцэг эх, багш нарт зориулсан гарын авлага) УБ.2006.
55. Н.Баяраа, П.Дамдин Монгол оронд тохиолддог аюулт үзэгдэл, гамшиг, сургамж. УБ. 2006.
56. Ник Картер. Гамшгийн менежмент. УБ. 2003.
57. Монгол Улсад гамшгийн аюулыг бууруулах, менежментийн тогтолцоог боловсронгуй болгох нь төслийн III шат. Мон/08/305 төсөл. Уур амьсгалын өөрчлөлт, гамшгийн эрсдэлийг бууруулах нь (сургалтын гарын авлага). УБ.2009.
58. ОБЕГ, НҮБ-ын хөгжлийн хөтөлбөр. Гамшгаас хамгаалах үндэс. (сайн дурынханд зориулав). УБ. 2017.
59. ОБЕГ. Гамшгийн эрсдэлийн удирдлагын эрх зүйн баримт бичгийн эмхэтгэл. УБ.2019.
60. Дэлхийн зөн ОУБ. Орон нутгийн оролцоотой гамшгийн эрсдэлийг бууруулах. (сургалтын гарын авлага). УБ. 2013.

- 61.С. Нямсүрэн. Сайн дурын үйл ажиллагааны харьцуулсан судалгаа. Магистрын зэрэг горилсон бүтээл. МУБИС. УБ. 2020.
- 62.Б.Батбаяр. Орон нутгийн гамшгаас хамгаалах үйл ажиллагаанд сайн дурынхны оролцоог бий болгох арга зам. ХСИС. 2016.

Гадаад эх сурвалж.

- 63.R.A. Cnaan, F.Handy, M.Wadsworth, Defining who is a volunteer: Conceptual and empirical considerations, *Nonprofit Volunt.Sect.Q.25* (1996)364–38
- 64.R.A. Cnaan, F.Handy, M.Wadsworth, Defining who is a volunteer: Conceptual and empirical considerations, *Nonprofit Volunt.Sect.Q.25* (1996)364–38
- 65.Сборник методических материалов в сфере государственной молодежной политики. Росмолодежь. Федеральное агентство по делам молодежи. М., 2009. –С. 8.
- 66.Стеббинс Р. А. Свободное время: к оптимальному стилю досуга // Социол. исслед. –2006.–№ 7.–С. 64-72.
- 67.Яковлев П.И. Формирование гражданского самосознания молодежи в условиях досуговой деятельности добровольческих объединений // Вестник ТГУ.–2011. –№8 (100).–С. 158-162.
- 68.Спирина М.О. Организационная специфика волонтерского движения: сравнение опыта России и Франции // Экономическая социология. Т. 16. –2015. –№ 2. –С. 24-54.
- 69.Колосова Р.П., Красновид А.В. Занятость волонтеров: возможности и ограничения. – М.: Экон. ф-т МГУ имени М.В. Ломоносова; ТЕИС, 2010.–С. 14.
- 70.Вандышева Л.В. Эмоциональный труд волонтеров: анализ опыта реализации // Фундаментальные исследования. – 2014. – № 9.–С. 838-842.
- 71.Шекова, Е. Л. Экономика и менеджмент некоммерческих организаций: учебное пособие. –СПб., 2003. – С. 147-149.
- 72.Моисейчева М. Виды волонтерства // ViZ-Vote, No 4.–М.: АНО«Брайтенарбайт», 2011.–С. 5.
- 73.Железовская И.А., Тарасова Т.Л. Гражданско-патриотическое воспитание обучающихся колледжа через систему волонтерской деятельности //Научные исследования в образовании.–2011.–№ 12.–С. 16-20.
- 74.Переясловец В.М., Переясловец Т.С. Опыт привлечения волонтеров для организации системы экологического мониторинга в Юганском заповеднике.
- 75.Петошина С.И., Рыжкова И.В., Тегалева Т.Д. Педагогическое волонтерство в образовательных учреждениях как фактор развития социальных и профессиональных компетенций студенческой молодежи // Современные проблемы науки и образования. –2015. –№ 6.–С. 431.

76. Australian Government, Spontaneous Volunteer Management Resource Kit: Helping to Manage Spontaneous Volunteers in Emergencies, Commonwealth of Australia, Canberra. 2010
- a. Холостова Е.И. Волонтеры // Словарь-справочник по социальной работе / под ред. проф. Е.И. Холостовой. М., 1997. –С. 89
 - b. Гареева Е.В. Анализ волонтерства как процесс асоциализации современной молодежи // V Международная студенческая электронная научная конференция «Студенческий научный форум» (15 февраля – 31 марта 2013 г.).
 - c. Холина О.И. Особенности волонтерского движения в России //Общество и право. –2012.– No 5 (42).–С. 296-299.
 - d. Тарасова Н.В. Волонтерская деятельность как историко - педагогический феномен// Педагогическое образование в России. –2012. –No 4. –С. 46-52.
 - e. J.Wilson, Volunteering, Annu. Rev. Sociol. 26(1) (2000) 215–240.
 - f. R.A. Cnaan, F.Handy, M.Wadsworth, Defining who is a volunteer: Conceptual and empirical considerations, Nonprofit Volunt.Sect.Q.25 (1996)364–383
 - g. L.A.Penner, Volunteerism and social problems: making things better or worse, J. Soc.Issues 60(3)(2004)645–666.
 - h. M.Snyder, A.M.Omoto, Volunteerism: social issues perspectives and social policy implications,
 - i. J.Wilson, Volunteering, Annu. Rev. Sociol.26(1) (2000) 215-240
 - j. R.A.Cnaan, F.Handy, M.Wadsworth and P.Dekker, L.Halman, A.Penner ...нап
 - k. R.A.Cnaan, F.Handy, M.Wadsworth, Defining who is a volunteer: Conceptual and empirical considerations, Nonprofit Volunt. Sect.Q.25 (1996) 364-383.
 - l. UNV and UNDP 2011.
 - m. Making all Voices count n.d.
 - n. Laws and Poicies affecting volunteerism since 2001.
 - o. A/57/352 para 28.
 - p. En.wikipedia.org/wiki/American_Red_Cross
 - q. L.S.Fernandez, J.A.Barbera, J.R.Vandorp, Spontaneous volunteer response to disasters: the benefits and consequences of good intentions, J.Emerg.Manag. 4(5)(2006)57-68
 - i. Helsloot, A.Ruitenberg, Citizen response to disasters: a survey of literature and some practical implications, J.Conting. CrisisManag. 12(3)(2004) 98-111.
 - r. J.Y.Hur, Disaster management from the perspective of governance: case study of the Hebei Spirit oil spill, Disaster Prev. Manag. 21(3)(20)(2012) 288-298
 - s. D.Alexander, (2010) The voluntary sector in emergency response and civil protection: review and recommendations. International Journal of Emergency Management 7(2),pp.151-16.

- t. R.R.Dynes, E.L.Quarantelli, D.Wenger, Individual and organizational response to the 1985 earthquake in Mexico City, Mexico. Book& Monograph Series No. Disaster Research Center, University of Delaware. Delaware,1990.
- u. Statista,2020,firefighting volunteers in Australia fy 2010-2019
- v. Victoria Bushfire Royal Commission,2010, Final Report- 2009
- w. Цахим эх сурвалж.**
- х. Монгол хэлний их тайлбар толь. <https://mongolmoli.mn>.
- у. Монгол УИХ. <https://www.parlament.mn>.
- z. ОБЕГ. www.nema.gov.mn.
- aa. Гамшиг судлалын хүрээлэн //www.nema.dri.gov.mn/.
- bb.Эрх зүйн мэдээллийн нэгдсэн систем. www.legalinfo.mn.
- cc.Мэдээллийн сан. <https://emdat.be/> The international Disaster Database.
- dd.Мэдээллийн сан
URL:<http://www.ugansky.ru/upload/medialibrary/852/pereyaslovets-v.m.-pereyaslovets-t.s.-opyt-privlecheniya-volonterov-dlya-organizatsii-sistemyekologicheskogo-monitoringa-v-yuganskom-zapovednike.pdf> (дата обращения: 15.03.2016).
- ee.Мэдээллийн сан. <https://www.undrr.org/publivation/2020-year-disasters/>.
- ff. Мэдээллийн сан. www.adrc.or.jp/publications
- gg.Мэдээллийн сан. Availableat:(http://www.fema.gov/media-library-data/20130726-1914-25045-9213/nrf_support_annex_volunteer_20130505.pdf), 2014
- hh.Мэдээллийн сан. URL: <https://www.scienceforum.ru/2013/157/3674#> (дата обращения 01.12.2015).
- ii. Мэдээллийн сан
<http://drr.ucepace.org/english/documents/References/Тоpec%20Preparedness%20Early%20Warning,%20Planning,%20and%20Evaluation/Twigg%202001%20CSR%20and%20disaster%20management.pdf>2001
- jj. Мэдээллийн сан. <http://emilms.fema.gov/IS700aNEW/glossary.htm>),
- 77.192.Мэдээллийн сан.<http://www.ugansky.ru/upload/medialibrary/852/pereyaslovets-v.m.-pereyaslovets-t.s.-opyt-privlecheniya-volonterov-dlya-organizatsii-sistemyekologicheskogo-monitoringa-v-yuganskom-zapovednike.pdf> (дата обращения: 15.03.2016).
- 78.193.Мэдээллийн сан. URL: <http://scientific-notes.ru/pdf/044-012.pdf> (дата обращения 01.01.2017).
- 79.195.Мэдээллийн сан. Availableat:(http://www.fema.gov/media-library-data/20130726-1914-25045-9213/nrf_support_annex_volunteer_20130505.pdf), 2014
- 80.196. Мэдээллийн сан. URL: <https://www.scienceforum.ru/2013/157/3674#> (дата обращения 01.12.2015).